

ГАМШИГ, УУР АМЬСГАЛЫН
ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ
ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭ

2024

МОНГОЛ УЛС



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



cadri
Partnership

Гамшгийн эрсдэлийг
бууруулах чадавхыг
бэхжүүлэх түншлэл

World Vision

ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ


КАДРИ (CADRI-Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх түншлэл) нь Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд гамшгийн болон уур амьсгалын эрсдэлийг бууруулах зорилгоор улс орнуудын харилцан уялдаатай, нэгдсэн шийдлүүдийг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн НҮБ-ын тэргүүлэл бүхий дэлхийн түншлэл, хамтын ажиллагаа юм.

Энэхүү хэвлэмэл материалыг мэдлэг, мэдээлэл олгох болон арилжааны бус бусад зорилгоор зохиогчийн эрх эзэмшигчийн тусгай зөвшөөрөл авалгүйгээр бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ямар ч хэлбэр, хэрэгслээр ашиглах, хуулбарлах боломжтой. Нэгдсэн Үндэстний Байгууллага уг баримт бичгийг ашигласан аливаа хэвлэмэл материалын хуулбарыг хүлээн авахдаа талархах болно.


2023 онд зохион байгуулагдсан Монгол Улсын гамшгийн болон уур амьсгалын эрсдэлийг удирдах үндэсний ба орон нутгийн чадавхын үнэлгээний үр дүн, зөвлөмжийг тус тайланд тусган танилцуулж байна. Үнэлгээнд 2024 оны эхэн үеийн техникийн шинэчлэгдсэн мэдээллүүдийг нэмж тусгасан болно.

© Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх түншлэл, 2024 он

Загвар: Карен Ачиенг



КАДРИ түншлэлийн багаас Онцгой байдлын ерөнхий газар, НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрыг удирдлага дор НҮБ-ын Монгол дахь төрөлжсөн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, 2023 онд зохион байгуулсан Монгол Улсын гамшиг, уурамьсгалын эрсдэлийг удирдах үндэсний болон орон нутгийн чадавхыг үнэлэх судалгааны үр дүн, зөвлөмжийг энэхүү тайланд тусган танилцуулж байна.



АГУУЛГА

ДЭЛГЭРЭНГҮЙ	6
ТАЛАРХАЛ	10
ӨМНӨХ ҮГС	12
ХУРААНГҮЙ	16
1. УДИРТГАЛ	19
1.1 Чадавхын үнэлгээний агуулга, үндэслэл	19
1.2 Уур амьсгал, гамшгийн эрсдэлийн нөхцөл байдал	21
2. ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ, ҮЙЛ ЯВЦ	28
2.1 КАДРИ чадавхын үнэлгээний арга зүй	28
2.2 Хязгаарлалт	32
3. ҮР ДҮН БА ЗӨВЛӨМЖ - САЛБАР ХООРОНД	34
3.1 Тойм	34
3.2 Засаглал	35
3.3 Мэдлэг мэдээлэл, технологи	42
3.4 Санхүүжилт	51
3.5 Хэрэгжилт	59
4. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР – БАЙГАЛЬ ОРЧИН	67
4.1 Засаглал	69
4.2 Хэрэгжилт	73
4.3 Санхүүжилт	77
4.4 Тоног төхөөрөмж	80
5. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР - ХӨДӨӨ АЖ АХУЙ	85
5.1 Засаглал	93
5.2 Хэрэгжилт	95
5.3 Санхүүжилт	98
5.4 Тоног төхөөрөмж	100
6. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР - ДЭД БҮТЭЦ	104
6.1 Засаглал	106
6.2 Хэрэгжилт	110
6.3 Санхүүжилт	114
6.4 Мэдлэг мэдээлэл, технологи	117

7. НИЙГМИЙН САЛБАР – ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН	122
7.1 Засаглал	123
7.2 Хэрэгжилт	126
7.3 Санхүүжилт	129
7.4 Мэдлэг мэдээлэл	131
7.5 Технологи, тоног төхөөрөмж	133
8. НИЙГМИЙН САЛБАР - НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	136
8.1 Засаглал	137
8.2 Хэрэгжилт	138
8.3 Санхүүжилт	141
8.4 Мэдлэг ойлголт	142
8.5 Технологи, тоног төхөөрөмж	143
ХАВСРАЛТ	145
Хавсралт 1: Зөвлөлдөх уулзалтууд хийсэн байгууллагууд	145
Хавсралт 2: Чадавхын үнэлгээний асуулга	148
НОМ ЗҮЙ	154

ДЭЛГЭРЭНГҮЙ

Товчлол	
АХБ	Азийн Хөгжлийн банк
АГАБТ	Азийн гамшгийн аюулыг бууруулах төв
ХОУ	Хиймэл оюун ухаан
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн ерөнхий газар
НЭЧ	Нян эсэргүүцэх чанар
Бакалавр	Бакалаврын зэрэг
КАДРИ	Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх
ОНСГЭУ	Олон нийтэд суурилсан гамшгийн эрсдэлийн удирдлага
УАӨ	Уур амьсгалын өөрчлөлт
УАӨДЗ	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
БЗМ	Баазын зохицуулалт болон менежмент
ХКС	Хяналтын камерын систем
ДЦХ	Дулаан, цахилгаан хосолсон
ХҮС	Хүмүүнлэгийн үндсэн стандарт
БНХАУЦУГ	БНХАУ-ын Цаг уурын газар
СХХДЦУХД	Солонгосын харилцаа холбоо, далай, цаг уурын хиймэл дагуул
УАЭҮ	Уур амьсгалын эрсдэлийн үзүүлэлт
ГЭС	Гамшгийн/Сүйрлийн эрсдэлийн сан
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
КНХ	Компанийн нийгмийн хариуцлага
МС	Мэдээллийн сан
БОХОНАХХ	Байгаль орчин, хүнс, орон нутгийн асуудал хариуцсан хэлтэс
ГББ	Гамшгийн бэлэн байдал
ГХТ	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
ГЭ	Гамшгийн эрсдэл
ГЭҮ	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ
ГХСБҮА	Гамшгийн хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаа
ГЭҮ	Гамшгийн эрсдэлийн удирдлага
ГЭУГ	Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар
ГЭУ/Б	Гамшгийн эрсдэлийн удирдлага / бууруулах
ГЭБ	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа
ШХМ	Шилжилт хөдөлгөөнийг хянах матриц
БОУАС	Байгаль орчин, уур амьсгалын сан
ДХЦАУМЕТ	Дунд хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээллийн Европын төв
ЭХХТ	Эрчим хүчний хөгжлийн төв

Товчлол	
БОНУ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
ЗДО	Зураг дүрслэх орчин
ШУТ	Шуурхай удирдлагын төв
ШУТА	Шуурхай удирдлагын төвийн албан хаагч
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
БОНХЗ	Байгаль орчин, нийгэм, хамтын засаглал
ЕХ	Европын Холбоо
ЭСХАХ	Эрт сэрэмжлүүлэг ба хариу арга хэмжээ
НУБ-ын ХХААБ	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага
ҮҮ цуврал	Fengyun цуврал (Хятадын цаг уурын хиймэл дагуулууд)
МУХХЕГ	Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар
УАНС	Уур амьсгалын ногоон сан
ЕЭЗ	Ерөнхий эргэлтийн загвар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДДБОС	Даян дэлхийн байгаль орчны сан
ОБМСТ	Онцгой байдлын менежментийн сайн туршлага
ГЗМС	Газарзүйн мэдээллийн систем
ХСТ	Хүмүүнлэгийн стандартын түншлэл
ООГХ	Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэн
МИД	Малын индексжүүлсэн даатгал
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ЭУИ	Эрсдэлийн удирдлагын индекс
ОУТББ	Олон улсын төрийн бус байгууллага
ХОУЭХАЗГ	Хот дахь олон улсын эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлэг
ОУШХБ	Олон улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
УАӨАЗГХЗ	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын зөвлөл
АШШҮ	Анхан шатны шуурхай үнэлгээ
УЦУОСМХ	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
ОУСБ	Олон улсын стандартчиллын байгууллага
МТ	Мэдээллийн технологи
ОУБХХ	Олон улсын байгаль хамгаалах холбоо
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
KfW	KfW Kreditanstalt für Wiederaufbau (Германы Засгийн газрын өмчит Хөгжлийн банк)
СЦУГ	Солонгосын цаг уурын газар
ГЭБОНЗ	Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлүүд
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНОК	Орон нутгийн Онцгой комисс
ОБМАЧҮАЗС	Онцгой байдлын үед мал, амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандарт

Товчлол	
ОНОБГ	Орон нутгийн Онцгой байдлын газар
Мастер	Магистерын зэрэг
МУМЭМС	Монгол Улсын малын эрүүл мэндийн мэдээллийн систем
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ГХЯ	Гадаад харилцааны яам
ОСАШШҮ	Олон салбарын анхан шатны шуурхай үнэлгээ
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ДНДС	Дундаж нарийвчлалтай дүрслэлийн спектррадиометр
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
МУС	Монгол Улсын стандарт
МНТ	Монгол төгрөг
ЭХЯ	Эрчим хүчний яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
СЯ	Сангийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
МУЗН	Монголын Улаан Загалмай Нийгэмлэг
МСК	Медведев-Спонхеуэр-Карникийн масштаб
МВт	Мегаватт
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
УАӨҮХ	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр
УАҮХ	Уур амьсгалын Үндэсний хороо
УАӨЦБҮХ	Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах үндэсний хороо
ҮТХН	Үндэсний тодорхойлсон хувь нэмэр
УНЯИ	Ургамлын нормчилсон ялгаврын индекс
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ХБЗ	Хүнсний бус зүйл
ТББ	Төрийн бус байгууллага
БНМ	Байгалийн нөөцийн менежмент
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮАЗҮ	Үйл ажиллагаа ба засвар үйлчилгээ
ХАЁТ	Хөгжлийн албан ёсны тусламж
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ГДХҮ	Гамшгийн дараах хэрэгцээний үнэлгээ
ЭҮТ	Экосистемийн үйлчилгээний төлбөр
Ph.D.	Философийн ухааны доктор
БАГ	Бэлчээр ашиглагчийн гэрээ
КГЗМС	Квантын газарзүйн мэдээллийн систем
СХ	Судалгаа хөгжил
ГСГЗ	Гол, сав газрын захиргаа

Товчлол	
ГСГМ	Гол, сав газрын менежмент
ГТЧИ	Гамшгийг тэсвэрлэх чадавхын индекс
СЗГ	Суурин зохицуулагчийн газар
ХХК	Хүлэмжийн хийн концентрац
ГТЧИХДШ	Гамшгийг тэсвэрлэх чадавхын индексийн хэмжилт, дүн шинжилгээ
ЭБ	Эрсдэлийг бууруулах
ЭХАА	Эрэн хайх, аврах ажиллагаа
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
БОСҮ	Байгаль орчны стратегийн үнэлгээ
УОК	Улсын онцгой комисс
ГЭБСҮАХ	Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ
ЖАХБМ	Жижиг арлын хөгжиж буй мужууд
НБСС	Норм ба стандартын систем (Оросын дизайны код)
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ХТУСТҮ	Хур тунадасны ууршилтын стандартчилагдсан индекс
ШРТД	Шатл радарын топографийн даалгавар
ХДМӨ	Хил дамнасан малын өвчин
УБ	Улаанбаатар
УБХГХХ	Улаанбаатар хотын газар хөдлөлтийн хагарал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБУОНҮ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Улс орны нийтлэг үнэлгээ
НҮБУБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Удирдлагын баг
НҮБГҮЗ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн үнэлгээ, зохицуулалтын газар
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НҮБГЭБГ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар
НҮББОХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр
НҮБУАӨСК	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц
НҮБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан
НҮБДАЭДКГ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар
НҮБСЗГ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин зохицуулагчийн газар
НҮБТХХАХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ
Ам.доллар	АНУ-ын доллар
ЭБИ	Эмзэг байдлын индекс
ТХХС	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний систем
УАЦЭА	Ус, ариун цэвэр, эрүүл ахуй
ДЦУБ	Дэлхийн цаг уурын байгууллага
ЦУСУМ	Цаг уурын судалгаа, урьдчилсан мэдээ

ТАЛАРХАЛ

КАДРИ түншлэлийн Тамгын газрын чадавхын үнэлгээний зохицуулагч Карла Лиенхарт, Екатерина Мелниченко нараас үнэлгээний ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, идэвх зүтгэл гаргасан дараах байгууллага, алба хаагчдад талархал илэрхийлье. Үүнд:

Монгол Улсын Засгийн газар, Онцгой байдлын ерөнхий газраас чадавхын үнэлгээний үйл явцыг удирдан чиглүүлж, дэмжлэг үзүүлсэн:

- Монгол Улсын Шадар сайдын зөвлөх Гончигийн Ганболд
- ОБЕГ-ын дэд дарга, бригадын генерал Батмөнхийн Ууганбаяр
- ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Думаагийн Намсрай
- ОБЕГ-ын Эрсдэлийн удирдлагын газрын дарга, хурандаа Дэмбэрэлнямын Баасансүрэн
- ОБЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Лувсаншаравын Өлзийбаяр
- ОБЕГ-ын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Чадраабалын Ариунаа
- ОБЕГ-ын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээний хэлтсийн дарга, хурандаа Дуудгайн Базаррагчаа
- ОБЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Энхбатын Амгалан
- ОБЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн, хошууч Нямсүрэнгийн Ананда
- ОБЕГ-ын Эрсдэлийн удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, ахмад Батбаатарын Амаржаргал
- ОБЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн, ахмад Түвдэндоржийн Зориг

Сүхбаатар, Увс, Дундговь аймгийн орон нутгийн удирдлагууд.

НҮБ-ын Суурин зохицуулагч ноён Тапан Мишрагийн удирдаж буй Монгол дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар, төрөлжсөн байгууллагуудад үнэлгээний явцыг зохион байгуулж, мэргэжлийн чиглэлээр хувь нэмрээ оруулан, дэмжлэг үзүүлсэн:

- Болдын Сувд, СЗГ
- Сүхбаатарын Жигжидпүрэв, ХХААБ
- Хархүүгийн Хишигжаргал, НҮБХХ
- Эрдэнэжавын Эрдэнэбат, НҮБХХ
- Төмөртоогогийн Дэлгэрнаран, НҮБХХ
- Лхагваагийн Билгүүн, НҮБ-ын Хүн Амын Сан
- Шагдарсүрэнгийн Энхцэцэг, НҮБ-ын Хабитат байгууллага

Мэргэжлийн туслалцаа үзүүлсэн **Дэлхийн Зөн Монгол ОУБ:**

- Сумьяагийн Оюунтөгс

КАДРИ түншлэлийн агентлагууд:

- Чинацу Эндо, НҮБ-ын ГЭБГ-ын бүс нутгийн газар
- Мэт Багосси, ОУШХБ-ын бүс нутгийн алба



НҮБ-ын Гамшгийн үнэлгээ, зохицуулалтын газар (НҮБГҮЗГ):

- Ман Тапа

Зохицуулалтаар хангасан **ДЦУБ**, мэргэжлийн туслалцаа үзүүлсэн **Солонгос Улсын Цаг уурын газар (СЦУГ) болон БНХАУ-ын Цаг уурын газар (БНХАУЦУГ):**

- Сүжин Ким, БНСУ-ын ЦУГ
- Жан Жианлэй, БНХАУ-ын ЦУГ

КАДРИ түншлэлийн нарийн бичгийн **газрын** баг хамт олонд тус тайланг нэгтгэх, дизайн хийхэд дэмжлэг үзүүлсэн:

- Фиона Шмидт
- Карен Ачиенг

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Онцгой Комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын дэмжлэгтэйгээр Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх түншлэл (КАДРИ)-ийн баг Монгол Улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхын үнэлгээг амжилттай хийж гүйцэтгэлээ.

Энэхүү үнэлгээг хийж хэрэгжүүлсэн НҮБ-ын удирдлага, зохицуулалт дор ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын олон улсын хамтын ажиллагаа (КАДРИ)-ны түншлэлд гүн талархал илэрхийлье.

Уур амьсгалын өөрчлөлт дэлхий нийтэд тулгамдсан асуудал болж байна. Монгол Улсын Засгийн газар уур амьсгалын өөрчлөлт нь байгаль, цаг уурын аюултай үзэгдэл, гамшгийн эрсдэлийн шинж, төрх байдалд нөлөөлж, эдийн засаг, нийгмийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байгааг анхаарч, бодлого, үйл ажиллагаа, засаглалын тогтолцоог бэхжүүлэхээс гадна уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшиг, аюулт үзэгдэл, ослын эрсдэлийг бууруулах, болзошгүй хохирлыг бууруулахаар цогц арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулах, эрсдэлийг удирдлагын үндэсний болон орон нутгийн тогтолцоог шинжлэн дүгнэх, гамшигт өртөж болзошгүй нийгэм, эдийн засгийн салбаруудын бэлэн байдлыг хангах, эрт зарлан мэдээлэх, эрсдэлийг бууруулахыг зорьж, эрсдэлийг бууруулах чадавхын үнэлгээг эхлүүлсэн билээ.

Хамтарсан Засгийн газар гамшгийг тэсвэрлэх эдийн засгийн болон дэд бүтцийн чадавх, нийгмийн сэтгэл зүй, иргэдийн оролцоо, хариуцлагыг дээшлүүлэхээр дэвшүүлсэн “Нэг улс нэгдсэн стандарт” зорилтыг хэрэгжүүлэхэд КАДРИ-ийн судалгаанд суурилсан зөвлөмжүүд чухал түлхэц үзүүлэх болно.

Монгол Улсад Онцгой байдлын алба үүсч байгуулагдсан 2004 онд НҮБ-ын Гамшгийн үнэлгээ, зохицуулалтын багийг урьж, шинэ тутам албаны бүтэц тогтолцоо, үйл ажиллагааны чадавхид үнэлгээ хийсэн нь манай улсын гамшгаас хамгаалах стратегийн чиглэлд томоохон үүрэг гүйцэтгэснийг дурдахад сэтгэл ханамжтай байна.

Гамшгийн төрөл, давтамж, түүнээс учрах хохирлын хэмжээ, өртөж буй хүн ам, нийгэм эдийн засаг, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө жилээс жилд нэмэгдсээр байгаа нь үндэсний болон орон нутгийн хэмжээнд гамшгийг даван туулах чадавхаа бэхжүүлэхийг шаардаж байна.

Монгол Улсын “Алсын хараа - 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг тусгасан бөгөөд Монгол Улс “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийг шат дараатай хэрэгжүүлж байна. Олон нийтийг мэдлэг мэдээллээр хангахад ахиц дэвшил гарч байгаа боловч гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, зохицуулалт, чадавхыг улам бүр сайжруулах нь чухал болж байна.

Иймд Монгол Улсын хувьд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь бүх яам, агентлаг, салбар, орон нутаг, үндэсний болон бүс нутаг, олон улсын хэмжээнд харилцаа, хамтын ажиллагаа, хүн бүрийн идэвхтэй оролцоог шаардсан цогц үйл ажиллагаа юм.

Энэхүү үнэлгээг хийхэд хамтран ажилласан холбогдох байгууллагууд, оролцогч талуудад талархал илэрхийлье. Үнэлгээнд суурилсан зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж ажилласнаар гамшгийн эрсдэлийг бууруулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг зохих салбарт чиглүүлж, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, болзошгүй хор хохирлыг бууруулахад ахиц дэвшил гарна гэж итгэж байна.

Хамтран ажилласан эрхэм та бүхэнд ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсье.

Эх дэлхий амгалан тайван байх болтугай!



С.Амарсайхан

**Монгол Улсын Шадар сайд,
Улсын Онцгой комиссын дарга,
Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хорооны дарга,
Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн орлогч дарга**



ӨМНӨХ ҮГ

Дэлхийн хэмжээнд агаарын дундаж температур хэдийн 1.1°C-ээр нэмэгдсэн энэ үед уур амьсгалын өөрчлөлтийн улмаас эрсдэлийн нөхцөл байдал хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж байна. Энэ нь гамшгийн цар хүрээ, давтамж, ноцтой байдлыг улам нэмэгдүүлж байгааг сүүлийн хорин жилийн хугацаанд цаг агаарын аюулт үзэгдлүүд хоёр дахин өссөнөөс харж болно. Энэ байдал Монгол Улсыг ч мөн тойроогүй. Монгол Улс зуд, шороон болон цасан шуурга, ган, үер, тал хээрийн гал түймэр болон газар хөдлөлт зэрэг олон төрлийн байгалийн аюулт үзэгдэлд өртөмтгий билээ. Сүүлийн 80 жилийн хугацаанд Монгол орны уур амьсгал ихээр дулааран дэлхийн дундаж үзүүлэлтээс давж, гадаргын температур 2.25°C-аар нэмэгдсэн. Үүний улмаас 2015-2021 онд байгалийн аюулт үзэгдлийн тоо 2.9 дахин нэмэгдэж, 7 жилийн хугацаанд нийт 394.6 тэрбум төгрөгийн хохирол (КОВИД-19 цар тахлыг оруулахгүйгээр) учирсан.

НҮБ-ын Гамшгийн үнэлгээ, зохицуулалтын баг Монгол Улсын байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой гамшгийн хариу арга хэмжээний чадавхын цогц үнэлгээг 2004 онд хийсэн ба тус үнэлгээ нь гамшгийн хариу арга хэмжээний үндэсний тогтолцоог бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Гамшгийн дараах хор уршгийг арилгах арга хэмжээнээс гамшгийг даван туулах чадавх руу шилжих нь тогтвортой хөгжилд нэн чухал ач холбогдолтой байдаг. Чадавхыг нэгдмэл бөгөөд үе шаттайгаар бий болгох нь чухал ба ингэснээр гамшгийг хохирол багатай даван туулах, иргэдийн амь насыг аврах, гамшгийн хариу арга хэмжээний санхүүжилтийг үлэмж хэмжээгээр бууруулах билээ. Тиймээс Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх түншлэл (КАДРИ)-ийн багийг ажиллуулан цогц үнэлгээ, дүн шинжилгээг хийсэн. КАДРИ түншлэлийн баг гэдэг нь улс орнуудад гамшиг, уурын амьсгалын эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлж цогц үнэлгээ хийж, Засгийн газарт хэрэгжүүлэх боломжтой зөвлөмжүүдийг санал болгох зорилгоор НҮБ-ын төрөлжсөн 20 байгууллага, хөгжлийн бусад байгууллагаас бүрдсэн олон улсын түншлэлийн тогтолцоо юм.

КАДРИ түншлэлийн баг 2023 оны 9 дүгээр сард Монгол Улсын гамшиг, уур амьсгалын эрсдэлийг удирдах чадавхыг үнэлэх зорилгоор цогц дүн шинжилгээг хийсэн ба энэхүү үнэлгээ нь нийгэмэдийн засгийн нэн чухал салбарын хэмжээнд эрт зарлан мэдээлэл, гамшгийн бэлэн байдал, эрсдэлийг бууруулах стратегийг сайжруулахад зөвлөмж өгөхөд чиглэсэн болно. Хөдөө аж ахуй, байгаль орчин, дэд бүтэц, боловсрол, нийгмийн хамгаалал ба хүний шилжилт хөдөлгөөн зэрэг салбаруудад цогц үнэлгээ, дүн шинжилгээ хийхдээ засаглал, хэрэгжүүлэх чадавх, санхүүжилт, мэдлэг болон техник тоног төхөөрөмж, технологи зэрэг 5 үзүүлэлтийг авч үзсэн. Ингэснээр улс орны давуу болон сул тал, хүндрэл, бэрхшээлүүдийг тодорхойлж, салбар тус бүрийн онцлог шаардлагад нийцсэн хэрэгжүүлэх боломжтой зөвлөмжийг өгч байна.

Энэхүү үнэлгээ нь Монгол Улсын Засгийн газар, оролцогч бүх талууд өөрсдийн ирээдүйн бодлого, хөтөлбөрийг тодорхойлох, үндэсний, бүс нутгийн хийгээд олон улсын түвшинд хамтын ажиллагааг бэхжүүлэх, эрсдэлийн мэдээллийн удирдлагыг сайжруулах, гамшгийг даван туулах чадавхыг бий болгох чиглэлээр санхүүгийн хөрөнгө оруулалтыг дэмжлэг үзүүлэх зэрэгт чиглүүлэх хэрэгсэл болно хэмээн миний бие найдаж байна. Гамшгийг даван туулах чадавхыг тэргүүн эгнээнд тавьснаар бид иргэдийн амь нас, амьжиргааг хамгаалж, нийгэмд тогтвортой байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах, урт хугацаандаа улс орны хөгжилд дэмжлэг үзүүлэх тогтвортой өсөлт хөгжилд хөтлөх болно.



**Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагч
Талан Мишра**



Зураг:НУБХХ/ Никола Петит

ХУРААНГУЙ

Монгол Улс нь ОХУ, БНХАУ-тай хиллэдэг, уул нуруу, говь цөл бүхий 1.5 сая хавтгай дөрвөлжин газар нутгаараа дэлхийд 19 дүгээрт ордог, Зүүн Азийн далайд гарцгүй орон юм. Нутаг дэвсгэрийн онцлогийн хувьд хойд болон баруун талаараа уулс, өмнөд хэсгээрээ говь цөлөөр хүрээлэгдсэн. 3.4 сая хүн амтай, нийт хүн амын 69 хувь нь хот суурин газарт, үүний 48 хувь нь Улаанбаатар хотод оршин суудаг. Нийт хүн амын 36%-ийг 17 хүртэлх насны хүүхдүүд, 3%-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна. Уламжлалт мал аж ахуй, газар тариаланд суурилсан эдийн засгаас олборлох үйлдвэрлэлд суурилсан эдийн засагт шилжиж байгаа Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн зуд, шороон шуурга зэрэг байгалийн гамшгууд тохиолддог. 2015 оноос хойш уур амьсгалын гаралтай аюулт үзэгдэл, ослын давтамж 2.9 дахин өссөн бөгөөд 2024 оны эрсдэлийн удирдлагын ИНФОРМ индексээр 116 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Нэг сая гаруй хүн өртөж, хүн амын эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчин, хүн амын амьжиргаанд хүндрэл учруулж буй байгалийн гамшгаас үүдэлтэй эрсдэлийн зэрэг “Дунд” гэсэн ангилалд байна.

Монгол орны уур амьсгал сүүлийн 80 жилд мэдэгдэхүйц дулаарч, гадаргын температур 2.25°C-аар нэмэгдэж, дэлхийн дулаарлын дундаж үзүүлэлтээс давсан. Энэ дулаарлын үр дүнд, сүүлийн 45 жилийн хугацаанд жил бүр хүйтэн өдрийн тоо 15-аар цөөрч, халуун өдрийн тоо 24-өөр нэмэгдэж, уулархаг нутгаар тал хээр, говийн бүс нутгаас илүү дулаарсан байдалтай байна. Сүүлийн хорин жилд хамгийн их болон бага температурын аль аль нь өсөж, дулаарал илүү удаан хугацаагаар үргэлжилж, түүхэн дэх хамгийн дулаан жилүүд ажиглагдсан байна. 2000-2015 оны хооронд усны нөөц мэдэгдэхүйц буурч, нуур, гол мөрөн, булаг шанд багассан нь ус зүйн тэнцвэргүй байдлыг улам нэмэгдүүлсэн. Энэ нь ургамлын хомсдол, байгалийн бүсийн шилжилт, хуурай газар нутгийн тэлэлт, биологийн олон янз

байдалд сөргөөр нөлөөлж, олон төрөл зүйл устах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн хортон шавьж, халдварт өвчний дэгдэлт, ой, бэлчээрийн талбайг сүйтгэж байна.

Гангийн аюул эдийн засаг, ялангуяа газар тариалан, мал аж ахуйд ихээхэн аюул учруулж, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Хахир өвөл буюу зудын нөхцөл байдал хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, эдийн засгийн тогтвортой байдлыг улам хүндрүүлж, хот суурин газарт шилжин суурьших хөдөлгөөнийг нэмэгдүүлж байна. Уур амьсгалын цаашдын төлөв байдлаас харахад өвлийн улиралд хур тунадас мэдэгдэхүйц нэмэгдэх, агаарын температур нутгийн баруун болон зүүн бүст, зуны улиралд баруун хэсгээр хамгийн их нэмэгдэх магадлалтай.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй тулгамдсан асуудалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегийг сайжруулахыг зорьж байна. Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), НҮБ-ын Суурин зохицуулагчийн хүсэлтээр, Монгол Улсын гамшиг, уур амьсгал эрсдэлийг удирдах чадавхын өнөөгийн байдал, давуу тал, сайжруулах чиглэлийг тодорхойлох чадавхын үнэлгээ хийх асуудлыг КАДРИ түншлэлийн баг дэмжин гүйцэтгэж байна. Тус үнэлгээгээр нийгэм, эдийн засгийн голлох салбаруудад эрт сэрэмжлүүлэх систем, гамшгийн бэлэн байдал, эрсдэлийг бууруулах ажлыг сайжруулах үр дүнтэй зөвлөмж өгөхийг зорьж байна.

2023 оны 6 дугаар сарын 05-29-ний өдрүүдэд КАДРИ-ийн түншлэлийн баг ОБЕГ-тай хамтран Монгол Улсын нийгэм-эдийн засаг, эрсдэлийг бууруулах засаглалын онцлогт нийцүүлэн үнэлгээний хамрах хүрээ, арга зүй, цаг хугацааг тодорхойлох ажлыг цахим болон танхимын хэлбэрээр хослуулан зохион байгуулсан. Энэхүү уулзалтаар Засгийн газрын яамд, агентлаг, НҮБ-ын Удирдлагын баг, хүмүүнлэгийн болон

хөгжлийн түншүүд, хувийн хэвшил зэрэг олон оролцогч талуудтай санал солилцож, зөвлөлдсөн.

Чадавхын үнэлгээнд бэлэн байдал, эрт сэрэмжлүүлэг, эрсдэлийг бууруулах гэсэн гурван чиглэлийг онцлон авч үзсэн. Энэхүү үнэлгээнд засаглал (бодлого, бүтэц зохион байгуулалт, зохицуулалт, хариуцлага), ажиллагааны бэлэн байдал (ур чадвар, арга зүй, чадамж), санхүүжилт (төрийн/хувийн хэвшлийн санхүүжилт, албан ёсны хөгжлийн санхүүжилт, шууд сан), эрсдэлийн мэдээлэл/мэдлэг (эрсдэлийн мэдээлэл, мэдээллийн

удирдлагын систем, эрт сэрэмжлүүлгийн системийн хүртээмж), техник тоног төхөөрөмж, технологийн хүртээмжтэй байдал гэсэн чадавхын таван хэмжигдэхүүнээр үнэлсэн. Энэхүү цогц үнэлгээ нь бодлого, хөтөлбөрийн цаашдын холбоо хамаарлыг тодорхойлох, үндэсний болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хууль эрх зүйн болон ажиллагааны баримт бичгийг шинэчлэн сайжруулахад дэмжлэг үзүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, менежментийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилготой.

Хэсэг III - Үнэлгээний гол үр дүн, зөвлөмж

Монгол Улсад гамшгийн эрсдэлийн удирдлагын системийг гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааны бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг зохицуулсан тогтвортой хууль эрх зүй, бүтэц зохион байгуулалтын хүрээнд дэмжин, хэрэгжүүлж байна. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулалтаар хангахад Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) гол үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улсад гамшгийн эрсдэлийг удирдах чиг хандлагыг Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, Улсын онцгой комисс гэсэн хоёр үндсэн бүтцийн үйл ажиллагааны дэмжлэгтэйгээр идэвхтэй хэрэгжүүлж байна. Эдгээр нь гамшгаас хамгаалах чиглэлээр салбар хоорондын зохицуулалтыг хангах, сайжруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын зөвлөмж өгөх зэргээр олон оролцогч талуудыг нэгтгэн хамтын ажиллагааны платформ болж ажилладаг. Мөн Монгол Улсын гамшгаас хамгаалах бодлого гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн бодлого стратегитай нийцсэн байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын төр захиргааны төв болон орон нутгийн байгууллагын хүчин чармайлтын үр дүнд гамшгаас хамгаалах чиглэлээр нэлээд ололт амжилт, ахиц дэвшил гарсаар байна. Хэдийгээр ололт амжилт, ахиц дэвшил гарч байгаа ч гамшгийн эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авахтай холбоотой оролцогч

талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл байсаар байна. Эдгээр бэрхшээлийн дунд эрт сэрэмжлүүлэх тогтолцооны асуудал, уур амьсгалын гаралтай гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээг яам, агентлагийн үйл ажиллагаанд иж бүрнээр нь нэгтгэн уялдуулж чадаагүйд асуудал оршиж байгаа юм. Мөн гамшгаас хамгаалах чиглэлээр бүх салбарын бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах, гамшгаас хамгаалах тогтолцооны илүү сайн бэхэжсэн, үр дүнтэй байдлыг хангахын тулд орон нутгийн түвшинд санал санаачилга гарган ажиллах шаардлагатай байна.

Тус тайланд Монгол Улсад гамшгийн эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх хүрээнд хэд хэдэн зөвлөмжийг онцлон тусгалаа. Эдгээрийн дотор гамшгаас хамгаалах ажиллагаанд гамшгийн дараах сэргээн босголт, бүтээн байгуулалтын үйл явцыг бүрэн нэгтгэх нь чухал. Одоогийн байдлаар ОБЕГ-ын үйл ажиллагааны чиг үүрэгт эдгээр нэн чухал үйл ажиллагааг бодлогын баримт бичигт өргөн хүрээтэй тусгах, мөн ажиллагааны бэлэн байдлын хангахад сэргээн босгох ажлыг тусгасан байдал хангалтгүй байна. Эдгээр зөвлөмжийг онцлон анхаарвал Монгол Улсын гамшгийг даван туулах чадавх мэдэгдэхүйц сайжрах боломжтой гэж үзэж байна.



Зураг: ОУУЗ болон УХСХ/ Мирва Хелениус

I. УДИРТГАЛ

1.1 Чадавхын үнэлгээний агуулга, үндэслэл

Уур амьсгалын өөрчлөлт нь гамшгийн эрсдэлийн шинж, төрх байдлыг өөрчлөн, нийгмийн эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлж байгааг хүлээн зөвшөөрч, Монгол Улсын Засгийн газар өөрийн бодлого, засаглалын тогтолцоог бэхжүүлэх арга хэмжээ авахаас гадна гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогыг нэгтгэн уялдуулах арга хэмжээ авч байна.

Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), НҮБ-ын Суурин зохицуулагчийн гамшиг, уур амьсгалын эрсдэлийг зохицуулах, бууруулах үндэсний болон орон нутгийн чадавхыг үнэлэхэд туслалцаа үзүүлэх хүсэлтийн дагуу КАДРИ-ын түншлэлийн баг идэвхжин ажиллав.

КАДРИ-ын түншлэлийн багийн гүйцэтгэх чадавхын үнэлгээний зорилго нь уур амьсгал, гамшгийн эрсдэлийг удирдах, Монгол Улсын үндэсний болон орон нутгийн тогтолцооны давуу, сул талд дүн шинжилгээ хийх, өртөх байдал өндөртэй нийгэм-эдийн засгийн салбаруудад эрт сэрэмжлүүлэх, гамшгийн бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хэрэгжих боломжтой зөвлөмж өгөхөд оршино. Чадавхын үнэлгээг Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллагын цаашдын бодлого, хөтөлбөрийн холбоо хамаарлыг тодорхойлох; үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшинд хамтын ажиллагааг бэхжүүлэх; хууль эрх зүйн орчин, эрсдэлийн мэдээллийн удирдлагын стандартыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эрсдэлийг удирдахад тэргүүлэх ач холбогдол өгөх санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гүйцэтгэсэн.

2023 оны 6-р сарын 5-29-ний өдрүүдэд НҮБ-ын Монгол Улс дахь Суурин зохицуулагчийн газар, КАДРИ-ын түншлэлийн Нарийн бичгийн дарга нарын газар, НҮБ-ын Ази Номхон далайн бүс нутгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын төлөөллөөс бүрдсэн КАДРИ-ын түншлэлийн баг ОБЕГ-тай хамтран Монгол Улсын нийгэм-эдийн засаг, эрсдэлийг бууруулах засаглалын онцлогт нийцүүлэн үнэлгээний хамрах хүрээ, арга зүй, цаг хугацааг тодорхойлох ажлыг цахим болон танхимын хэлбэрээр хослуулан зохион байгуулсан. Уг ажиллагааны зорилго КАДРИ-аас ОБЕГ-тай зөвлөлдөн, тэдний санал болгосон төрийн болон төрийн бус байгууллагуудтай КАДРИ-ын үнэлгээний баг чадавхын үнэлгээний зорилго, үр өгөөжийг танилцуулах зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан.

Зөвлөлдөх уулзалтад Засгийн газрын яамд, агентлаг, НҮБ-ын Удирдлагын баг, хүмүүнлэгийн болон хөгжлийн түншүүд, олон улсын байгууллага, санхүүгийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөллөөс хамруулан оролцуулж, үнэлгээний ажлын цар хүрээгээ томьёолсон.

Бэлэн байдал, эрт сэрэмжлүүлэг, эрсдэлийг бууруулах гэсэн гурван гол чиглэлийг чадавхын дараах таван хэмжигдэхүүнээр үнэлсэн. Үүнд: **засаглал** (бодлого, бүтэц тогтолцоо, зохицуулалт, хариуцлага), **ажиллагааны бэлэн байдал** (ур чадвар, арга зүй, чадамж), **санхүүжилт** (төрийн болон хувийн хэвшлийн санхүүжилт, албан ёсны хөгжлийн санхүүжилт, босоо сан), **эрсдэлийн мэдээлэл/мэдлэг** (салбар дундын, хүн амын төрөл бүрийн бүлгүүдийн, ялангуяа эмэгтэйчүүдийн, эрсдэлийн

мэдээллийн хүртээмжтэй байдал, мэдээллийн удирдлагын систем, эрт сэрэмжлүүлэх системийг онцолсон), мөн **техник, тоног төхөөрөмж, технологийн хүртээмж**.

Засгийн газрын байгууллагууд, НҮБ-ын Удирдлагын баг, иргэний нийгмийн байгууллага болон хамрах хүрээг тогтоох ажлын үеэр зөвлөлдсөн бусад оролцогч талууд уур амьсгал, гамшгийн эрсдэлийг удирдах үндэсний болон

орон нутгийн чадавхыг дараах тэргүүлэх салбараар үнэлэхээр тодорхойлсон:

1. Мал аж ахуй, газар тариалан, газрын доройтлыг онцлон Хөдөө аж ахуй, Байгаль орчин
2. Дэд бүтэц ба ус, ариун цэвэр, эрүүл ахуй
3. Боловсрол
4. Эрүүл мэнд
5. Нийгмийн хамгаалал ба хүн амын шилжилт хөдөлгөөн

Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхын шинэлэг чиг хандлагыг хөгжүүлэх үндэслэл

Монгол Улсад 2003 онд Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) байгуулагдсан нь тус улсын гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг дээшлүүлэх чухал алхам болсон. Иргэний хамгаалалтын байгууллага, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газар гэсэн гурван байгууллага нэгдэж тус байгууллага байгуулагджээ. Байгуулагдсаны дараа жил нь буюу 2004 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн үнэлгээ, зохицуулалтын (НҮБГҮЗ) баг байгууллагын бүтэц тогтолцоо, үйл ажиллагааны чадавхын үнэлгээ хийсэн нь ОБЕГ-ын үйл ажиллагааг чиглүүлэх төдийгүй Монгол Улсын гамшгаас хамгаалах ерөнхий стратегийн чиглэлд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

2017 онд шинэчлэгдсэн Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу онцгой байдлын салбарт олон шинэ өөрчлөлт гарсан. Энэ хуулийн хүрээнд улсын түвшнөөс орон нутгийн түвшин хүртэл сайн зохион байгуулалттай эрсдэлийн засаглалын тогтолцоог бүрдүүлэх нөхцөлийг бий болгосон. Энэ тогтолцоо нь гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, үйл ажиллагааг стратегийн томоохон баримт бичгүүдтэй уялдуулан хэрэгжүүлэхэд чухал ач холбогдлоо үзүүлж байна. Үүнд Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний (ГЭБСҮАХ) дунд хугацааны стратеги, Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үндэсний хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого болох “Алсын хараа 2050” зэргийг багтаан үзэж болно.

Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах зохион байгуулалтын бүтцэд гамшгийн эрсдэлийг урт хугацаанд бууруулахад анхаарч Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, гэнэтийн гамшгийн үед шуурхай ажиллах үүрэг бүхий Онцгой комиссыг байгуулахаар тусгасан. Эдгээр нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд үйл ажиллагаа явуулж байна. Тэдний үүрэг бол гамшгаас хамгаалах, үр дүнтэй, шуурхай хариу арга хэмжээ авах, мөн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зохицуулах явдал юм.

Өнгөрсөн жилүүдэд Монгол Улс гамшгийн эрсдэлийн удирдлага, эрсдэлийг бууруулах чиглэлээр томоохон ахиц дэвшилд хүрээд байна. Үүнд эрх зүйн баримт бичгийн шинэчлэл, стандартчилах үйл явц, бүтэц зохион байгуулалтын асуудлыг үндэсний болон орон нутгийн бүх түвшинд сайжруулсныг нэрлэж болно. Эрсдэлийн үнэлгээ хийх, гамшгийн улмаас учирсан хохирлыг тооцох, гамшгийн эрсдэлийг бууруулахад улсын төсвийн санхүүжилтийн хуваарилалт, эрсдэлийг тооцох санхүүжилтийг дэмжих, хариу арга хэмжээний чадавхыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг боловсрол, барилга байгууламж гэх зэргээр салбаруудын үйл ажиллагаанд уялдуулан тусгах зэрэгт мэдэгдэхүйц ахиц гарсан.

Монгол Улсын Засгийн газраас боловсруулсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний баримт бичгийн дунд

хугацааны сайн дурын үндэсний тайлан"-д одоогийн чадавх, сул талуудыг аль хэдийн онцолсон байна. Иймд КАДРИ түншлэлийн баг тодорхойлсон салбаруудын гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чадавхыг үнэлэхдээ дунд хугацааны тайланд тусгагдсан болон өөр хэрэгжиж буй бусад төсөл, хөтөлбөрийн асуудлыг давхцуулалгүй үлдсэн асуудлыг одоогийн мэдлэг, мэдээлэл, нөхцөлд суурилан өмнө өгүүлсэн чадавхыг үнэлэх таван хэмжигдэхүүнээр үнэлж, хүндрэл бэрхшээлийг тодорхойллоо. КАДРИ түншлэлийн чадавхын үнэлгээ одоо хийгдэж байгаа эсвэл аль хэдийн төлөвлөгдсөн санаачилгуудаар шийдэгдэж байгаа цоорхойг давтахгүйгээр өнөөгийн мэдлэг ойлголт, мэдээлэлд суурилсан.

Тулгамдсан үндсэн асуудлын нэг нь үнэлж, дүн шинжилгээ хийж тодорхойлсон, эрсдэлийг


багасгах, бууруулах тодорхой, үр дүнтэй арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд үүсэх хүндрэл байна. Уур амьсгалын нөлөөллөөс үүдэлтэй гамшгийн сөрөг үр дагавар орон нутагт шууд нөлөөлөөд зогсохгүй нийгмийн, үйлдвэрлэлийн төрөл бүрийн салбарт шууд бусаар нөлөө үзүүлсээр байна. Эдгээр нөлөөлөл хот суурин газарт шилжин суурьших хөдөлгөөн, хотжилтын явцыг нэмэгдүүлж, хот суурин газарт тохиолдох гамшгийн эрсдэл, тухайлбал газар хөдлөлт, объектын гал түймэрт өртөх эрсдэлийг нэмэгдүүлэхэд хүргэдэг байна. Монгол Улсын өмнө тулгарч буй энэ асуудлыг шийдвэрлэхдээ хэрэгжүүлж байгаа бодлого стратеги, авч байгаа арга хэмжээг улс орны гамшгийн эрсдэлийн хувьсан өөрчлөгдөж байгаа шинж чанарт нийцүүлэхэд анхаарлаа хандуулах хэрэгтэй.

1.2 Уур амьсгал, гамшгийн эрсдэлийн нөхцөл байдал

Монгол Улс нь ОХУ, БНХАУ-тай хиллэдэг, уул нуруу, говь цөл бүхий 1.5 сая хавтгай дөрвөлжин газар нутгаараа дэлхийд 19 дүгээрт ордог, Зүүн Азийн далайд гарцгүй орон юм. Нийт 3.4 сая хүн амтай бөгөөд хүн амын 69% нь хот суурин газарт, үүний 48% нь нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг. Монгол орны хүн амын 36%-ийг хүүхэд, залуучууд, 3%-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна. Уламжлалт мал аж ахуй, газар тариаланд суурилсан эдийн засгаас олборлох үйлдвэрлэлд суурилсан эдийн засагт шилжиж байгаа Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн зуд, шороон шуурга зэрэг байгалийн гамшгууд тохиолддог. Монгол Улсын аюулт үзэгдэл, гамшиг, ослын статистик мэдээллээс харахад 2015-2021 онд уур амьсгалтай гаралтай аюулт үзэгдлийн тоо давтамж 2.9 дахин өссөн байна.

2024 оны эрсдэлийн удирдлагын ИНФОРМ индексээр Монгол Улс 191 орноос 116-д жагсан байгалийн гамшгаас үүдэлтэй эрсдэлийн зэрэг "Дунд" гэсэн ангилалд байна. Тус улсад шороон шуурга, салхи, аянга, цасан шуурга зэрэг олон төрлийн шуурга байнга тохиолддог. XXI зууны эхэн үед Монгол Улсад тохиолдсон эдгээр хүчтэй салхи, шуурганы нөлөө сая гаруй хүнийг хамарч, нийгмийн эрүүл мэнд, эдийн засгийн хүндрэл, хүн амын амьжиргаа, цаашлаад хөгжлийн үйл явцад сөргөөр нөлөөлсөн.

2001-2022 онд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын давтамжийг ОБЕГ-ын дата мэдээлэлд үндэслэн дараах зурагт үзүүлэв.



Зураг 1. 2001-2022 онд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын давтамж, хувиар, ОБЕГ

Дэлхийн дулаарлын улмаас Монгол орны уур амьсгал илт өөрчлөгдөж, дэлхийн дунджаас илүү дулаарсан ажиглагдаж байна. Цаг уурын 48 станцын мэдээллээр сүүлийн 80 жилийн хугацаанд гадаргын температур 2.4°C-аар нэмэгдсэн нь бодитой өсөлт юм. Энэхүү дулаарлын улмаас өнгөрсөн 45 жилийн хугацаанд хүйтэн өдрүүд дунджаар 15 хоногоор буурч, халуун өдрүүд 24 хоногоор нэмэгджээ. Тал хээр, говийн бүс нутгаас илүү уулархаг хэсгээр дулаарч байна. 2000 оноос хойш сүүлийн 76 жилийн хамгийн дулаан арван жил бүртгэгдэж, сарын хамгийн их температур 2.6°C, хамгийн бага температур 0.3°C-аар нэмэгдсэн байна. Халуун өдрүүдийн үргэлжлэх хугацаа 13 хоногоор нэмэгдсэн.


Түүнчлэн 2000-2015 оны хооронд усны нөөц мэдэгдэхүйц буурч, нуур цөөрмийн 21%, гол мөрний 12%, булаг шандын 15% ширгэсэн. Хур тунадасны хэлбэр, ялангуяа дулааны улиралд өөрчлөгдөх нь ус зүйн тэнцвэрт байдлыг алдагдуулж байна. Энэ нь ургамлын бүрхүүлийн хомсдол, доройтол, байгалийн бүсийн шилжилт, хуурай бүсийн эзлэх хувийг, уулархаг бүс, хойд

зүгт тэлэх байдалд хүргэж байна. Биологийн олон янз байдлын амьдрах орчин улам бүр доройтож, олон төрөл зүйл устах эрсдэл өндөр байна. Дэлхийн биологийн олон янз байдал, төрөл зүйлийн 30 орчим хувь нь устаж үгүй болсон бөгөөд энэ хэвээр үргэлжилбэл 2050 он гэхэд 50 хувьд хүрч магадгүй. Хортон шавьжийн өвчлөл, төрөл зүйлийн цөөрөл нь ой, бэлчээрийн талбайд сөргөөр нөлөөлж, ургамлын өсөлт, ургац, тариалангийн үйлдвэрлэлийг бууруулж байна.

Монгол Улсад байнга тохиолддог байгалийн аюулт үзэгдэл бол ган гачиг ба эдийн засаг, тэр дундаа газар тариалан, мал аж ахуйн салбарт сөрөг нөлөө үзүүлдэг. Гангийн гамшиг ядуурлыг бууруулах улс орны хүчин чармайлт, авч буй арга хэмжээнд хүндрэл бэрхшээл учруулж байна. Түүнчлэн Монгол Улсад маш хүйтэн өвөл болж, зудын гамшиг тохиолддог. Зудын гамшиг нь газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлд ноцтой нөлөөлж, эдийн засгийг хямраах, ядуурлыг нэмэгдүүлэх, хот суурин газарт чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх зэрэг олон үр дагавартай.

Цаашид Монгол Улсын хэмжээнд өвлийн улиралд орох хур тунадас эрс нэмэгдэх, зуны улиралд орох хур тунадас үндсэндээ өөрчлөгдөхгүй байх төлөвтэй байна. Өвлийн улиралд баруун, зүүн хэсгээр, зуны улиралд баруун хэсгээр агаарын температур хамгийн их нэмэгдэх төлөвтэй байна. Өвлийн хур тунадас төв, баруун, зүүн хэсгээр, мөн зуны улиралд баруун хэсгээр эрс нэмэгдэнэ.


2030 он гэхэд хуурайшилтын хувьд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 0.6% нь хэт хуурайшилттай байгаа хэмжээ өөрчлөгдөхгүй, хэвээр байх төлөвтэй байна. Хуурай бүс нутгийн хэмжээ 3.7%-аас 43.4% хүртэл, хуурайвтар бүс нутгийн хэмжээ 5.9%-аас 45.5% хүртэл нэмэгдэх төлөвтэй байна. Харин чийглэг бүс нутгийн хэмжээ 6.3%, чийглэг бүс 3.2%-аар тус тус буурах төлөвтэй байна.



Зураг 2. Хуурайшилтын индекс ба түүний тархалтын төлөв, 2030 онд

2050 он гэхэд Монгол Улсын хуурайшилтын индексэд өөрчлөлт орох төлөвтэй байгаа нь тус улсын уур амьсгалд мэдэгдэхүйц өөрчлөлт гарахыг харуулж байна. Нутаг дэвсгэрийн 0.6%-ийг эзэлж буй маш хуурай хэсэгт өөрчлөлт илрэхгүй байх төлөвтэй байна. Хуурай бүсүүд мэдэгдэхүйц өргөжиж нийт нутгийн 45.7%-ийг хамарч байгаа нь одоогийн байдлаас 6.0%-аар өссөн үзүүлэлт юм. Харин хуурайвтар бүс Монгол орны нийт нутаг дэвсгэрийн

ойролцоогоор 39.6%-ийг эзэлж, одоогийн хэмжээндээ байх төлөвтэй байна. Гэсэн хэдий ч чийглэг газар мэдэгдэхүйц багасаж, чийглэг багатай бүсүүд 6.5%, чийглэг бүсүүд 0.6%-аар багасах төлөвтэй байна. Эдгээр төлөв нь 2050 он гэхэд Монгол орон даяар хуурайшилт ихсэх хандлагатайг харуулж байна.



Зураг 3. Хуурайшилтын индекс ба түүний тархалтын төлөв, 2050 онд

1.2.1 Аюулын төлөв байдал

Аюул	Цуварсан эрсдэл	Уур амьсгалын өөрчлөлт
Ус, цаг агаарын гаралтай		
Ган, зуд	<ul style="list-style-type: none"> Халдварт өвчин, цар тахал Хөрсний доройтол Биологийн олон янз байдлын алдагдал 	Нэмэгдэх
Хэт халалт	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн эрсдэл 	Мэдэгдэхүйц нэмэгдэх
Үер	<ul style="list-style-type: none"> Халдварт өвчин, цар тахал Бэлчээрийн даацын доройтол Дэд бүтцийн доголдол Эрүүл мэндийн эрсдэл Нийгмийн эрсдэл 	Нэмэгдэх (улирлын хур тунадасны улмаас голын хөндий үерт автах)
Геологийн гаралтай		
Газар хөдлөлт	<ul style="list-style-type: none"> Нийгмийн эрсдэл Эрүүл мэндийн эрсдэл Дэд бүтцийн доголдол 	

Аюул	Цуварсан эрсдэл	Уур амьсгалын өөрчлөлт
Хүрээлэн буй орчны гаралтай		
Хөрсний доройтол	<ul style="list-style-type: none"> • Үер • Ургамлын хомсдол • Газар тариалан, мал аж ахуйн аюултай байдал 	Шууд бус нэмэгдэх
Гал түймэр	<ul style="list-style-type: none"> • Биологийн олон янз байдлын алдагдал • Дэд бүтцийн доголдол 	Нэмэгдэх
Биологийн гаралтай		
Халдварт өвчин тахал/цар тахал	<ul style="list-style-type: none"> • Дэд бүтцийн доголдол • Хүчирхийлэл 	Нэмэгдэх

1.2.2 Хүн амын эмзэг байдал


Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж Монгол орны цаг агаар дулаарч, мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг хүн амд үзүүлэх эдийн засгийн сөрөг нөлөөлөлжих байна. Мөн эрсдэлийн мэдээлэлд суурилагагүй, төлөвлөлтгүй хотжих явц хурдацтай байгаа тул хүн ам, биет хөрөнгө (нэн чухал дэд бүтэц, барилга, байшин) геологийн гаралтай аюул, тухайлбал газар хөдлөлтийн аюулд өртөх байдлыг нэмэгдүүлж байна. Хүн амын гамшигт өртөх байдал нэмэгдэх нь ядуу, эмзэг бүлгийн иргэдийн эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Олон малчин өрх өвлийн улиралд цаг агаарын хүнд нөхцөлд орохгүй, өвлийг өнтэй давахын тулд отор нүүдэл хийдэг. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, өндөр настай малчин өрхүүдэд отор нүүдэл хийх асуудал хязгаарлагдмал байна. Энэ байдал нь өвлийн хүнд хэцүү цагт мал сүргээ бэлчээрт гаргах, өнтэй өвөлжихөд хүндрэл учруулдаг. Малчин өрх айлуудад хангалттай дэмжлэг, тусламж байхгүйгээс отор нүүдэл хийх боломжгүй болж,

цаг агаарын хүнд нөхцөлд өөрсдийгөө болон мал сүргээ эмзэг байдалд оруулдаг¹. Уур амьсгалын өөрчлөлт нь дэлхийн хамгийн эмзэг хүн амын бүлгүүдэд илүү хүндээр нөлөөлж, цаашид энэ байдлыг улам гүнзгийрүүлнэ гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад амьжиргааны доод түвшнээс доогуур амьдарч буй хүн амын тоо бага зэрэг буурч, хүн амын дунд ядуурлын хувь 2016 онд 29.6% байсан бол 2018 онд 28.4% болж буурсан байна. 2016-2018 оны хооронд ядуурлын түвшин тогтмол хэвээр байсан. Хэдийгээр 2018 оны байдлаар ядуурлын түвшин хөдөө орон нутагт (30.8%) хотын түвшинтэй (27.2%) харьцуулахад өндөр хэвээр байгаа ч энэ хоёрын ялгаа аажмаар буурч байна².

Сүүлийн 7 жилийн хугацаанд гамшиг, аюулт үзэгдэл, осолд өртсөн хүн амын тоо (Коронавируст халдвар /COVID-19/-ыг оруулалгүй)-г дараах зурагт үзүүлэв.



Зураг 4. Гамшиг, аюулт үзэгдэл, осолд нэрвэгдсэн хүн амын тоо (2015-2022 он), ОБЕГ

Монголын Улаан Загалмай Нийгэмлэг (МУЗН), ОУУЗХ-оос³ хийсэн нарийвчилсан судалгаанаас үзэхэд уур амьсгалын өөрчлөлт ядуу гэр бүл, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өндөр настан, хүүхдүүд зэрэг тодорхой бүлэгт ноцтой нөлөө үзүүлэх төлөвтэй байна. Хүн амын эдгээр хэсэг уур амьсгалын гаралтай аюулт үзэгдэл, гамшигт илүү өртөмтгий, эмзэг байдаг. Мэдээлэл, үйлчилгээ, санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал, мөн эрүүл мэндийн хувьд эрсдэлтэй эдгээр зорилтот бүлэг гамшигт илүү өртөмтгий болж, тэдний эмзэг байдал улам бүр нэмэгдсээр байна.

Уур амьсгалын гаралтай гамшгийн үр дагавар хүүхэд, залуучуудад илүү сөргөөр нөлөөлж байна. Зудын хамгийн том шууд сөрөг үр дагаврын нэг бол хүүхдүүдийг сургуульд явахад хүндрэл учруулж байгаа явдал юм. Их хэмжээний цас орж, -40 хэм хүртэл хүйтэрч байгаа нь хүүхдүүд, сургуулийн багш, ажилтан, албан хаагчид сургууль, боловсролын байгууллагад ирж очиход ихээхэн хүндрэл учирна. Иймд ахлах ангийн хүүхдүүд ихэвчлэн төв газарт сургуульд суралцахын оронд хөдөө гэрийн ажилд туслан гэр бүлийнхэнтэйгээ үлддэг. Мөн үерийн улмаас хүүхдүүд гэрээс сургуульдаа ирж, буцахад хүндрэлтэй байдал үүсдэг. Сургуульд сурдаг малчин өрхийн хүүхдүүд хөдөө гэр бүлдээ туслахын тулд гэртээ харих, буцах үед хол зам туулдаг тул үерийн үед их эрсдэлтэй. Хичээлийн жил эхлэхэд үер болж, ялангуяа аймаг, дүүргийн төвтэй холбосон алслагдсан дүүргүүдийн зам, гүүр эвдэрсэн тохиолдолд сургууль тасалдаж, олон хүүхдүүдэд тасралтгүй сурч боловсроход хүндрэл учруулдаг⁴.

Дэлхийн бусад олон орны нэгэн адил сүүлийн үеийн Коронавируст халдвар /COVID-19/ цар тахал сургамж өгч, хүн амын биологийн аюулд өртөхөөс урьдчилан сэргийлэх, цар тахлын үед бусад аюулт үзэгдэл, осолтой зэрэгцэн хариу арга хэмжээ авах мэдлэг, дадал нэмэгдэж, улс оронд эрсдэлийн иж бүрэн ойлголтыг бий болгосон.

Эдгээр бүлгүүдийн нийгмийн бүлгүүдийн эмзэг байдал уур амьсгалын өөрчлөлтөөр улам бүр эрчимжиж, ядуурал, хүн амын өсөлт, хурдацтай хөгжиж буй хотжилт зэрэг хүчин зүйлүүд улам бүр нэмэгдсэн. Монгол Улсад агаарын жилийн дундаж температур мэдэгдэхүйц нэмэгдэж, жилийн хур тунадасны хэмжээ багасаж, улирлын чанартай хур тунадас тогтворгүй байна. Эдгээр уур амьсгалын өөрчлөлт газар хөдлөлт, үер, ган, зуд зэрэг байгалийн гамшгийн нийлмэл эрсдэлийг улам бүр нэмэгдүүлэх тул, гамшигт бэлэн байх, гамшгийг даван туулах, тэсвэрлэх чадавхаа сайжруулах хэрэгтэй.



Зураг: ОУУЗ болон УХСХ/ Мирва Хелениүс

II. ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ, ҮЙЛ ЯВЦ

2.1 КАДРИ чадавхын үнэлгээний арга зүй

КАДРИ үнэлгээ, төлөвлөлтийн арга хэрэгслийг ашиглан Гамшиг, уур амьсгалын эрсдэлийн удирдлагын системийн чадавхыг үнэлэх ажлыг гүйцэтгэсэн. Энэ аргачлалыг Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн тэргүүлэх дөрвөн чиглэл (2015-2030 он) (Зураг 1-ийг харна уу), КАДРИ үнэлгээний таван хэмжигдэхүүний (Зураг 2-ыг харна уу) дагуу үндэсний болон

орон нутгийн түвшинд байгаа чадавх, хүндрэл бэрхшээл, сорилтыг үнэлж тодорхойлох зорилгоор боловсруулсан. Энэ аргачлал нь чадавхыг үнэлэхэд чиглүүлэгч аналитик суурь болох модулийн асуумжаас бүрдэнэ. Үүнд: уулзалт ярилцлага /хагас бүтэцтэй ярилцлага/, хоёрдогч мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг орно.



Зураг 5. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны үндсэн чиглэл

КАДРИ аргачлал нь Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дөрвөн тэргүүлэх чиглэлийн дагуу боловсруулсан ерөнхий асуулга бөгөөд уур амьсгалын үйлчилгээ, КАДРИ-ын түнш байгууллагуудын боловсруулсан салбар/ асуудлын тусгай модулиудыг багтаасан: Хөдөө

аж ахуй ба хүнсний аюулгүй байдал; соёл; боловсрол; байгаль орчин; эрүүл мэнд; хүн амын шилжилт хөдөлгөөн; дэд бүтэц; хүнсний тэжээллэг байдал; ус ариун цэвэр, эрүүл ахуй гэсэн салбарт чиглэсэн асуумж модулиас бүрдсэн.



Зураг 6. ТХЗ-той уялдуулсан КАДРИ чадавхын үнэлгээ, төлөвлөлтийн модулиуд.

Үнэлгээний үе шатанд дараах чадавхын хэмжүүрүүдийг авч үзсэн:

Засаглал: Үүнд Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохтой (УАӨДЗ) холбоотой хууль тогтоомж, бодлого, байгууллагын чиг үүрэг, зохицуулалтууд багтана. Мөн эдгээр баримт бичиг дэх үүрэг, хариуцлагыг тусгасан.

Хэрэгжилтийг хангах чадавх: Энэ хэмжүүрт техникийн, удирдлагын болон зөөлөн ур чадвар, чадамжийг хамарна. Үүнд удирдлага,

захиргааны болон төлөвлөлтийн тогтолцоо, харилцаа холбооны урсгал системүүд орно.

Санхүүжилт: Энэ хэмжүүрт Гамшгийн эрсдэлийг бууруулах, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаанд зориулсан төсөв боловсруулах, эрсдэл шилжүүлэх, хувийн хэвшлийн санхүүжилт зэрэг санхүүгийн хэрэгслийг хамруулсан. Мөн Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох технологи, үйлчилгээнд төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хамаарна.

Мэдлэг: Энэ чиглэл мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хуваалцах, мэдээлэл үүсгэх, түгээх арга зүйд төвлөрсөн. Үүнд мэдээллийн сан, мэдээллийн удирдлагын систем, ажиглалтын газрууд багтана.

Техник тоног төхөөрөмж, технологи: Энэ хэмжигдэхүүн материаллаг нөөц, технологи, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хүртээмж, тохиромжтой байдал, ашиглалтыг үнэлсэн.

Үнэлгээний баг:

Чадавхын үнэлгээг ОБЕГ, НҮБХАС, ХХААБ, НҮБХХ, ОУШХБ, НҮБГҮГ, НҮБ-ын ХАБИТАТ, НҮБГЭБГ, Дэлхийн зөн, ДЦУБ (БНХАУ, Солонгосын цаг уурын мэргэжилтнүүд), КАДРИ-ын Нарийн бичгийн дарга нарын газар

зэрэг үндэсний болон олон улсын байгууллагын 16 мэргэжилтнээс бүрдсэн баг хамтран гүйцэтгэсэн. Тус тайланг НҮБ-ын Хүүхдийн сан болон ДЭМБ-ын мэргэжилтнүүд хянасан.

Засгийн газар

- Шадар сайдын зөвлөх, Г.Ганболд
- ОБЕГ-ын дэд дарга, бригадын генерал Б.Ууганбаяр
- ОБЕГ-ын дэд дарга, бригадын генерал Д.Намсрай
- ОБЕГ-ын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын дарга, хурандаа Д.Баасансүрэн
- ОБЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Л.Өлзийбаяр
- ОБЕГ-ын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газрын Гадаад, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Ч.Ариунаа
- Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн үнэлгээний хэлтсийн дарга, хурандаа Д.Базаррагчаа
- ОБЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн, гадаад хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч Э.Амгалан
- ОБЕГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн, гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, ахмад Н.Анандаа
- Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн, ахмад Б.Амаржаргал
- Сүхбаатар, Увс, Дундговь аймгийн орон нутгийн удирлага, албан хаагчид

ГАБСХЧ баг

- НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Чинацу Эндо
- НҮБ-ын Гамшгийн үнэлгээ зохицуулалтын багийн Ман Тапа
- НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага Мэт Багосси / ГАБСХЧ-ын Тамгын газар/
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Екатерина Мельниченко / ГАБСХЧ-ын Тамгын газар/
- БНСУ-ын Цаг уурын газрын Сүжин Ким
- БНХАУ-ын Цаг уурын газрын Жан Жианлэй
- Дэлхийн Зөн байгууллагын С.Оюунтөгс

Монгол Улс дахь НҮБ


- НҮБ-ын Суурин зохицуулагч Тапан Мишра
- НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын Б.Сувд
- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын С.Жигжидпүрэв
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Х.Хишигжаргал
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Э.Эрдэнэбат
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Т. Дэлгэрнаран
- НҮБ-ын Хүн Амын Сангийн Л. Билгүүн
- НҮБ-ын Хабитат байгууллагын Ш.Энхцэцэг

Зураг 7. КАДРИ чадавхыг үнэлгээний багийн бүрэлдэхүүн

Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ

Чадавхын үнэлгээг үндэсний болон орон нутгийн түвшинд гамшиг, уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцооны давуу, сул талуудыг нийгэм, эдийн засгийн салбарыг хамруулан оролцогч талуудын мэдээлэлд суурилан гүйцэтгэсэн. КАДРИ түншлэлийн баг улс орны оролцогч талуудаас (засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэм) авсан ярилцлага, үйл ажиллагааны тайлан зэргээс мэдээлэл цуглуулсан болно.

Хянасан баримт бичгийн жагсаалтыг Хавсралт 1-д оруулсан. КАДРИ үнэлгээний асуумжийн дагуу уулзалтыг гол оролцогч талууд болох төрийн захиргааны 100 гаруй төлөөлөгч, иргэний нийгмийн 7 төлөөлөгч, хувийн хэвшлийн 2 байгууллага, орон нутгийн 120 гаруй төлөөлөгчтэй уулзалт, ярилцлага хийсэн.



Зураг 8. КАДРИ Үнэлгээний багийн ажилласан аймгууд

Зөвлөмжийг засаглал, хэрэгжилт, санхүүжилт, мэдлэг мэдээлэл, технологи, тоног төхөөрөмж гэсэн чадавхын тодорхойлсон хэмжигдэхүүнээр салбар бүрээр зохион байгуулсан. Агуулгыг оновчтой болгож, давтагдал үүсэхээс зайлсхийж зарим тохиолдолд мэдлэгийн хэсгийг ч технологи, техник тоног төхөөрөмжийн хэсэгтэй хослуулан авч үзсэн. Энэ арга нь зөвлөмжийг утга агуулгын хувьд иж бүрэн, давхцалгүй болгосон гэж үзэж байна.

Үнэлгээний багийн санал болгосон зөвлөмжийг ажилласан мэргэжилтний мэдлэг, туршлага,

гол оролцогч талуудын дунд зохион байгуулсан үнэлгээний үр дүнг танилцуулах дүгнэлт уулзалтаас гарсан дүгнэлтэд үндэслэн гурван үндсэн шалгуураар ангилсан:

- **Яаралтай байдал:** “Яаралтай”-аас “Яаралтай биш” хүртэл.
- **Хэрэгжүүлэлтийн төвөгтэй байдал:** “Хэрэгжүүлэхэд хялбар”-аас “Хэцүү” хүртэл.
- **Төсөв (зардал)-ыг харгалзан үзэх:** “Бага төсөв”-өөс “Их төсөв” хүртэл.

2.2 Хязгаарлалт

- Үнэлгээнд Уур амьсгалын тухай хууль, Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хууль зэрэг одоо боловсруулж байгаа эрх зүйн болон бодлогын гол баримт бичгүүдийг сайтар судлаагүй.
- Судалгаанд үерийн гамшгийн төрөлд сургууль, эрүүл мэндийн барилга, байгууламж, эрчим хүчний дэд бүтцийн асуудлыг голчлон авч үзлээ. Учир нь үнэлгээний багт энэ чиглэлийн мэргэжилтэн багтсан бөгөөд бусад чиглэлээр үнэлэхэд багийн гишүүдийн мэдлэг, туршлага дутмаг тул үнэлгээний үр дүнд сөргөөр нөлөөлнө гэж үзсэн болно. Иймээс үнэлгээний цогц байдалд нөлөөлж бусад онц чухал дэд бүтцийн салбаруудыг орхигдуулсан байж болзошгүй.
- Үнэлгээний багт боловсрол, УАЦЭА (Ус, ариун цэвэр, эрүүл ахуй), эрүүл мэнд зэрэг төрөлжсөн салбарыг хариуцан ажиллах мэргэжилтэн дутмаг байсан. Энэ хязгаарлагдмал байдал салбарын шинжилгээний ерөнхий иж бүрэн байдлыг бууруулах замаар холбогдох бусад салбаруудад эрүүл мэнд, боловсролын салбарын мэдээллийг нэгтгэхэд хүргэсэн.
- Хувийн хэвшлийн оролцоо хамгийн бага байсан бөгөөд хоёр удаа зөвлөлдсөн. Үнэлгээний аргачлалын дагуу төрийн байгууллагуудад чиглэсэн болно
- Үндэсний хэмжээнд ялангуяа нийслэл хотод чухал ач холбогдолтой агаарын чанарын асуудлыг үнэлгээнд хамруулаагүй. Энэ нь гамшгийн эрсдэлийн удирдлага гэхээсээ байгаль орчны менежментийн хүрээнд агаарын чанарыг ангилсантай холбоотой. Иймд нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж буй томоохон эрсдэлт хүчин зүйлийг үнэлээгүй сул талтай болсон.



Зураг: Монгол Улс дахь НУБ-ын ХХ

III. ҮР ДҮН БА ЗӨВЛӨМЖ САЛБАР ХООРОНД

Энэхүү тайланд тусгасан үр дүн, зөвлөмжүүд нь төрийн захиргааны төв, нутгийн удирдлагууд, иргэний нийгмийн, хүмүүнлэгийн болон хөгжлийн түнш байгууллагуудтай хийсэн зөвлөлдөх уулзалтууд болон хоёрдогч мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ дээр үндэслэн боловсруулсан. Зөвлөмжүүд төрийн захиргааны төв, орон нутгийн удирдлагуудтай зөвлөлдөн цуглуулсан санал мэдээлэлд үндэслэсэн болно.

3.1 Тойм

Энэ бүлэгт гамшгийн эрсдэлийг бууруулах, удирдах ажлыг зохицуулалтаар хангах, тэр дундаа эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох ажиллагааны бэлэн байдлыг хангахад Монгол Улсад одоо хэрэгжиж байгаа тогтолцоонд хийсэн дүн шинжилгээг танилцуулна. Мөн засаглал, мэдлэг ойлголт ба технологи, санхүүжилт, хэрэгжилтийн чадавх гэсэн бүтэцтэйгээр олон салбарт нийтлэг байгаа асуудлыг онцлон үнэлсэн. Чадавхын үнэлгээг:

- i) урт хугацааны гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаа,
- ii) эрт сэрэмжлүүлэх,
- iii) хариу арга хэмжээ авах, сэргээн босгох, бэлэн байдал

гэсэн чиглэлээр гүйцэтгэж дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн урт хугацааны гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаанд гамшиг өмнө мэдэгдэж буй гамшгийн эрсдэлийг бууруулах, багасгах мөн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд дасан зохицох чадавхыг авч үзсэн. Эрт сэрэмжлүүлгийг эрт авах арга хэмжээг зохицуулах бэлэн байдлыг хангах гамшгийн эрсдэлийн удирдлагын функц гэж авч үзсэн. Бэлэн байдал гамшгийн үр дагаврыг урьдчилан таамаглах, үр дүнтэй хор уршгийг арилгах хариу арга хэмжээ авах, гамшгийн үр дагаврыг арилгах, түүнийг сэргээх Засгийн газрын мэдлэг, чадавх гэж авч үзсэн болно.

3.2 Засаглал

3.2.1 Давуу тал

Одоогийн хэрэгжиж буй хууль эрх зүй, бүтэц тогтолцоо нь гамшгийн өмнө эрсдэлийг бууруулах хөрөнгө оруулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах таатай орчныг бүрдүүлж байна. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) гамшгийн эрсдэлийн удирдлага, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг удирдан чиглүүлэн ажиллаж байна. Сүүлийн хорин жилийн хугацаанд хөгжсөн Онцгой байдлын байгууллагын тогтолцоо гамшгийн

Эрх зүйн баримт бичгүүд

Монгол Улс нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулахад чиглэсэн засаглалын тогтолцоог бүрдүүлсэн Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуультай. Түүнчлэн Улсын нөөцийн тухай хууль нь гамшиг, онцгой байдлын үед улсын нөөцийг шуурхай зохион байгуулах, гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн. Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг дээр дурдсан гурван хуульд голчлон тодорхойлсон байдаг бол Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд байгаль орчин, уур амьсгалтай холбоотой асуудлыг тусгасан бөгөөд уур амьсгалын гаралтай гамшгийн аюулыг эрт сэрэмжлүүлэхэд чиглэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааг Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолоор зохицуулж байна. Засгийн газар Уур амьсгалын тухай хуулийн төслийг боловсруулж байна. Эрсдэлийг шилжүүлэх зохицуулалтын орчин хөгжиж, Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хуулийн төслийг мөн боловсруулж байна. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны, тухайлбал эрт зарлан мэдээлэл, эрт сэрэмжлүүлгийн систем зэрэг бүх үйл ажиллагааны салбар хоорондын зохицуулалтыг дараах байдлаар харуулав. Үүнд:

- **2017 онд баталсан Гамшгаас хамгаалах тухай хуулиар** улс орны гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл

эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхдээ холбогдох салбарууд, олон оролцогч талуудыг зохицуулалтаар хангах бүтцийг бий болгосон байна. Мөн Засгийн газраас уур амьсгалын болон дасан зохицох төлөвлөгөөний эрх зүйн баримт бичгийг боловсруулж байгаа нь уур амьсгалын гаралтай гамшгийн асуудалд анхаарал хандуулж байгааг харуулж байна.

ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтыг зохицуулдаг. Гамшгаас хамгаалах тухай хууль анх 2003 онд батлагдсан бөгөөд үүний дараа ОБЕГ байгуулагдсан түүхтэй. 2017 онд уг хуульд гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, сэргээн босгох үйл ажиллагааг бэхжүүлэх зэрэг олон чиглэлээр өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан. Тус хуульд нэр томьёоны тайлбарыг тодотгож, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гамшгийн өмнө, гамшгийн үед, гамшгийн дараа хийх хэмээн онцлон тодорхойлж өгсөн. Гамшгийн өмнөх үйл ажиллагаанд гамшгийн эрсдэлийн үнэлгээ; бэлэн байдал, эрсдэлд суурилсан төлөвлөлт; гамшгаас хамгаалах сургалт; эрсдэлийн мэдээллийн удирдлага зэрэг 2017 онд хийсэн олон өөрчлөлтийн дунд үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ зөвлөл), хариу арга хэмжээний (Онцгой байдлын комисс) олон талт байгууллагын тогтолцоог байгуулсан явдал юм.

- **2015 онд баталсан Галын аюулгүй байдлын тухай хууль** нь гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааны явц, удирдлага зохион байгуулалт, холбогдох эрх, үүргийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд зохицуулдаг. Тус хууль анх 1999 онд батлагдаж, 2015 онд хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан.

- **2007 онд баталсан Улсын нөөцийн тухай хууль** нь гамшиг, онцгой байдлын үед нөөцийн бэлэн байдал, тусламжийн бараа, бүтээгдэхүүнийг шуурхай хуваарилах зохицуулалтыг хангадаг.
- **1995 онд баталсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль** нь газар, хөрс, газар доорх баялаг ба ашигт малтмал, ус, ургамал, амьтан, агаар зэрэг байгалийн нөөцийн менежментийг зохицуулдаг. Энэ нь засгийн газар, аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны нөөцийн хяналт шинжилгээ, нөлөөллийн үнэлгээ хийхийг үүрэг болгосон.
- **1997 онд баталсан Ус цаг уур, орчны хяналтын тухай хууль** нь нар, хур тунадас, агаар, хөрсний чийг, нар/ус/дулааны энерги зэрэг физик элементүүдээр тодорхойлогддог ус, цаг уур, уур амьсгалын нөөцийн чанар, хүртээмжид хяналт тавих үйл ажиллагааг зохицуулдаг.
- **Засгийн газрын 2015 оны эрт сэрэмжлүүлэх талаарх 286 дугаар тогтоол нь** "Гамшгаас урьдчилан сэргийлэх тухай", "Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай" хуулиудтай уялдаж, ус, цаг агаарын аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг

зохицуулалтаар хангасан. Уг тогтоолд цаг агаарын аюултай үзэгдлийн төрөл, урьдчилан мэдээлэх/сэрэмжлүүлэх давтамж, мэдээлэл түгээхэд ашиглах харилцааг зааж өгсөн.

Боловсруулж буй бусад хуулиуд:

- **Уур амьсгалын тухай хууль** (төсөл)
- **Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хууль** (төсөл) одоогоор гамшгийн эрсдэлийн даатгалын бүтээгдэхүүнийг өргөн хүрээнд зохицуулах зорилгоор боловсруулж байгаа бөгөөд одоогийн төсөл нь сүүлийн хэдэн жилийн хугацаанд олон удаа шинэчлэгдсэний тав дахь хувилбар юм. Хуулийн одоогийн хувилбарт нийтийн өмчийн эрсдэлийн даатгал тусгагдаагүй байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ажлыг олон салбарт хэрэгжүүлдэг бөгөөд хууль, журам, дүрэм, заавар зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулагдана. Эдгээрийг "Үйлдвэрлэл, нийгмийн салбар"-ын холбогдох бүлгүүдэд тусгасан болно.

Бүтэц тогтолцоо

Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) 2004 онд байгуулагдаж улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж, төрөөс баримтлах бодлогыг төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага зэрэг олон оролцогч талуудтай үйл ажиллагаагаа уялдуулж, удирдан чиглүүлж хэрэгжүүлдэг. ОБЕГ, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, түүний удирдлага, бүтэц зохион байгуулалт Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудалд хамаарна. Монгол Улсын гамшгийн эрсдэлийн удирдлага/бууруулах зохион байгуулалтын салбар дундын зохицуулалтын хоёр тулгуур нь

- (1) Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл,
- (2) Улсын онцгой комисс бөгөөд гамшгийн өмнө эрсдэлийг бууруулах бодлогын зөвлөмж

(ГЭБ зөвлөл), гамшгийн үед хариу арга хэмжээ авахад шийдвэр гаргах (онцгой комисс) салбар хоорондын зохицуулалт, хамтын ажиллагааны зохицуулах үүрэг гүйцэтгэдэг.


а) Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл: Үндэсний хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл (ГЭБҮЗ) төр, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллага, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн төлөөлөл болох 23 гишүүнээс бүрддэг. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл (ГЭБҮЗ)-ийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлэх бөгөөд жилд нэгээс доошгүй удаа хуралддаг. Орон нутгийн түвшинд. 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт нийт Гамшгийн эрсдэлийг бууруулах орон

нутгийн 31 зөвлөл (ГЭБОНЗ) ажиллаж байна. ГЭБОНЗ-ийг орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүлдэг.

b) Улсын онцгой комисс: Улсын онцгой комиссыг (УОК) Шадар сайд тэргүүлж, улсын хэмжээнд тохиолдсон гамшиг, онцгой нөхцөл байдлын үед зохицуулалт хийх, шийдвэр гаргах, шуурхай арга хэмжээ авах удирдлага зохицуулалтаар хангахаар тухай бүр шуурхай хуралддаг. Тухайн шатны Засаг даргын удирдлага дор аймаг, нийслэл, сум, дүүрэгт орон нутгийн Онцгой комисс (ОНОК) ажилладаг. УОК томоохон гамшгийн үед

шуурхай хариу арга хэмжээ авах зорилгоор Шуурхай штабыг (УОКШШ) байгуулдаг. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд ОБЕГ, орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар (ОБГ) удирдан зохион байгуулна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу ОБЕГ-ын удирдлага дор орон нутгийн (аймаг, нийслэл, сум, дүүрэг) онцгой байдлын газар, хэлтэс гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хариу арга хэмжээ, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай явуулдаг.




Зураг 9. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тогтолцоо

Эрт зарлан мэдээлэх, эртнээс сэрэмжлүүлэх системийн зохион байгуулалтын тогтолцоог тодорхойлсон бие даасан бодлогын баримт бичиг байхгүй ч Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ), Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэн (ООГХ) болон ОБЕГ аюулын хяналт, ажиглалт, урьдчилан

таамаглах/эрт илрүүлэх (ЦУОШГ, ООГХ) болон сэрэмжлүүлэг түгээх (ОБЕГ, ЦУОШГ) гол үүрэг гүйцэтгэдэг.

ОБЕГ-ын бүтцийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, дэмжлэг үзүүлэх гэсэн үндсэн үүргийн хүрээнд гаргасан байна.



Зураг 10. ОБЕГ-ын зохион байгуулалтын бүтэц

Төлөвлөх

- **Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газар:** Гамшгаас хамгаалах эрх зүйн баримт бичиг, бодлого, стратеги, төлөвлөгөө боловсруулах үүрэгтэй.

Мөн бүх холбогдох оролцогч талуудтай уялдаа холбоотой ажиллах, түншлэлийг байгуулах үүрэгтэй.

Хэрэгжүүлэх

- **Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар:** Гамшгийн эрсдэлийн үнэлгээний эрх зүйн орчин, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтөд дэмжлэг үзүүлэх эрсдэлийн удирдлагаар хангаж ажилладаг. Мөн гамшгийн эрсдэлийг бууруулах шинжлэх ухааны судалгаа, инновацийн бодлого, шинжлэх ухааны үндэслэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй.

- **Гамшгаас урьдчилан сэргийлэх газар:** Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохицуулах, олон нийтэд урьдчилан сэргийлэх сурталчилгаа хийх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй.

- **Гамшгийн шуурхай удирдлагын газар:** Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай техник хэрэгсэл, боловсон хүчний бэлэн байдлыг төлөвлөх, зохион байгуулах үүрэгтэй.

Тус газар үндэсний хэмжээнд эрт сэрэмжлүүлэх системийг найдвартай, тасралтгүй удирдан зохион байгуулах, удирдлагаар хангах үүрэгтэй.

- **Гал түймэртэй тэмцэх газар:** Гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, дүрэм журам, стандарт боловсруулах, мөрдүүлэх, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах, гал түймрийн хяналтын үйл

Хяналт тавих

- **Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газар:** Гамшгаас хамгаалах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ

Дэмжлэг үзүүлэх

- **Санхүү хангалт, хөрөнгө оруулалтын газар:** Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөлт, гүйцэтгэлийг хариуцдаг. Тус хэлтэс нь мөн логистик, хангамжийн үйл ажиллагааг төлөвлөх, техник, технологийг шинэчлэх, бэлэн байдлыг хангах, стандарт, норм боловсруулах, нөөцийг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх үүрэгтэй.
- **Захиргааны удирдлагын газар:** Байгууллагын удирдлага, удирдлагын манлайллыг

Бодлогын баримт бичиг

Монгол Улсын гамшгаас хамгаалах үндэсний бодлого стратеги нь гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн томоохон стратегид байнга нийцэж ирсэн. НҮБ-аас 1994-2005 онд "Аюул багатай дэлхийн төлөө Йокохама стратеги", 2005-2015 онд "Хёогогийн үйл ажиллагааны хүрээ" баримт бичгийг хэрэгжүүлэх хугацаанд Монгол Улс "Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлсэн. 2011 онд Гамшгаас хамгаалах талаар Төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг боловсруулж, 2020 он хүртэл хэрэгжүүлсэн. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (I шат: 2017-2020 он, II шат: 2021-2025 он, III шат: 2026-2030 он), урт хугацааны хөгжлийн стратеги болох Монгол Улсын "Алсын хараа 2050" бодлогын баримт

ажиллагааг удирдана. Мөн тус газар нь гал түймрийн хяналтын норм, дүрэм журмыг боловсруулдаг.

- **Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газар:** Гамшиг, онцгой байдлын үед тусламжийн бараа, нөөцийг удирдаж, зохицуулах бөгөөд агуулахын менежментийг хариуцан ажиллана.

хийж, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийнэ. Улирлын болон жилийн тайланд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

хэрэгжүүлэх, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, боловсон хүчний судалгаа, хүний нөөцийн хөгжил, алба хаагчийн нийгмийн асуудлыг зохицуулах, боловсон хүчнийг удирдан зохион байгуулах, алба хаагчийн сургалт зохион байгуулах, дотоод ажлын зохицуулалтыг хангах үүрэгтэй.

бичгүүдэд улс орны хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн стратегийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тусган хэрэгжүүлж байна. Түүнчлэн, Олон нийтийн оролцоотой Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар (2015-2020, 2021-2025 он) хэрэгжүүлж байна. Энэ тайланг бичих үед Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө боловсруулах шатандаа явж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, одоо хэрэгжиж байгаа салбар хоорондын бодлогын үндсэн баримт бичгүүдийн жагсаалтыг дараах байдлаар харуулав. Холбогдох салбарын бодлого, стратегийг Үйлдвэрлэлийн салбар, Нийгмийн салбар гэсэн бүлгүүдэд тусад нь

авч үзэхийг анхаарна уу.

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс
- Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр (хэрэгжилт дууссан)
- Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр

- Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө
- Монгол Улсад Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги
- Үндэсний дасан зохицох төлөвлөгөө (боловсруулж байгаа)

3.2.2 Хүндрэл, бэрхшээл

Гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хариу арга хэмжээ авах зохион байгуулалтын механизмыг хуулиар маш сайн тодорхойлсон боловч хэрэгжилтийн түвшинд хариуцах байгууллагын талаар тодорхой хэмжээний төөрөгдөл, тодорхой бус байдал байна. Энэ ялангуяа гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанаас хойшлуулшгүй сэргээн босгох/сэргээн засварлах үешатанд шилжихүйл явцад ажиглагдаж байна. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.16-д "хойшлуулшгүй сэргээн босгох" гэж гамшиг, аюулын улмаас үүссэн нөхцөлийг хэвийн байдалд оруулахад чиглэсэн шинээр босгох, сэргээн засварлах арга хэмжээ гэж тодорхойлсон. Харин нийгэм эдийн засгийн ямар салбарт хэзээ, хэн ямар арга хэмжээ авах нь өнөөгийн үйл ажиллагааны тогтолцоонд тодорхойгүй байна. Гамшгийн дараах сэргээн босгох, сэргээн засварлах үйл ажиллагааны талаар одоогоор баримтлах бодлого байхгүй. Үүний нэгэн адил яам, орон нутгийн засаг захиргааны байгууллага цаашид гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд илүү сайн дасан зохицохын тулд тухайн холбогдох хөгжлийн салбарын бодлого, төлөвлөлтөд ямар арга хэмжээг нэн тэргүүнд тавих асуудал тодорхойгүй байна.

Одоогийн эрх зүйн зохицуулалтаар нийгмийн бусад бүлгүүдээс илүү анхаарал, зардал шаарддаг нийгмийн эмзэг бүлгүүдийг хамгаалах байдал хязгаарлагдмал хүрээтэй байна. Гамшгийн үр дагаврын улмаас өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхэд, эмэгтэйчүүд бие бялдрын сул байдал, үндсэн үйлчилгээ авахад хүндрэл үүсэх, жендерт

суурилсан хүчирхийлэлд өртөх зэрэг асуудалд өртөмтгий байдалд байдаг. Гамшгаас хамгаалах тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, (жирэмсэн) эмэгтэйчүүдийг гамшгаас хамгаалах заалт байгаа. Гэсэн хэдий ч эмзэг бүлгийн хүн амыг гамшгийн үед хариу арга хэмжээ авах, сэргээн босгох, сэргээн засварлах үе шатанд шаардлагатай тусламж үйлчилгээгээр хангах, гамшгийн өмнөх эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцуулах, гамшигт өртөмтгий, эмзэг байдлыг багасгахад чиглэсэн заалт харагдахгүй байна.

Монгол Улсын хууль тогтоомжууд нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны өргөн хүрээг хамардаг ч эрт сэрэмжлүүлэх тогтолцооны хамрах хүрээ хязгаарлагдмал бөгөөд нэн түрүүнд сэрэмжлүүлэг мэдээг түгээн дамжуулахад анхаардаг. Сэрэмжлүүлэг мэдээллийг хүлээн авч олон нийтэд мэдээлэх чиглэлээр ОБЕГ, Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ), Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэн (ООГХ) гол үүрэг гүйцэтгэж, хамтран ажилладаг.

Иргэний хамгаалалтын байгууллага, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газар гэсэн гурван төрийн байгууллагыг нэгтгэж 2004 онд ОБЕГ-ыг үүсгэн байгуулжээ⁵. Энэ онцлог нь өнөөдрийн ОБЕГ, орон нутгийн онцгой байдлын газрын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд туссан. Үүний үр дүнд аврах ангиуд (гал унтраах, эрэн хайх, аврах ангиуд), байцаагч (галын аюулгүй байдлын хяналт, гамшгаас хамгаалах хяналт) нар тусдаа бэлтгэгдэж, үүрэг гүйцэтгэж байна. Монгол

Улс газар зүйн хувьд өргөн уудам (21 аймаг, 330 сум) нутаг дэвсгэртэй, Онцгой байдлын байгууллагын хүний нөөц болон санхүүгийн

боломж хязгаарлагдмал байдлыг харгалзан эдгээр чиглэлээр бэлтгэгдэх боловсон хүчний нөөцийг оновчтой болгох хэрэгцээ байна.

Урьдчилан сэргийлэх

ОБЕГ-ын харьяа газруудын одоогийн чиг үүрэг гамшгийн дараах сэргээн босголт, сэргээн засварлах үйл ажиллагааг чиглүүлэх боломж ОБЕГ-т олгохгүй байна. Энэ нь бодлого эсвэл сэргээн босгох, сэргээн засварлах үйл ажиллагааны бэлэн байдал сул байгааг илтгэж байна. Гамшиг, уур амьсгалын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нь үндсэндээ

тухайн нийгэм, эдийн засгийн салбарын ажил юм. Гэсэн хэдий ч яам, орон нутгийн засаг захиргаа бүрд эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх онцлон зориулсан чадавх (техникийн мэдлэгтэй ажиллах хүчин, төлөвлөгөө, төсөв) одоогоор байхгүй байна.

3.2.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Үер, зуд, газар хөдлөлт, хүчтэй салхи, шуурга, гал түймэр зэрэг зонхилон тохиолддог гамшгийн төрлүүдээр, гамшгийн эрсдэлийн удирдлагын үе шат (гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох/сэргээн засварлах, эрсдэлийг бууруулах, бэлэн байдал) бүрээр салбарын яамд, агентлагуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон удирдамж боловсруулах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгийн эрсдэлийг бууруулах стратегид хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн хэрэгцээ болон өвөрмөц эмзэг байдлыг ангилан тусгах. Үүний тулд Жендерийн Үндэсний хороо (ЖҮХ)-ны оролцоог Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ) зөвлөлийн ерөнхий чиг үүрэгт тусгаж, зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулах хэрэгтэй.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
ОБЕГ, ЦУОШГ, ООГХ болон бусад яам, агентлаг, байгууллагатай хамтран i) Эрсдэлийн талаарх мэдлэг, мэдээлэл; ii) илрүүлэх, ажиглах, хяналт тавих, дүн шинжилгээ хийх, урьдчилан таамаглах; iii) сэрэмжлүүлгийг хүргэх, мэдээлэх; iv) хариу арга хэмжээ авах бэлэн байдал гэсэн үндсэн дөрвөн асуудлыг багтаасан, хүн амд шууд хүрэх, аюулын эрт зарлан мэдээлэх системийг сайжруулах бодлого, төлөвлөгөөг (богино, дунд, урт хугацааны) боловсруулах	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Засгийн газрын хэмжээнд уур амьсгалын гаралтай гамшгаас хамгаалах үйл ажиллагааг илүү уялдуулан хэрэгжүүлэхийн тулд Гамшгаас хамгаалах тухай хууль, Уур амьсгал, Байгаль орчны тухай хуулиудын хоорондын уялдаа холбоог сайжруулах.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Одоо байгаа бэлтгэгдсэн аврагчдыг илүү оновчтой болгож чадавхийг бүрдүүлэхийн тулд хүний нөөцийн нэгж хоорондын уялдаа холбоог бий болгох (жишээлбэл, гал унтраах анги, эрэн хайх, аврах анги)	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Гамшиг, уур амьсгалын эрсдэлийг бууруулахад салбарын яамд, орон нутгийн засаг захиргаанд шаардагдах чиг үүргийн хамгийн бага чадавхыг тодорхойлж, энэ чиг үүргийг яам, орон нутгийн удирдлагын хүрээнд тодорхой нэгж хэлбэрээр байгуулах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Засгийн газрын системийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах, удирдах техникийн болон үйл ажиллагааны мэдлэг, ур чадварыг хуваалцахаар газар/яам, агентлаг хооронд томилон ажиллуулах механизмыг бий болгох.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

3.3 Мэдлэг мэдээлэл, технологи

Аюул, хүн ам, эд хөрөнгийн өртөх болон эмзэг байдлын талаарх мэдлэг ойлголт нь гамшгийн эрсдэлийг үр дүнтэй бууруулах, удирдах үндэс болдог. Гамшгийн эрсдэлийг бууруулах урт хугацааны хөрөнгө оруулалтыг аюулт үзэгдлийн магадлал, гамшгийн улмаас учирсан хохирол, хор уршиг, эрсдэлд орсон хүн ам, эд хөрөнгийн төрөл бүрийн эмзэг байдал зэрэг хүчин зүйлд үндэслэн гамшгийн болзошгүй нөлөөлөл дээр суурилж хийдэг. Аюулт үзэгдэл, ослын урьдчилан сэргийлэх мэдээллийн оновчтой, үнэн зөв байдал нь шуурхай мэдээлэл хүргэх, арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг эрт сэрэмжлүүлэх системийн үр нөлөөг тодорхойлдог. Гамшгийн улмаас учирсан хохирол, үр нөлөө, хүн ам, эд хөрөнгийн өнөөгийн эмзэг байдлыг ойлгох нь цаг уурын гаралтай төрөл бүрийн үзэгдлийн нөлөөлөлд суурилсан урьдчилан мэдээлэх ажлыг хөнгөвчилж, улмаар хариу арга хэмжээ авахад шаардлагатай бэлтгэл бэлэн байдлыг эрэмбэлэх, эртнээс

сэрэмжлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд тусалдаг. Хамгийн чухал нь эрсдэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, дүн шинжилгээ хийх, түгээхэд технологийн хэрэглээ, хүртээмжтэй байдлыг шаарддаг.

Ерөнхийдөө Монгол Улс аюул, өртөх байдал, эмзэг байдлын талаар өндөр мэдлэг ойлголт, мэдээлэлтэй бөгөөд боломжит технологиудыг ашиглах чадавхтай. Аюулт үзэгдэл ослын түүхэн мэдээ, учирсан хохирол, өртөх байдал, эмзэг байдлын өнөөгийн өгөгдөл мэдээлэл, мэдлэг ойлголтын түвшин нь урт хугацааны гамшгийн эрсдэлийг бууруулах, эрт сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хангалттай гэж үздэг. Техник технологи, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, түүнийг сайжруулахад хөрөнгө оруулахаас гадна эрсдэлийн талаарх мэдлэг ойлголтыг илүү нэмэгдүүлэхийн тулд үргэлжлүүлэн хөрөнгө оруулах нь зүйтэй.

3.3.1 Давуу тал

Аюулын хяналт, ажиглалт, урьдчилан таамаглах

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөнд суурилсан аюул (зуд, ган, ноцтой цаг агаарын үзэгдэл/шуурга), геологийн аюул (газар хөдлөлт), ус цаг уурын аюул (үер) зэргийг хянах,

ажиглах, үнэлэх чадвартай. Зөвхөн цаг уурын аюулаас гадна газар хөдлөлт зэрэг геологийн аюулаас урьдчилан сэргийлэх механизмыг боловсруулж, тасралтгүй сайжруулж байна.

УС ЦАГ УУРЫН АЮУЛ

Ихэнх гамшгийн нөхцөл байдалд цаг уурын үзэгдэл шууд болон шууд бусаар холбоотой байдаг. Иймд аюултай цаг агаарыг үнэн зөв урьдчилан таамаглах, урьдчилан бэлтгэх, шуурхай, тодорхой илрүүлэх, аюултай нөхцөл байдлыг цаг алдалгүй мэдэгдэх, арга хэмжээ авах нь эрт сэрэмжлүүлэх системийн амин чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Мал аж ахуйн үндсэн үйлдвэрлэлтэй Монгол Улс өвөл, зундаа эрс тэс уур амьсгалтай тул зөвхөн богино хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээ чухлаас гадна сар, улирлын цаг уурын урьдчилсан мэдээ маш чухал байдаг.

Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-аас улсын хэмжээнд цаг уурын ажиглалтын 137 станц, 181 хяналтын цэг, 152 ус цаг уурын станцын сүлжээг ажиллуулж байна. Анхны ажиглалт 1936 онд Монгол Улсын Ус цаг уурын үндэсний алба байгуулагдахад эхэлсэн.⁶ ЦУОШГ-аас урьдчилсан мэдээг боловсруулж, Ус, цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс (УЦУОШХ) хүчтэй салхи, шороон болон цасан шуурга, зуд, үерийн аюулын бүсчлэлийн зураглалыг тогтмол шинэчлэн боловсруулдаг. Үерийн аюулын дүн шинжилгээг 25, 50, 100 болон 200 жилийн дундаж хугацаагаар хийх боломжтой.

ЦУОШГ мянга гаруй станцаас ажиглалтын мэдээг 5 минутын зайтай цуглуулж, өгөгдөл дамжуулах, чанарын хяналтын автомат механизмыг ажиллуулахад 3 минут орчим зарцуулж, ажиглалт хийснээс 8 минутын дараа өгөгдлийг шалгах боломжтой болгодог. ЦУОШГ Улаанбаатар хотын орчимд хоёр радар ажиллуулж, Япон Улсын Химавари, Солонгос Улсын Харилцаа холбоо, далай, цаг уурын хиймэл дагуулаас (ХХДЦУХД) авсан зайнаас

тандан судлах өгөгдлийг мөн ашигладаг. Ажиглалтын өгөгдлийг интернэт сүлжээ эсвэл хиймэл дагуулаар дамжуулж цуглуулдаг.

ЦУОШГ урьдчилан таамагласан хугацаанаас хамааран маш богино хугацааны (3/6/12 цаг), богино хугацааны (3 өдөр), дунд хугацааны (7 хоног), нэг сар, улирлын (гурван сар) цаг агаарын урьдчилсан мэдээ гаргадаг. Мөн агаарын чанар, гадаргын усны чанар, хөрсний чанар зэрэг хөдөө аж ахуй, байгаль орчинтой холбоотой усны түвшин, салхины хурд зэрэг урьдчилсан мэдээгээр хангадаг. ЦУОШГ нь АНУ (Байгаль орчны урьдчилан таамаглах үндэсний төв, Цаг агаарын судалгаа, урьдчилсан мэдээллийн үндэсний төв (ЦАСУМ)), ЕХ (Дунд хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээний Европын төв, ДХЦАУМЕТ), Япон улс (Япон улсын Цаг уурын агентлаг) зэрэг гадаад эх сурвалжаас авсан тоон загварын өгөгдлийг ашиглан зургаан гишүүнээс бүрдсэн нэгдмэл загвар дээр тулгуурлан ажилладаг.

Цаг агаарын бүх мэдээллийг өөрийн вэб сайт, телевиз, радио, фейсбүүк болон бусад сувгуудаар дамжуулан түгээдэг. Аюултай нөхцөл байдлын үед цахим дохиолол, дуут дохио, мессеж зэргийг ашиглан үүрэн холбооны оператор компаниудтай байгуулсан гэрээний дагуу ОБЕГ эсвэл ЦУОШГ-аас гамшиг, цаг агаарын мэдээг хүргэдэг. Гамшгийн аюулын тухай сэрэмжлүүлгийг түгээх зорилгоор дуут дохионы цамхаг, телевиз, радио станцууд ажилладаг.

Олон төрлийн аюулт үзэгдлийн эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан цаг агаарын мэдээг бусад салбаруудын мэдээлэлтэй нэгтгэж, салбар бүрийн цаг агаарын үзэгдлийн

нөлөөллийг авч үздэг нөлөөлөлд суурилсан урьдчилан таамаглалд анхаарал хандуулж байна. Салбар тус бүрийн мэдээллийн багцад дүн шинжилгээ хийх, цаг агаарын үзэгдлийн нөлөөллийг дангаар нь үнэлэхэд хэцүү байдаг.

ГЕОЛОГИЙН АЮУЛ

Монгол Улсад 1967 онд анхны газар хөдлөлтийн станцыг суурилуулсан ба өнөөдрийн байдлаар тус улсад газар хөдлөлтийг хянах 100 гаруй станц ажиллаж байна. Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэн (ООГХ) газар хөдлөлтийн аюулыг өдөр тутам хянаж, дүн шинжилгээ хийж, газар хөдлөлтийн станцуудын сүлжээг улс, орон даяар удирдаж зохион байгуулдаг цорын ганц байгууллага юм. Тус станцууд мэдээллийг илрүүлсний дараа (~2 минут), автомат мэдэгдэл (~1 минут) болон дахин дүн шинжилгээ хийсэн мэдээллийг (~10 минут) дараа илгээж ажилладаг. Орос, Хятад зэрэг хил орчмын бүс нутгаас ажиглалтын мэдээлэл цуглуулах, хяналт шалгалтыг 24 цагийн турш явуулдаг. Улс орон даяар газар хөдлөлтийн аюулын зураглалыг гаргадаг бөгөөд хамгийн сүүлийн үеийн зураглалыг 2018 онд гаргасан байна. Сүүлийн жилүүдэд их хэмжээний газар хөдлөлтийн тохиолдол гараагүй ч ажиглалтын сүлжээг тасралтгүй өргөжүүлснээр Улаанбаатар хот орчимд

Өртөх байдал

Эрсдэлд өртсөн хүн ам, эд хөрөнгө зэрэг мэдээллийг холбогдох яам, газрууд удирдан зохицуулдаг. Монгол Улсын өртөх байдлын талаарх мэдээллийг Үндэсний Сансрын дэд бүтцийн нэг хэсэг болгон дижитал хэлбэрээр авах боломжтой. 2022 онд Барилга, хот байгуулалтын яам, Геодези, зураг зүйн газартай хамтран өртөх байдлын мэдээлэл, байгалийн нөөц, газрын талаарх дижитал мэдээллийг нээлттэй Гео-портал (<https://nsdi.gov.mn/>, <https://egazar.gov.mn/>)-ыг хүн бүрд нээлттэй боловсруулсан. Гео-портал дээр барилга байгууламж, суурин газар, газар

Цаг уур судлалын өндөр хөгжилтэй орнууд хүртэл цаг уурын үзэгдэл бүрийн нөлөөнд суурилсан урьдчилсан мэдээг эрчимтэй хөгжүүлэхээр ажиллаж өргөжүүлж байна.

газар хөдлөлтийн хагарлыг илрүүлсээр байна. 2005 оноос хойш Улаанбаатар хот орчимд их, бага хэмжээний газар хөдлөлтүүд ойр ойрхон тохиолдож энэ чиглэлд судалгааг илүү нэмэгдүүлэхэд хүргэж байна. Саяхан Улаанбаатар хотод тооцооллоор М7+ газар хөдлөлт үүсгэх чадвартай 50 км урт идэвхтэй шинэ газар хөдлөлтийн хагарлыг (УГХХ) илрүүлсэн⁷. Улаанбаатар хотоос өмнө зүгт 170 км (Дэрэн сум), баруун зүгт 300 км (Могод сум), хойд зүгт 285 км (Бүрэн бүтээл сум) зайд тус тус байрлах газар хөдлөлтийн гурван станцад суурилан нийслэл хотын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх энгийн системийг бий болгосон. Ингэснээр газар хөдлөлтийн байршлаас хамааран ойролцоогоор 46-84 секундний хугацаанд урьдчилан мэдэх боломжтой. Тодорхой магнитудаас хэтэрсэн газар хөдлөлтийн мэдээллийг шаардлагатай хариу арга хэмжээ авхуулахаар ОБЕГ-т автоматаар илгээдэг.

ашиглалт, дэд бүтэц, тээврийн сүлжээ, соёл, археологийн үнэт зүйлс, хүн ам зүй зэрэг мэдээлэл багтсан. Байгалийн баялаг, газрын хөрөнгийн хувьд геологи, хөрс, газрын бүрхүүл, газарзүйн байдал (өндөр ба гүнийг оруулаад), ус судлалын мэдээлэл байдаг. Гео-порталын мэдээллийг Газар зохион байгуулалтын Геодези, зураг зүйн хэлтсийн Газрын ангиллын нэгдсэн удирдлагын систем, төрийн бүх байгууллагуудын мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сангаас авсан.

Гамшигтай холбоотой статистик мэдээлэл

ОБЕГ гамшгийн тохиолдлын (байгалийн болон нийгмийн гамшиг, ой хээрийн түймэр, бусад осол гэх мэт) бодит цагийн мэдээллийг 7 хоногийн 24 цагийн турш цуглуулдаг. Сүүлийн жилүүдэд гамшигтай холбоотой статистик мэдээллийг цуглуулах, хадгалах аргачлал, тогтолцоог боловсронгуй болгож эрсдэлийн талаарх мэдээллийг нэг платформд нэгтгэх ажил үргэлжилсээр байна. ОБЕГ вебд суурилсан гурван платформыг удирдан зохицуулдаг. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний систем (ТХХС)⁸ (www.vms.nema.gov.mn, хаалттай хандалт) төв, орон нутгийн хэмжээнд ОБЕГ-ын операторуудаар дамжуулан ослыг бүртгэдэг. Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журмын дагуу (Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр тогтоол) эдгээр ослыг цаашид судалж, осолд өртсөн хүн ам, эд хөрөнгө, шууд хохирол, хэрэгцээний талаарх мэдээллийг өөр платформ дээр (www.data.nema.gov.mn, хаалттай хандалт) байршуулдаг. Гамшиг осолд өртсөн хүмүүсийг нас, хүйс, жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй (хараа, сонсгол, хэл яриа, бие бялдар, оюуны) болон ажил эрхлэлт, сургуулийн насны/

Эрсдэлийн үнэлгээ

Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан шаардлагын дагуу төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, захиргааны байгууллага (улсын болон орон нутгийн) бүр эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай. Орон нутгийн түвшний эрсдэлийн үнэлгээний хэрэгжилт 2020 он гэхэд 100 хувь хийж гүйцэтгэсэн. Эдгээр үнэлгээг орон нутгийн хөгжлийн 2030 оны төлөвлөгөөний хүрээнд хийсэн. Хотын эсвэл салбарын эрсдэлийн үнэлгээг мөн хийсэн. Тухайлбал, Улаанбаатар хотын газар хөдлөлт (2013 он), үерийн (2015 он) эрсдэлийн үнэлгээ, авто зам, төмөр замын эрсдэлийн үнэлгээг тус бүр хийсэн. Жил бүр зудын эрсдэлийн үнэлгээг хийдэг.

Газар хөдлөлтийн хувьд 2013 онд Улаанбаатар хот орчмын бүс нутагт газар хөдлөлтийн тохиолдож болзошгүй хоёр хувилбарыг ЖАЙКА боловсруулсан байна. Нэг нь Хустайн

завсардсан зэрэг нийгмийн бусад төлөвөөр ангилдаг. Гамшигт тооцогдох зарим ослыг осол гарснаас хойш ойролцоогоор 2-4 сарын дараа гамшиг, аюулт үзэгдлээс учирсан хохирлыг албан ёсоор тооцдог. Хохирлыг тооцохдоо Байгалийн гамшиг, хүчтэй салхи шуурганы улмаас учирсан хохирлыг үнэлэх зааварт (2022 он) заасан аргачлалыг баримтална. Монгол Улсын гамшигтай холбоотой статистик мэдээллийг 2000 оноос хойш гаргасан ч мэдээлэл цуглуулах аргачлал, журмыг шинэчилсний дараа буюу саяхнаас задлан мэдээлэл цуглуулж эхэлсэн. Монгол Улсын гамшигтай холбоотой статистик мэдээллийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын (НҮБГЭБГ) удирдан зохицуулдаг гамшигтай холбоотой статистикийн дэлхийн Гамшгийн мэдээллийн удирдлагын систем болох DesInventar-д⁹ оруулдаг байсан. Гэвч Төрийн албаны Нууцын тухай хуульд өөрчлөлт оруулж, гамшгийн мэдээг дахин ангилсны улмаас (мэдээлэл бүрийг гамшигтай холбоотой гэж үзээгүй) DesInventar дахь мэдээллийг шинэчлэх ажлыг 2016 онд түр зогсоосон.

газар хөдлөлтийн хагарал дээр үндэслэсэн (хамгийн их магнитуд Мв 7.5) бол нөгөө нь Эмээлт (хамгийн их магнитуд Мв 7.0) болон Гүнжийн газар хөдлөлтийн хагарлуудын (хамгийн их магнитуд Мв 6.6) нэгдсэн хувилбар юм. Газар хөдлөлтийн хоёр хувилбарын хувьд Медведев-Спонхеуэр-Карник (МСК) масштабын газар хөдлөлийн эрчмийг VIII-IV гэж тооцсон¹⁰. Хустайн хувилбарын дагуу Улаанбаатар хотын барилгуудын 60 хувь нь нурах магадлал өндөртэй байна. Саяхан Эмээлтийн газар хөдлөлтийн хагарлын газар хөдлөлтийн хувилбарт үндэслэн хийсэн өөр нэг судалгаагаар нийт хохирлыг 27 тэрбум ам.доллар (ДНБ-ний 26%) байх магадлалтай гэж тооцоолжээ¹¹.

Саяхан ОБЕГ, Азийн хөгжлийн банк (АХБ) хамтран хэрэгжүүлсэн техникийн туслалцааны төслийн хүрээнд улсын хэмжээнд гамшгийн

эрсдэлийн үнэлгээ хийхээр ажиллаж, газар хөдлөлт, шороон шуурга, хүчтэй салхи шуурга, цасан шуурга, ган, зуд, үер, ой, хээрийн түймэр, аянга цахилгаан/аадар бороо, малын өвчин, орон сууц, барилга байгууламжийн гал

түймрийн үнэлгээг улсын болон орон нутгийн хэмжээнд хийсэн. Зам, тээвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч, харилцаа холбоо зэрэг тодорхой салбаруудад эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байна¹².

Гамшиг, цаг уурын эрсдэлийн мэдээллийн порталууд

Эрсдэлийн мэдээллийг нэгтгэж, олон нийтэд нээлттэй болгох зорилгоор тодорхой ажлууд хийгдсээр байна. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, статистик мэдээллэл, гамшигт нэрвэгдсэн (хүн ам, эд хөрөнгө) талаарх мэдээллийг хамруулсан гамшгийн эрсдэлийн мэдээллийн санг (www.risk.nema.gov) ОБЕГ боловсруулж байна. Мөн Ус, цаг уур, хүрээлэн

буй орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн нь цаг уурын богино, урт хугацааны (30 жил хүртэлх) мэдээлэл, цаг уурын үзэгдлийг эдийн засгийн хөрөнгө, байгалийн нөөцтэй (жишээ нь: мал аж ахуй, газар тариалан, дэд бүтэц) харилцан үйлчлэлийн дүн шинжилгээ хийдэг Уур амьсгалын үйлчилгээний системтэй (<http://119.40.97.103/climateservice/>).

3.3.2 Хүндрэл, бэрхшээл

Аюулын хяналт, ажиглалт, урьдчилан таамаглах

Ус, цаг уурын аюулын талаар газар, агаар, алсын зайн ажиглалтын сүлжээг олон улсын хамтын ажиллагааны дагуу өргөжүүлэхээр ажиллаж байна. Гэвч мэдээлэл цуглуулах, шийдвэрлэх давтамж бага хэвээр байна. Япон, Солонгос зэрэг улсаас хүлээн авдаг хиймэл дагуулын мэдээлэл Монгол Улсын ажиглалтын хүрээнээс ихэнхдээ гадуур байдаг. Түүнчлэн ажиглалтын талбайн нөхцөл байдал, тоног, төхөөрөмжийн хувьд хуучирсан, эвдрэл, доголдол гарсан тохиолдолд засвар үйлчилгээний хомс байдлаас шалтгаалж ажиглалтын мэдээллийн чанар мууддаг. Саяхан суурилуулсан хоёр радарын нэг нь мэдээллийн чанарын асуудлаас болж ажиллахгүй байна. Өвөл, зуны улирлын цаг агаарын өөрчлөлт тоног төхөөрөмжийн бат бөх, бүрэн байдалд тодорхой хэмжээнд нөлөө үзүүлдэг.

ЦУОШГ-аас Ажиглалтын мэдээлэл цуглуулах, Цаг агаарын графикийн дүн шинжилгээ, бодит цагийн видео хяналт зэрэг зарим системийг аль хэдийн бүтээсэн. Системийг бүтээх, сайжруулах бусад төслүүд хэрэгжиж байгаа ч системийн нийцтэй байдал, дотоодын статистикийн дүн шинжилгээний функцээс шалтгаалан яам, агентлагуудтай гамшгийн

бодит мэдээллийг хуваалцахад дутмаг байна. Системүүдийн хоорондын уялдаа холбоо байхгүй тул мэдээллийг хялбар солилцохын тулд нэмэлт мэдээлэл боловсруулах шаардлагатай байдаг.

Монгол орны цаг агаарын урьдчилсан мэдээ өндөр хөгжилтэй орнуудынхаас их ялгаатай биш ч богино хугацааны урьдчилсан мэдээтэй холбоотой асуудлууд байна. Хот, аймгийн төвүүдийн богино хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээг өдөр бүр голчлон гаргаж байгаа боловч урьдчилсан мэдээний цаг хугацаа, орон зайн нарийвчлал хангалтгүй байдаг. Төрөл бүрийн тоон урьдчилсан мэдээний загварыг боловсруулах, турших, техникийн болон тооцоолох нөөц боломж хомс байна. Өндөр нарийвчлалтай урьдчилан мэдээлэх системийг боловсруулахад тооцоолох, багтаамжийн нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн, харилцаа холбооны сүлжээний тогтворгүй байдлаас болж ажиглалтын мэдээлэл дутуу байна.

Газар хөдлөлтийг илрүүлэхээс эхлээд автомат мэдэгдэл очих хүртэл хугацаа 3 минут орчим байгаа нь газар хөдлөлтийн тархалтын хурдтай харьцуулахад харьцангуй удаан байна.

Сэрэмжлүүлэх, эрсдэлийн мэдээллийг түгээх

Хувь хүн өөрөө идэвхтэй мэдээлэл түгээлтийн (веб хуудас, телевиз, радио, Фейсбүүк гэх мэт) гол сувгуудаар хайлт хийн мэдээлэл олж, баталгаажуулж байна. Олон нийтэд шууд мэдээлэх (цахим мэдээлэл, дуут дохио, мессеж гэх мэт) сувгууд дутагдалтай байна. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн системд ашигладаг дуут дохионы цамхаг, телевиз, радио станцууд, цахим дэлгэцийн самбарууд хуучирч, ашиглалтанд байгаа техник хэрэгслийн тоо цөөрч байна. Мессеж нь гар утасны операторын хэрэглэгчдээс хамаардаг тул бүс нутаг бүрт үр дүнтэй

мэдээллээр хангахад хүндрэлтэй. Мөн хөдөө орон нутгийн болон эмзэг бүлгийн иргэдэд (хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан, хүүхэд, гадаадын иргэд гэх мэт) зориулсан мэдээлэл хүргэх суваг дутагдалтай байна. Олон талын төлөөлөлтэй зөвлөлдөх уулзалт хийхэд аюулт үзэгдлийг сэрэмжлүүлэхээс илүүтэйгээр аюулт үзэгдэлд хэрхэн бэлтгэх, хувийн бэлтгэлээ хангах, шаардлагатай авах алхамуудын талаар мэдээлэл түгээх шаардлагатай байна. Гэхдээ эдгээр мэдээллийг илгээхдээ одоогийн эрт сэрэмжлүүлэхтэй хамт илгээхгүй байх шаардлагатай.

Гамшигтай холбоотой статистик мэдээлэл

Эдийн засгийн алдагдал, хохирлын талаарх мэдээлэл хомс хэвээр байна. Эдийн засгийн шууд хохиролыг тооцох аргачлалыг саяхан боловсруулсан бөгөөд хохиролыг тооцохдоо


энэхүү аргачлалыг бүрэн ашиглах боломжтой аж ахуйн нэгжүүд хязгаарлагдмал байна. Монгол Улсад эдийн засгийн шууд бус хохирлыг тооцох асуудал тулгамдсан хэвээр байна.

3.3.3 Зөвлөмж

Ажиглалтын сүлжээ, түүний чанар, урьдчилсан мэдээлэл

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Эрт илрүүлэх боломжит нөөцийг сайжруулахын тулд ажиглалтын сүлжээг өргөжүүлж, дотоод болон гадаад мэдээллийн эх сурвалж (жишээ нь, FУ цуврал мэдээлэл, радарын мэдээлэл, цэргийн болон бусад яамдын мэдээлэл, цагдаагийн ХКС-ийн видео бичлэг)-ийн хэрэглээг нэмэгдүүлэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Төсвийг урьдчилан баталгаажуулж, сэрэмжлүүлэх, ажиглалтын сүлжээ (гидромет, газар хөдлөлт)-ний засвар үйлчилгээг бүс нутаг бүрд хариуцах албан хаагчдыг томилж, тоног төхөөрөмж тус бүрийн ажиглалтын хугацаанд дүн шинжилгээ хийх замаар ашиглаж буй тоног төхөөрөмжийн ажиллагааг системтэйгээр зохицуулах.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Шороон шуурга, зуд, цасан шуурга, хот суурин газрын үерийн усанд автагдах зэрэг цаг уурын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх хяналт, эрт сэрэмжлүүлэх чадавхыг сайжруулах зорилгоор төлөвлөгөө боловсруулж, хөрш орнуудтай мэдээлэл солилцох, техникийн хамтын ажиллагааг идэвхтэй явуулах.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Бусад орны тоон загварын өгөгдөлд үндэслэн урьдчилсан мэдээллийн дүн шинжилгээг дэмжих зорилгоор Монгол Улсын онцлогт тохирсон өгөгдөл, загваруудыг нэгтгэж, тооцоолох. Олон улсын хамтын ажиллагааны дагуу урт хугацааны зохицуулалт хийхийн тулд тоон урьдчилсан мэдээллийн загварын мэргэжилтнүүдийг оролцуулж урьдчилсан мэдээллийн гүйцэтгэлийг сайжруулах, илүү нарийвчилсан мэдээ гаргах шаардлагатай байна.	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв
Монгол орны газар нутаг, ургамал, цаг уурын нарийвчилсан шинж чанарыг нэгтгэж, боломжит загварт тулгуурлан технологийн байршил тодорхойлох чадварыг сайжруулах.	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Өндөр чанартай ажиглалтын мэдээллийг цуглуулах ажлыг өргөжүүлэх, хиймэл оюун ухаан (AI) зэрэг мэдээлэл технологи (MT)-ийн дэвшилтэт аргыг идэвхтэй нэгтгэсэн загваруудыг ашиглах замаар мэдээллийн чанарыг сайжруулах	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв
Цаашид нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ боловсруулах, дэвшилтэт, нарийвчлал сайтай тоон урьдчилсан мэдээ, загварчлалыг хэрэгжүүлэх өндөр хүчин чадалтай тооцооллын системийг нэвтрүүлэх	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Их төсөв
Цаг агаарын үйл явдал тус бүрийн тодорхой талбар, зорилтот (гамшгаас урьдчилан сэргийлэх агентлагууд, нүүдэлчид эсвэл олон нийт), цаг хугацааны хувьд тохирсон нөлөөлөл дээр суурилсан урьдчилсан мэдээг боловсруулах. Гамшийн төрөл бүрээр нэн тэргүүнд анхаарах чиглэлийг тодорхойлж, үе шаттайгаар ажиллах.	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Олон чиглэлээр нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээллийн судалгаа, стандартчилал хийж, холбогдох яамдтай идэвхтэй харилцаж, хамтран ажиллах.	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв



Зураг 11. Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээг боловсруулах үйл явцын жишээ

Сэрэмжлүүлэх, эрсдэлийн мэдээллийг хүргэх, түгээх

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Цаашид нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ боловсруулах, дэвшилтэт, нарийвчлал сайтай тоон урьдчилсан мэдээ, загварчлалыг хэрэгжүүлэх өндөр хүчин чадалтай тооцооллын системийг нэвтрүүлэх	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Нийгмийн бүлгүүдийг ялангуяа орон нутгийн түвшинд, идэвхжүүлж, эмзэг бүлэгт зориулсан захиалгат мэдээлэл боловсруулан хүргэх замаар мэдээлэл түгээх системийг нэмэгдүүлэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Их төсөв
Улаанбаатар болон томоохон хотуудаас эхлээд 4G, 5G технологид шилжих зэрэг харилцаа холбооны сүлжээний шинэчлэлийг өргөжүүлэх. Алслагдсан байршлын хувьд хиймэл дагуулын харилцаа холбооны сүлжээг хиймэл дагуулын харилцаа холбооны дэд бүтцээр (дохио хүлээн авагч, дамжуулагч) орлуулах. Богино долгион ашиглан харилцаа холбооны сүлжээг нэвтрүүлэх асуудлыг авч үзэх.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Их төсөв
Гамшгийн төрөл, түвшнээс хамааран зорилтот хүмүүст зориулсан i) сэрэмжлүүлэх, ii) иргэдийн бэлэн байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор багц мессеж боловсруулах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

Эрсдэлийн үнэлгээ

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Улаанбаатар хотын газар хөдлөлтийн хагарлын нөхцөл байдал, хүн амын өртөх эрсдэл, болзошгүй хохирол өндөр байх магадлалд үндэслэн эрсдэлийн үнэлгээ хийх (Монгол Улсын нийт хүн амын 50 гаруй хувь нь Улаанбаатар хотод оршин суудаг бөгөөд хот суурин газрын болон хот орчмын суурьшлын бүсүүд өргөжиж байна).	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа барилга байгууламжийн газар хөдлөлтийн эрсдэлийг даван туулах бат бэх байдлыг судлахын тулд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, газар хөдлөлтөд тэсвэртэй барилга байгууламжийн инженерийн шийдлийн судалгаа, хөгжлийг дэмжих.	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв

Эрсдэлийн мэдээллийн платформ

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Яам, агентлагууд гамшгийн талаарх мэдээллийг салбар хооронд нэгтгэх, ойлгох, удирдахын тулд шинэ платформ бий болгохоосоо өмнө одоо байгаа эрсдэлийн мэдээллийн платформуудыг ашигладаг байх нөхцөлийг бүрдүүлэх. Олон нийтийн системүүд хоорондын нийцлийг хангах, хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэхийн тулд систем, мэдээллийн сангийн бүтэц болон бусад тогтолцоог стандартчилах салбар/яам хоорондын механизмыг ашиглахыг зөвлөмж болгож байна.	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв

3.4 Санхүүжилт

3.4.1 Давуу тал

Монгол Улс гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг санхүүжүүлдэг олон төсвийн

аргачлалтай бөгөөд санхүүгийн аргачлалын сонголтууд ч мөн хөгжиж байна.

Төсвийн аргачлал

Монгол Улсад төсвийн хэд хэдэн аргачлал байдаг.

- 1.0% төсвийн хуваарилалт. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн байгууллагуудад жил бүрийн төсвийн 1.0-ээс доошгүй хувийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зарцуулахыг 2017 онд боловсруулсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн заалтанд тусгасан байна.
- Улсын болон орон нутгийн нөөц сангийн 30%-ийг гамшгаас хамгаалах, сэргээн босгох/сэргээн засварлах үйл ажиллагаанд ашиглах боломжтой.
- Байгалийн нөөцийн хураамж зэрэг орон нутгийн түвшний татварын орлого (бусад хураамжийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, хөдөө аж ахуйн салбар бүлгээс харна уу).
- Сангийн яамнаас гүйцэтгэлд суурилсан төсвийн нэмэлт хуваарилалт.

Сангийн яамнаас мэдээлснээр гамшгийн эрсдэлийн удирдлага/бууруулах, уур

амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагаанд төсвийг тодорхойлох механизм байдаг ба энэ нь тухайн үйл ажиллагаанд хуваарилагдсан төрийн нөөцийг хянах боломжийг олгодог.

Орон нутгийн засаг захиргаа гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд зориулсан төсвийн 1.0%-ийг хуваарилах боломжийг 2017 онд хэрэгжиж эхэлснээс хойш улам их ашиглаж байна. Монгол Улсын Засгийн газраас гаргасан Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний дунд хугацааны тайланд дурдсанаар сүүлийн таван жилийн хугацаанд орон нутгийн (аймгийн) түвшинд Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөв дөрөв дахин нэмэгдсэн.


ОБЕГ-аас өгсөн хамгийн сүүлийн үеийн мэдээллээр 2022 онд дунджаар төсвийн 2.5%-ийг, 2023 онд аймаг, дүүрэг, Улаанбаатар хотод 1.16%-ийг Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд тус тус төсөвлөгдсөн байна. Доорх хүснэгтэд орон нутаг (аймаг), дүүрэг, хотын захиргаанд (энд зөвхөн Улаанбаатар хотод) Гамшгийн эрсдэлийг бууруулах төсвийн хуваарилалтыг дүгнэн харуулав.

Хүснэгт 1. Орон нутаг (аймаг), дүүрэг, Улаанбаатар хотын ГЭБ төсвийн хуваарилалт (эх сурвалж: ОБЕГ), Валютын ханш 1 ам.доллар = 3444.6 төгрөг (Үндэсний статистикийн хорооны 2022 оны ханш)

Захиргаа	2022 оны ГЭБ төсвийн нийлбэр /ам.доллар/	2022 оны төсвийн дундаж хувь	2023 оны ГЭБ төсвийн нийлбэр /ам.доллар/	2023 оны төсвийн дундаж хувь
Аймаг	3,680,577.96 ам.доллар	1.94%	2,340,670.40 ам.доллар	0.66%
Дүүрэг	1,080,531.85 ам.доллар	3.42%	1,369,244.61 ам.доллар	2.33%
Хотын захиргаа (Улаанбаатар хот)	11,187,772.17 ам.доллар	2.90%	7,681,356.33 ам.доллар	1.04%
Нийт дүн	15,948,881.97 ам.доллар	2.25%	11,391,271.34 ам.доллар	1.16%


Доорх графикт Гамшгийн эрсдэлийг бууруулах төсвийн хуваарилалтын эзлэх хувийг орон нутаг (аймаг), дүүрэг, Улаанбаатар хот тус бүрээр харуулж байна. ОБЕГ-аас гаргасан гамшгийн эрсдэлийг бууруулах төсвийн мэдээлэл нь тухайн орон нутгийн засаг захиргааны төвлөрсөн цэгүүдийн тоон мэдээлэлд үндэслэсэн бөгөөд орон нутгийн засаг захиргааны тайланд зэрэг ялгаатай

Гамшгийн эрсдэлийг бууруулах төсвийг тайлбарласан болохыг анхаарна уу. 2017 оны Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу улсын нөөцийн сангийн тодорхой хэсгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны жилийн төсөвт хуваарилалт хийх зарим орон нутгийн засаг захиргаанууд боломжтой байсан.




Зураг 12. Дүүргийн ГЭБ төсвийн эзлэх хувь

Аймгийн ГЭБ төсөвт эзлэх хувь (Аймаг)



Зураг 13. Аймгийн (орон нутгийн) ГЭБ төсвийн эзлэх хувь



Зураг 14. Улаанбаатар хотын ГЭБ төсвийн эзлэх хувь

2017 оны Гамшгаас хамгаалах тухай хуульд гамшгийн эрсдэлийг бууруулахад хувийн хэвшлийн байгууллагуудад төсөв хуваарилах заалт бий. Хуульд зааснаар "хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5-аас доошгүй хэмжээний

хөрөнгийг төлөвлөж, зарцуулна" гэж заасан байдаг. Гэвч хувийн хэвшлийн байгууллагуудад төсөв хуваарилах нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо байхгүй бөгөөд энэ заалтын хэрэгжилтийн төлөв тодорхойгүй байна.

Санхүүгийн аргачлал

Монгол Улс мал аж ахуй¹³, газар тариалан (буудай) зэрэг хөдөө аж ахуйн зарим хөрөнгийг цаг агаарын эрс тэс, уур амьсгалаас хамгаалж улсаас санхүүжүүлдэг индексжүүлсэн даатгалд хамруулдаг. Индексжүүлсэн даатгал малчид, хөдөө аж ахуйн нэгжүүдийн бодит хохирлоос үл хамааран тухайн бүс нутагт учирсан нийт алдагдлын тодорхой хувийг харгалзан нөхөн олговор олгодог. Хохирлын нөхөн олговрыг тухайн бүс нутгийн босгыг давсан хохирлын хувь хэмжээнээс хамаарч хувийн болон улсын даатгалын компаниудын түншлэлээр нөхөн олгодог. Жишээлбэл, 5 хүртэлх хувийн хохирлыг ач холбогдолгүйд тооцож индексжүүлсэн даатгалд хамруулахгүй. 6%-иас 25%-30%-ийн хохирлыг хувийн даатгалын компаниуд хариуцдаг бол 25%-иас дээш хохирлыг Монгол Улсын Үндэсний давхар даатгал ХК¹⁴ хариуцдаг. Монгол банк, Монгол Улсын Үндэсний давхар даатгал ХК, Санхүүгийн зохицуулах хорооноос эрсдэлийн даатгалын тогтолцоо, санхүүгийн болон эрсдэлийн удирдлагын талаар олон нийтэд боловсрол олгох зорилгоор улс орон даяар олон нийтэд тогтмол мэдээлэл өгдөг.

Монгол Улсад хувийн хэвшлүүдээр дамжсан эрсдэлийн даатгалын төрөл бүрийн сонголтууд байдаг. Газар хөдлөлт, үер, гал түймэр болон зонхилон тохиолддог бусад гамшиг, аюулт үзэгдлийн эрсдэлээс хамгаалах үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл гэх мэт олон төрлийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн 17 даатгалын компани байдаг. Хаан банк (жилийн 1.2%-ийн хөнгөлөлттэй), Төрийн банк (жилийн 2.6% хүртэлх хөнгөлөлттэй) зэрэг арилжааны банкнууд малчдад зориулсан зээлийн хүүгийн хөнгөлөлттэй эрсдэлийн даатгалыг үйлчилгээ үзүүлдэг. Бүх малаа малын индексжүүлсэн даатгалд даатгуулсан тохиолдолд энэ хөнгөлөлт хамаарна. Түүнчлэн Голомт банк ипотекийн зээл олгохдоо даатгалын шимтгэлийг сар бүр төлөх боломжийг олгож байхад бусад банкнууд жилд нэг удаа шимтгэл төлөхийг шаарддаг. Арилжааны банкнууд зээлийн үйл ажиллагаандаа ипотекийн зээл, тээврийн хэрэгслийн зээл гэх мэт төрөл бүрийн зээл авахад ихэвчлэн үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, зээлдэгчийн амь насны

даатгалд хамрагдах нөхцөл тавьдаг. Урьдчилан таамаглашгүй гамшиг, онц нөхцөл байдлын үед гарч болох санхүүгийн их хэмжээний хохирлыг багасгах зорилгоор энэ шаардлагыг тогтоосон байдаг. Жижиг хувийн даатгалын компаниуд давхар даатгалд хамрагдахгүй байх тохиолдол элбэг байдаг нь гамшгийн дараах эдийн засгийн хямралд хүргэж болзошгүй үр дагавартай байдаг. Давхар даатгал нь том болон жижиг даатгалын компаниудын хувьд гамшгийн үед эрсдэлээс хамгаалахад тусалдаг амин чухал аюулгүй байдлын сүлжээ болдог.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 2009-2014 онд хувийн даатгалын компаниудтай хамтран ажиллаж, нийгмийн эмзэг бүлэг, эмэгтэйчүүд, дунджаас доогуур орлоготой өрх, жижиг бизнес эрхлэгчдэд туслах зорилгоор бичил даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Даатгалын бүтээгдэхүүнд гал түймэр, байгалийн гамшиг, цахилгааны гэмтэл болон гуравдагч этгээдийн улмаас учирсан хохирол зэрэг төрөл бүрийн эрсдэлийг даатгалд хамруудаг болсон Ингэснээр орон сууц, тоног төхөөрөмж,

тогтвортой орлогыг гамшгийн үед даатгуулсан байдаг. Энэ бүтээгдэхүүн карт хэлбэрээр ихэвчлэн 5,000-10,000 төгрөгийн хооронд хэлбэлзэх даатгалын шимтгэлийн хэмжээ багатай, тухайн бүс нутагт тус үйлчилгээг авахад хялбар байдгаараа онцлогтой. Гэсэн хэдий ч өрхийн орлого багатай, зорилтот хэрэглэгчдийн ойлголт дутмаг байгаагаас шалтгаалан уг бүтээгдэхүүний хэрэглээ хязгаарлагдмал байна.

Монгол Улсын Засгийн газар тариалангийн даатгал¹⁵, газар хөдлөлтийн эрсдэлээс хамгаалах орон сууцны даатгал¹⁶, гамшгийн эрсдэлийн даатгал¹⁷ зэрэг олон хууль тогтоомжийг боловсруулж байна.

Үндэсний ногоон санхүүжилт нь ногоон санаачилгыг санхүүжүүлэхэд санхүүгийн салбарын нөөцийг татан оролцуулах механизм юм. Тухайлбал, энэхүү механизмаар дамжуулан "Нэг тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг дэмжих зорилгоор жил бүр их хэмжээний хөрөнгийг арилжааны банкнуудаар дамжуулан төвлөрүүлдэг.

Нэмэлт санхүүгийн дэмжлэг

Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэхийн тулд олон улсын сангууд хөрөнгө оруулалт хийсээр байна. Үүний дотор Азийн хөгжлийн банк (АХБ) Монгол Улсын эрт сэрэмжлүүлэх системийг сайжруулах төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй байна.

Монгол Улс Гамшгийн эрсдэлийг бууруулах, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг хамтарсан төсөл, санаачилга, хөтөлбөрүүдэд зориулсан хоёр талын, олон талт эх сурвалжаас гадна НҮБ, Монголын Улаан Загалмай Нийгэмлэг, ТББ-аас төрөл бүрийн санхүүжилт авдаг. 2023 оны 8 дугаар сард КАДРИ түншлэлээс хийсэн аналитик зураглалаар Монгол Улсын Гамшгийн эрсдэлийг бууруулах, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүмүүнлэгийн болон хөгжлийн 26 түншийн¹⁸ 108 хөтөлбөрийг тодорхойлсон бөгөөд тэдгээрийн

68 орчим хувь нь Засгийн газраас эхлээд олон нийтийн түвшинд хүртэлх олон төрлийн аюул, ослыг хамарсан байна. 2023 оны 8 дугаар сарын байдлаар 59 хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 5 нь хэрэгжихээр төлөвлөсөн, 44 нь хэрэгжиж дууссан байна. Хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн ихэнх нь хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал (17) зэрэг дээр төвлөрч олон талт түншүүд (34) болон НҮБ-аас (18) санхүүжүүлж байна. Мөн салбар дамнасан (13) төслийг тодорхойлсон.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (2023 он) мэдээлснээр Монгол Улс нь 2021 онд уур амьсгалтай холбоотой бүтээн байгуулалт, нөлөөллийг бууруулах, дасан зохицох арга хэмжээнд зориулж 234.5 сая ам.долларын санхүүжилт хүлээн авчээ. Хөрөнгө оруулалтын дийлэнх нь Хөдөө аж ахуй, Ойн аж ахуй, загас агнуур, тээвэр, агуулахын салбаруудад зориулагдсан байна.

3.4.2 Хүндрэл, бэрхшээл

Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ) үйл ажиллагааны төсвийн нийт хуваарилалт ахиц дэвшлийг харуулж байгаа ч одоогийн мэдээллээр төсөвт ямар төрлийн ГЭБ арга хэмжээг тусгаж байгааг тайлбарлаагүй, Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагаанд зориулсан төсвийн тэмдэглэгээг өргөн ашигладаггүй байна. Монгол Улсын Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн дунд хугацааны хэрэгжилтийн тайланд мэдээлснээр гамшиг, аюулт үзэгдэл, осол, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн зардал 88.4 хувиар өссөн байна. Үүнтэй адил зудын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхэд шаардагдах зардал (өвс, тэжээл бэлтгэх) 9.2 хувиар, улсын нөөцөөс автомашин, гэр, дулаан хувцас, хэрэгцээт бараа бүтээгдэхүүнээр хангахад зарцуулсан зардал 9.2 хувиар өссөн¹⁹. Сүхбаатар, Увс аймгуудтай зөвлөлдөхөд гал унтраах ангиудын гаражийн талбай (Сүхбаатар) барих, холбооны хэрэгсэл (Увс) худалдан авахад тус аймгууд төсвийн 1 хувийг зарцуулсан байна. Бүх салбарын газар/хэлтсүүд (хөдөө аж ахуй, байгаль орчин, боловсрол, барилга хот байгуулалт, орон нутгийн хөрөнгө оруулалтын газар, орон нутгийн цаг уурын газар)-тэй зөвлөлдөхөд эрсдэлийг бодитой бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хангалттай төсвийг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байгаагаа илэрхийлсэн.

Одоогийн төсөв, санхүүгийн бодлого гамшгийн улмаас гэнэт их хэмжээний төсвийн зардал шаардагдах эсвэл ДНБ-ний алдагдал өндөр байх төлөвтэй байгаагаас болзошгүй сүйрлийн хувилбарыг хангалттай авч үзээгүй байна. (жишээ нь: Барилгын нуралтаар ДНБ-ний 25%-ийг алдаж болзошгүй-Эмээлтийн газар хөдлөлтийн хагарлын хувилбар).

Эрсдэлийн даатгалд хөрөнгө оруулах нь амьжиргаагаа дөнгөж залгуулж буй иргэдийн сонголт биш боловч бусадтай харьцуулахад гамшгийн хор нөлөөг хамгийн их хүртдэг. Монгол Улсын эрсдэлийн даатгалын үйл ажиллагаа дунджаас доогуур түвшинд (олон улс) хөгжсөн байна. Монгол Улсын эрсдэлийн даатгалын салбарын шимтгэлийн тооцооллыг илүү үнэн бодит гаргахын тулд эрсдэл, алдагдал, хохирлын талаарх үнэн зөв, бодит мэдээллийн талаар хүртээмжийг сайжруулахыг шаардлагатай байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад хэрэгжүүлж буй нэгдсэн тогтолцоо/стратеги байхгүй байна. Монгол Улсад гамшгаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагаанд чиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтээс илүү гамшгийн хариу арга хэмжээнд (болзошгүй онц байдал) төвлөрсөн гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн ихээхэн ажил хийгдэж байна.

ХАЙРЦАГ 1.

Гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн жишээ нь даатгал, нөхцөлт санхүүжилт, нөхцөлт нөөц болон нөөцийн сангууд байдаг.

Гамшгийн эрсдэлийн санхүүжилт нь гамшгийн улмаас учирсан хохирол, онцгой байдлын зардлыг санхүүжүүлэхэд эрсдэлийн давхаргын аргыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, гамшгийн давтамж, хүндрэлийн хэмжээ нь ашиглах санхүүгийн хэрэгслийг тодорхойлно. Хохирол, онцгой байдлын зардлыг бууруулах зорилгоор бага давтамжтай, ноцтой хохиролтой гамшгуудад даатгалын хэрэгсэлүүдийг ашиглахыг саналболгодог. Гэхдээ даатгал нь гамшгийн хохирлыг бууруулдаггүй, харин эрсдэлийг шилжүүлдэг бөгөөд даатгалын салбарыг сайн хянаж, удирдан зохицуулаагүй тохиолдолд санхүү, эдийн засгийн бусад олон асуудлыг дагуулж болзошгүйг анхаарах нь чухал юм. Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын эрэмбэлэлд гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилт суурилдаг. Эдгээр хөрөнгө оруулалтыг эрэмбэлэн тогтоосны дараа тэдгээрийг санхүүжүүлэх хамгийн санхүүгийн хэмнэлттэй хэрэгслийг тодорхойлдог. Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтэд гамшгийн шууд бус нөлөөллийг тогтоохын тулд зардал - үр ашгийн магадлалын дүн шинжилгээг ашигладаг (учир нь зардал-үр ашгийн дүн шинжилгээнд шууд, шууд бус зардлыг багтаасан байх ёстой).

3.4.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг салбарын бодлого, төлөвлөгөөнд тусгах нь төсвийн хуваарилалтад таатай орчныг бүрдүүлнэ. Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ) төсвийг удирдан чиглүүлэхэд Сангийн яамны харьяа газар, хэлтсүүд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг яамд, ОБЕГ-ын дэргэдэх зөвлөлдөх байгууллагаар дамжуулан боломжит төсвийг оновчтой болгох.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Зардал, үр ашгийн шинжилгээнд үндэслэн аюулын тодорхой салбаруудад эрсдэлийг бодитой бууруулах шийдлүүдийн талаар салбар байгууллага, орон нутгийн засаг захиргаа, сонгогдсон орон нутгийн төлөөлөгчдөд мэдлэг ойлголт олгох чиглэл өгөх. Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний болон орон нутгийн зөвлөлийн гишүүд, улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах албаны гишүүдэд зориулсан гарын авлагыг ашиглах (2023 он, төсөл)	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор нэн чухал дэд бүтэц, барилга байгууламжийг засварлах, сайжруулахад; эрсдэлийн мэдээлэлд үндэслэсэн төлөвлөлт, бодлого боловсруулахад; хүн амд шууд хүрэх эрт зарлан мэдээллийн системд; судалгаа шинжилгээ, технологи, инженерийн шийдлийг хөгжүүлэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн буюу даван туулах чадавхыг бий болгоход зориулан төсвийн нийт хуваарилалтыг нэмэгдүүлэх	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Байгаль орчин, нийгэм, хамтын засаглал (БОНХЗ), Компанийн нийгмийн хариуцлага (КНХ)-ын хүрээнд хувийн компаниуд бизнесээ орон нутгийн болзошгүй гамшгаас хамгаалах хэрэгсэл/урамшуулал болгон хуулийн этгээдэд 1.5%-ийн төсөв хуваарилах хуулийн заалтыг дэмжих мөн гамшиг, уур амьсгалын эрсдэлийг бууруулахад хувь нэмэр оруулах шийдлийг (технологи, хүний нөөц) боловсруулах. “Тогтвортой бонд” эсвэл “даван туулах бонд” нийгэмд тэсвэртэй байдлыг бий болгоход хамтын хөрөнгө оруулалт хийх олон арга замуудын нэг байж болно.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Монгол Улсын Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцооны нэг хэсэг болох Сангийн яамыг төсөв, санхүүгийн бодлогын дагуу хөрөнгө оруулалтын хэмжээг зөв хослуулах стратегийн үндэс болгон гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийг (гамшгийн эрсдэлийн санхүүжилт гэх мэт) бэхжүүлэх ²⁰ .	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд гамшгийн хохирлын талаарх түүхэн мэдээлэлд үндэслэн гамшгийн тодорхойлолт, хэмжих нэгжийг тодорхой болгох. Гамшиг тохиолдохоос өмнө бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ авах замаар гамшгийн болон уур амьсгалын эрсдэлийг бууруулсны дараа үлдсэн эрсдэлийг шийдвэрлэхийн тулд эрсдэл шилжүүлэх механизмыг гамшгийн эрсдэлийг бууруулах ерөнхий санхүүжилтэд нэмэлтээр ашиглах хэрэгтэй.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Эрсдэлийн талаарх одоогийн мэдлэг, мэдээлэл болон туршлагатай улс орнуудын сургамжид үндэслэн гамшигт нөхцөл байдлын төсөв, санхүүгийн бэлэн байдлыг тусгасан сэргээн босгох, сэргээн засварлах бүтцийг бий болгох. Төв Азийн эрсдэлийн сангийн механизмын талаарх яриа хэлэлцүүлгийг урагшлуулах нь стратегийн боломжит хувилбаруудын нэг юм.	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв

3.5 Хэрэгжилт

Хэрэгжилтийн чадавхыг үнэлэхдээ үйл ажиллагааны журам, тухайн чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийн чадавхад үндэслэн дүн шинжилгээ хийдэг. Хүний нөөцийн чадавхын үнэлгээг голчлон холбогдох хариуцсан хэлтэс,

албадтай зөвшилцсөний үндсэн дээр ажиглалт хийж байсан бол ОБЕГ/ОНОБГ-ын албан хаагчдын гамшгийн эрсдэлийг бууруулах чиг үүргийн чадавхыг судалгаа хийж үнэлсэн.

3.5.1 Давуу тал

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа

Монгол Улс гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, гамшгийн дараах хохирол, алдагдлын бүртгэл тооцоог боловсруулах зорилгоор үндэсний болон орон нутгийн захиргааны байгууллагууд ашигладаг эрсдэлийн үнэлгээ, гамшигтай холбоотой статистик мэдээллийг цуглуулах аргачлал болон стандарттай. Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг үндсэн арван аюул (ган, зуд,

барилгын түймэр, хээрийн түймэр, газар хөдлөлт, үер, химийн бодисын осол, цацраг туяаны осол, мал, амьтны гоц халдварт болон зоонозын өвчин, ил болон далд уурхай)-д хийх боломжтой ба эрсдэлийн үнэлгээний стандарт Монгол Улс MNS ISO 31000:2020 Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын эрсдэлийн үнэлгээний чанарыг Эрсдэлийн менежментэд ашиглах боломжтой.

Эрт сэрэмжлүүлэг

Үндэсний болон орон нутгийн хэмжээнд аюулт үзэгдлийн хяналт, ажиглалт, урьдчилан таамаглах үүрэг бүхий холбогдох байгууллагуудын үүрэг, хариуцлагыг Засгийн газрын тогтоол, заавар, үйл ажиллагааны удирдамжаар сайтар тодорхойлсон байдаг. Ус цаг уурын аюул болон газар хөдлөлтийн аюулын аль алинд нь анхааруулга өгөх шалгуур тогтоосон байдаг.

Орон нутгийн ус цаг уурын байгууллагууд хамгийн бага хүний нөөц, тоног төхөөрөмжтэй ажиллаж, ажиглалтын өгөгдөл дамжуулах, сэрэмжлүүлэг түгээх үйл ажиллагааны

удирдамжийг зохих ёсоор дагаж мөрддөг.

Үүний нэгэн адилаар Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэн (ООГХ) техникийн чадавхыг өргөтгөх шаардлагатай хэвээр байгаа ч газар хөдлөлтийн үйл ажиллагааг хянах чадварлаг эрдэмтдийн багтай.

ОБЕГ, ЦУОШГ, ООГХ-ын хооронд сэрэмжлүүлэг (ООГХ болон ОБЕГ, ЦУОШГ болон ОБЕГ хооронд) дамжуулах, сэрэмжлүүлгийг олон нийтэд түгээх үйл ажиллагааны протокол үйлчилж, хэрэгжиж байна.

Хариу арга хэмжээ авах, сэргээн босгох бэлэн байдал

ОБЕГ нь мөрдөж буй үйл ажиллагааны протокол, техникийн заавар/стандарт, дотоод сургалтын механизм, эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн тогтмол хуваарилалт зэрэг гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах бат бөх суурьтай.

Орон нутгийн онцгой байдлын газрын ISO гэрчилгээ хариу арга хэмжээ авахад бэлэн байх хамгийн бага түвшнийг баталгаажуулдаг. Үндэсний, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги нэгжүүд аврах, гал унтраах үндсэн хэрэгсэл, гамшгийн дараах хариу арга хэмжээ авах механизм, сайн харилцаа холбооны хэрэгсэл, газрын зураг зэрэг ажиллагааны хэрэгслээр тоноглогдож, бэлтгэгдсэн хүний нөөцөөр хангагдсан байдаг. Түүнчлэн холбогдох төрийн байгууллага, газар, албан тушаалтнуудтай босоо болон хэвтээ тэнхлэгийн дагуу холбоотой байж, шаардлагатай болон онцгой байдлын үед дайчлагдахад бэлэн байдаг. Тус улс одоогоор Хот дахь Олон улсын эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлэг (ХДОУЭХАЗБ)-ийн²¹ стандартын дагуу дунд түвшний хот суурин газрын аврах, эрэн хайх ажиллагааг явуулж байгаа бөгөөд аврах тоног төхөөрөмжтэй хослуулсан Эрэн хайх, аврах (ЭХА) болон гал унтраах үндсэн хүчин чадалтай.

ОБЕГ-ын хүний нөөцийн сургалт нь Цагдаагийн академийн Дотоод хэргийн анги, Онцгой

байдлын сургууль (бакалавр, магистр, докторын зэрэг)-аар дамжуулан алба хаагчдыг гамшгийн үед ажиллах (эрэн хайх, аврах, гал унтраах) практик ур чадварт сургах танхимын тогтмол сургалтын хөтөлбөрийг боловсруулж, удирдлагын түвшний боловсон хүчнийг бэлтгэдэг.

Хүмүүнлэгийн үндсэн стандарт (ХҮС) болох СФЕР төсөл хүмүүнлэгийн үндсэн стандарт монгол хэл дээр байдаг ба ажиллагааны явцад ашиглах боломжтой.

Монгол Улс иргэд, олон нийтийн гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд нийгмийг бүхэлд нь хамарсан соёлыг төлөвшүүлэх эрмэлзэлтэй байдаг. Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрийн (2015-2020, 2021-2025 онууд) хүрээнд ОБЕГ-аас иргэд болон сургуулиудад анхан шатны аврах ур чадвар олгох сургалтыг тогтмол явуулдаг. Боловсролын хүрээнд 2019 онд цэцэрлэг, ерөнхий болон дээд боловсрол зэрэгт нэвтрүүлсэн аюулгүй амьдралын ур чадварын нэмэлт хичээл орж байна.

Монгол Улсын Засгийн газраас “Улаанбаатар хотын бүс нутагт газар хөдлөлт болсон” сэдвээр газар хөдлөлтийн аюулын хор уршгийг арилгах ажиллагааны стратегийн команд штабын дадлага сургуулийг 2023 оны 05 дугаар сард 3 өдрийн турш зохион байгуулж дадлага

сургуульд төрийн үйлчилгээ, сургууль, олон нийт, төрийн бус байгууллагуудаас оролцож, газар хөдлөлтийн бэлэн байдлыг хангахад суралцсан.

Монгол Улсад үндэсний, олон улсын 300 гаруй төрийн бус/иргэний нийгмийн байгууллага байдгаас хэд хэд нь гамшгийн эрсдэлийн удирдлага (ихэвчлэн онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах, бэлэн байдал), байгаль орчныг хамгаалах, тэр дундаа биологийн төрөл зүйл, ойн аж ахуй, ус, хөрсний менежментийн

чиглэлээр идэвхтэй ажилладаг²². Гамшгийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас дурдвал Дэлхийн зөн, Пипл ин Нийд, Монголын Улаан Загалмай Нийгэмлэг, Хүүхдийг Ивээх Сан зэрэг байгууллага багтдаг. Эдгээр төрийн бус байгууллагууд гамшиг/онцгой байдлын үед НҮБ болон Монгол Улсын Засгийн газраас хамтран зохицуулдаг Олон Улсын Хүмүүнлэгийн тусламжийн багийн гишүүд юм.

3.5.2 Хүндрэл, бэрхшээл

Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох

Бодлого, төлөвлөлтийг эрсдэлийг бууруулах бодит арга хэмжээ болгон хөрвүүлэн хэрэгжүүлэхэд чадавхын дутагдал илт харагдаж байна. Эдгээр дутагдлууд ихэнхдээ хүний нөөцийн чадавх (техникийн болон үйл ажиллагааны мэдлэг), санхүүгийн эх үүсвэрийн хүртээмж зэрэг төрөл бүрийн хүчин зүйлүүдтэй холбоотой. Салбарын яам, газрууд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх техникийн мэдлэгтэй хэдий ч санхүүгийн эх үүсвэрийг урьдчилан бүрдүүлэхэд хүндрэлтэй байгааг оролцогч байгууллагууд дурдлаа. ОБЕГ/ОНОБГ зэрэг зохицуулах байгууллагууд, орон нутгийн удирдлага, төлөвлөлтийн албан хаагчид санхүү,

хүний нөөцийг хуваарилах эрх мэдэлтэй боловч гамшгийн өмнөх эрсдэлийг бууруулах эсвэл уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр тухайн салбарын оролцооны талаар хангалттай мэдлэггүй байна.

Үйл ажиллагааны журмын хувьд эрсдэлийн үнэлгээний зааварт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхдүүд зэрэг хамгийн эрсдэлтэй хүн амын эмзэг байдлыг шийдвэрлэх талаар хязгаарлагдмал байдаг. Нэмж дурдахад засгийн газар болон хувийн хэвшлийн байгууллагуудын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, байгаль орчны эрсдэлийн үнэлгээтэй нэлээн олон зүйл дээр давхцаж байна.

Эрт сэрэмжлүүлэх систем

Гамшгийн төрөл, тайлбар, анги, үйл ажиллагааг хариуцсан байгууллагаар нь ангилаагүй тул тусгай заавар/гарын авлагыг гаргахад хүндрэлтэй байна. Үр дүнтэй эрт сэрэмжлүүлэх системд зөвхөн ЦУОШГ, ООГХ, ОБЕГ зэрэг байгууллагууд төдийгүй эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагууд хамрагддаг. Тиймээс төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс өөр өөр салбаруудад зориулсан хариу арга хэмжээний үйл ажиллагааны шат дарааллыг идэвхжүүлэх системд зориулсан үйл

ажиллагааны болон процессын (operational and procedural) журам, удирдамж шаардлагатай.

Эрт сэрэмжлүүлэх системийн сургалтыг жилд нэг удаагийн арга хэмжээнд чиглэсэн хөтөлбөр хэлбэрээр зохион байгуулах хандлагатай байдаг ба системчилсэн байдлаар зохион байгуулдаггүй. Үүний үр дүнд, цаг агаарын урьдчилсан мэдээний албан ёсны болон мэдээллийн сувгуудын талаар онцгой байдлын холбогдох газрууд тодорхой мэддэггүй.

Хариу арга хэмжээ авах, сэргээн босгох бэлэн байдал

ОБЕГ-ын хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны чадавх өндөр, цаашид чадавхыг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарал хандуулдаг. Хариу арга хэмжээнд үүрэг, хариуцлагыг илүү тодорхой зааглахаас гадна салбарын яам, орон нутгийн засаг захиргаатай илүү нягт уялдаатай ажиллахыг шаарддаг эрт сэргээн босгох, урт хугацааны нөхөн сэргээх, дахин сэргээн засварлах руу шилжих механизм дутагдал ажиглагдаж байна. Энэ дутагдал 2023 онд болсон томоохон үерийн гамшгийн дараа илүү мэдрэгдсэн. Одоогийн зохион байгуулалт дор ОБЕГ/ОНОБГ аль цэг хүртэл хариу арга хэмжээ авах, орон нутгийн засаг захиргаа, салбарын яамд аль цэгээс эхлэн сэргээн

босгох ажиллагааг эхлүүлэх ёстой гэдэг дээр эргэлзээтэй байна.

Гал унтраах, эрэн хайх, аврах ажиллагааны хүний нөөцийн чадавхыг чигүүрэг, хариуцлагаар тодорхой зааглан тусад нь бэлтгэдэг. Гэвч газар дээрх нөхцөл байдал эдгээр чадавхыг хосолсон хэлбэрээр эзэмшсэн байхыг шаардаж байна. Жишээ нь: Гал сөнөөгчид өөрийн ажил, гүйцэтгэх үүргээс давж амь нас аврахыг зөвшөөрдөггүй/бэлтгэгдээгүй байдаг. Эрэн хайх, аврах ажиллагааг явуулах шаардлагатай байхад зөвхөн гал сөнөөгчийн нөөц бэлэн байх тохиолдлууд байдаг.

ОБЕГ/ОНОБГ өөрийн чадавхыг үнэлэх

2023 оны 12 дугаар сард ОБЕГ, ОНОБГ-ын албан хаагчдын чадавхын шуурхай үнэлгээг хийсэн. Нийт 80 ахлагч, түрүүч, офицер (эмэгтэй 13, эрэгтэй 67) хамрагдсан.

Судалгааны үр дүн нь гамшиг, уур амьсгалын эрсдэлийг бууруулах, удирдахтай холбоотой шаардлагатай мэдлэг, чадараа ашиглах итгэх итгэлийн хэмжээг үзүүлсэн болно. Энэхүү судалгааг зөвхөн хувь хүмүүсийн ойлголтод тулгуурлан авсан бөгөөд тэдний мэдлэгийг бодитойгоор үнэлэх, шалгах зорилгогүй гэдгийг анхаарна уу. Нийт судалгааны дүнг энэ тайлангийн Хавсралт хэсгээс харах боломжтой. Энэ хэсэгт зарим онцлох зүйлсийг тэмдэглэн харуулсан болно.

Судалгаанд хамрагдагсдын 30 орчим хувь нь онцгой байдлын болон гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд үүрэг, хариуцлага хүлээдэг гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын 16% нь өөрсдийгөө эрсдэлийг бууруулах арга хэмжээ, гамшгийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн нэг хэсэгт хамрагддаг гэж, 15 орчим хувь нь гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх үүрэгтэй гэж хариулсан байна.

Судалгаанд оролцогчид ерөнхийдөө ган, зуд, цаг агаарын эрс тэс үзэгдэл, ой, хээрийн

түймэр, хот суурин газрын түймэр, хүн, малын халдварт өвчин зэрэг байгалийн төрөл бүрийн аюулын талаарх хязгаарлагдмал мэдлэгтэйг харуулсан. Үерийн аюулын хувьд судалгаанд оролцогчдын 67% нь "сайн" мэдлэгтэй гэж хариулжээ. Гэвч газар хөдлөлтийн аюулын талаарх мэдлэгийг сайжруулах шаардлагатай байгаа нь илт байсан буюу 58% нь газар хөдлөлтийн талаарх мэдлэг муу гэж хариулсан.

Удирдлагын түвшний албан тушаалтнууд хууль тогтоомжийн мэдлэгтэй байгаа боловч Онцгой байдлын үед ажиллах, гамшгийн дараах сэргээн босголт, сэргээн засварлах ажлыг зохицуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг удирдан чиглүүлэх зэрэг үйл ажиллагааны чадавхтай холбоотой сайжруулалт хийх шаардлагатай байна.

Тодорхой чиг үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн чадавхын түвшнийг ойлгох нь нэн чухал боловч ОБЕГ/ОНОБГ-ын гамшгийн эрсдэлийн удирдлагын мөчлөгийн - бууруулах/урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх үед тухайн чиг үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд шаардагдах чадавхыг тодорхойлох шаардлагатай байна.

3.5.3 Зөвлөмж

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Эрсдэлийн үнэлгээнд эрсдэлт бүлгийн хүн ам (хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхдүүд)-ын оролцоог хангах зорилгоор эрсдэлийн үнэлгээний удирдамж, зааварт тусгаж, шинэчлэх; байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний удирдамжийг оновчтой болгохын тулд болзошгүй давхардлыг арилгах.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
ОБЕГ-ын болон орон нутгийн ОБГ-ын бие бүрэлдэхүүн хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд, түүнчлэн чадавх сайжруулах цаашдын хөтөлбөрүүдэд жишиг болгох үүднээс чиг үүргүүдийн хүрээнд шаардагдах үндсэн гол мэдлэг, ур чадваруудыг тодорхойлох	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Онцгой байдлын сургуулийн сургалтын хөтөлбөрт онцгой байдлын удирдлагын модулиас гадна гамшгийн эрсдэлийг бууруулах зайлшгүй шаардлагатай зүйлсийг нэгтгэн бэхжүүлэх. Энэ сургалт нь ОБЕГ-аас албан хаагчдаас гадна бусад хүмүүст нээлттэй байж, орон нутгийн засаг захиргаа, салбарын яам, газруудаас гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгтэй, өргөн хүрээний төрийн албан хаагчдыг бэлтгэхэд хувь нэмэр оруулах учиртай. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн гишүүд, төрийн болон орон нутгийн гамшгаас хамгаалах албаны гишүүдэд зориулсан гарын авлагыг ашиглах (2023 он, төсөл)	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Дотоодын сургалтын хөтөлбөрийг бэхжүүлэхийн тулд дотоодын бусад боловсролын байгууллагууд, бусад улс орны төрийн албан тушаалтнуудад зориулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтын институт/курсүүдтэй түншлэл тогтоох.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

Эрт сэрэмжлүүлгийн үр дүнтэй системүүд - сэрэмжлүүлгээс эрт арга хэмжээ авах хүртэл

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Сэрэмжлүүлэх мэдээллийг төрийн байгууллага, иргэдийн аль алиных нь бэлэн байдалтай уялдуулахын тулд системийн хэмжээний үйл ажиллагааны журам, протоколуудыг бий болгох. Хянах, ажиглах, таамаглах, сэрэмжлүүлэх мэдээллийг түгээх нь эрт зарлан мэдээлэх систем буюу “хүн амд шууд хүрэх” эрт зарлан мэдээлэх системийн нэг хэсэг юм	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Сайжруулах шаардлагатай газруудыг тодорхойлохын тулд сүүлийн үеийн томоохон гамшгийн тохиолдолд (жишээлбэл, 2023 оны зуд, энэ зун болсон үер) тулгуурлан хэрэгжүүлж буй эрт сэрэмжлүүлэх системийн үр нөлөөг хянан үзэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Гамшгийн төрөл бүрд салбараар ангилсан хариу арга хэмжээ авах/сэргийлэх үйл ажиллагааны механизмыг тусгасан удирдамжийг боловсруулах замаар үйл ажиллагааны журмыг дахин шинэчлэх (жишээ нь төрийн болон хувийн хэвшлийн бүх гол байгууллага, иргэдийг хамарсан үерийн хариу арга хэмжээний гарын авлага). Ингэхдээ гарын авлагын хүртээмжийг хэсэг хэсгээр нь ангилсан хайлтын функц, тусдаа хуудасны тусламжтайгаар сайжруулж, бодит нөхцөл байдалд лавлагаа болохуйц гарын авлагыг хүссэн үедээ хурдан ашиглах боломж бүрдүүлэх.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Томоохон гамшиг бүрийн дараа эрт сэрэмжлүүлэх системийн үйл ажиллагааны журам, гарын авлагыг хянаж, шинэчлэх ажлыг зохион байгуулах журам гаргах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Иргэний байгууллага, нийт иргэд үйл ажиллагааны удирдамжийг авах нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх (жишээ нь сургалтын хөтөлбөрийг тогтмол зохион байгуулах, гадаа цахим самбар ажиллуулахдаа гамшгийн үед хариу арга хэмжээ авах зааварчилгааг үзүүлэхийг шаардах, гамшигтай холбоотой кино, жүжиг, хошин шогийн зурагтай ном гаргахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох гэх мэт).	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

Хор уршгийг арилгах, сэргээн босгох бэлэн байдал

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
<p>ОБЕГ, орон нутгийн засаг захиргаа, салбарын яамд гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанаас сэргээн босгох ажиллагаанд шилжихэд шаардлагатай үйл ажиллагааны журам, үүрэг хариуцлагыг тодорхойлох. Хүмүүнлэгийн ажиллагааны үндсэн стандарт SPHERE, түргэвчилсэн эхний үнэлгээ (IRA), салбар хоорондын түргэвчилсэн эхний үнэлгээ (MIRA), гамшгийн дараах хэрэгцээний үнэлгээ (PDNA), гамшгийн дараах сэргээн босгох ажиллагаа (DRF) зэрэг олон улсын стандарт, арга зүйг судлах</p>	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
<p>Бүх нисэх онгоцны буудал, хил гаалийн боомтын захиргаа дээр хүмүүнлэгийн тусламжийн төвүүдийг байгуулж, тэдгээрийн чиг үүргийг цаг хугацааны явцад (гаалийн бүрдүүлэлт, агуулахын багтаамж) сайжруулан бэхжүүлэх.</p>	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Их төсөв
<p>Эрэн хайх, аврах, гал түймэр унтраах ажиллах хүчний чиг үүргийг хооронд нь уялдуулах. Жишээлбэл гал түймэртэй тэмцэх чиглэлээр бэлтгэгдсэн алба хаагчдыг аврах ажиллагааны бусад ур чадвартг тодорхой хэмжээгээр сургаж болно.</p>	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
<p>Хөгжлийн ололтыг тогтвортой байлгах, шинэ санаачилгын улмаас үүсэх гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг бүх хөгжлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, хяналтад тусгах.</p>	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
<p>Гамшгийн эрсдэлийн удирдлага/бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнийг хөгжлийн бүх төлөвлөгөө, бодлогод тусгах төрөл бүрийн чиглэлээр орон нутгаас үндэсний түвшин хүртэл сонгогдсон төлөөлөгчид, төрийн албан хаагчдын чадавхыг өргөн цар хүрээтэй нэмэгдүүлэх.</p>	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв



Зураг: Монгол Улс дахь НҮБ-ын ХХ

IV. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР – БАЙГАЛЬ ОРЧИН

Монгол Улсын эдийн засгийн салбар нь газарзүйн байршил, цаг агаарын онцлогтой шууд хамааралтай учраас уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн өртөмтгий орнуудын нэгд тооцогддог. Ус, ойн нөөц, бэлчээрийн талбай, биологийн төрөл зүйлд температур, хур тунадасны өөрчлөлт ихээхэн нөлөөлдөг. Ган, зуд, ой хээрийн түймэр, цасан шуурга, үер, хэт хүйтэн зэрэг нь улс орны хэмжээнд томоохон хэмжээний гамшигт тооцогдож байна. Эдгээр гамшгийн 81 орчим хувийг хүчтэй салхи, бороо, аянга цахилгаан эзэлж байна. Сүүлийн 20 жилийн хугацаанд байгалийн гамшгийн давтамж хоёр дахин нэмэгдсэн. Жилд учрах хохирлын хэмжээ дунджаар 50-70 тэрбум төгрөг байна. Энэ зууны дунд үе гэхэд малын хорогдол одоогийнхтой харьцуулахад 50 орчим хувиар өсөх төлөвтэй байгаа бол энэ зууны эцэс гэхэд хоёр дахин нэмэгдэх төлөвтэй байна.

Монгол Улс 1996 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцод нэгдэн орсон. 2010 онд Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталж, улмаар 2012 онд Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийг шинээр баталсан. 2020 онд Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (УЦУОСМХ)-ээс Монгол орны цөлжилтийн төлөв байдлыг үнэлэх үндэсний 5 дахь удаагийн судалгааг хийж, улс орны цөлжилтийн зураглал, атласыг шинэчилсэн. Энэ судалгаагаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь нь их, бага хэмжээгээр цөлжилтөд өртсөн байна. Үүнээс 4.7% нь маш их, 18.6% их, 22.1% дунд, 31.5% бага түвшинд байна. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын гаргасан сүүлийн тайланд газрын үр шим буурч, нийт газар нутгийн 8.9%-д нөлөөлсөн байна. Энэ бууралт гантай маш их холбоотой бөгөөд бэлчээрийн талбайн даац нэмэгдсэнээр нөхцөл байдал улам

даамжирсан байна. Байгууллагын болон засаглалын бүтцийн сул байдал, эдийн засгийн хүчин зүйлс, шинжлэх ухаан, мэдлэг мэдээлэл, технологи, соёлын нөлөө зэрэг нь улсын хэмжээнд газрын доройтлын шууд бус хүчин зүйл болж байна²³.

Монгол Улс хоёр том ойн биомын өлгий нутаг юм: хойд зүгийн нутгийн 14.2 сая га талбайг (87%) эзэлдэг голдуу шинэс, хус модноос бүрддэг тайган ой, өмнөд хэсгийн хуурай бүс нутагт 2.0 сая га (13%) талбайг эзэлдэг загийн ой. Загийн ойг үндэсний тодорхойлолтоор "ой" гэж үздэг. Хойд тайгын ой нь хойд талаараа Сибирийн тайга, өмнөд талаараа бэлчээрийн талбайн хоорондох шилжилтийн бүсэд оршдог бөгөөд ихэвчлэн далайн түвшнээс дээш 800-2500 метрийн өндөрт уулын энгэр хэсэгт оршино.

Монгол Улсын ой мод үр шим багатай, удаан ургадаг тул ган, түймэр, хортон шавжид өртөх байдал өндөр байдаг. Мөнх цэвдгийн хайлалт, ойн доройтол улам бүр нэмэгдсээр байна. Энэ нь ойн эзлэх талбай зохих хэмжээгээр буурахад хүргэж болзошгүй юм. Ой мод ихээхэн хэмжээгээр сүйдсэнээр экологийн тэнцвэрт байдлыг сэргээх, байгалийн нөхөн ургах хурд бага байдаг. Энэ нь нэг талаараа манай улс дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын эх газрын эрс тэс уур амьсгалд байрладагтай холбоотой бөгөөд ургамлын өсөлтийн хурд, хөрсний чийгийн агууламжийг хязгаарладаг.

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 0,4%-ийг буюу 660.9 мянган га талбайг ус бүхий талбай эзэлдэг. Үүний 221.3 мянган га талбай буюу усны нөөцийн 33.5%-ийг гол, горхи, 423.8 мянган га буюу 64.1%-ийг нуур, цөөрөм, 13,2 мянган га талбай буюу 0.2%-ийг булаг, шанд, 2.6 мянган га талбай буюу 0.4%-ийг мөнх цас, мөсөн голууд тус тус эзэлдэг байна.

Нуур, цөөрөм нийт усны талбайн 423.8 мянган га буюу 64.1 хувийг эзэлдэг. Гол горхи, булаг шанд 13,2 мянган га талбайг эзэлдэг нь усны нөөцийн 2,0%-ийг бүрдүүлдэг бол байнгын цас, мөсөн голууд 2,6 мянган га буюу усны нөөцийн 0,4%-ийг эзэлдэг байна.

Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн хоёр дахь удаагийн үнэлгээний тайланд (2014 он) мэдээлснээр 1999-2012 онд ой хээрийн түймэрт өртсөн газар нутгийн хэмжээ өмнөх жилүүдийнхээс 64 мянган га буюу 13.3 хувиар нэмэгдсэн байна.

Газарзүйн болон цаг уурын өвөрмөц нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын байгаль орчны салбар уур амьсгалын өөрчлөлтийн улмаас ихээхэн сорилттой тулгарч байна. Уур амьсгалын өөрчлөлтөд өртөх, эмзэг байдал бүхий гол асуудлыг багтаасан тайлбарыг харуулав. Үүнд:

- **Мөнх цэвдэг ба мөсөн голын хайлалт.** Монгол орны хувьд мөнх цэвдэг, мөсөн гол хайлж байгаа нь нэн чухал асуудал юм. Энэ үзэгдэл нь гадаргын усны хомсдол, хөрс, бэлчээрийн даацын доройтолд хүргэж байна. Мөнх цэвдэг хайлснаар уулын экосистем, ой мод, биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэхүү үүсэж буй нөхцөл байдал нь мөнх цэвдэгтэй холбоотой генетикийн өвөрмөц нөөцийг хадгалах, хариу арга хэмжээ авах хүрээнд судалгаа хийх шаардлагатайг харуулж байна. Түүнчлэн мөнх цэвдэг хайлж байгаа нь замын дэд бүтцийг сүйтгэж, зам засварын арчлалт, зардлыг ихээхэн нэмэгдүүлдэг.
- **Усны хомсдол.** Монгол Улсын усны нөөц маш хүнд байдалд байгаа бөгөөд тус асуудлыг хянахын тулд ус судлалын томоохон сүлжээг ажиллуулдаг. Сүүлийн 70 жилийн хугацаанд мөсөн голуудын хэмжээ эрс багассан бөгөөд 2003-2020 оны хугацаанд Потанины мөсөн гол өндөрлөгийн олон түвшинд багассан байна. Мөсөн голын ийнхүү багасаж байгаа нь Арктикийн цас, мөсний бүрхэвч багасах үзэгдлийн нэг хэсэг бөгөөд энэ нь өндөр уулархаг нутгийн хөрсний чийгийн горим, цэнгэг усны эх үүсвэрт нөлөөлдөг.

Мөнх цэвдгийн талбай 1971 онд нийт нутаг дэвсгэрийн 63% байсан бол 2016 он гэхэд 29.3% хүртэл буурчээ.

- **Ойн доройтол.** Хүний буруутай үйл ажиллагаанаас гадна уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй агаарын болон хөрсний температурын өсөлт, удаан үргэлжилсэн ган зэрэгтэй холбоотой ой, хээрийн түймэр ихсэж байгаа нь Монгол орны ойн бүс нутагт аюул заналхийлж байна. Эдгээр өөрчлөлтөөс үүдэн ойн үл мэдэгдэх өвчлөл, хортон шавж, мэрэгч амьтдын тархалт, түймэр давтамж, эрчим нэмэгдэж байгаа нь ойн доройтол хурдсаж байгааг харуулж байна. Ой хээрийн түймэр давтамж болон эрчим нэмэгдэж байгаа нь ойн доройтол хурдсаж байгааг харуулж байна. Ой мод нүүрстөрөгчийн нэн чухал шингээгч бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чухал ач холбогдолтой юм.
- **Ган, цөлжилт, бэлчээрийн даацын доройтол.** Монгол Улсад ган гачиг, хуурайшилт улам нэмэгдэж байгаа нь цөлжилт, газрын доройтолд нөлөөлж байна. Нийт нутаг дэвсгэрийн нэлээд хэсэг нь доройтолд өртөж байгаа бөгөөд бэлчээрийн талбайд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ нь ургамлын өсөлт, ургацын бууралт, үндэс системийг сулруулж, хөрс, бэлчээрийн даацын доройтлыг улам нэмэгдүүлэхээс гадна ойт хээр, хээрийн бүс нутагт бэлчээрийн талбайн даац хэтрэх, хөрс, ургамлын үржил шимийг цаашид бууруулахад нөлөөлж буй гол хүчин зүйл юм.

Дүгнэж хэлэхэд уур амьсгалын өөрчлөлт нь Монгол Улсын мөнх цэвдэг, усны нөөц, ой мод, бэлчээрийн талбай зэрэгт ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгаа нь манай орны байгаль орчны салбарын өртөх байдал өндөр байгааг харуулж байна. Энэхүү нөхцөл байдал нь байгалийн экосистемд заналхийлээд зогсохгүй улсын нийгэм, эдийн засагт илүү өргөн хүрээний нөлөө үзүүлж байна. Тиймээс эдгээр өөрчлөлтийг сааруулах, дасан зохицохын тулд яаралтай, иж бүрэн арга хэмжээ авах шаардлага тулгарч байна.

4.1 Засаглал

4.1.1 Давуу тал

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг шууд тусгаагүй хэдий ч хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар тусгасан бөгөөд байгаль орчны байцаагчид нөхөн төлбөрийн үнэ хэмжээг үнэлж, тогтоодог.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлд байгалийн гамшиг тохиолдсон газар нутагт урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, байгаль орчныг засаж сайжруулах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг холбогдох төрийн байгууллагууд хамтран авч хэрэгжүүлэх талаар тусгасан. Мөн байгалийн гамшиг, гэнэтийн аюулын хор уршгийг арилгах зардлыг улсын төсвөөс гаргаж, учруулсан хор уршгийг тогтоосны дараа түүнийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ гэж заасан. Мөн хуулийн 23 дугаар зүйлд байгалийн гамшиг, онц байдлын үед засгийн газар хэрхэн хариу арга хэмжээ авах, онц байдал зарласан бүс нутагт хохирлыг бууруулах, байгаль орчныг хамгаалахад анхаарч ажиллах талаар дэлгэрэнгүй тусгасан бөгөөд дээрх үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, онц байдлын тухай холбогдох хууль, журам, дүрэмд нийцсэн байх ёстой.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-ний тухай хуулийн 2012 оны шинэчилсэн найруулга нь байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулах зорилготой юм. Тус хуулийн 3.1.3 дахь заалтад тодорхойлсон "Байгаль орчны стратегийн үнэлгээ"-г улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд

баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюултай уялдуулан тодорхойлох гэж заасан.

"Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам", "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-ыг Засгийн газрын 2023 оны 02 дугаар сард 58 дугаар тогтоолоор баталсан бөгөөд тус журамд бодлого, хөтөлбөр боловсруулах явцад стратегийн үнэлгээ хийж, тайлангаа ирүүлэхийг салбарын яамдад үүрэг болгосон. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний танилцуулсан дүгнэлтээр шинжээчдийн зөвлөл тайланд үнэлгээ хийнэ.

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хуульд:

- Засгийн газар нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг сайжруулахын тулд ус цаг уур, байгаль орчин, цаг уурын нөөц боломжийн мэдээллийг ашиглах үндсэн үүрэгтэй. Энэ мэдээллийг ашиглах нь мөн байгаль орчны аюул, бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилготой.
- БОАЖЯ нь өгөгдөл мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх зорилгоор Ус цаг уур, байгаль орчны хяналт-шинжилгээтэй холбоотой үндэсний бодлогыг боловсруулж, бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, үндэсний сүлжээг удирдах, бодлого, хөтөлбөрийг баталдаг. Мөн цаг агаарт нөлөөлөх үйл ажиллагааг урьдчилан таамаглах, мэдээлэл түгээх, хянах эрх мэдэлтэй.
- Цаг уур, орчны шинжилгээний газар болон Бохирдлын хяналт нь ус цаг уурын болон байгаль орчны мэдээллийг цаг тухайд өгч, сэрэмжлүүлж, бохирдлын асуудлыг шийдвэрлэдэг.

Аймаг, сумын Засаг дарга нь мэдээлэл түгээх, аюул ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, гамшгийн хохирлыг тооцох, холбогдох дүрэм журмыг шинэчлэн боловсруулах, тэдгээрийг үндэсний хэмжээнд тайлагнах үүрэгтэй.

2011 онд батлагдсан Уурамьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УАӨҮҮА)-т уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үйл ажиллагааг хамтад нь багтаасан. Хөтөлбөрийн эхний үе шатад (2011-2016 он) хууль эрх зүйн болон зохион байгуулалтын тогтолцоо, чадавхыг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулсан. Хоёр дахь үе шатад (2017-2021 он) уур амьсгалын нөлөөллийг сааруулах, дасан зохицох арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлсэн. Гэсэн хэдий ч үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр нөлөөг үнэлэх үнэлгээ хийгдээгүй байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хуулийн этгээд нь жилийн төсөв эсвэл үйлдвэрлэл/үйлчилгээний зардлынхаа тодорхой хувийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд хуваарилах үүрэгтэй. Гэсэн хэдий ч дээрх төсвийн хуваарилалтад хатуу хяналт тавихгүй байна.

Газрын тухай хуулиар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар өмчлөл, ашиглалт, түүнтэй холбоотой асуудлыг зохицуулж, хүний эрүүл мэнд, байгаль, үндэсний аюулгүй байдал, экологийн тэнцвэрт байдалд хохирол учруулах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх асуудлыг зохицуулдаг. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлого хэрэгжүүлэх, газар, кадастрын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг зохицуулах, газар зохион байгуулалтын санхүүжилтэд хяналт тавих үүрэгтэй. Байгаль орчны байгууллага нь газар ашиглалт, элэгдлээс хамгаалах, цөлжилтийг бууруулах талаар зааварчилгаа боловсруулдаг. Орон нутгийн төрийн байгууллагууд, тэр дундаа Иргэдийн төлөөлөгчдийн хурал, бүх шатны Засаг дарга нар хууль тогтоомжид хяналт тавих, менежментийн төлөвлөгөө батлах,

зөрчлийг арилгахын зэрэгцээ газрыг үр ашигтай ашиглуулах үүрэг гүйцэтгэдэг.

Аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нар газар, нөөц баялгийг холбогдох хууль, гэрээ хэлэлцээрийн дагуу үр ашигтай ашиглах, хамгаалах, зөрчлийг арилгах, хууль сахиулах үүрэгтэй. Гэвч газар ашиглалтын төлөвлөгөөнд ерөнхий заавраас өөрөөр уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгаас урьдчилан сэргийлэх талаар тусгайлсан заалт байхгүй. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тодорхой арга хэмжээ хязгаарлагдмал боловч гамшгаас урьдчилан сэргийлэх ерөнхий заавар, газрыг нөхөн сэргээх үүрэг хариуцлагыг тогтоосон. Үндэсний газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд экологи, эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан Монгол Улсын хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлсон. Газар ашиглагч нь үйл ажиллагааныхаа улмаас элэгдсэн газрыг нөхөн сэргээх үүрэгтэй бөгөөд тухайн газарт учирсан хохирлыг хариуцагч этгээдийн зардлаар нөхөн сэргээж, газрын бүрэн бүтэн байдлыг хадгалах, хамгаалах үүргийг бататгасан хуультай.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ГОУХАН-тэй хамтран Уур амьсгалын тухай хуулийг боловсруулах ажилд идэвхтэй оролцож байна. Энэ санаачилга нь нүүрстөрөгчийн ялгарлыг хянах, бууруулах арга хэмжээг авах, дасан зохицох үйл ажиллагааг тохируулах замаар нүүрстөрөгчийн хий ихээр ялгаруулдаг салбаруудын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэгддэг. Түүнчлэн уг хууль тогтоомжид үндэсний хүлэмжийн хийн (ҮХХ) тооллого, тайлангийн ил тод байдал, нүүрстөрөгчийн хийн бүртгэлийг хийх, нүүрстөрөгчийн үнэ тогтоох, нүүрстөрөгчийн зээлд хамрагдах төслүүдийг тодорхойлох, эдгээр зээлийн өмчлөлийн талаарх Уур амьсгалын үндэсний хорооны (УАҮХ) үүрэг, хариуцлагыг тодорхойлно. Цаашлаад уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийх, дасан зохицох үйл ажиллагааг удирдан чиглүүлэх зохицуулалтыг хийнэ.

4.1.2 Хүндрэл, бэрхшээл

Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн талаар хэрэгжиж байгаа хууль тогтоомж байхгүй бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг тодорхойлж, хууль тогтоомжийн хүрээнд эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээний аргуудыг тусгаагүй байна. Хөгжлийн бодлого төлөвлөлт, удирдлагын тухай хууль тогтоомжид нийцүүлэн үндэсний хөтөлбөрүүдийг цуцалсан ч Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Үндэсний хөтөлбөрт (УАӨЭҮХ) салбар яамдын үүрэг, хариуцлагыг тодорхойлж тусгасан хэвээр байна. “Алсын хараа 2050” урт хугацааны бодлого нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, уур амьсгалын эрсдэлийн даатгалын тогтолцоог судлах мөн эрт сэрэмжлүүлэх, гамшгийн менежментийн чадавхыг нэмэгдүүлэх зорилготой юм. Гэсэн ч эрсдэл, эмзэг байдлыг үнэлэх арга зүй түүнчлэн дасан зохицох стратегийг хэрэгжүүлэх заавар, дүрэм журам дутмаг байгаа нь одоогийн хэрэгжиж байгаа хууль тогтоомж, менежментийн төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн үр нөлөөнд эргэлзээ төрүүлж байна.

Үүний үр дүнд яам тус бүр бие даасан бодлого, дүрэм, журам боловсруулснаар Газрын тухай хууль болон бусад байгалийн нөөц ашиглалтын хууль тогтоомжийн хооронд уялдаа холбоогүй байдал ажиглагдаж байна. Газар ашиглах, төрийн газар эзэмших эрх, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглахад ард иргэд, малчид, аж ахуйн нэгжүүдийн үүрэг, хариуцлагын хооронд тодорхой уялдаа холбоо дутагдаж байна.

УАӨДЗ дахь үүрэг хариуцлагын тодорхойгүй байдал нь хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, шинжлэх ухааны салбарт байгууллагын түүхэн мэдээллийн санг хадгалах үйл явцад

чухал үүрэгтэй байдаг. Энэ асуудал нь үүрэг, хариуцлагын хуваагдлаас үүдэлтэй бөгөөд Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ) газрыг ашиглах бодлогыг хариуцаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) байгалийн нөөцийн удирдлагын бодлогыг хянаж байна. Боломжит, төлөвлөгдсөн усны нөөц, газар болон нийт экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах маш чухал.

Мөн Бэлчээрийн хэрэглэгчийн гэрээ (БХГ)-ний дагуу малын тоо толгойг бууруулах хэмжээг бэлчээрийн даацын дагуу бодитойгоор тооцох чухал байна. Энэхүү стратеги нь малчдын орлогыг хамгаалж, нийгмийн болон жендерийн тэгш байдлын зарчмыг дээдлэн хүндлэх ёстой. Энэ санаачилгыг үр дүнтэй удирдан чиглүүлэх, дэмжихийн тулд нарийн бөгөөд хатуу бодлогын тогтолцоо шаардлагатай.

Салбар тус бүрийн бодлого, хууль тогтоомж, байгууллагын тогтолцоонд байгаа хуваагдмал байдал нь нэгдмэл байдалд сөрөг нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Энэхүү хүндрэл, бэрхшээл нь үр дүнтэй шийдвэр гаргах, бодлого хэрэгжүүлэхэд саад болж, илүү нэгдмэл, уялдаа холбоотой арга барил шаардлагатайг харуулж байна. Өргөн уудам нутаг дэвсгэртэй учраас Монгол Улсын Засгийн газар нь ойн салбарын бодлого, хууль тогтоомжийг олон нийтийн дунд үр дүнтэй хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй тулгардаг. “Тэрбум мод” аян ойн засаглалд хямд өртөгтэй, өндөр үр өгөөжтэй, шинэлэг арга барилыг судлах боломжийг олгож байна. Ойн нөөцөд хяналт тавих, хууль бусаар мод бэлтгэх, ой хээрийн түймэр гарсан тохиолдлыг мэдээлэхэд орон нутгийн иргэдийн оролцоог дэмжих зохицуулалтыг бэхжүүлэх шаардлагатай байна.

4.1.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ажиллагаанд оролцогч байгууллагуудын хүрээнд үүрэг, хариуцлагыг тодорхой болгох	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Нийгэм, эрүүл мэнд, боловсрол зэрэг бүх салбарын үндэсний болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээний үр дүнг тусгах	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Тогтвортой хөгжлийн зорилтын дагуу улс орны уур амьсгалын өөрчлөлтийн үүрэгтэй нийцэж буй бодлого, төлөвлөгөөний уялдаа холбоог сайжруулах.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Усны эх үүсвэрийг хамгаалах, түүнийг сайжруулах тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлэх. Малын тоо толгойг бэлчээрийн талбайн даацтай уялдуулан зохицуулах Экосистемийн үйлчилгээний төлбөрийн механизмыг орон нутагт хэрэгжүүлэх.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үзэл баримтлалыг дахин сэргээж, шинэчлэх. Үүнд “Алсын хараа 2050” зэрэг үндэсний хэмжээний бодлогын баримт бичигтэй уялдуулан Байгаль орчны стратегийн үнэлгээ хийх шаардлагатай. Үүний зэрэгцээ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийдэг дотоодын мэргэжлийн компаниудын чадавхыг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулах.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв

4.2 Хэрэгжилт

4.2.1 Давуу тал

Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан төрийн байгууллага ба уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагаа, төслүүдийн зохицуулалтыг хянадаг. Үүнд харилцан уялдаа холбоог арилгах, давхардлаас зайлсхийх, уур амьсгалд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах, байгалийн нөөцийн менежментийн төлөвлөлт зэрэг иж бүрэн үйл ажиллагаа орно. БОАЖЯ-ны дотоод зохицуулалт нь газрын дарга нар үйл ажиллагаагаа уялдуулан хэлэлцдэг Сайдын зөвлөлийн хурлаар явагддаг. Гэсэн хэдий ч яамны хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг зохицуулах тодорхой механизм байдаггүй.

Ой мод, Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН), гол мөрний сав газар, биологийн олон янз байдлын менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд боловсруулах үүрэгтэй. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) нь байгаль орчны хохирлоос урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг ой, хээрийн түймэр, ялангуяа хуурайшилтын үед онцгой анхаарч, Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)-тай хамтран гал түймэртэй тэмцэх ажлыг зохион байгуулдаг.

2011 онд Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөрөөс (УАӨҮХ) уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагаар Уур амьсгалын үндэсний хороог (УАҮХ) томилсон. Тухайн үеийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ахлуулсан УАҮХ нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, салбарын нэгдмэл байдлыг хангах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, оролцогч талуудад чиглэл өгч, хяналт тавьж ажиллахыг үүрэг болгожээ.

Уур амьсгалын үндэсний хороонд уур амьсгалтай холбоотой асуудал, шийдвэрлэх арга замын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөгөө өгөх зорилгоор 2021 онд УАҮХ-ны шийдвэрээр УАҮХ-ны мэргэжлийн зөвлөлийг байгуулсан. Эдгээр зөвлөлийн бүрэлдэхүүн, чиг үүргийг мөн сайдын шийдвэрээр баталсан. Зөвлөл нь төрийн болон төрийн бус, эрдэм шинжилгээний, боловсролын байгууллагуудын уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр мэдлэг, туршлагатай мэргэжилтэн, шинжээчдээс бүрдэнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах бодлого, чиглэлтэй холбоотой асуудалд Зөвлөл болон УАҮХ-ны байнгын чиг үүрэг байхгүй.

2002 оноос өмнө Газар ашиглалтын газар нь Байгаль орчны яамны харьяанд байсан ч бие даасан байгууллага болж, газар ашиглалтын бүртгэл, кадастрын судалгаа болон газар төлөвлөлтийг аймгийн хэмжээнд зохион байгуулж бие даасан байгууллага болсон. Гэвч Газар ашиглалтын газар нөхөн сэргээх үйл ажиллагаанд анхаарлаа хандуулах нь бага байсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны газар нөхөн сэргээхтэй холбоотой тодорхой үүрэг хариуцлага нь цөлжилтийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой байдаг.

Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн үндэсний хороо (УАӨЦҮХ)-г байгуулж, Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 333 дугаар тогтоолоор баталсан. УАӨЦҮХ-г Ерөнхий сайд тэргүүлж, салбар хоорондын уялдааг хөнгөвчлөх зорилготой бөгөөд цөлжилтийг сааруулах, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр улирал бүр хуралддаг.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь бүх аймагт үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн захиргааны нэгж бөгөөд мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан. Голын сав газрын захиргааг бүх 29 голын сав газарт байгуулсан.

Байгаль хамгаалагчид Тусгай хамгаалалттай газар нутаг, сумдын захиргааны удирдлага доор ажилладаг. Түүнчлэн сайн дурын байгаль хамгаалагчид Экологийн бодлогын хэлтэстэй хамтран гэрээгээр ажилладаг. Бэлчээрийн талбайн менежментийн Бэлчээр ашиглагчдын бүлэг, Ойн менежментийн ойн ашиглагчдын бүлэг, Олон нийтэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн бүлгүүд зэрэг олон

4.2.2 Хүндрэл, бэрхшээл

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой санаачилгад үндэсний, орон нутгийн оролцогч талуудын хооронд сайтар уялдаа холбоо байхгүй нь засгийн газрын чадавх хязгаарлагдмал, янз бүрийн салбаруудын үүрэг, хариуцлага тодорхой бус байдагтай холбоотой юм. Ихэнхдээ уур амьсгалын өөрчлөлтийг зөвхөн Байгаль орчны яамны үүрэг гэж үздэг. Энэ ойлголт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийн менежментийг салбарын бодлого, төлөвлөлтөд үр дүнтэй тусгахад саад тотгор болдог.

Одоогийн байдлаар Уур амьсгалын өөрчлөлтийн (УАӨ) асуудлаар яамдын хооронд тогтмол уялдаа холбоо байхгүй байна. Өдөр тутмын үйл ажиллагаанд салбар хоорондын уялдаа холбоог хангах цаг хугацаа хязгаарлагдмал, төрийн албан хаагчдын халаа сэлгээ их, чадавх бага байгаа зэрэг нь эдгээр хүчин чармайлтад саад учруулж байна. Түүнчлэн Стратегийн төлөвлөлт, Уур амьсгалын өөрчлөлтийн газрын албан хаагчдын тоо уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН)-ийн зорилтыг хэрэгжүүлэх салбар хоорондын үр дүнтэй уялдаа холбоог хангахад хангалтгүй байна.

Засгийн газрын бүтэц ойр ойрхон өөрчлөгдөх нь байгалийн нэн чухал нөөц, ялангуяа ус, ой модыг зохисгүй удирдахад хүргэсэн. 2000 оноос хойш эдгээр нөөцийг хариуцдаг агентлагийн бүтцэд олон өөрчлөлт орсон байна. Шинээр байгуулагдсан байгууллагууд төрийн албан хаагчид бага цалин олгох, хөдөлмөрийн нөхцөл хүнд зэргээс шалтгаалан албан хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллуулахад

нийтийн санаачилгыг байгалийн нөөцийг хамгаалах зорилгоор байгуулсан.

2020 оны 01 дүгээр сард Засгийн газраас Экологийн цагдаагийн албыг байгуулснаар бүтэц зохион байгуулалтад томоохон өөрчлөлт орсон. Нийслэл хотод хэлтэс байгуулж, орон нутгийн төлөөлөгчдийг сонгон шалгаруулж, чадавхыг нь дээшлүүлэхээр ажиллаж байна.

бэрхшээлтэй тулгардаг. Мөн нэн чухал нөөц баялгийн шинэчилсэн зохицуулалтын тогтолцоог бий болгох сорилттой эдгээр байгууллагууд тулгарч байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй усны салбарын эмзэг байдлыг энэ сорилт улам бүр хүндрүүлж байна.

Одоогийн байдлаар БОАЖЯ-д цөлжилттэй холбоотой асуудалд хариуцсан боловсон хүчин дутмаг байгаа ба зөвхөн нэг мэргэжилтэн томилогдон ажиллаж байна. Цөлжилт нь мал тоо толгой нэмэгдэж байгаатай нягт уялдаа холбоотой бөгөөд бэлчээрийн даац ашиглалтыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны чиг үүрэгт хамаарч байна. Малын тоо толгойг зохицуулах зорилгоор Төсвийн тухай хуулиар малын татвар ногдуулж 12 үйл ажиллагааг санхүүжүүлсэн боловч үр дүнд хүрээгүй. Малчид ган, зуд, бэлчээрийн даацын хомсдол зэрэг хүндрэлтэй тулгарч байгаа хэдий ч малын тоо толгойг бууруулахад татварын хэмжээ (0- 2500 төгрөг) түлхэц болж чадахгүй байна.

Монгол Улсын үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрт Байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ) тусгагдаагүй байна. Монгол Улсын Их Хурал Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг баталснаас хойш үндэсний бодлогын дунд хугацааны хөтөлбөрүүдийг долоон зорилтот хүрээнд нэгтгэсэн боловч БОСҮ-ний хэрэгжилт шинэчилсэн бодлогын баримт бичигт тодорхойгүй хэвээр байна. Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний (БОНУ) журамд гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх заалт хангалттай тусгагдаагүй байна.

Хэдийгээр тус журмын хүрээнд эдийн засгийн үйл ажиллагааны экологид үзүүлэх нөлөөллийг тооцдог ч уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг шийдвэрлэхэд хангалтгүй байсаар байна. Нэмж дурдахад эл журамд хууль тогтоомж хоорондын ойлгомжгүй зөрчил оршсоор байна.

Хэдийгээр голын сав газрын менежмент (ГСГМ) Монгол Улсад харьцангуй шинээр гарч ирсэн ч зөвхөн 29 голын сав газрын төлөвлөгөөг боловсруулсан. Гэсэн ч усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа, ус, хэрэглэгчид хоорондын зөрчилдөөн, захиргааны албан хаагчдын хязгаарлагдмал нөөц боломж зэргээс шалтгаалан эдгээр ГСГМ төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Төлөвлөгөөнд голын сав газрын эрх баригчдад (ГСГЭБ) зориулсан тодорхой удирдамжийг боловсруулж өгөөгүй бөгөөд усны салбарт чиглэсэн дасан зохицох шаардлагатай тодорхой өртөмтгий бүс нутгийг тодорхойлж чадахгүй байна. Төлөвлөгөөний нарийвчилсан мэдээлэл болон газар, ус ашиглалтын хүрээ/зохицуулалт дутмаг байгаа нь тэдгээрийг амжилттай хэрэгжүүлэхэд саад болдог.

Аймгуудын хэмжээнд ойг гал түймэр, хууль бус мод бэлтгэлээс хамгаалах үүрэг бүхий Ойн Ашиглагчдын бүлгүүд (ОАБ) ажилладаг. Эдгээр бүлгийг олон улсын хандивлагчдын санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдээс дэмжлэг авах зорилгоор байгуулсан. Тэдэнд ой хамгаалах хүч хэрэгсэл мөн байгаль хамгаалах үйл ажиллагаанаасаа ашиг хүртэх урамшуулал дутмаг байдаг.

Гамшгийн эрсдэлийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр хууль тогтоомжийн хоорондын тодорхой бус зохицуулалтаас шалтгаалан

орон нутгийн засаг захиргааны албан хаагчид сүүлийн үеийн хууль тогтоомжийн өөрчлөлтийг дагаж мөрдөхийг хичээдэг. Энэ нь бодлого хэрэгжүүлэх, орон нутаг, тухайн байгууллагын асуудлыг шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна. Төв болон орон нутгийн засаг захиргаа хоорондын зохицуулалт дутмаг, агентлаг хоорондын хамтын ажиллагааны асуудал эдгээр бэрхшээлийг улам хурцатгаж, санхүүгийн хязгаарлалт нь орон нутгийн үр дүнтэй засаглалыг улам бүр доройтуулж байна.

Ой хээрийн түймрийн хариу арга хэмжээ ихэвчлэн урьдчилан сэргийлэх гэхээсээ илүү сэргээн босгох шинжтэй байдаг. Аймгийн Хөдөө аж ахуйн газрууд болон орон нутгийн Онцгой байдлын газар (ОНОБГ)-ууд хамтран 5-10 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байгаа ч үер усны аюул, малын өвчин, ган гачиг, мэрэгч амьтдаас байгаль, орчинд учруулж буй гамшиг ихсэж байна.

Сум хөгжүүлэх, ялангуяа дэд бүтэц, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа шинжлэх ухааны судалгаа гэхээсээ илүү олон нийтийн санал хүсэлтэд түлхүү тулгуурласан байдаг. Энэ хандлага нь ялангуяа бэлчээрийн даац, уурхайн бүс нутагт цаг агаарын эрс тэс уур амьсгал, газар ашиглалтын үзүүлэх нөлөөллийг үл тоомсорлон эрсдэлд илүү хүргэж байна. Аймгийн Газрын алба сумдын газрын менежер нарт тусалж байгаа ч тэдний чадавх хязгаарлагдмал хэвээр байна. Сумын төлөвлөлтийг боловсронгуй болгох, газар ашиглалт, захиргааны үндэсний мэдээллийн санд Газрын албанаас тавигдсан шаардлагыг хангахын тулд мэргэжлийн гэрчилгээтэй байгууллагуудыг татан оролцуулж байна.

4.2.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээний үр дүнг нийгэм, эрүүл мэнд, боловсрол зэрэг төрөл бүрийн салбарын үндэсний болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уяодуулах.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг голын сав газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал болон газар ашиглалтын төлөвлөгөөнд тус тус тусгах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр холбогдох бүх талуудын нөөцийг дайчилж, хүчин чармайлтыг нэгтгэн хууль сахиулах, бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Цаг уур, орчны шинжилгээний газар, Эдийн засгийн хөгжил, Сангийн яамдын нягт хамтын ажиллагааны хүрээнд уур амьсгалын өөрчлөлт, хөгжлийн зохицуулалтыг сайжруулах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд байгаль хамгаалагчдын эрх үүргийг нэмэгдүүлж, орон нутгийн Байгаль орчны газруудын зохицуулалтыг сайжруулах. Үүнд, орон нутгийн түвшинд хөдөө аж ахуй, газар ашиглалт, дэд бүтэц зэрэг салбаруудын хамтын ажиллагааг сайжруулах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Бодлого, төлөвлөлтөөс бодит хэрэгжилтэд шилжих, ялангуяа орон нутгийн нөөцийг стратегийн хувьд дайчлан эмзэг бүлгүүдийг дэмжих.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай нягт хамтран газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, газрын доройтлын үндсэн шалтгааныг арилгахад анхаарах замаар газар нөхөн сэргээхэд чиглэсэн асуудалд Газар зохион байгуулалт, ашиглалтын байгууллагад дэмжлэг үзүүлэх. Ялангуяа бэлчээрийн талбайн даац хэтэрсэн үед малчдын байгууллага, хоршоод хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Усны газрын үйл ажиллагааг сайжруулахын тулд чадварлаг боловсон хүчин, мэргэжилтнүүдийг ажиллуулах, газар ашиглалтын байгууллагатай уялдаа холбоотой ажиллах, уялдаа холбоог хангах засаглалын бүтцийг боловсронгуй болгох.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв

4.3 Санхүүжилт

4.3.1 Давуу тал

БОАЖЯ, ялангуяа түүний Стратегийн төлөвлөлт, уур амьсгалын өөрчлөлтийн газар нь Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн, Гол мөрний сав газрын захиргаа (ГМСГЗ), ус хамгаалах арга хэмжээ, Ойн газар (ойн менежментийг гал түймэртэй тэмцэх арга хэмжээтэй уялдуулах), Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа зэрэг төрөл бүрийн байгууллагуудын төсөв, төлөвлөлтийг хариуцдаг ба техникийн хангамж, хөрөнгө оруулалтыг голчлон ГЗГӨХБ/УАӨДЗ болон Биологийн төрөл зүйлийг хамгаалах төслүүдээс авдаг

НҮББОХ-ын НУАС төслийн санхүүжилтээр Монгол Улсын дасан зохицох үндэсний төлөвлөгөөг боловсруулах ажил үргэлжилж байна. 2013 оны Технологийн хэрэгцээний үнэлгээний тайланд нөлөөллийг бууруулах, дасан зохицох хүчин чармайлтын гол технологиудыг тодорхойлсон. Гэвч Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ) төсөвтөө уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тодорхой ажлуудыг тусгадаг бол бүс нутаг, аймаг, сумдын түвшинд эрсдэл, эмзэг байдлын үнэлгээнд суурилсан төлөвлөлт, төсөв дутмаг байна.

Төлөвлөлт, санхүүжилтийн систем нь бүс нутгийн байгаль, цаг уурын нөөц, эрсдэлийн түвшний ялгааг харгалзан үзэх шаардлагатай. Өнөөгийн хууль эрх зүйн орчин байгаль орчны


нөхцөл байдлын өөрчлөлтийг хөгжлийн бодлого төлөвлөлт, санхүүжилтэд тусгаж эхэлж байна. Жишээлбэл, 2017 оны "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тооцох аргачлал"-д төсвийн орлогын шилжүүлгийг аймаг, сумдад орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын онцлог, орон нутгийн татварын үйл ажиллагааг харгалзан тус бүр 25 хувьтай байхаар хуваарилжээ. Энэхүү орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, төсвийг боловсруулахдаа уур амьсгалын эрсдэлийн индексийг харгалзан үзэх шаардлагатай.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу Засгийн газар байгалийн баялаг, байгаль орчинтой холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор төрөөс нэмэлт орлого олдог. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу Улсын Их хурлын 1998 оны 188 дугаар тогтоолоор "Байгаль хамгаалах сан"-г байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор бүтэц, орон тоог нь шинэчилсэн. Дараа нь Улсын Их хурлын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар энэ санг "Байгаль орчин, уур амьсгалын сан (БОУАС)" болгон өөрчилсөн. Сангийн орлого, зарлагын удирдлагыг "Засгийн газрын тусгай сангийн тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу зохицуулж, Засгийн газрын төсвийн хөрөнгөөр хянадаг.

4.3.2 Хүндрэл, бэрхшээл

Байгаль орчны төсөл болон үндэсний хэмжээний санаачилгын санхүүжилт олон улсын буцалтгүй тусламжаас гадна Засгийн газрын жил бүрийн төсөвт тулгуурладаг. Гэвч байгаль хүрээлэн буй орчинд чиглэсэн үндэсний хөтөлбөрүүдийг дэмжих Байгаль орчин, уур амьсгалын сангийн санхүүжилт нэлээд хязгаарлагдмал байна. Орон нутгийн удирдлагууд өөрсдийн орлогын эх үүсвэрийг байгаль хүрээлэн буй орчны төслүүдэд ашиглах боломжтой боловч тэдний зарцуулалт нь шаардлагатай хэмжээнээс бага байдаг.

2013 он гарснаас хойш мөрдөгдөж буй Төсвийн тухай хуульд орон нутгийн засаг захиргаанд амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-г нэвтрүүлсэн. Харамсалтай нь ОНХС-ийн хүрээнд хэрэгжиж холбогдох журамд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тусгаагүй нь тухайн салбарын хөгжилд шинээр гарч ирж буй эрсдэлийг үр дүнтэй шийдвэрлэхэд эргэлзээ бий болгож байна.



Үндэсний болон орон нутгийн түвшинд төсвийн хязгаарлагдмал байдал, хоорондоо өрсөлдөх тэргүүлэх чиглэлүүд нь гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход шаардлагатай хангалттай хөрөнгө хуваарилахад хүндрэл учруулж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагаанд зориулсан санхүүгийн хуваарилалтыг зүгээр нэг төсвийн ажил гэж үзэхгүй, харин ирээдүйд илүү их зардал гаргаж болзошгүй хохирол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чухал хөрөнгө оруулалт гэж үзэх ёстой.

Одоогийн байдлаар байгаль орчны салбарын Гамшгийн эрсдэлийн удирдлагын (ГЭУ) санхүүжилт нь зөвхөн гал түймрээс урьдчилан сэргийлэх, усны эх үүсвэрийг хамгаалах, түүнчлэн холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд чиглэгдэж байгаа нь хязгаарлагдмал байна. Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг иж бүрнээр нь хамруулах ногоон санхүүжилтийн механизмыг өргөжүүлэх томоохон боломж байна.

4.3.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
<p>Уур амьсгалын эрсдэлийн үзүүлэлт/индекс тэй уялдуулан орон нутгийн хөгжлийн сангийн удирдамж, зааварыг шинэчилж, уур амьсгалын хүчин зүйлсэд илүү нарийвчлалтай дүн шинжилгээ хийх, үнэлэх боломжийг олгох. Уур амьсгалын эрсдэлийн үзүүлэлт/индекс болон Эмзэг байдлын индекс (ЭБИ)-ийг Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний чухал бүрэлдэхүүн хэсэг болгох.</p>	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
<p>Байгалийн нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүждэг салбаруудыг багтаасан уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийн удирдлагын санхүүжилтийн эх үүсвэрийг зохицуулалтаар хангах. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сангийн хөрөнгийг Уур амьсгалын эрсдэлийн үзүүлэлтээр тодорхойлсон эмзэг болон өндөр эрсдэлтэй бүс нутгийн хэрэгцээг хангахад онцгой анхаарч, төсвийг эдгээр эх үүсвэртэй уялдуулан зарцуулах.</p>	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
<p>Бүх хуваарилалт нь Парисын хэлэлцээрийн дагуу олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай Үндэсний дасан зохицох төлөвлөлт болон Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэхийг нягтлах.</p>	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
<p>Даатгалын хуульд сүүлийн үеийн хөгжил дэвшлийг тусгахын тулд даатгалын тогтолцооны зохицуулалтуудыг шинэчлэх, хөдөө орон нутгийн малчдын амьжиргааг дэмжих. Уг шинэчлэл нь малчдын хэрэгцээнд нийцүүлж тусгайлан боловсруулсан даатгалын шаардлагуудыг тусгасан байх хэрэгтэй. Уурын амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор нийгмийн эрүүл мэндийн асуудлыг судалж, зохих бодлого чиглэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хэрэгтэй.</p>	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв

4.4 Тоног төхөөрөмж

Голын сав газрын менежментийн төлөвлөгөөнд ган, гангийн нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор сонгосон Хур тунадасны стандартчилагдсан индекс (ХТСИ)-ийг ашиглахыг тусгасан. Олон жилийн турш тооцоолж, хянасан ХТСИ нь жил бүрийн хур тунадас, хуурайшилтыг хэмждэг. Үүнийг гадаргын ус, нуур, цөөрөм багасаж, ширгэх эрсдэлийг үнэлэхэд өргөн хэрэглэдэг.

Усны нөөц, биологийн төрөл зүйл, экосистемийн үйлчилгээ, ой мод, газар тариалан, мал аж ахуй, тариалангийн аж ахуй, нийгмийн эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг төрөл бүрийн салбарт уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийсэн. Тус үнэлгээг Их Британийн Байгаль орчин, хүнс, хөдөөгийн асуудал эрхэлсэн газрын (БОХХАЭГ) олон шалгуурын шинжилгээний аргачлалын дагуу хийсэн. НҮБХХ-ийн 2012 оны тайланд бэлчээрийн мал аж ахуй, бэлчээрийн биологийн төрөл зүйл, дэд бүтэц, тариалангийн аж ахуйг хамгийн эмзэг салбар гэж тодорхойлсон.

Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийг урьдчилан таамаглахын тулд Хүлэмжийн хийн концентрац (ХХК)-ын төрөл бүрийн хувилбарын дагуу 1986-2005 оны цаг уурын үеийг хамруулж, ХХК 2.6, ХХК 4.5, ХХК 8.5 зэргийг багтаасан Ерөнхий эргэлтийн загвар (ЕЭЗ)-ын 10 өгөгдлийг сонгон ашигласан. Ингэхдээ 2016-2100 он хүртэлх өгөгдлийг 1986-2005 онтой харьцуулж, өвөл, зуны температур, хур тунадасны өөрчлөлтийг голчлон авч үзсэн.

Уур амьсгалын өөрчлөлтийн түүхэн судалгаанд Н.Баатарбилэг, Г.Якоби болон бусад эрдэмтэн судлаачид модны цагаригийн өсөлтийн жилийн өгөгдлийг ашиглан Палмерын гангийн үзүүлэлтийг сайжруулж, модны цагаригийн өсөлт ба өмнөд хэлбэлзлийн хоорондын хамаарлыг судалсан. Мөн Р.Мижиддорж модны цагаригийн өсөлтийн индекс ба голын урсац хоорондын хамаарлыг судалсныг 2012 онд хийсэн ажилдаа баримтжуулсан байдаг. Одоогоор тус салбарт эрсдэлийн шинжилгээ, үнэлгээ хийх эрх зүйн бодлогын заалт дутмаг байна.

НУАС НҮБХХ-ын "Хөдөөгийн иргэдийн дасан зохицох чадавх, эрсдэлийн менежментийг сайжруулах" төслийн хүрээнд Жэмп Консалтинг компани төрөл бүрийн арга, мэдээллийн эх сурвалжийг ашиглан эмзэг газруудын зураглалыг хийсэн. Гол техникт дараах зүйлсийг багтаасан. Үүнд:

- **Уур амьсгалын өөрчлөлтийн загварын үр дүн:** ДЗНДС, Ландсат, ШРТД өндрийн загвараас 30км х30 км сүлжээ болон зайнаас тандан судлах өгөгдлийг ашигласан.
- **Газарзүйн мэдээлэл ба сэдэвчилсэн зураглал:** Газар ашиглалт, усны байгууламж, гал түймэрт өртөмтгий газар зэргийг хамарсан олон төрлийн сэдэвчилсэн зураглалыг агуулсан.
- **Статистикийн мэдээлэл:** Статистикийн мэдээлэлд хүн амын тоо, малын тоо толгой, ойн тооллого зэрэг багтана.
- Мэдээлэл боловсруулахад QGIS, ArcGIS зэрэг газарзүйн мэдээллийн систем, дижитал боловсруулалтад зориулсан ENVI-г ашигласан. Уг төсөл НҮБУАӨСК, УАӨАЗГХЗ, ОУБХХ зэрэг тогтолцоог үндэслэн судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээ, зэрэглэл тогтоох олон арга зүйг ашигласан.

Төслийн зорилтод 4 аймгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээнд орон зайн өгөгдлийг цаг уурын нөхцөл, дасан зохицох арга хэмжээ зэрэг олон төрлийн мэдээлэлд нэгтгэн үндэслэж байршлуудыг эрэмбэлсэн. Агаарын температур, хур тунадасны шинжилгээг 30км х 30км цаг уурын загвар ашиглан хийсэн. Түүнчлэн, ТЕРРА хиймэл дагуулын МОДИС-ийн өгөгдлөөс авсан газрын гадаргын температур, ууршилт, ургамалжилт зэрэг өгөгдлийг ашигласан бөгөөд 1км х 1км-ийн NDVI өндөр нарийвчлалтай болгосон. Энэхүү шинжилгээнд 2000-2001 оны 5-8 дугаар сарын мэдээлийг хамарсан бөгөөд орон зайн ялгаа, он цагийн өөрчлөлт, хазайлтын нарийвчилсан судалгаа багтсан. Мөн Монгол орны нийт

нутаг дэвсгэрийг хамарсан Акуа, Терра-ийн МОДИС мэдрэгчээс авсан хиймэл дагуулын мэдээллийг татан авч, тасралтгүй цагийн цуврал болгон боловсруулсан. Олон талт дүн шинжилгээний аргыг ашиглан дээрх дөрвөн аймгийн 68 сумыг дасан зохицох үйл ажиллагааг явуулахаар сонгож, орон зайн мэдээлэл боловсруулах, газар зүйн мэдээллийн систем ашиглан зураглал боловсруулсан бөгөөд энэ нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаанд өргөн хэрэглэгддэг, олон төрлийн файлын форматыг дэмжихээс гадна олон программчлалын хэл, веб үйлчилгээтэй нэгтгэх боломжийг олгодог ороо алдартай.

ОБЕГ зуд, ой, хээрийн түймэр, үер, хүчтэй салхи зэрэг гамшгийн улмаас учирсан хохирол,

4.4.1 Давуу тал

Ус цаг уур орчны шинжилгээний алба 1980-аад оноос эхлэн жил бүрийн 8 дугаар сарын дундуур бэлчээрийн талбайн улсын хяналтыг шугаман цэгийн аргаар хийж ирсэн. Хуурай бэлчээрийн талбайд тохиромжтой энэ арга нь ургамлын зүйлийн бүрдэл, олон наст ургамлын хоорондын зай, гектарын ургац зэрэг үзүүлэлтүүдийг үнэлдэг. Энэ зорилгоор бэлчээрийн талбайн олон төрлийн экосистемийг төлөөлдөг 1500 гаруй хяналтын цэгийг ашигладаг.

Энэ хяналт нь олон төрлийн хэрэглээнд маш чухал үүрэгтэй ба үндэсний тайланд хувь нэмэр оруулах, бэлчээрийн талбай дахь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг үнэлэх, цөлжилтийн зураглал боловсруулах, бэлчээрийн талбайн даацыг тооцоолох, зудын эрсдэлийн зураглалыг гаргахад тусалдаг. Өгөгдөл нь бэлчээрийн талбайн менежмент, төлөв байдал, нөхөн сэргээх чадвар, доройтлын түвшнийг үнэлэхэд чухал юм. Түүнчлэн тухайн бүс нутгийн экологийн чадавхад тулгуурласан

хэрэгцээг үнэлэх аргачлалыг боловсруулах зорилгоор НҮБХХ-ийн Уур амьсгалын ногоон сантай хамтран ажиллаж байна. Энэ түншлэл нь дээрх гамшгийн талаарх ойлголт, хариу арга хэмжээг сайжруулахад чиглэдэг. Түүнчлэн БОАЖЯ хүний буруутай үйл ажиллагааны улмаас байгаль экологид учирсан хохирлыг тооцох аргачлалыг нэвтрүүлсэн. Энэ аргачлал нь гамшгийн үнэлгээнээс ялгаатай боловч ой мод, усны нөөц, биологийн төрөл зүйл, газар нутагт нөлөөлж буй хортой үйлдлээс үүдэн байгаль хүрээлэн буй орчинд учирч буй хохирлыг тодорхойлж, байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг иж бүрнээр нь авч үзэх боломжийг олгодог.

төлөвийн болон шилжилтийн загвар ашиглан шинэ бэлчээрийн талбайг харьцуулах зорилготой.

Бэлчээрийн талбайн хяналтаас гадна ус цаг уурын алба эдгээр бэлчээрийн талбайн цэгүүдэд таван жил тутамд хөрсний хяналт хийж, байгаль орчны иж бүрэн үнэлгээ хийхэд хувь нэмэр оруулдаг.

НҮБХХ-ийн УАНС-ийн төсөлд уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын асуудлыг газар төлөвлөлтийн арга зүйд тусгах санаачилгыг гаргасан. Энэ ажил 14 голын сав газрыг хамарсан дөрвөн аймгийн сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, голын сав газрын менежментийн төлөвлөгөөнд онцгойлон чиглэгдэж байгаа юм. Зорилго нь эдгээр бүс нутгийн төлөвлөлтийн үйл явцад уур амьсгалын хүчин зүйлсийг нэгтгэх замаар тэдгээрийн тэсвэрлэх чадавх, тогтвортой байдлыг сайжруулах явдал юм.

4.4.2 Хүндрэл, бэрхшээл

Уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах арга зүйд нэгтгэхэд байгууллагын чадавх хязгаарлагдмал, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй байдлаас шалтгаалж хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. ГЗБГЗЗЕГ-ийн албан хаагчид тухайн газрын төлөв байдлын түвшинд уур амьсгалын эрсдэл, эмзэг байдлын иж бүрэн үнэлгээ хийх, ялангуяа уур амьсгалын загварчлал, экосистемийн үнэлгээ зэрэг дэвшилтэт арга техникийг ашиглахад шаардлагатай ур чадвар, хүний нөөц дутмаг байна. Үүний улмаас Газрын албанаас аргачлалыг батлахад хүндрэл үүсдэг.

ЦУОШГ-аас цаг агаарын урьдчилсан мэдээний уламжлалт аргаас орчны нөлөөлөлд суурилсан таамаглалын аргад шилжиж байгаа нь цаг агаарын урьдчилсан мэдээг түгээх аргаас цаг агаарын урьдчилсан мэдээний хэрэглээг сайжруулах өөрчлөлт юм. Энэ шинэ арга нь эмзэг байдал, эрсдэлд өртөх магадлалыг илүү нарийвчлалтай үнэлэх боломжийг олгодог нийгэм-эдийн засгийн суурь мэдээллийг агуулсан байдаг. Цаашилбал, ЦУОШГ нь орчны нөлөөлөлд суурилсан таамаглалын төлөвлөлт, санхүүжилтийн стратегийг хэрэгжүүлснээр уур амьсгалын үйлчилгээний үр нөлөөг улам сайжруулж, болзошгүй гамшгийн эрсдэлийг хохирол учрахаас өмнө бууруулах зорилготой юм.

ГЗБГЗЗЕГ-ын бэлчээрийн талбайн төлөв байдал, чанарт хяналт тавих чиглэлээр 6000 гаруй цэгт бэлчээрийн талбайн ашиглалтын тохируулга хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл түгээх зэрэгт хяналт хийж байна. Мөн мэргэжлийн байгууллагаар дамжуулан

таван жил тутамд бэлчээрийн талбайг дүгнэн баталгаажуулж, нөхцөл байдал, өөрчлөлтийг үнэлдэг. Гэсэн хэдий ч зохицуулалт, нөөцийн хуваарилалтад бэрхшээлтэй асуудал байсаар байна.

ГЗБГЗЗЕГ үр дүнтэй ажиллахын тулд орон нутгийн салбар нэгжүүдийг хяналт шинжилгээнд хамтран ажиллахыг уриалсан боловч ялангуяа цаг уур болон газрын албан хаагчдын хоорондын хяналт шинжилгээний зорилт, аргачлал зэргээс хамаарч үр өгөөж багатай байсан. Цаг уурын аргачлалд хугацаа их шаарддаг шинж чанартай бол газрын албан хаагчид илүү үр дүнтэй зураг авдаг.

6000 гаруй цэгт хяналт тавих, хээрийн ажлын санхүүжилт хязгаарлагдмал байгаа тул ГЗБГЗЗЕГ зайнаас тандан судлах аргыг нэвтрүүлэхээр судалж байна. Гэсэн хэдий ч энэ хүрээнд тохиромжтой технологийг ашиглахад бэрхшээлтэй тулгарч байдаг.

Цаашлаад ус, уур амьсгал, хүрээлэн буй орчны хүчин зүйлсийг хянах цэгийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай боловч санхүүжилтийн хязгаарлагдмал байдал нь үйл ажиллагааг өргөжүүлэхэд саад болж байна. Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэснээр экологийн мэдэгдэхүйц өөрчлөлттэй эсхүл давхцаж буй бүс нутагт илүү олон хяналтын цэгүүдийг бий болгох боломжтой болно. Эдгээр бэрхшээлийг даван туулж, нэмэлт санхүүжилт авах нь бэлчээрийн талбайн хяналт болон экологийн ерөнхий менежментийн үр нөлөөг дээшлүүлэхэд нэн чухал юм.

4.4.3. Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
<p>Байгаль орчин, цаг уурын мэдээллийг байгууллага хооронд, тэр дундаа газар ашиглалт, голын сав газрын менежментийн төлөвлөлтийн талаарх мэдээллийг түгээх хүрээнд ГМС форматыг багтаасан мэдээлэл солилцох дүрэм журмыг боловсруулах. Эрсдэлд суурилсан, уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн туршлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тавигдах шаардлага, дүрэм журам нь товч, тодорхой байх.</p>	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
<p>Улс орны уур амьсгалд дасан зохицох шинжлэх ухааны ач холбогдлын талаар шийдвэр гаргагчид болон орон нутгийн иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар, боломжит шийдлүүдийн талаар үндэсний болон орон нутгийн түвшний шийдвэр гаргагчдын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх. Гамшгийн эрсдэлийг бууруулах, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэгт эко системд суурилсан арга барилыг нэвтрүүлэхийг дэмжих.</p>	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
<p>Хөдөө аж ахуй, тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг тодорхой салбарт тэдгээрийн өвөрмөц хэрэгцээ шаардлагад тохирсон уурын амьсгалын мэдээллийн үйлчилгээг бий болгох.</p>	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв
<p>Цаг агаарын урьдчилсан мэдээнд салбарын онцлогт тохирсон бэлэн байдлын шаардлагуудыг тусгах, олон нийтийн мэдээллийн хүртээмжийг хангах, байгаль орчны мэдээллийн найдвартай байдлыг сайжруулах</p>	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
<p>Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн цаашдын төлөвт газрын хөрс, газар ашиглалтад хүлээгдэж буй өөрчлөлтийн талаарх мэдээллийг тусгах. Энэ алхам нь эрсдэлийн үнэлгээний нарийвчлал, үнэн зөв байдлыг дээшлүүлэх чухал ач холбогдолтой.</p>	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв



Зураг. Монгол Улс дахь НҮБ-ын ХХ

V. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР – ХӨДӨӨ АЖ АХУЙ

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, ажлын байр бий болгох, хөнгөн үйлдвэрийг түүхий эдээр хангах зэрэг эдийн засгийг төрөлжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ салбарыг дөрвөн үйлдвэрлэлийн систем эсвэл дэд салбар болгон ангилна. Үүнд:

- i) **Мал аж ахуйн өргөн цар хүрээтэй үйлдвэрлэлийн систем:** Энэ систем өргөн уудам бэлчээрийн талбайд адуу, тэмээ, үхэр/сарлаг, хонь, ямаа зэрэгцэн оршиж, жилийн турш хамт бэлчээрлэдэг уламжлалт хагас нүүдлийн бэлчээрийн талбайн хэв маягийг агуулсан;
- ii) **Томоохон газар тариалангийн механикжсан систем:** Энэ систем тариалангийн механикжсан арга техникийг ашиглан томоохон газар тариалангийн талбайд үр тариа, тэжээлийн ургамал тариалахыг чухалчилдаг;
- iii) **Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл:** Энэ ангилал төмс болон бусад хүнсний ногоо тариалах, механикжсан болон энгийн үйлдвэрлэлийн хоёр аргыг ашигладаг бөгөөд ихэвчлэн өрхийн фермерүүд ажилладаг;
- iv) **Хот орчмын өргөн цар хүрээтэй мал аж ахуйн үйлдвэрлэлийн систем:** Энэ систем нь сүүний чиглэлийн үхэр, гахай, шувууны аж ахуйг хамардаг.

Түүнчлэн Монгол Улсын газар тариалангийн нөхцөл байдалд тодорхой үүрэг гүйцэтгэдэг зөгийн аж ахуй, цаа бугын аж ахуй зэрэг нэмэлт дэд салбарууд байдаг. Эдгээр үйлдвэрлэлийн систем бүр хөдөө аж ахуйн салбарын улс орны эдийн засагт олон талт үүрэг гүйцэтгэхэд ихээхэн хувь нэмэр оруулдаг.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын эдийн засгийг хөдөө аж ахуйн салбар голлон хөгжүүлж, мал аж ахуйн салбарыг түлхүү анхаарч ирсэн. Тус салбар 1990-ээд оны сүүл хүртэл улсын ДНБ-ний 30-40%-ийг бүрдүүлж чухал үүрэг гүйцэтгэсэн. Ялангуяа мал аж ахуйн өргөн цар хүрээтэй үйлдвэрлэл Монгол Улсын газар тариалангийн тулгын чулуу болж, эдийн засаг, соёлын өвийг уламжлан үлдээсээр ирсэн. Таван хошуу мал олон зууны туршид уламжлалт мэдлэг, мал маллах арга техник, байгалийн шалгарлын хүчинд тулгуурлан хөгжиж, сонгомол үржүүлгийн замаар улам бүр нэмэгдсээр ирсэн. Өргөн уудам тал нутагтаа олон зуун жилийн турш монголчууд болон мал сүрэг урт удаан биологийн харилцаатай байсаар байна. Тал нутаг хэдийгээр эзгүй мэт харагддаг ч 70 сая гаруй мал бэлчээрлэж байгаа нь 2022 оны байдлаар тус улсын түүхэнд бүртгэгдсэн хамгийн өндөр тоо юм. Орон нутгийн хүн амын 80 орчим хувь нь мал аж ахуйгаар амьжиргаагаа залгуулдаг хэвээр байгаа бөгөөд улсын нийт өрхийн 30 орчим хувь нь мал аж ахуй эрхэлдэг.


Гэвч 2000-аад оны эхээр нүүрсний томоохон ордууд, алт-зэсийн хүдрийн нөөцийг илрүүлснээр томоохон өөрчлөлт гарсан. Ашигт малтмалын эдгээр арвин нөөц, уул уурхайн салбарын үйл ажиллагааны өсөлттэй зэрэгцэн Монгол Улсын эдийн засгийн дүр төрхийг шинэчилсэн. Одоогийн байдлаар ДНБ-д хувь нэмэр оруулж буй гол салбаруудад уул уурхай, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбар багтаж, алт, зэс, нүүрс, ноолуур зэрэг түүхий эдийн экспортын нөлөө мэдэгдэхүйц өсөлттэй байна.

Зураг 1-т 1990 оноос өнөөг хүртэлх Монгол Улсын ДНБ-ний өөрчлөлтийг хөдөө аж ахуй, уул уурхай, үйлдвэрлэл, барилгын салбараар дүрсэлсэн. 1990 оноос хойш зах зээлийн эдийн

засагт шилжсэнээр эдгээр салбарт өөрчлөлт гарсан. 1990 онд хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтыг багтаасан аж үйлдвэр маш чухал байсан ба тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, ажиллах хүчинд

чухал байр суурь эзэлж, ДНБ-ний 21.3%-ийг бүрдүүлдэг байсан ч түүнээс хойш 9%-иар буурчээ. Үүний зэрэгцээ уул уурхай 23.3%, хөдөө аж ахуй 12.6% болж өссөн байна.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БҮРДЭЛ, үйлдвэрлэлийн үндсэн салбараар




Зураг 15. Дотоодын нийт бүтээгдэхүүний бүрдэл, үйлдвэрлэлийн үндсэн салбараар
Эх сурвалж: YCX, www.1212.mn

2022 оны байдлаар манай улсын хөдөө аж ахуйн салбар ДНБ-ний 12.8%-ийг бүрдүүлж байна. Гэсэн ч 2022 онд аж үйлдвэрийн салбарын ДНБ-ний статистикт санаа зовоосон чиг хандлага гарсан. Хөдөө аж ахуйн салбар нь уул уурхай, бөөний болон жижиглэнгийн худалдааны

давамгайлан зонхилох нөлөөлөлд орж гурав дахь байр руу түлхэгдсэн байна. Энэ шилжилт нөхөн сэргээгдэхгүй олборлох нөөц, импортод суурилсан барааны худалдаанд ихээхэн хамааралтай ба дотоодын үйлдвэрлэлийн салбар байхгүй байгааг онцолж байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, сая төгрөг



Зураг 16. Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн, сая төгрөгөөр
Эх сурвалж: YCX, www.1212.mn

2022 оны улсын статистикийн мэдээллээр хөдөө аж ахуйн салбарын албан ёсны ажил эрхлэлт 24.99 хувь байгаа нь хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний Монгол Улсын эдийн засагт ногдох хувь юм.

2022 онд улсын хэмжээнд нийт өрхийн 26 хувь буюу 248.3 мянган өрх мал аж ахуй эрхэлж байгаагийн 190.8 мянга нь малчин өрх байна. Сүүлийн арван жилд малчин өрхийн тоо мэдэгдэхүйц өсөж, 45.5 мянгаар нэмэгджээ. Газар тариалангийн салбарт 17.7 мянган өрх, 1.6 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж байна.

Монгол Улсын газар тариалангийн салбар 60 гаруй жилийн өмнөөс эхэлж улаан буудай, төмс, хүнсний ногоо, арвай, хөх тариа, овьёос зэрэг малын тэжээлийн үр тарианд голлон анхаарч ирсэн. Дэлхийн банкны мэдээлснээр сүүлийн 10 жилд газар тариалангийн үйлдвэрлэлийн өсөлт улаан буудай, төмс, гурилын импор 78%, 95%, 96%-иар тус тус буурч, тэжээлийн үйлдвэрлэл 250 хувиар өссөн байна. Харин 2022 онд тариалангийн талбай 2021 оныхтой харьцуулахад 56.5 мянган га (8.4%)-аар буурч, 618.6 мянган га болжээ.

Хүснэгт 2. НИЙТ УРГАЦ ХУРААЛТ, төрөл, мянган тонноор


Газар тариалан	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Улаан буудай	465.3	368.5	488.3	203.9	467.1	231.4	436.1	411.4	406.1	566.3	401.9	401.9
Төмс	245.9	191.6	161.5	163.8	165.3	121.8	168.9	192.2	244.3	182.6	214.0	214.0
Ногоо	98.9	101.8	104.8	72.3	94.4	82.1	100.7	99.5	121.2	121.7	148.9	148.9
Тэжээлийн ургамал	46.2	42.6	44.3	49.2	53.4	47.9	123.8	121.1	182.1	293.7	171.2	171.2

Эх сурвалж: YCX, www.1212.mn

Дэлхийн хамгийн сийрэг хүн амтай, далайд гарцгүй хамгийн том орон болох 3.4 сая хүн амтай Монгол Улс нь мал аж ахуйн салбартай. Дотоодын махны хэрэгцээг хангах чадвартай ч сүүлийн гучин жилд махны экспорт хязгаарлагдмал байсан. Малын тоо толгой бэлчээрийн талбайн даацаас бараг гурав дахин нэмэгдэж байгаа нь шинээр төллөж буй төлийн тоо толгойтой холбоотой юм.

Өнгөрсөн зуунд Монгол Улсын малын тоо 5.2 дахин, сүүлийн арван жилд 1.6 дахин өссөн үзүүлэлттэй байна. Монгол орны мал аж ахуйн гол төрөл зүйл бол адуу, Бактрийн тэмээ, үхэр, хонь, ямаа бөгөөд эдгээрийг ихэвчлэн “таван хошуу мал” хэмээн нэрлэдэг. Малын тоо толгойн чиг хандлагыг доорх графикт үзүүлэв.

ҮНДСЭН 5 ТӨРЛИЙН МАЛЫН ТОО, (сая толгойгоор)



Зураг 17. Үндсэн 5 төрлийн малын тоо, (сая толгойгоор)

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үндэс юуны өмнө газар, байгалийн нөөцийн хүртээмж, ашиглалтад суурилдаг. Монгол орны бэлчээрийн болон тариалангийн талбай, байгалийн нөөцийн хүртээмж болох ус зэрэг нь өргөн уудам, олон янзын газар нутагт хөдөө

аж ахуйн салбарыг дэмжих чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Статистикийн мэдээгээр Монгол Улсын газар тариалангийн талбай 113.6 сая га эзэлдэг бөгөөд энэ нь нийт газар нутгийн 72.6%-ийг бүрдүүлдэг.

Хүснэгт 3. Газар тариалангийн талбай, сая га

Төрөл	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	10 жилийн өөрчлөлт
Газар тариалангийн нийт газар	115.36	115.08	115.00	114.93	114.84	114.81	114.74	114.04	113.98	113.57	-1.79
Бэлчээрийн талбай	111.03	110.65	110.61	110.49	110.43	110.39	110.33	109.65	109.58	109.15	-1.87
Хадлангийн талбай	1.71	1.72	1.72	1.74	1.71	1.71	1.71	1.71	1.71	1.71	0.00
Тариалангийн газар	0.99	1.01	1.03	1.07	1.09	1.10	1.12	1.13	1.13	1.14	-0.15
Орхигдсон тариалангийн талбай	0.31	0.31	0.31	0.26	0.24	0.23	0.22	0.21	0.21	0.22	0.09
Хөдөө аж ахуйн барилга байгууламж барих газар	0.071	0.077	0.074	0.111	0.117	0.116	0.104	0.088	0.089	0.091	-0.02
Хөдөө аж ахуй эрхлэхэд тохиромжгүй газар	1.260	1.260	1.260	1.260	1.260	1.260	1.260	1.261	1.260	1.260	-

Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn, Газрын ангиллын нэгдсэн мэдээллийн сангийн 2020, 2022 оны нэгдсэн тайлан

Энэ өргөн уудам газрын тариалангийн талбайд бэлчээрийн талбай зонхилох бөгөөд нийт газар тариалангийн талбайн 96.1%-ийг эзэлдэг. Бэлчээрийн талбайг хот, аж үйлдвэр, уул уурхайн салбарын бүтээн байгуулалтад зориулан өөрчилсөн гэдгийг онцолж байна. Энэ чиг хандлагыг бэлчээрийн мал аж ахуйн бус ашиглалтад шилжүүлснээр 1945 онд 130.0 сая га, 1964 онд 122.1 сая га, 1989 онд 122.7

сая га, 2009 онд 111.3 сая га, 2020 онд 109.1 сая га болж буурсан байна. Зөвхөн сүүлийн 10 жилд малын тоо толгой 57.5 хувиар өссөн ч бэлчээрийн талбай 1.9 сая га-аар буурчээ.

2017 оны бэлчээрийн талбайн төлөв байдлыг 2022 оны хяналтын үр дүнтэй харьцуулж үзвэл доройтлын хэмжээ жил бүр нэмэгдэж байгаа нь илт харагдаж байна²⁴.

Хүснэгт 4. Бэлчээрийн талбайн доройтлын ангиллын хувь

Доройтлын түвшин	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
I - Доройтоогүй	30.0%	19.0%	17.0%	11.5%	13.5%	12.4%
II - Бага зэрэг доройтсон	54.0%	38.0%	35.0%	46.6%	45.6%	52.3%
III - Дунд зэрэг доройтсон	12.0%	19.0%	22.0%	19.6%	19.3%	15.8%
IV - Их доройтсон	4.0%	20.0%	21.0%	16.6%	14.9%	14.8%
IV - Бүрэн доройтсон	0.0%	4.0%	5.0%	5.7%	6.7%	5.1%

Эх сурвалж: Газрын ангиллын мэдээллийн нэгдсэн сангийн 2022 оны нэгдсэн тайлан

Тариалангийн талбайн тухайд Монгол Улсын Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хөрс, агрохимийн лаборатори тариалангийн талбайн хэмжээнд жигд тархсан хөрсний ноцтой элэгдэл эвдрэлийг тогтоосон. Тариалангийн талбайн 61.4% нь их, 34.9% нь дунд зэргийн, 3.7% нь бага зэрэг элэгдэлд орсон байна.^{25[1]} Газар тариалангийн зүүн бүсийн хөрсний ялзмагийн агууламж 1.8-2.1% дунд ба/эсвэл бага дунд зэргийн байна. Үүний нэгэн адил хөрсний азотын хангамж нийтээрээ дунд буюу бага байдаг бол ихэнх газар тариалангийн хөрс ургамлын шим тэжээлийн дутагдалтай байдаг (Монгол Улсын газар тариалангийн систем, 2019 он). Монгол орны газар тариалангийн тогтолцоонд өргөн хэрэглэгддэг уринш, уринш төмстэй хоёрын талбайн эргэлт нь хөрсний үржил шимийг хурдасгадаг. Химийн бордоо, хортон шавжтай тэмцэх хэрэгслийн хэт их

хэрэглээ, тариалангийн талбайн доройтож, үржил шим буурч байгаа нь тариалсан талбайг талхлагдсан тал хээр болгон хувиргаж байна. Энэ нь тариалангийн талбайг хэсэгчлэн ашиглах, хөрсний доройтол, хөрсний үржил шим алдагдах, тариалангийн талбайн уринш алдагдахад хүргэсэн. 2015 оны байдлаар 120,000 орчим га тариалангийн талбайг ашиглах боломжгүй гэж тооцсон (НРСО 2015 он).

Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлтийн уршгаар Монгол Улсад цаг уурын болон цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж, эрчим, урьдчилан мэдээлэх боломжгүй байдал, хэмжээ эрс нэмэгдсээр байна. Доорх хүснэгтэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд эрсдэл учруулж буй аюулын үндсэн төрлүүдийг үзүүллээ.

Хүснэгт 5. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гол эрсдэл учруулж буй аюулын төрлүүд

Мал аж ахуй	Газар тариалан
Ган	Ган
Зуд	Жавар
Үер	Үер
Шороон /Элсэн/Цасан шуурга	Мөндөр
Хээрийн түймэр/Ой хээрийн түймэр	Шуурга
Хил дамнасан малын өвчин (ХДМӨ)	Ургамлын хортон шавж, өвчлөл

Бэлчээрийн талбайд түшиглэсэн Монгол орны мал аж ахуйн тогтолцоо нь уур амьсгалын эрсдэл, зудад маш эмзэг байдаг ба малын бэлчээрийн талбайд нэвтрэх боломжийг хаадаг хахир хатуу өвлийн үзэгдэл. Гантай зун болсны дараа малын өөх тосны нөөц дутагдаж, өндөр зардал, хомсдолоос болж тэжээл хомсдох нь үүнийг улам хурцатгадаг. Үүнээс шалтгаалж олон малчид малаа алдаж, ядууралд өртөж, хот руу нүүн шилжих, ядуурал, нийгмийн асуудалд байнга өртдөг. Энэ нөхцөл байдлыг 1 ба 2-р графикт харуулав²⁶.


1999-2002 оны хооронд Монгол Улс гурван удаа дараалан зудын гамшигтай нүүр тулж, улсын хэмжээнд нийт малын 25%-ийг алдсан. Эдгээр ган, зудын улмаас 12,000 гаруй малчин өрх бүх хөрөнгөө алдаж, ихэнх нь ядуурлын түвшний шугамаас доошилсон байна. 2009-2010 оны зуднаар 10.3 сая толгой мал хорогдсон (улсын нийт малын 25%) нь Монгол Улсын нийт

хүн амын 28%-д нөлөөлсөн. Улаан загалмай нийгэмлэгийн мэдээлснээр 220,000 малчин өрх өртөж, 44,000 нь бүх малаа алдаж, 164,000 нь мал аж ахуйн талаас илүү хувийг алдсан байна. 2010 оны зудын улмаас хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний ДНБ 2%-иар буурсан²⁷. Зуд нь нялхсын эндэгдлийн түвшин нэмэгдсэнтэй мөн холбоотой²⁸.

Гуравдахь удаагийн үндэсний тайлангийн мэдээллээс харахад²⁹ (2018), 1990-ээд оноос хойш зудын давтамж нэмэгдэж, 2080 он гэхэд ХХК 4.5 хувилбарын дагуу 5-20%-иар өсөх төлөвтэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас мэдээлснээр 2010-2021 онд ЦУОШГ-аас өвөлжилт хүндэрсэн 1472 нөхцөл байдал ажиглагдсаныг доорх графикт харуулав. Энэ тоо баримтаас харахад Завхан, Увс аймгууд зуд ихтэй байгааг харуулж байна.


1999-2022 ОНЫ ЭЦЭСТ ХОРОГДСОН НИЙТ МАЛ



Зураг 18. 1999-2022 оны эцэст хорогдсон нийт мал

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо: www.1212.mn

МАЛЫН ХОРОГДЛЫН ТҮВШИН



Зураг 19. Малын хорогдлын түвшин

Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний статистикийн хороо: www.1212.mn

Үндэсний статистикийн хорооноос (ҮСХ) гаргасан мэдээллээр 2009-2019 оны хооронд болсон 4200 гаруй байгалийн гамшгийн улмаас учирсан хохирол жилд дунджаар 95 тэрбум төгрөг (28.4 сая еврод) хүрчээ. Энэ арван жилд 2,008 орчим ой, хээрийн түймэр 28 саяга талбайг сүйтгэсэн байна (МСИС, 2020 он). Монгол орны цаг уурын нөхцөл байдал өөрчлөгдөх нь урьд

өмнө нь байсан хатуу ширүүн нөхцөл байдлыг улам хүндрүүлнэ. Температурын өсөлтийн хандлага Монгол Улсын хүнсний ногооны үйлдвэрлэлд ашигтай мэт боловч дэлхийн дулааралтай холбоотой цаг агаарын эрс тэс өөрчлөлтүүд үйлдвэрлэлийн тодорхойгүй байдал, ургацын бууралтад хүргэдэг.

Цаашилбал, эдгээр цаг уурын эрсдэл хөгжлийн доройтлын түвшин, ханган нийлүүлэлтийн сүлжээгээс үүдэлтэй үйлдвэрлэлийн эрсдэлийг улам хүндрүүлдэг. Үүний томоохон бэрхшээл бол орон нутгийн үр тарианы үйлдвэрлэл дутуу хөгжсөн явдал юм. Үрийг ихэвчлэн Хятад, Орос улсаас импортолдог. Хятад улсаас импортлох бүтээгдэхүүн нь орон нутгийн цаг уурын нөхцөлд тохиромжгүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй (Пөшк, 2016).

Ургамал Хамгааллын хүрээлэнгээс 2019 онд хийсэн судалгаагаар манай улсад бэлчээрийн талбай, хээр тал, ойд өргөн тархсан 700 гаруй төрлийн хортон шавж амьдардаг болохыг тогтоожээ. Эдгээр хортон шавж газар тариалангийн үр шимд ихээхэн нөлөөлж, тариалангийн ургацыг 2-10%, төмс, хүнсний ногооны ургацыг 13-30%, хадлан, бэлчээрийн талбайг 19-40%-иар бууруулж байна.

5.1 Засаглал

5.1.1 Давуу тал

Газар ашиглалт, сайжруулалт, бэлчээрийн талбайн хамгаалалтыг зохицуулахад хэрэгжүүлж байгаа тогтолцоо сайжирч бэлчээрийн нэгдсэн менежментийн тогтолцоог бүрдүүлэхээр байна. Байгаль экологи, бэлчээрийн даацтай уялдуулан малын тоо, төрөл, бүрэлдэхүүний тодорхой хязгаарыг тогтоохоор байна. Бэлчээрийн талбай, өвс, тэжээл, усан хангамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ мал аж ахуйн салбартай холбоотой эрсдэлийг бууруулахын тулд мал, ургамлын өвчин, бэлчээрийн мэрэгч, шавжтай тэмцэх стратеги хэрэгжүүлэхээр байна.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) талаарх заалтуудыг улс орны дунд болон урт хугацааны хөгжлийн стратеги, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд сайтар тусгаж өгсөн.

Хөдөө аж ахуйн салбарын уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн гамшигт хэт эмзэг өртөмтгий, байгаль цаг уурын хүчин зүйлээс

НҮБХХААБ-аас хийсэн 2021 оны судалгаагаар Монгол орны малчин өрхүүдийн Тэсвэрлэх чадавхын индексийн хэмжилт, дүн шинжилгээний (ГТЧИХДШ) хэрэгслийг ашиглан үнэлгээ хийснээр чухал үр дүн гарчээ. Уг дүн шинжилгээнд 21 аймгийн 330 сумын 10,000 мянга гаруй малчин өрх, тэр дундаа нийслэлийн 6 дүүрэг хамрагдсан байна. Үр дүн нь эдгээр өрхүүдийн дунд тэсвэрлэх чадавхын дундаж түвшин 40-45 байгааг харуулсан.

Түүнчлэн дүн шинжилгээ нь тэсвэрлэх чадавхын түвшний ялгааг мөн онцолсон. Хүн амын нэлээд хэсэг буюу ойролцоогоор 57% нь дунджаас доогуур тэсвэрлэх чадавхтайг харуулсан. Нөгөөтээгүүр, хүн амын дөнгөж 10% нь тэсвэрлэх чадавх өндөртэй байсан бөгөөд Тэсвэрлэх чадавхын индекс (ТЧИ) 70-аас давсан байна. Нийт өрхийн 20 гаруй хувь нь 20-оос доош оноотой байсан нь санаа түгшүүлэм.

бүрэн хамааралтай байдлыг харгалзан энэ интеграци нь хамгийн чухал ач холбогдолтой юм. Монгол Улс "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчны тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартайгаараа онцлогтой хөдөө аж ахуйг эдийн засгийн хөдөлгөгч хүч болгох амбицтай зорилт тавин ажиллаж байна. Энэ алсын хараа нь хөдөө аж ахуйн тогтвортой байдлыг хангах, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх, нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн өөрчлөх асуудлыг хамардаг. Гол зорилго нь хариуцлагатай, өндөр бүтээмжтэй, тогтвортой хөдөө аж ахуйн салбарыг бий болгох явдал юм.

Зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үнэлэх аргачлал, байгууллагын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан мөн улсын болон аймгийн хэмжээнд яаралтай өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх зэрэг арга хэмжээг сайтар бүрдүүлсэн. Түүнчлэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаасан хариу арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжсэн байна.

Нянгийн эсрэг тэсвэрлэх чадавхын (НЯТЧ) олон салбарыг хамарсан үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, хил дамнасан малын өвчлөлийг (ХДМӨ) хянах стратеги, мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагын стратегийг

багтаасан "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлал хэрэгжиж байна. Газар тариалангийн салбарт Жендерийн стратеги боловсруулсныг дурдах нь зүйтэй.

5.1.2 Хүндрэл, бэрхшээл

Бодлогын баримт бичгүүдэд Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), тогтвортой хөгжлийн хоорондын уялдаа холбоог хүлээн зөвшөөрсөн байдаг ч энэ ойлголтыг практикт хэрхэн хэрэгжүүлэх талаар тодруулахад ихээхэн зөрүүтэй байна. Энэ дутагдал нь Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ) үйл ажиллагааг хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн стратеги, бодлогын баримт бичигт уялдуулан нэгтгэхэд саад болж байна.

Зудын бэлэн байдалд ихээхэн анхаарал хандуулж байгаа ч хөдөө аж ахуйн салбарт нөлөөлж болзошгүй бусад төрлийн байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх төлөвлөлт, нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах зэрэг засаглалын тогтолцоо маш хязгаарлагдмал байдаг. Орон нутагт энэ чиглэлээрх дэмжлэг үзүүлэхийн тулд үйл ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх ёстой.

Салбарын бодлого, зорилтууд нь цаашдын хөгжлийг онцолсон боловч эмзэг бүлгийн хүн амын гамшгийг тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, эдгээр бүлгийн хүмүүсийг тодорхойлоход чиглэсэн тодорхой заалтууд эсвэл зорилтууд дутмаг байна.

Малын тоо толгойг бэлчээрийн талбайн даацтай уялдуулах замаар эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн бодлого баримталж байгаа нь сайшаалтай ч гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн зарим арга хэмжээ нь эдгээр бодлоготой зөрчилдөж байна. Үүний нэг жишээ нь бэлчээрийн талбайн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн төсвөөс жил бүр гүний худаг гаргаж, улмаар байгалийн нөөц, хадлангийн талбайн гүний усыг улам шавхаж, газрын доройтолд хүргэж байгаа явдал юм. Гамшгийн эрсдэлийг

бууруулах, малчид ард иргэдийн гамшгийг тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэхийн тулд олон нийтэд түшиглэсэн тогтвортой, хариуцлагатай хөгжлийг дэмжих нь чухал юм. Үүнд малын ашиг шимийг дээшлүүлэх, бууц, арьс шир зэрэг бүх дайвар бүтээгдэхүүнд нэмүү өртөг тооцох, эцсийн дүндээ малын нийт тоо толгойг бууруулах зорилгоор үржлийн тодорхой төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай.

Одоо мөрдөгдөж буй журмын дагуу Монгол Улсын Засгийн газар дэлхийн болон олон улсын хэлэлцээрт нэгдэн орсноор амлалтаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Гэсэн хэдий ч эдгээр амлалтыг бодитоор хэрэгжүүлэхэд ихэвчлэн үр ашигтай байдал дутагддаг. Орон нутгийн иргэдийн оролцоогүйгээр бодлого, шийдвэр гаргах нь салбарын хөгжил, гамшгийн эрсдэлийг бууруулах санаачилгын хэрэгжилт, хяналт сулрахад хүргэдэг. Энэ хандлага нь дэлхийн тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үндэсний зорилтуудыг хэрэгжүүлэхэд саад учруулж байна. Тулгамдсан зорилтууд, одоогийн бодит байдал хоорондын ялгаа нь давамгайлж буй бэрхшээлийг амжилттай даван туулахад хүртээмжтэй засаглал, олон нийтийн идэвхтэй оролцоо зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах, онцгой байдлын асуудал хариуцсан улсын болон орон нутгийн зөвлөл, комиссын талаарх одоогийн хууль эрх зүйн орчин төрийн байгууллага, төрийн албан хаагчдын үүрэг хариуцлагаар хязгаарлагддаг. Энэ бүтцэд орон нутгийн малчид, тариаланчид, нөхөрлөл, мөн тэдгээрийн эрх ашгийг төлөөлдөг төрийн бус байгууллагуудын (ТББ) оролцоо ихээхэн дутагдалтай байна. Засгийн газрын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадавхыг олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагатай уялдуулан сайжруулах нь чухал.

5.1.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхийг дэмжиж иргэдэд зөвлөгөө үзүүлэх ажлыг хөдөөгийн хүн амыг дэмжих ажиллагаатай уялдуулах.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Хөдөө аж ахуйн салбар дахь төлөвлөлтийн уялдаа холбоог сайжруулахын тулд хөдөө аж ахуй, онцгой байдлын удирдлага, байгаль орчин, нийгмийн болон хэрэглээний шинжлэх ухаан зэрэг холбогдох салбаруудын идэвхтэй үүрэг, оролцоог хангах	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Салбарын хөгжил, гамшгийн эрсдэлийг бууруулах талаар бодлого, шийдвэр гаргахад орон нутгийн иргэдийг идэвхтэй оролцуулах замаар засаглалын хүртээмжийг чухалчлах	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

5.2 Хэрэгжилт

5.2.1 Давуу тал

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийн дагуу эрсдэлийг арилгах, бэлтгэл ажлыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны харьяа Гамшгаас хамгаалах улсын алба (ГХУА) нь үндэсний хэмжээнд өөрийн салбарын хэмжээнд хамаарах гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нь хуулиар хүлээсэн үүргийн дагуу салбарын гамшгаас хамгаалах албыг удирдахаас гадна Улсын онцгой комисс, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрийн салбарын хариуцсан гишүүн, мөн Уур амьсгалын үндэсний хорооны гишүүний үүргийг гүйцэтгэдэг.

Төрийн албанд хуулиар хүлээсэн дээрх үүргээс гадна, тус салбарын гамшгаас хамгаалах улсын алба нь НҮБ-ын ХХААБ-тай хамтран хүмүүнлэгийн тусламжийн үеийн хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн салбарыг

удирдах ба мөн салбарын холбогдох гишүүдийн хариу арга хэмжээ, хөдөө аж ахуйн салбарын онц байдлын үеийн хүнсний аюулгүй байдлын техникийн стандарт, холбогдох бодлого, заавар зэрэг нь хүмүүнлэгийн тусламжийн стандарт заавартай нийцэж ажиллаж байна.

Монгол Улс 2017 оноос хойш Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд анхдагч үүрэг гүйцэтгэж, шинэлэг хандлагыг дэлхийн хэмжээнд хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Монгол Улс өргөн хүрээний туршлага, суралцах үүрэг амлалт нь Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны алсын харааг төлөвшүүлэх, хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэ арга нь гамшгийн эрсдэлийн удирдлагад чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

Зудын эрсдэлийн үнэлгээ, эрт хариу арга хэмжээний үүрэг, хариуцлагыг оновчтой тодорхойлсон. Монгол Улс нь НҮБ-ын ХХААБ, Монголын Улаан Загалмай Нийгэмлэг (МУЗН) зэрэг байгууллагын дэмжлэгтэйгээр Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны (УСҮА)

системийн иж бүрэн тогтолцоог бий болгоход ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн. Энэхүү систем нь зудын эрсдэлийн зураглалд үндэслэн олон төрлийн урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээг хөнгөвчилсөн байдаг.

"Алсын хараа-2050"-ын хүрээнд тусгагдсан хөгжлийн хэтийн төлөвийг тодорхой болгохын тулд мал аж ахуй, газар тариалангийн салбарын дунд болон богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр,

арга хэмжээний оновчтой зорилтуудыг тодорхойлсон. Эдгээр зорилтууд нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ холбогдох эрсдэлийг бууруулахыг чухалчилдаг. Түүнчлэн урьдчилан тооцоолоогүй эрсдэлээс үүдэлтэй эдийн засгийн алдагдал, тодорхойгүй байдлыг бууруулах зорилгоор хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог бэхжүүлэхэд ихээхэн анхаарч байна.

5.2.2 Хүндрэл, бэрхшээл

Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ) үйл ажиллагаа нь Онцгой байдлын газрын харьяалалд, голчлон ОБЕГ, байдаг бол уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагаа нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяанд байдаг. Энэ үүрэг хариуцлагын хуваарилалт нь хөдөө аж ахуйн салбар дахь Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагааны хүчин чармайлтыг нэгтгэх, уялдуулахад бэрхшээлтэй тулгардаг ба энэ нь уур амьсгалтай холбоотой эрсдэл, эмзэг байдлыг үр дүнтэй шийдвэрлэх шаардлагатай зохицуулалтын асуудалд саад учруулж болзошгүй юм. Газар тариалан дахь гамшгийн эрсдэлийг үр дүнтэй бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохын тулд хөдөө аж ахуй, байгаль орчин, эрүүл мэнд, төсөв санхүүжилт зэрэг төрөл бүрийн салбарын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Одоогоор салбар хоорондын зохицуулалт байхгүй байгаа нь хэсэгчилсэн хүчин чармайлт, үйл ажиллагааны үр ашиггүй байдалд хүргэж байна. Төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт тавихад бүхий л салбарын хамтын ажиллагаа (ОБЕГ, холбогдох яамд, орон нутгийн газар/хэлтсүүд гэх мэт), төсөл/хөтөлбөрүүдийн хоорондын зохицуулалт чухал юм.

Аймаг, сумын хэмжээнд гамшгаас хамгаалах үндсэн төлөвлөгөө байдаг ч хэд хэдэн чиглэлээр дутагдалтай байдаг. Хамгийн том дутагдал нь зудын гамшгаас бусад гамшгийг хамарсан, байнга шинэчлэгдэж байдаг

онц байдлын төлөвлөгөө байхгүй байгаад оршино. Нэмж дурдахад эдгээр төлөвлөгөөнд орон нутгийн иргэдийн саналыг хангалттай тусгаагүй. Орон нутгийн өвс, тэжээлийн нөөцөөс гадна гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд зориулсан тусгай төсөв байхгүй байна. Гамшгийн үед сумын засаг дарга, аймаг, Засгийн газрын хяналтад байдаг нөөцийн сангаас хэт их хамааралтай байдал нь төрөл бүрийн гамшгийн үед хариу арга хэмжээ авахад тохиромжгүй байдаг. Хандивлагчдын санхүүжилттэй төслүүдээр бий болсон үр дүнтэй туршлагыг хадгалан өргөжүүлэхэд орон нутагт тодорхой хэмжээний хүндрэл бэрхшээл үргэлжилсээр байна.

Гамшгийг тэсвэрлэх хамгийн бага чадавхтай малчин өрхүүд хязгаарлагдмал хөрөнгө, боловсрол, үндсэн үйлчилгээний хүртээмжээр тодорхойлогддог гэдгийг онцолж байна. Эдгээр эмзэг байдал нь тэднийг өвөлжилтийн бэлтгэл хангалтгүй, нэг удаагийн гамшгийн тохиолдолд мал сүргээ алдах эрсдэлд оруулж байна. Энэ нь эргээд эдгээр өрхүүдийг ядуурал руу түлхэж болзошгүй ба тэдний гамшгийг тэсвэрлэх чадавх, сайн сайхан байдлыг бүхэлд нь сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатайг онцолж байна.

Салбарын яам, аймгийн удирдлагуудын дунд гамшгийн бэлэн байдлын чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг ОБЕГ хариуцдаг гэсэн нийтлэг ойлголттой байдаг.

Салбарын хэмжээнд үер, шороон болон цасан шуурга, ой, хээрийн түймэртэй тэмцэхэд чиглэсэн тусгайлсан гамшгаас хамгаалах төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын тодорхой тогтолцоо байхгүй. Газар тариалангийн дэд салбарт тусгайлан зориулсан гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ) төлөвлөгөөг хараахан боловсруулаагүй байна.

Гамшгийн үед эмзэг байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үр шим хүртэгчдийг тодорхойлох тогтсон механизм байдаггүй. Хяналт-шинжилгээ, үнэлгээг тодорхой шалгуур үзүүлэлтээр хийдэггүй бөгөөд орчны нөлөөлөлд суурилсан хяналт дутмаг байна.

5.2.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Орон нутгийн иргэдийн гамшгийг даван туулах чадавхыг сайжруулахын тулд малын өвс, тэжээл хадгалах, боловсруулах байгууламж/ агуулах зэргийг орон нутагт байгуулахад дэмжлэг үзүүлэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Өндөр төсөв
Хөдөө аж ахуйн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулах санаачилгын хэрэгжилт, үр нөлөөг үр дүнтэй хянахын тулд тодорхой шалгуур үзүүлэлтийг боловсруулах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Мал аж ахуйд түшиглэсэн амьжиргааг хамгаалахын тулд Онцгой байдлын үед мал, амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандартыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, Хүмүүнлэгийн тусламжийн Стандартын Түншлэлд чадавхыг бэхжүүлэх хүчин чармайлтыг төвлөрүүлэх. Мал амьтны эрүүл мэндийн салбарын онцгой байдлын үед бэлтгэх зааварчилгаа болох Онцгой байдлын менежментийн сайн туршлагыг онцолж, Сфер стандартыг дагаж мөрдөх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Эрсдэлийн түвшин зэрэглэлд нийцүүлэн нөөцийн бүтээгдэхүүний хангалтыг бүх түвшинд хийх, зохицуулах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

5.3 Санхүүжилт

5.3.1 Давуу тал

НҮБХХ, НҮБ-ын ХХААБ, ОУХБ, Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслийн хүрээнд 2011-2020 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн төсвийн зарцуулалтын талаарх хийсэн тайлангаас харахад 2011 оныг эс тооцвол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төсвийн хуваарилалтын нэгдсэн төсөв сүүлийн арван жилд ДНБ-ний 0.2-1.6%, ерөнхий төсвийн 0.8-4.2%-тай, улсын төсвийн 1.1%-5.5%-тай тэнцэж байна. 2011 онд гарсан онцгой хэлбэлзэл буюу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгосон хөнгөлөлттэй зээлийн зардалд 176.8 тэрбум төгрөг, ноолуурын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжид 130.0 тэрбум төгрөг төсөвлөсөн нь яамны төсөв ихээхэн нэмэгдсэнтэй холбоотой байж болох юм.

Үүнээс дүгнэхэд энэ салбарын төсвийн ерөнхий хэмжээ, бүтэц нь сүүлийн арван жилийн хугацаанд хувьсан өөрчлөгдөж, мөнгөн тусламж, урсгал шилжүүлэг, цэвэр зээлээс хасагдсан эргэн төлөлт зэрэг хүчин зүйлс голчлон нөлөөлсөн байна.

Улсын төсвөөс хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгосон нийт мөнгөн тусламж, хөнгөлөлттэй зээлийн хүү төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн 34.1%-ийг эзэлж байна. Мөн 2010-2020 оны дундаж урсгал зардлын 46.9%-ийг эзэлж байгаа нь салбарын төсөвт ихээхэн хувь нэмэр оруулж байгааг тодотгож байна.

Сүүлийн 5 жилийн дунджаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн зардлыг дараах байдлаар хуваарилсан байна. Үүнд:

- 19.5%-ийг мал аж ахуйг хөгжүүлэхэд.
- 10.6%-ийг тариалан эрхлэлтийг хөгжүүлэхэд.
- 2.8%-ийг хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд.
- 11.1%-ийг хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд.
- 24.0%-ийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний дэд хөтөлбөрт.
- 6.1%-ийг малаж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэрийн менежментийн бодлогод.
- Зөвхөн 0.1%-ийг мал аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэрийн судалгаанд.

2021 оны төсвийн зарцуулалтыг салбаруудын зориулалтын ангиллаар авч үзэхэд батлагдсан төсвийн 41.4%-ийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих мөнгөн тусламж, урамшуулалд олгож байгаа нь анхаарал татаж байна. Нэмж дурдахад, нэлээд хэсэг буюу 32.7%-ийг төрөл бүрийн мал эмнэлгийн үйлчилгээ, оношилгоо, тандалт судалгаанд зориулсан.

Монгол Улсын нотолгоонд суурилсан Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь дан ганц зардал багатай байгаад зогсохгүй гамшигт өртсөн иргэдийн нэр төрийг эрхэмлэдэг. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан доллар бүрээс айл өрхүүд 7 доллароос илүү үр өгөөж хүртэх боломжтой бөгөөд ингэснээр амьжиргааны алдагдлыг багасгаж, олон талын ашиг тусыг бий болгож байна.

5.3.2 Хүндрэл, бэрхшээл

Хил дамнасан малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, усны нөөцийг зохицуулах, хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжих, тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх зэрэг чухал арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүгийн асар их нөөцтэй шаардлагатай. Одоогийн санхүүжилтийн хомсдол нь эдгээр нэн тэргүүний санаачилгыг амжилттай хэрэгжүүлэхэд ихээхэн саад учруулж байна.

Гамшгийн хариу арга хэмжээний үйл ажиллагааг төлөвлөх, хянах, үнэлэхэд орон нутгийн иргэд, ялангуяа малчид, тариаланчдын оролцоо хязгаарлагдмал байгаа нь гамшгийн эрсдэл, түүнийг тэсвэрлэх чадавхыг сайжруулах арга барилын талаарх ойлголт муу байгааг харуулж байна. Гамшигтай холбоотой эрсдэлийн талаарх энэ хязгаарлагдмал мэдлэг нь тэдэнд эрсдэл шилжүүлэх эсвэл даатгалын боломжит хувилбаруудыг авч үзэхэд эргэлзээ төрүүлдэг.

Түүнчлэн гамшгийн эрсдэлд чиглэсэн даатгалын компаниуд нь малчдад эдгээр эрсдэлээс хамгаалахын ач холбогдлыг таниулсан сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй. Малчдын дунд түгээмэл хэрэглэгддэг даатгалын нэг бүтээгдэхүүн бол Малын индексжүүлсэн даатгал (МИД) юм. Гэвч энэ төрлийн даатгал нь малчдад тохиромжгүй байж болох хохирлын босгыг тогтоодог тул эдгээрийг сонгох нь ховор байдаг. Ихэнхдээ банкнаас зээл хүссэн, эсвэл улс, аймаг, сумынхаа тэргүүний малчны болзол хангасан малчид л тус бүтээгдэхүүнийг сонгох нь элбэг байна.

Мал аж ахуйн татвараар орон нутгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх хуулийн заалттай. Харамсалтай нь, малчдыг онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ татвараас чөлөөлөх тухай хуулийн заалт нь тус татварыг төлөхөд саад болж, хэрэгжүүлэх боломжгүй болгож байна. Газрын төлбөрийн тухай хууль, тэр дундаа төлбөрийг хонин толгойд шилжүүлэх тухай заалт хүчин төгөлдөр хэвээр байна. Харамсалтай нь энэ заалтыг албан ёсоор хүчингүй болгоогүй ч, малын тоо толгойн татвар гэсэн шинэ татварыг

нэвтрүүлж, татварын тогтолцоонд төөрөгдөл үүсгэж байна.

Үйлдвэрлэлийн зогсонги байдал нь тариаланчдыг үйлдвэрлэлийн эрсдэлтэй тулгарахад эмзэг байдалд оруулдаг учир ихэвчлэн хөрөнгө оруулалтад саад болдог. Монголын хүнсний ногооны салбар цаг уурын тааламжгүй байдлаас шалтгаалан байгалийн хөгжлийн сорилттой тулгардаг. Бүс нутгийн бусад орны нэгэн адил Монгол Улс газар тариалангийн үйл ажиллагаанд ихээхэн нөлөөлөх байгалийн төрөл бүрийн эрсдэлд өртдөг. Азийн гамшгийн аюулыг бууруулах төвөөс Монгол Улсад тохиолдох томоохон хэмжээний гамшгаар ган, газар хөдлөлт, тахал, өлсгөлөн, үер, ойн түймэр, хүчтэй салхи болон их хэмжээний цас (зуд) хэмээн тодорхойлсон (АГБТ, 2020 он).

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг нэмэгдүүлж, байгалийн гамшгийн давтамжийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл гэж үздэг бэлчээрийн даац, бэлчээрийн доройтлыг арилгахад малын тоо толгойг бэлчээрийн даацын хүчин чадалтай тэнцвэржүүлэх нь чухал юм. Энэ тэнцвэрт байдалд хүрэхийн тулд махны экспортыг яаралтай нэмэгдүүлэх шаардлагатай байна. 3.4 сая хүн 70 сая гаруй малтай зэрэгцэн оршиж байгаа нь дотоодын махны зах зээл, хэрэглээг хурдацтай хангаж байгаатай холбоотой тулгамдсан асуудал юм. Экспортын нөөцийг ашиглаагүй ч малын эрүүл мэндийг дэмжих, мал сүрэг, бүс нутгийг эрүүлжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт, нөөц, хөрөнгө оруулах нь нэн чухал. Иймд салбарын яамны төсвийн зарлагын багагүй хэсгийг, тодруулбал 32.7%-ийг мал эмнэлэг, оношилгоо, тандалт судалгааг сайжруулахад зориулдаг.

Гамшгийн эрсдэлийн талаарх ойлголт хязгаарлагдмал тул хөдөө орон нутгийн иргэд өөрсдийгөө болон амьжиргаагаа үр дүнтэйгээр хамгаалахад шаардлагатай нөөц хомс байдаг. Иймээс гамшиг тохиолдоход тэд хяналтаа эргүүлэн авахад хүндрэлтэй байдаг ба энэ нь ихээхэн хохирол учруулж, даван туулах стратеги, тэсвэрлэх чадавх нь хязгаарлагдмал гэдгийг онцолж байна.

5.3.3. Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Үндэсний гамшгийн эрсдэлийн санг байгуулж, гамшгийн эсрэг санхүүгийн тэсвэртэй байдлыг сайжруулахын тулд дэлхийн ГЭС-д нэгдэх талаар анхаарах.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Өндөр төсөв
Даатгалыг илүү үр дүнтэй болгохын тулд цаг агаарт суурилсан газар тариалангийн даатгалын тогтолцооны тэргүүн туршлагыг судлах, хэрэгжүүлэх	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Малчид, тариаланчдын дунд эрсдэлийн даатгалын ашиг тусын талаарх мэдлэгийг дээшлүүлж, мэдээллээр хангаж шийдвэр гаргахад туслах.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Бэлчээрийн малын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэн зөв тооцож, шударга, тогтвортой ашиглалтыг хангах үүднээс Газрын төлбөрийн тухай хуулийг шинэчлэх.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Малчдын өмнө тулгамдаж буй тодорхой хэрэгцээ, бэрхшээлийг илүү үр дүнтэй шийдвэрлэхийн тулд Малын даатгалын бодлогыг сайжруулж, боловсронгуй болгох.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Газар тариалан, хүнсний ногооны тариаланчдад тусгайлан зориулсан бичил даатгалын тогтолцоог боловсруулж, тэдэнд чиглэсэн санхүүгийн хамгаалалтыг санал болгох	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

5.4 Тоног төхөөрөмж

5.4.1 Давуу тал

ЦУОШГ жил бүр зудын эрсдэлийн зураглал боловсруулдаг нь цаг уурын урьдчилсан мэдээнд суурилсан хариу арга хэмжээнд чухал үүрэг гүйцэтгэж байна. Зайнаас тандан судлах өгөгдөл, газар ажиглалтыг нэгтгэн боловсруулсан эдгээр эрсдэлийн зураглал нь өргөн хүрээний үзүүлэлтийг хамардаг. Энэхүү найдвартай эрт зарлан мэдээлэх систем нь цаг уурын урьдчилсан мэдээнд суурилсан хариу арга хэмжээг идэвхжүүлэхэд тус дөхөм болсон. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийн сан, мал, ургамлын өвчний хяналтын тогтолцоо тасралтгүй сайжирч байна.

Монгол Улсын Малын эрүүл мэндийн мэдээллийн системийг (МУМЭМС) 2016 онд боловсруулж, 2019 оноос улсын хэмжээнд хэрэгжүүлсэн нь нийтийн хүнсний аюулгүй байдал, малын эрүүл мэндийг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Хил дамнасан малын өвчний эмнэл зүйн шинж тэмдгүүдэд эрт зарлан мэдээлэх, хариу арга хэмжээ авах (ЭСХАХ) системийн 40 орчим модуль нэмэгдэн өргөжиж байгаа нь түүний гамшигт тэсвэртэй байдал, дасан зохицох чадавхыг харуулж байна.

Ургамлын гарал үүсэл, агрохимийн бүртгэлийн системийг НҮБ-ын ХХААБ болон Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр боловсруулсан ба энэ систем нь 2022 онд анх удаа төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариаланчдад төрөөс мөнгөн тусламж олгох боломжийг олгосон байна. Энэ нь хөдөө аж ахуйн салбарын үүсэл гарлын чанар, аюулгүй байдлыг сайжруулж байгаа юм.

Мөн үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн тариалангийн талбайд усалгааны дэвшилтэт техник, ус бага зарцуулах технологийг нэвтрүүлэх юм. Хөрсийг салхи, усны элэгдэл, эвдрэл, малын бэлчээрийн аюулаас хамгаалахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эхлүүлнэ. Үүнд тариалангийн талбайг хаших, ойн зурвас байгуулах зэрэг үйл ажиллагаа орно. Газар тариалангийн бүс нутагт Тариалангийн талбайн хортон шавж, үлдэгдлийн шинжилгээний болон чанарын хяналтын лаборатори байгуулах нь чухал үүрэгтэй юм. Мөн тариалангийн талбайд

5.4.2 Хүндрэл, бэрхшээл

Салбарын эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан бодлого боловсруулах арга барилд мэдэгдэхүйц сул талууд байна. Өсөн нэмэгдэж буй гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг үр дүнтэйгээр удирдахад тус хангалтгүй байдал нь саад болж байна Түүнчлэн ажиллах хүч, ялангуяа гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийн хомсдолтой байгаа нь яам болон бусад холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд нөлөөлж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар олон нийтэд сурталчлах ажлыг зөвхөн Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) хариуцаж байгаа тул үүрэг хариуцлагын тодорхой сорилттой тулгардаг. Боловсролын системд гамшгийн эрсдэлийг бууруулах

ургамал хамгааллын иж бүрэн арга хэмжээ авах, ургамлын өвчин, хогийн ургамал, хортон шавж, мэрэгч амьтдын тархалтыг тасралтгүй судлах, хянах зэрэг ургамлыг хамгаалах, хорио цээрийн хатуу арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй. Хяналтын арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг тогтмол зохион байгуулна. Эдгээр олон талт арга хэмжээ нь уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлээс үүдэлтэй үүсэж буй бэрхшээлийг үр дүнтэй шийдвэрлэхийн зэрэгцээ хөдөө аж ахуйн салбарын тэсвэртэй, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх зорилготой.

Монгол Улс шинэчлэл, өгөгдөлд суурилсан арга барил, иж бүрэн системд тууштай хандаж байгаа нь гамшгийн эрсдэлийн удирдлага, хөдөө аж ахуйн салбарт өөрийн давуу талыг харуулж байна. Эдгээр давуу тал нь гамшгийн эрсдэлтэй тулгарч буй хүмүүсийн гамшгийг тэсвэрлэх чадавхыг бий болгох, хүнсний аюулгүй байдлыг хангах, дэмжихэд чухал ач холбогдолтой.

чиглэлээр сургалт явуулах тодорхой зорилтууд байдаг ч Гамшгаас хамгаалах Хүнс хөдөө аж ахуйн улсын алба гэх мэт бусад төрийн үйлчилгээний чиг үүрэг тодорхойгүй учраас энэ нь хөдөө орон нутагт хүндрэлтэй байдаг.

Газар тариалангийн дэд салбарт өгөгдлийн удирдлагатай холбоотой бэрхшээлүүд тулгардаг. Учирсан хохирлыг системтэй мэдээлдэггүй, байгалийн болон химийн аюулын талаарх мэдээллийг бүрэн нэгтгэдэггүй. Мал аж ахуйгаас шалтгаалсан байгаль орчин, бэлчээрийн даацын доройтлыг ч хангалттай тооцдоггүй. Эцэст нь, ялангуяа суурь судалгаа дутмаг байгаа цаг уурын санхүүжилтийн хэрэглээнд нотлох баримт, шинжлэх ухаанд суурилсан төлөвлөлт зайлшгүй шаардлагатай юм.

5.4.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Хөдөө аж ахуйн хүнсний системийг сайжруулахын тулд төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан уур амьсгалд тохирсон ухаалаг технологийг нэвтрүүлэх, шилдэг туршлагыг хуваалцах.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Одоогийн инновацийг дэмжих зорилгоор нэн чухал салбаруудад тасралтгүй суурь судалгаа хөгжүүлэх.	Яаралтай	Төвөгтэй	Өндөр төсөв
Олон нийтийн гамшгийн даван туулах чадавхыг сайжруулахын тулд хөдөө аж ахуйн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулах/удирдах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тухай олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Өндөр төсөв
Гамшгийн нөлөөлөл, хариу арга хэмжээний стратегийн үр нөлөөг хянах хэмжүүр, үзүүлэлтүүдийг бий болгох	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв



Зураг: Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн Сан

VI. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР – ДЭД БҮТЭЦ

Монгол Улсын дэд бүтцийн хөгжилд газарзүйн өвөрмөц байршил, өргөн уудам нутаг дэвсгэр, нийгэм эдийн засгийн хүчин зүйлс, хүн амын нягтаршил бага зэрэг хүчин зүйлс нь ихээхэн нөлөөлнө. Чадавхыг үнэлэх явцад дэд бүтцийн үнэлгээ хэд хэдэн үндсэн чиглэлд төвлөрсөн. Үүнд:

- Эмнэлэг, сургуулийн дэд бүтэц (бүтцийн бэлэн байдлын төлөв).
- Цаг хугацаа, багийн туршлагын хомсдлоос шалтгаалсан Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үерээс хамгаалах дэд бүтэц.
- Эрчим хүчний дэд бүтэц.

Эмнэлэг, сургууль

Эмнэлэг, сургуулийн барилга байгууламжийг энгийн үед зайлшгүй шаардлагатай үйлчилгээг үзүүлэхээс гадна гамшгийн дараах нүүлгэн шилжүүлэлт, эмнэлгийн яаралтай

тусламжийн байраар ашиглагддаг. Энэхүү хэсэгт Улаанбаатар хотын газар хөдлөлтийн эрсдэлийн хүрээнд, эмнэлэг, сургуулийн бүтцийн бэлэн байдалд дүн шинжилгээ хийсэн.

Эрчим хүчний дэд бүтэц

Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний асар их нөөц бололцоотой ч нийт эрчим хүчний 93%-ийг нүүрсээр ажилладаг цахилгаан станцаар хангадаг ба эдгээр станцуудын ихэнх нь 1960-1980 онд баригдсан. Нүүрс нь дулааны гол эх үүсвэр бөгөөд хүлэмжийн хийн ялгаруулалт, агаарын бохирдлыг ихэсгэж байгаа нь Улаанбаатар хотын агаарын бохирдол Бээжин, Шинэ Дели зэрэг хотын бохирдлын түвшнээс давж байна. Энэ нь нийгмийн эрүүл мэндийн хямралыг үүсгэж нэн ялангуяа хүүхдүүдэд нөлөөлж байна. Үүнээс гадна цахилгаан, дулааны дотоодын хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбогдуулан нүүрсний хэрэглээ нэмэгдсээр байна. Цахилгаан эрчим хүчний эрэлт хэрэгцээ одоогийн хангаж буй хүчин чадлыг давж байгаа энэ үед Монгол Улс ОХУ-аас өндөр өртөгтэй эрчим хүч импортлох болсон нь эрчим хүчний аюулгүй байдал, нийгэм эдийн засгийн байдлыг хүндрүүлж байна.

Монгол Улсын цахилгаан эрчим хүчний системд төвийн эрчим хүчний систем (улсын цахилгаан эрчим хүчний 90 гаруй хувийг хангадаг үндсэн сүлжээ), зүүн, баруун, Алтай-Улиастайн эрчим хүчний систем, Өмнөговийн бүсийн тусгаарлагдсан ДЦС гэсэн дөрвөн бие даасан сүлжээ багтдаг. Цөөн хүн амтай, том газар нутгийг хамарсан эдгээр сүлжээ нь гол төлөв томоохон хот, аж үйлдвэрийн бүс нутгуудыг хамарч үйлчилдэг. Одоогоор 329 сум, 326 суурин газар шугаманд холбогдож, цахилгаан эрчим хүчний хүртээмж 98%-тай байна. Таван дүүргийг сэргээгдэх эрчим хүчээр хангаж байна. Эрчим хүчний салбарын 2015-2030 онд хөгжүүлэх бодлогод тусгагдсанаар 2015 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Улсын нийт суурилуулсан хүчин чадал 1082 МВт байхаар тооцсон.

Тус салбарын хөрөнгө, барилга байгууламж гал түймэр, үер, хүчтэй салхи, шороон болон цасан шуурга, аянга цахилгаан, газар хөдлөлт, хөрсний гулсалт зэрэг байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшгийн эрсдэлтэй гэдгийг салбарынхан нь хүлээн зөвшөөрдөг. Эдгээр гамшгийн улмаас

эрчим хүчний системийн доголдлын шаталсан үр дагаврыг эрчим хүчний системийн уналтын нийгэм, эдийн засгийн өргөн хүрээний нөлөөллийг тусгасан "ДАТ Консалтинг" ХХК-ийн гаргасан Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлангаас Зураг 9-т дэлгэрэнгүй харуулсан.



Зураг 20. Эрчим хүчний системийн доголдлын үр нөлөөнүүд

Монгол Улсын эрчим хүчний салбарын хөрөнгө, барилга байгууламж гамшигт өртөмтгий байгаа хэдий ч тус салбарын онцлогт тохирсон гамшиг осол, түүний үр дагавруудын талаарх албан ёсны бүртгэл байхгүй байв. Эрчим хүчний яам гамшгийн эрсдэлийн үнэлгээг салбарын онцлогт тохируулан 2023 онд анх удаа хийснээр энэ байдал өөрчлөгдсөн. Энэхүү санаачилга тус яаманд Салбарын хяналтын газрыг байгуулсны дараа Засгийн газраас баталсан хяналтын хуудсын дагуу гарчээ.

Үүнээс өмнө хэд хэдэн бага хэмжээний гамшгийн эрсдэлийн үнэлгээ (ГЭҮ)-г тухайн салбарын хувийн компаниудын шаардлагын дагуу хийж байсан. Онцгой байдлын Ерөнхий Газрын (ОБЕГ) журмын дагуу "Дат Консалтинг" ХХК 2021 онд баруун бүсийн эрчим хүчний системд зориулсан цогц ГЭҮ-г хийсэн. Эдгээр эрсдэлийн үнэлгээ гал түймэр, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, газар хөдлөлт зэрэг гамшиг болон норм, стандарт, технологийн шаардлага хангаагүй зэрэг олон төрлийн зөрчлүүдийг багтаасан байв.

6.1 Засаглал

6.1.1 Давуу тал

Үерээс хамгаалах дэд бүтэц

Үерээс хамгаалах бүтэц бол үерийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн зорилго бүхий чухал дэд бүтэц юм. Монгол Улсад хэрэгжиж байгаа хууль, эрх зүйн зохицуулалтын дагуу орон нутгийн засаг захиргаанд (аймаг, хот, сум, дүүрэг) өөрийн нутаг дэвсгэрт үерээс хамгаалах дэд бүтцийг хот эсвэл суурин газрын хөгжил, байгалийн нөөцийн ерөнхий менежменттэй уялдуулан төлөвлөх, барьж байгуулах, засвар үйлчилгээ хийх бүрэн эрхийг олгосон. Үерээс хамгаалах дэд бүтцийн хэрэгжилтийг зохицуулдаг гол хууль эрх зүйн орчныг тоймлон харуулав.

- **Гамшгаас хамгаалах тухай хуульд** (2017 он) төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдүүд гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлнэ хэмээн заасан. Бүтцийн арга хэмжээнд барилга байгууламж, объект, зам, гүүр зэрэг биет үйл ажиллагаа багтдаг. Үер бол эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай аюулт үзэгдлүүдийн нэг юм. Тус хуулийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт нутаг дэвсгэртээ гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх, хяналт тавих бүрэн эрхийг олгосон.
- **Усны тухай хууль** (2012 он) нийт усны нөөцийн менежментийг үерийн аюулаас хамгаалах тодорхой хэмжээний үйл ажиллагааны хамтаар зохицуулдаг. Энэхүү хуулийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд усны гамшгаас урьдчилан сэргийлэх зэрэг усны нөөцийн менежментийн төлөвлөгөө, хөтөлбөрийг хэлэлцэн батлах эрхийг олгодог. Мөн аймаг, нийслэлийн Засаг дарга нарт усны нөөцийн менежмент, түүний дотор үерийн аюул, “усны барилга байгууламж (энэ нь үерийн аюулаас хамгаалах)” барих төсвийг шийдвэрлэж,

хэрэгжүүлэх эрхийг олгодог. Энэ хууль нь мөн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад газар зохион байгуулалтын төлөвлөгөөний арга зүйн удирдамжийг боловсруулж, батлах эрхийг олгодог.

- **Барилгын тухай хуулиар** (2016 он) авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц, үерийн хамгаалалтын бүтэц зэргийг тодорхойлсон. Аймаг эсвэл нийслэлийн Засаг даргад барилгын ажлын зөвшөөрөл олгох бүрэн эрх байдаг.
- **Газрын тухай хуульд** (2002 он) байгалийн аюул, гамшгаас шалтгаалан тухайн газрыг анх ашиглах зориулалтаар ашиглах боломжгүй болсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах тухай заалтыг тусгасан. Тогтоосон хугацаанд газраа чөлөөлөөгүй тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга нар нүүлгэн шилжүүлэх бүрэн эрхтэй.
- **Хот байгуулалтын тухай хуульд** (2008 он) гамшигт үзэгдэл тохиолдох магадлалтай бүс нутагт хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах заалт байдаг.

Өнгөрсөн жилүүдэд Улаанбаатар хотын үерийн менежментийн урт хугацааны төлөвлөгөөг олон үе шаттайгаар боловсруулсан. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа (ЖАЙКА, 2009 он), Улаанбаатар хотын үерийн эрсдэлийн үнэлгээ, үерийн эрсдэлийн удирдлагын стратеги (Дэлхийн банк, 2015 он) өнөөгийн Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг (Геодези, Усны барилга байгууламжийн газар, 2023 он) боловсруулахад хувь нэмэр оруулсан.

Дээрх хоёр баримт бичиг нь Улаанбаатар хотын үерээс хамгаалах дэд бүтцийг багтаасан үерийн менежментийн арга хэмжээний урт

хугацааны техникийн хөрөнгө оруулалтыг удирдан чиглүүлдэг.

Эмнэлэг, сургууль

Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) шинэ болон одоогийн сургуулийн дэд бүтцийг хариуцдаг. Эмнэлгийн барилга байгууламжийн хувьд Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу төлөвлөлт, зураг төсөл, засвар үйлчилгээ, менежментээс эхлээд эрүүл мэндийн дэд бүтцийг **Эрүүл мэндийн яам** (ЭМЯ) хариуцна. Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төв зохицуулалтын стандартыг тогтоодог. Монгол Улс 1950-аад онд Оросын Зураг төслийн кодыг (SNIP-Барилгын норм, дүрэм журам) хэрэгжүүлж байсан ч цаг хугацааны явцад барилгын норм газар хөдлөлтийн хүчин зүйлсийг нэгтгэн хөгжүүлж, боловсронгуй болгосон. Сүүлд сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах нормыг MSK 8-92 болгон шинэчилсэн. Засгийн газрын гурван чухал байгууллагаас (БШУЯ, ЭМЯ, Барилгын хөгжлийн төв) гадна улсын, орон нутгийн болон бусад төрийн байгууллагууд эмнэлэг, сургуулийн барилгыг ашиглалтад оруулах үйл ажиллагаанд оролцон ажилладаг. Сургуулийн барилгын жишээг доор харуулав.

- Төлөвлөх: Нийслэлийн Боловсролын газар, Хот төлөвлөлтийн газар
- Загвар: Нийслэлийн боловсролын газар,

Эрчим хүчний дэд бүтэц

Эрчим хүчний тухай хууль эрчим хүчний салбарын хууль эрх зүйн үндсэн суурь болдог боловч тус хууль болон түүний нэмэлт журамд Гамшгийн эрсдэлийн удирдлага (ГЭУ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагааны асуудлыг тодорхой тусгаагүй. Гэсэн хэдий ч хэд хэдэн заалтууд Монгол Улсын Засгийн газар, Эрчим хүчний яам, мэргэжлийн хяналтын байцаагчид, хэрэглэгчид аюулгүйн нөөц, санхүүжилт, тоног төхөөрөмж, хяналтын системийн чадавхтай холбоотой үүрэг даалгавар өгч Гамшгийн

Барилгын хөгжлийн төв, Орон нутгийн удирдлагын газрын алба, ОБЕГ (гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх)

- Барилга байгууламж: Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар (худалдан авалт), Барилгын хөгжлийн төв (хяналт), Улсын хяналтын комисс (ашиглалтын гэрчилгээ)
- Үйл Ажиллагаа ба засвар үйлчилгээ: БШУЯ, Барилгын хөгжлийн төв болон Мэргэжлийн хяналтын газар

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн хүрээнд онд Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл (анхлан Засгийн газрын 2014 оны 118 дугаар тогтоол)-ийг байгуулсан. БШУЯ, ЭМЯ-ны оролцоотой тус зөвлөлийг Монгол Улсад газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлыг өргөн хүрээнд дэмжих зорилгоор тусгайлан байгуулсан.

"Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод боловсролын болон эрүүл мэндийн салбарын тусгай хөрөнгө оруулалтыг Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030 он, Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний дагуу тус тус хэрэгжүүлэхээр тусгасан.

эрсдэлийн удирдлага (ГЭУ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагааг шууд бусаар дэмждэг. ГЭБ үйл ажиллагаанд дараах заалтууд багтана. Үүнд:

- Эрчим хүчний тухай хуулийн дагуу Засгийн газар байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн хохирлыг сулруулах, эрчим хүчний аюулгүйн нөөц болон хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх (5.1.4.) зорилгоор эрчим хүчний аюулгүйн нөөцийг (3.1.28-д тусгасны дагуу) бүрдүүлэх, санхүүжүүлэх үүрэгтэй.

- Эрчим хүчний яамны үүрэг хариуцлагад байгалийн гамшиг, гэнэтийн ослын үед эрчим хүчээр хангах журам (6.1.4.) батлах, хий, төвлөрсөн дулаан хангамжийн үндсэн шугам сүлжээ, хангамжийн дүрэм, эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны журам тогтоох (6.1.5) зэрэг багтана.
- Хэрэглэгчид техникийн ашиглалт болон аюулгүй ажиллагааны бүх дүрэм (30.1.3.)-ийг дагаж мөрдөх ёстой ба цахилгаан дамжуулах шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг (30.1.8) хариуцна.
- Хяналтын улсын байцаагч хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл (32.1.1.), ашиглалтын болон аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй (32.1.2.), эрчим хүчний чанар муу (32.1.3.) зэрэг шалтгаанаар үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох эрхтэй. Тэд мөн байгалийн гамшиг, түлшний хомсдол, эрчим хүчний хангамжид осол, саатал гарсан (32.2.5.), техникийн шаардлага зөрчсөн (32.3.2.) зэрэг тохиолдолд үйлчилгээг хязгаарлана.

6.1.2 Хүндрэл, бэрхшээл

Үерээс хамгаалах дэд бүтэц

Үерээс хамгаалах дэд бүтцийг үр дүнтэй байлгахад босоо тогтолцооны арга барил, тусгай санхүүгийн эх үүсвэртэй засаг захиргаа хоорондын урт хугацааны зохицуулалт шаардлагатай. Одоо мөрдөгдөж буй Хууль эрх зүйн болон зохион байгуулалтын зохицуулалт

ийм системтэй үерийн менежментийг зөвшөөрөх цар хүрээ хязгаарлагдмал ба хот төлөвлөлт, усны нөөцийн менежментийн хүрээнд үерээс хамгаалах ажлыг орон нутгийн засаг захиргаа бүрэн хариуцах үүрэгтэй.

Эмнэлэг, сургууль

Эмнэлэг, сургуулийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн эмзэг байдлын талаарх мэдээлэл байгаа бөгөөд энэ нь эмнэлэг, сургуулийн барилгуудад ихээхэн хохирол учирч, газар хөдлөлтийн гамшгийн дараа

үргэлжлүүлэн үйлчилгээ үзүүлэх боломжтойг харуулж байна. Одоогийн салбарын стратеги ихэвчлэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглээгүй байна.

Эрчим хүчний дэд бүтэц

Эрчим хүчний байгууллагуудын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө (ГХТ), улсын болон орон нутгийн засаг захиргаа, Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), орон нутгийн Онцгой байдлын газар (ОНОБГ) болон бусад холбогдох байгууллагуудын үйл ажиллагаа, уялдаа холбоо ихээхэн дутагдалтай байна. Энэхүү буруу уялдаа холбоо нь гамшгийн үед хариу арга хэмжээ авах, сэргээн босгох үйл ажиллагааг зохицуулалтгүй, үр дүнгүй болоход хүргэдэг. Нэгдмэл удирдлагагүйгээс шалтгаалан байгууллага бүр бие даан ажиллаж, хариу арга хэмжээ авахдаа давхардсан хүчин чармайлт

эсвэл дутагдал гаргаж, улмаар гамшгийн үед болон дараа нь тулгарч буй хүндрэл бэрхшээлийг илүү нэмэгдүүлдэг.

Эрчим хүчний салбарын байгууллагуудын одоогийн ГХТ ихэвчлэн иж бүрэн биш байна. Гамшгийн төрөл бүрийн цагийн байдалд байгууллага, тухайн байгууллагын алба хаагчдын бие даасан бэлтгэлийн нарийвчилсан стратеги дутмаг байгаа нь гамшгийн үед яаралтай хариу арга хэмжээ авахад шаардлагатай удирдамж хангалтгүй, дэд бүтэц болон алба хаагчдыг бүгдийг илүү эрсдэлд оруулж болзошгүй гэсэн үг юм.

Эрчим хүчний салбарын байгууллагуудын алба хаагчдын гамшгийн эрсдэлийн удирдлагын үүрэг, хариуцлагыг тодорхойлохдоо оновчтой бус байгаа явдал нь гол асуудал юм. Тодорхой

тусгаагүй энэ байдал нь ослын үед алба хаагчид өөрсдийн тодорхой үүрэг, аргачлалын талаар мэдлэггүй байж болзошгүй тул төөрөгдөл, үр дүнгүй байдалд хүргэдэг.

6.1.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Үерээс хамгаалах дэд бүтэц			
<p>Үерийн менежментэд тохирсон усны менежмент, хамгаалалтын элементүүдийг тусган Усны тухай хуулийг сайжруулах:</p> <ul style="list-style-type: none"> • Үерийн гамшгаас хамгаалах ажилд талуудын эрх үүргийг нэмэгдүүлсэн, тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох. • Сав газрын хэмжээнд үерийн менежментийн иж бүрэн стратегийг хэрэгжүүлэхэд анхаарч, үндэсний хэмжээнд нэмэлт хүн хүч дайчлах, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх.. 	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Сургууль, эмнэлэг			
<p>Улаанбаатар хот газар хөдлөлтийн өндөр эрсдэлтэй тул нийслэлийн барилга байгууламжийг бэхжүүлэх нь гамшгийн эрсдэлийг бууруулах гол арга хэмжээ гэж үзэн боловсролын салбарын төлөвлөлтөд тусгах.</p> <ul style="list-style-type: none"> • Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн дэргэдэх 2014 онд байгуулагдсан Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх. • Анх санал болгосон “27 арга хэмжээ”-ний хэрэгжилтэд явцын хяналт, дүгнэлт хийх. • Сургууль, эмнэлгүүдэд онцгой анхаарал хандуулж, газар хөдлөлтийн эрсдэлий хамгийн сүүлийн үеийн нөхцөл байдалд тулгуурлан нэн тэргүүнд авах арга хэмжээг тодорхойлох. 	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Эрчим хүчний дэд бүтэц			
<p>Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах: Онцгой байдлын ерөнхий газар, орон нутгийн Онцгой байдлын газар болон бусад холбогдох яам, байгууллагын зохицуулалт, харилцаа холбоог сайжруулах шаардлагатай.</p>	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Эрчим хүчний дэд бүтэц			
Эрсдэлийн үнэлгээ хийх, санхүүжилт татан төвлөрүүлэх хэрэгсэл болгон албан ёсны Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээний төлөвлөлтийг жил бүр хийж, танилцуулах	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагааг илүү үр дүнтэй зохион байгуулахын тулд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр салбаруудын түвшинд ойлголт мэдлэг, ур чадвар, техникийн чадавхыг нэмэгдүүлэх	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Дэд бүтэц, орон нутгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, тэсвэрлэх чадавхыг сайжруулахын тулд гамшгийн эрсдэлийн удирдлага, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хөгжлийн бүх төлөвлөгөө, бодлогод тусгах.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, гамшиг, уур амьсгалын эрсдэлийн үнэлгээнд суурилан учирч буй хүндрэл бэрхшээлээс суралцаж, сайн туршлагыг авч хэрэгжүүлэхийн тулд холбогдох стандарт, нормыг шинэчлэх.	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв

6.2 Хэрэгжилт

6.2.1 Давуу тал /одоогийн чадавх

Үерээс хамгаалах дэд бүтэц

Улаанбаатар хотыг үерээс хамгаалах дэд бүтцийн зураг төсөл, угсралт, зохицуулах чиг үүрэг бүхий Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ байдаг. Улаанбаатар хотын хэмжээнд тус байгууллага нь дээрдурдсан техникийн чиг үүргийг гүйцэтгэх хоёр хэлтэс, таван албан газартай ба нийт 139 ажилтан (9 удирдах ажилтан 17 талбайн

захиргааны ажилтан, 133 инженер) ажилладаг. Ажилтнуудын орон тоо хязгаарлагдмал хэдий ч тус газар нь үерийн эрсдэлийн шинжилгээ хийх, техникийн бэлтгэлийн арга хэмжээг боловсруулах, үерийн аюулаас хамгаалах инженерийн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай техникийн чадавхтай.

Эмнэлэг, сургууль

Монгол Улсын барилга байгууламжийн эмзэг байдлын үнэлгээ, инженерийн стандарт, технологи хангалттай түвшинд байна. Барилга, хот байгуулалтын яамны 100 гаруй техникийн ажилтан барилга байгууламжийн газар хөдлөлтийн эмзэг байдалд үнэлгээ хийх сургалтад хамрагдсан. 2016-2019 оны хооронд

сургууль, эмнэлэг зэрэг нийт 199 нийтийн барилга байгууламжид үнэлгээ хийсэн. 2023 оны есдүгээр сарын байдлаар хоёр сургууль, нэг цэцэрлэг, хоёр эмнэлгийг тохижуулахаар төлөвлөж байгаагаас гурвынх нь барилгын зураг төслийг боловсруулахаар төлөвлөжээ.

Эрчим хүчний дэд бүтэц

Эрчим хүчний салбарын Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ) хандлага бат бөх, олон талт ба социализмын үеийн улс орны иргэний хамгаалалтын түүхэн үндсээр тодорхойлогддог. Энэ үндэс суурь нь салбарыг гамшгийн үед болон гамшгийн дараа бусад салбарт үр дүнтэйгээр туслах боломжтой чадварлаг шуурхай баг, аюулгүйн хангамжийн систем, туслах хэрэгслээр тоногдсон.

Эрчим хүчний яам (ЭХЯ) эрчим хүчний бодлого, стратеги, төлөвлөлтийн үндэс суурийг бүрдүүлж, эрчим хүч үйлдвэрлэх шугам сүлжээг хөгжүүлэхээс эхлээд төвлөрсөн дулаан хангамж хүртэл өргөн хүрээний үйл ажиллагаанд хяналт тавьдаг. ЭХЯ-ны бодлого нүүрс болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт суурилсан эрчим хүчний үйлдвэрлэлийг хамарч, эдгээр эрчим хүчний нөөцийг боловсруулах, хадгалах, ашиглах, мөн нүүрсний импорт, экспортод анхаардаг. Тус яам нь цахилгаан эрчим хүч дамжуулах, түгээх бүтээн байгуулалтад зориулан батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй. Салбарын хяналтын газрыг 2023 онд байгуулж, томоохон санаачилга гарган салбар байгууллагуудын эрсдэлийн үнэлгээг анх удаа хийсэн. Тус үнэлгээг хийхэд Засгийн газраас баталсан шалгуур үзүүлэлтийг баримталсан нь ЭХЯ-ны

эрсдэлийн удирдлагын арга барилд чухал алхам болсон юм. Салбарын хяналт газар эрсдэлийн үнэлгээнд зөвхөн нэг удаа оролцоод зогсохгүй, салбарын барилга байгууламжийн байнгын хяналт, үнэлгээнд идэвхтэй оролцдог. Эдгээр барилга байгууламжийг Засгийн газраас баталсан эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу тогтмол үнэлдэг.

Судалгааны үндэслэлүүд мөн чухал үүрэг гүйцэтгэх ба ЭХЯ-ны дэргэдэх тусгай судалгааны хүрээлэн гамшгийн удирдлага, эрсдэлийг бууруулах судалгааны үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулдаг. Системд засвар үйлчилгээ хийх нь ялангуяа зуны саруудад үйл ажиллагааны доголдлын эрсдэлийг бууруулж, системийн аюулгүй байдал, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн байнгын чухал ажил юм. Системийн засвар үйлчилгээ нь нэмэгдэж буй ачааллыг бууруулах, өвлийн улиралд хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Түүнчлэн сүүлийн үед ОБЕГ-тай хамтран ажиллаж, болзошгүй гамшгийн үед бэлэн байх, гамшгийг тэсвэрлэх чадавхыг баталгаажуулсан идэвхтэй арга хэмжээ болох гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах чиглэлээр салбарын зүгээс ихээхэн анхаарч байгаа нь илт харагдаж байна.

6.2.2 Хүндрэл, бэрхшээл

Үерээс хамгаалах дэд бүтэц

Геодези, усны барилга байгууламжийн газрын ажлын онцлох томоохон ажлын нэг нь үерээс урьдчилан сэргийлэх дэд бүтцийн засвар үйлчилгээг тогтмол хийхэд оршино. Хотын ус зайлуулах хоолойны 60% нь 1966-1987 оны хооронд баригдсан тул Улаанбаатар

хотын газар хөдлөлтийн эрсдэлийг харгалзан үзэж зохих засвар, шинэчлэлтийг хийх шаардлагатай. Хүчтэй бороо, үер бүрийн дараа ус зайлуулах хоолойг цэвэрлэх нь одоогоор хангалтгүй байгаа хүн хүч, санхүүгийн эх үүсвэр шаарддаг засвар үйлчилгээний нэг хэсэг юм.

Эрчим хүчний дэд бүтэц

Эрчим хүчний салбар гамшгийн эрсдэлийн удирдлагад ахиц дэвшил гаргахын зэрэгцээ даван туулах чадавх, бэлэн байдлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай томоохон хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Онцгой байдлын багийн хүний нөөцийн хомсдол бол анхаарал татахуйц дутагдал юм. Энэхүү хүний нөөцийн хомсдол нь гамшиг тохиолдсон үед хямралыг үр дүнтэй удирдаж, хариу арга хэмжээ авах чадварлаг боловсон хүчин хангалтгүй байж хойшлуулсан эсвэл хангалтгүй хариу арга хэмжээ авч, нөхцөл байдлыг улам хурцатгаж болзошгүй гэсэн үг.

Өөр нэг чухал асуудал бол гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудалд төрийн албан хаагчдын техникийн чадавх хязгаарлагдмал байдаг. Энэ хязгаарлагдмал байдал нь үр дүнтэй стратеги, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд саад болдог. Гамшгийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд Засгийн газрын удирдлагын түвшний албан хаагчид чухал үүрэг гүйцэтгэдэг.

Бүх систем, өндөр хүчдэлийн шугам сүлжээнүүд хуучирч, муудсан тул системд бүхэлд нь техникийн шинэчлэл хийхэд нөөцийн хуваарилалт маш их дутагдалтай байна.

Түүнчлэн гамшгийн эрсдэлийн удирдлага, эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохтой холбоотой судалгаа шинжилгээний ажилд нөөцийн хуваарилалт мэдэгдэхүйц дутагдалтай байна. Гамшгийн эрсдэлийн хувьсан өөрчлөгдөж буй мөн чанар, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг ойлгоход судалгаа маш чухал. Энэ салбарт хангалттай хөрөнгө оруулалт хийхгүй бол тухайн салбар өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицох, гамшгаас хамгаалах стратегид шинэчлэл хийх, эдгээр эрсдэлийг бууруулах шинэ технологи, туршлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх чадваргүй болж болзошгүй.

Салбарын бүтээн байгуулалт, засвар үйлчилгээний төлөвлөгөөнд гамшгийн эрсдэлийн мэдээллийг үргэлж авч үздэггүй нь болзошгүй эмзэг байдалд хүргэдэг. Цахилгаан эрчим хүчний багана, уур, халуун усны хоолой зэрэг салбарын байгууламжууд гуравдагч этгээдийн аюулгүй байдалд эрсдэл учруулдаг. Цахилгааны шугам, хоолойн орчмын хамгаалалтын бүсэд газар ашиглах нь, ялангуяа хот суурин газар болон тариалангийн талбайд, галын болон аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж, цахилгаан байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг хязгаарладаг.

6.2.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Үерээс хамгаалах дэд бүтэц			
Хүний нөөцийг тоо, чанарын хувьд системтэй нэмэгдүүлэх замаар үерээс хамгаалах дэд бүтцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх. Үерийн менежментийн урт хугацааны мастер төлөвлөгөөний санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хамгийн багадаа 3-5 жилийн хугацаатай боловсруулах	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Эрчим хүчний дэд бүтэц			
Бүх холбогдох гамшигт зориулсан бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж, үүнд бэлэн байдлын хэсгийг тусгаж хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээнүүдийг багтаах	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Галын аюулгүй байдлын дүрэм, зааврыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн хэрэгжүүлж, бэлэн байдлыг дээшлүүлэх	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Эрсдэл, эмзэг байдлыг бууруулахын тулд цахилгаан шугам сүлжээний бүрэлдэхүүн хэсгийг тогтмол шинэчлэх.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Их төсөв
Салбарын нэн чухал дэд бүтэц, байгууламжуудын зураглал, бүртгэлийг гаргаж, төрөл бүрийн гамшгийн нөхцөл байдлын үед аюулгүй байдлыг эн тэргүүнд хангах	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Эрт сэрэмжлүүлэх систем, мэдээлэл түгээх, харилцаа, холбооны системийн ашиглалт хэрэглээг үр дүнтэй байлгахын тулд холбогдох байгууллагууд, байгууллага хоорондын зохицуулалтыг сайжруулах.	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Засгийн газраас тогтоосон эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаанд чиглүүлсэн байдлыг хянах, хэрэгжүүлэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Салбарын албан хаагчид, ялангуяа төрийн болон хувийн хэвшлийн албан хаагчдад зориулсан гамшгийн эрсдэлийг бууруулах (гамшгийн бүр төрлөөр), уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох сургалтын хөтөлбөрүүдийг санаачлан боловсруулах, хэрэгжүүлэх	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

6.3 Санхүүжилт

6.3.1 Давуу тал /одоогийн чадавх

Үерээс хамгаалах дэд бүтэц

2017 оноос эхлэн Улаанбаатар хот үерийн аюулаас хамгаалах үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж өргөтгөж байна. Жил бүр 4-5 тэрбум төгрөгийн (1.2 -

1.4 сая ам.доллар) хөрөнгө оруулалтаар ус зайлуулах хоолой, ус зайлуулах шугам, үерийн сувгийн угсралт, засвар үйлчилгээг хийж байна.

Эрчим хүчний дэд бүтэц

Эрчим хүчний салбарын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагааг нэн тэргүүнд авч үздэг эрх зүйн орчныг онцолж Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу хуваарилдаг. Энэхүү хуваарилалтыг ГЭБ, УАӨДЗ үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон онцолсон тус улсын бодлогын баримт бичигт тусгасан байдаг.

Түүнчлэн ГЭБ, УАӨДЗ үйл ажиллагаанд зориулсан олон улсын санхүүжилт, ногоон технологийг нэвтрүүлэх зэрэг нь санхүүгийн нэмэлт боломжийг бий болгож байна. Монгол Улсын хэмжээнд салбар байгууллагуудын тогтмол төсвийг гамшгийн эрсдэлийн үнэлгээнд тодорхой хэмжээгээр тусгах нь эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг тогтвортой явуулах санхүүгийн бааз суурийг бүрдүүлдэг.

6.3.2 Хүндрэл, бэрхшээл

Үерээс хамгаалах дэд бүтэц

Урт хугацааны үерийн менежментийн төлөвлөгөө (Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө) байгаа ч эдгээр нь тодорхой хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй ирдэггүй.

Хотын үерээс хамгаалах дэд бүтцийн ажилд шаардлагатай бүх инженерийн ажлыг хийхэд хангалттай санхүүгийн эх үүсвэр байдаггүй. Дунджаар шаардлагатай төсвийн 10 орчим хувийг хэрэгжүүлэхэд зарцуулдаг.

Эмнэлэг, сургууль

Улаанбаатар хотын хэмжээнд бүтцийн хувьд эмзэгт тооцогддог нэлээд олон эмнэлэг, сургууль байсаар байна. Гэвч тус асуудлыг яаралтай шийдвэрлэх тал дээр дутагдалтай ажиллаж байна.

Сургуулийн аюулгүй байдлын үнэлгээний³⁰ дагуу сургуулиудын дийлэнх нь гамшгийн эрсдэлийг бууруулах (88%), онцгой байдлын үед боловсролын тасралтгүй үйл ажиллагааг

хангах (80%) зардлыг төсөвт тусгаагүй байна. Баригдсан он, одоогийн барилга байгууламжийн нөхцөл байдал, аюулын эрсдэл зэрэг асуудлуудыг системтэйгээр үнэлээгүй тохиолдолд аль нэг сургуулийн засварын ажлыг эрэмбэлэх тогтсон шалгуур байхгүй. Нэмж хэлэхэд, одоогийн хэрэгжүүлж буй удирдамж, нөөцийн дагуу сургуулиудын бүтцийн шинэчлэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй юм.

Эрчим хүчний дэд бүтэц

Одоогийн санхүүгийн эх үүсвэрийн хуваарилалт салбарын гамшгийг тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэхэд хангалтгүй байгаа нь тогтолцоог сайжруулахад чиглэсэн төсвийн нэгдмэл байдлыг жил бүр хийх шаардлагатайг харуулж байна. Нэмж дурдахад, даатгалын тогтолцоо онцгой байдлын үед гарсан бүх

болзошгүй үр дагаврыг нөхөхөд дутмаг байна. Тухайн салбарт дэмжлэг үзүүлж байсан үүрэг болон одоогийн эмзэг байдлын хоорондын ялгаа гамшгийн бэлэн байдал, эрсдэлийн менежментийг сайжруулахад анхаарах зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

6.3.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Үерээс хамгаалах дэд бүтэц			
<p>Үерээс хамгаалах дэд бүтцийн санхүүгийн хөрөнгө оруулалтыг дунд хугацаанд (таван жил) төлөвлөх:</p> <ul style="list-style-type: none"> Төсвийн хязгаарлагдмал байдлыг харгалзан үзэж төсвийн тогтмол хуваарилалтыг санхүүгийн бусад хэрэгсэл, нөөцөөр нөхөх. 	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
<p>Үерээс хамгаалах томоохон хэмжээний дэд бүтцийг санхүүжүүлэхийн тулд тогтвортой бонд гаргах талаар бодож үзэх нь зүйтэй.</p> <ul style="list-style-type: none"> Санхүүжилтийн нэмэлт боломжийг эрэлхийлж, одоогийн хэрэгжиж буй Ногоон санхүүжилтийн механизмыг ашиглах. 	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар 1.5%-ийн хөрөнгийг төсөвлөж зарцуулах заалтыг мөрдүүлэх замаар хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог идэвхжүүлэх	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Уур амьсгалын ногоон сан, Монгол Улс дахь магадлан итгэмжлэгдсэн санхүүгийн компаниуд болон олон улсын байгууллагуудаас уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр санхүүжилтийн дэмжлэг авах хувилбаруудыг судлах	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Сургууль, эмнэлэг			
Инженерийн өнөөгийн стандарт, технологийг ашиглан боловсрол, эрүүл мэндийн салбарт эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээнийхөтөлбөрийг хэрэгжүүлэх ³¹ , хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Сургууль, эмнэлэг			
Гамшгаас гамшгаас хамгаалах тухай хуульд заасан зайлшгүй шаардлагатай 1.0%-ийн ГЭБ төсвийн хуваарилалтыг ашиглан эдгээр хөтөлбөрт жил бүрийн төсвийн тодорхой хэсгийг зориулах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Сургууль, эмнэлгийн барилга байгууламжийг хүчитгэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг яамдууд тусгайлан боловсруулах	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээ, инженерийн шийдэл, стандартыг шинэчлэн, сайжруулахын зорилгоор эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалт ажилд нөөц, хүч хуваарилах.	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв
Эрчим хүчний дэд бүтэц			
Эрчим хүчний салбарт гамшгаас хамгаалах даатгалын тогтолцоог тусгайлан хэрэгжүүлэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Их төсөв
Гамшгийн эрсдэлийн удирдлага/бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ажиллагаанд зориулж тогтмол төсөв хуваарилах.	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлийн судалгаа, хөгжүүлэлтийн ажилд төсөв тогтмол хуваарилах	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв

6.4 Мэдлэг мэдээлэл, технологи

6.4.1 Давуу тал

Үерээс хамгаалах дэд бүтэц

Бодлого, төлөвлөгөөнд тусгахын тулд орон зайн дүн шинжилгээ/загварын хэрэгслээр дүрслэн харуулсан үерийн эрсдэлийн талаарх мэдлэгийг үерийн мэдээлэл, өртөх байдлын өгөгдөл (жишээ нь, барилга) дээр үндэслэн авах боломжтой. Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг (2023 он) 100 жилийн үерийн туршлага дээр суурилсан

эрсдэлийн загварыг танилцуулж байна. Одоогийн дүн шинжилгээ үерээс хамгаалах үерийн хамгаалалтын сувгууд болох Туул, Улиастай, Сэлбэ, Дунд гол орчмын хуучирсан, шинэчлэх, засвар үйлчилгээ хийх шаардлагатай далангуудын байршлын дэд бүтцийг хамруулан тодорхойлсон.

Эмнэлэг, сургууль

Эмнэлэг, сургуулийн газар хөдлөлтийн эрсдэлийн талаар тодорхой хэмжээний мэдлэг бий. 2013 онд ЖАЙКА төсөл Улаанбаатар хот орчмын бүс нутагт газар хөдлөлтийн хоёр хувилбарыг боловсруулсан байна. Нэг нь Хустайн газар хөдлөлтийн хагарал дээр үндэслэсэн (хамгийн их магнитуд Мв 7.5) бол нөгөө нь Эмээлт (хамгийн их магнитуд Мв 7.0) болон Гүнжийн газар хөдлөлтийн хагарлуудын (хамгийн их магнитуд Мв 6.6) нэгдсэн хувилбар юм.

Дээрх газар хөдлөлтийн хувилбарт үндэслэн Улаанбаатар хотын сургууль, эмнэлэг зэрэг олон нийтийн барилга байгууламжийн бүтцийн үнэлгээг хийсэн. Үнэлгээнд хамрагдсан 199 нийтийн барилга байгууламжаас 185 барилгад газар хөдлөлтийн хүчитгэл хийх шаардлагатай байгааг тодорхойлсон³². Эмнэлэг, сургуулийн барилга байгууламжийн мэдээллийг БШУЯ, ЭМЯ хариуцдаг боловч мэдээллийг нэгэн зэрэг Барилга, хот байгуулалтын яамны харьяа Геодези, зураг зүйн газраас боловсруулсан Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан болох Гео-порталаар дамжуулан авах боломжтой.

Эрчим хүчний дэд бүтэц

Монгол Улсын эрчим хүчний салбар гамшгийн эрсдэлийн удирдлагын (ГЭУ) мэдлэг, технологи нь чухал ач холбогдолтой давуу талтай болохыг харуулдаг. ОБЕГ-аас эрчим хүчний салбарт гал түймэр, салхи шуурга, газар хөдлөлт, үер зэрэг төрөл бүрийн аюулын үед өргөнөөр ашигладаг гамшгийн эрсдэлийн үнэлгээний иж бүрэн удирдамжийг боловсруулсан. Эдгээр удирдамжийг ОБЕГ-ын цахим хуудаснаас үзэх боломжтой бөгөөд тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн компаниуд төрийн худалдан авах ажиллагааны системээр үр дүнтэй хэрэгжиж, нарийн мэргэжлийн компаниуд ГЗМС болон зайнаас тандан судлалыг ашиглан үнэн зөв үнэлгээ хийдэг.

Өндөржүүлсэн бэлэн байдал, сайн тоноглогдсон байгууламжийг бий болгон байнгын бэлэн

байдалтай байх нь салбарын үйл ажиллагааны салшгүй хэсэг юм. Үүнд Улаанбаатар хотод цахилгааны шугам сүлжээний доголдлын үед нөөцлөхөд бэлэн технологиор тоноглогдсон байршилтай үйл ажиллагааны доголдлыг бууруулах, сэргээх төлөвлөгөө багтана. Төвийн цахилгааны систем онцгой байдлын үед идэвхэждэг автомат систем бүхий найдвартай, дэвшилтэт технологитой. Тус салбар цахилгаан станцад гарсан гал түймрийн үед шуурхай ажиллах зорилгоор автоматжуулсан гал унтраагчаар тоноглогдож, шуурхай арга хэмжээ авахад гал унтраах бригад бэлэн байдаг нь гамшгийн эрсдэлийн удирдлагын иж бүрэн арга барилыг онцолж байна.

6.4.2 Хүндрэл, бэрхшээл

Үерээс хамгаалах дэд бүтэц

Үерийн эрсдэлийн талаарх мэдлэг ойлголт, технологи үерээс хамгаалах дэд бүтцийн шийдлийг танилцуулахад хангалттай ч хэрэгжиж байгаа эрсдэлийн загварчлал хот

орчмын гэр хороолол, албан бус суурин газрууд гэх мэт тодорхой хорооллын эмзэг байдлыг бүрэн дүүрэн тодорхойлж чадаагүй гэж үзэж байна.

Эмнэлэг, сургууль

Одоогийн байдлаар эмнэлэг, сургуулийн барилгын эрсдэлийн үнэлгээг зөвхөн Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын хийсэн үнэлгээгээр хязгаарлаж байна. Гамшгаас хамгаалах тухай хуулиар төрийн захиргааны байгууллага бүр гамшгийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх үүрэг хүлээсэн ч эмнэлэг, сургуулийн барилга байгууламжийн газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээг тогтмол

хийдэггүй. Саяхан Улаанбаатар хотын бүсэд (Улаанбаатар хотын газар хөдлөлтийн хагарал, УГХХ) М76-аас дээш газар хөдлөлт үүсгэнэ гэж тооцоолсон 50 км урт идэвхтэй газар хөдлөлтийн хагарлын шугам олдсон. УГХХ-ийн газар хөдлөлтийн хувилбар Улаанбаатар хотын бүс нутагт шинэ хүндрэл бэрхшээл үүсгэж байгаа ч ямар нэгэн эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй байна.

Эрчим хүчний дэд бүтэц

Монгол Улсын эрчим хүчний салбарт гамшгийн эрсдэлийн удирдлагад хэд хэдэн бэрхшээл тулгарч байна. Онц чухал дэд бүтцийн зураглал, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийдэггүй нь дүн шинжилгээг дутуу хийхэд хүргэдэг. Гамшгийн эрсдэлийг удирдах, бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар иж бүрэн мэдлэг ойлголт, туршлага мэдэгдэхүйц дутмаг байна. Нэмж дурдахад, тус салбарт алдагдал, хохирлын талаарх мэдээллийг цуглуулах, хадгалах системчилсэн арга барил дутмаг, төрөл бүрийн гамшгийн эмзэг цэгүүдийг тусгайлан тодорхойлсон зүйл байхгүй байна.

Албан хаагчдын гамшгаас хамгаалах бэлтгэл сургуулилт гал түймэр, үер, газар хөдлөлтийн хувилбараар хязгаарлагдаж, гамшгийн эрсдэлийн удирдлагын өргөн хүрээг хамарсан асуудлыг үл тоомсорлодог. Монгол Улс ихэвчлэн 1960-1980 оны хооронд баригдсан нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцуудад найддаг нь эрсдэл дагуулж байна.

Тус үйлдвэрүүдэд газар хөдлөлт, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга зэрэг байгалийн гамшгийн эсрэг шаардлагатай чадавх (хучилт бэхжилт) байхгүй. Жишээлбэл, 2023 онд орсон аадар борооны улмаас цахилгааны 20 тулгуур багана нурсан. Чухал байгууламжуудыг газар хөдлөлт мэдрэгчээр тоноглоогүй, барилгын зоорийн давхарт цахилгааны дэд станц суурилуулах нийтлэг байдал нь үерийн ихээхэн эрсдэлийг дагуулж байна.

Социализмын үеийн стандарт, хэм хэмжээ одоог хүртэл хэрэглэгдэж байгаа нь өнөөгийн хэрэгцээг хангахгүй байх нь элбэг. Эдгээр стандарт, нормыг үнэлэх, шинэчлэхэд чиглэсэн судалгаа дутмаг байна. Салбарын гамшгийн эрсдэлийг бууруулах, тухайлбал албан хаагчдын бэлэн байдал, албан байгууллагын барилга, цахилгаан станц, бусад ашиглалтын байгууламжийн аюулгүй байдлыг хангахад анхаарал бага хандуулдаг.

6.4.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Үерээс хамгаалах дэд бүтэц			
<p>Үерийн эрсдэлийн үнэлгээг өртөх хүн ам, нийгэм, эдийн засгийн эмзэг байдалтай уялдуулан шинэчилж байх:</p> <ul style="list-style-type: none"> • Үерийн хамгаалалтын дэд бүтцэд хийх арга хэмжээг нэн тэргүүнд авахын тулд дээрх үнэлгээг зардал, үр ашгийн шинжилгээнд ашиглана. 	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
<p>Уламжлалт инженерийн шийдлээс гадна ногоон технологийн хамрах хүрээг өргөжүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> • Байгальд суурилсан шийдлийг үерээс хамгаалах, үерийн аюулын эсрэг авах арга хэмжээний салшгүй хэсэг болгох. • Эдгээр арга хэмжээг Монгол Улсын ногоон санхүүжилтийн үндэсний механизм, Уур амьсгалын ногоон сан, Даян дэлхийн байгаль орчны сан зэрэг санхүүжилтийн олон механизмыг ашиглан хэрэгжүүлэх хад хэрэглэх. 	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв
Сургууль, эмнэлэг			
<p>Газар хөдлөлтийн сүүлийн үеийн нөхцөл байдалд үндэслэн Улаанбаатар хотын бүх сургууль, эмнэлгийн барилгуудад газар хөдлөлтийн тэсвэржилтийн эрсдэлийн үнэлгээг хийх.</p> <ul style="list-style-type: none"> • Эдгээр үнэлгээнд техникийн мэдлэг, хүний нөөцийн болон бусад боломжтой өгөгдөл мэдээллийг ашиглах. 	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
<p>Салбарын стратеги, төлөвлөгөөнд газар хөдлөлтийн үнэлгээний үр дүн (томоохон хэмжээний газар хөдлөлт)-г тусгахыг нэн тэргүүнд анхаарах.</p>	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Эрчим хүчний дэд бүтэц			
<p>Төр, хувийн хэвшлийн албан хаагчдад зориулсан гамшгийн эрсдэлийн удирдлага/бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.</p>	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Эрчим хүчний дэд бүтэц			
Боловсролын байгууллагууд сургалтын хөтөлбөртөө Монгол Улсад тохиолдох гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны чиглэлээр тусгайлсан бүлэг эсвэл хичээлийг оруулахыг дэмжих.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Төрөл бүрийн гамшгийн үед аюулгүй байдлыг хангах, нэн чухал дэд бүтэц, байгууламжийн зураглал, бүртгэл тооллогыг сайтар хийх.	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
<p>Бүх салбарын барилга байгууламжид газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ хийх:</p> <ul style="list-style-type: none"> • Дэд бүтцийн бүсэд гамшгийн онцлогтой эмзэг цэгүүдийг тодорхойлж, эрсдэлийг хянах мэдрэгч эсвэл тоолуур суурилуулах. 	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв



Зураг: Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Нийгэмлэг/ Роб Фью

VII. НИЙГМИЙН САЛБАР – ХҮН АМЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ, Парисын хэлэлцээрийг баталсанаас хойш 9 жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд дээрх баримт бичиг нь 2030 он хүртэлх мөрийн хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх чухал бодлогын баримт бичиг хэвээр байна. Эдгээр анхдагч баримт бичиг нь гамшиг болон хүн амын шилжилт хөдөлгөөн хоорондын харилцан хамаарлыг бататгаж, гамшгийн нөхцөлд шилжин суурьших, нүүлгэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх үндэсний болон олон улсын хүчин чармайлтыг нэмэгдүүлсэн.

Монгол Улсын газарзүйн өвөрмөц байршил, хүн ам зүйн онцлог, орон нутгийн хүн ам нь мал аж ахуйгаас хамааралтай байгаа нь тус улсыг байгаль орчны өөрчлөлт, цаг агаарын хүнд нөхцөлд онцгой өртөмтгий болгодог. Ихэвчлэн уур амьсгалын өөрчлөлт, бусад олон аюулт эрсдэлийг дагуулдаг цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж, хэмжээ, үргэлжлэх хугацаа нэмэгдсээр байгаа нь шилжин суурьших, хүний шилжилт хөдөлгөөн, сэлгэлт хөдөлгөөний урьд өмнө байгаагүй үр дагаварт хүргэж байна.

Урт, богино хугацааны дотоодын шилжилт хөдөлгөөн Монгол Улсад эрт дээр үеэс бий болсон уламжлалтай. Богино хугацааны хөдөлгөөний талаарх мэдээллийг (<3 сар) системтэйгээр цуглуулдаггүй. Орон нутгаас хот суурин газарт, тэр дундаа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг дор хаяж гурван үндсэн шалтгаанаар дэмжиж байгааг сүүлийн үеийн чиг хандлага харуулж байна. Үүнд, (а) Засгийн газрын хяналтад олон арван жил байсны дараа иргэдэд чөлөөтэй зорчих эрх олгосон шинэ хууль эрх зүйн орчин (1992 оноос хойш); (б) Уур амьсгалын өөрчлөлтөөс

үүдэлтэй байгалийн гамшиг, цаг агаарын эрс тэс байдал, малын хорогдол зэрэг нь орон нутгийн иргэдийг хот суурин газарт илүү сайхан амьдрах нөхцөл, ажил хөдөлмөр эрэлхийлэхэд түлхэц болсон; (в) Монгол Улсын хэмжээнд эрүүл мэндийн³³ тусламж үйлчилгээний хүртээмж, боловсролын салбар зэрэг суурь үйлчилгээ, дэд бүтэц нь хот суурин газар болон орон нутгийн хэмжээнд ялгаатай байх гэх мэт.

Монгол Улсад “хот” гэдэг нэр томъёо ихэвчлэн хоёр дахь том хот болох Дархан хотоос 13 дахин том нийслэл Улаанбаатарыг хэлдэг. Иймээс сүүлийн арван жилд хүн амын шилжилт хөдөлгөөний гэнэтийн өсөлтөөс үүдэн Улаанбаатар хотод 1.5 сая³⁴ гаруй хүн (нийт хүн амын 45.9%) оршин сууж байна. Ус, хөрс, дуу чимээний бохирдол, хэт их түгжрэл, төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, гамшгийн нөхцөл байдлыг нийслэл рүү чиглэсэн нүүлгэн шилжих хөдөлгөөн хэд дахин нэмэгдүүлж олон янзын үр дагаварт хүргэж байна. Засгийн газраас тасралтгүй өсөн нэмэгдэж буй дотоод шилжилт хөдөлгөөний урсгалыг зохицуулах хэд хэдэн арга хэмжээг 1994 оноос хойш авч байна. Гэсэн ч эдгээр арга хэмжээ зөвхөн хөдөлгөөний хязгаарлалт дээр тулгуурладаг тул эргээд эмзэг байдал, тэгш бус байдал, нийгмийн тусгаарлагдмал байдал, түүнчлэн ядуурал, тогтмол бус шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэхэд хүргэсэн³⁵.

Хүн амын шилжилт хөдөлгөөний салбарын чадавхыг үнэлэх хэрэгсэл үндэсний хэмжээнд эрсдэлийг бууруулах, дасан зохицох төлөвлөлтөд хүн амын шилжилт хөдөлгөөний талуудын интеграцийн түвшинг тодорхойлоход хэрэглэгддэг бөгөөд дараах үндсэн элементүүдэд төвлөрдөг. Үүнд, (а) гамшгийн

нүүлгэн шилжүүлэлт; (б) хил дамнасан нүүлгэн шилжүүлэлт; (в) албадан нүүлгэх; (г) төлөвлөсөн нүүлгэн шилжүүлэлт; (д) хөнгөвчлөх шилжилт хөдөлгөөн; (е) ГЭБ үйл ажиллагаанд цагаачид болон дүрвэгсдийг хамруулах; (ж) гадаадад байгаа иргэдэд үзүүлэх тусламж. Нөхцөл байдлаас шалтгаалж эдгээр элементүүдийн цөөн хэдэн хэсэг нь үндэсний бодлогын цөмд оршиж, зарим улс орон албадан нүүлгэн шилжүүлэлтийн олон хувилбарыг шийдвэрлэх өргөн хүрээний арга хэрэгсэл, бэлэн байдлын чадавхыг боловсруулж байхад, бусад нь чадавх, эрсдэлийн үнэлгээнээс хамааран хамгийн боломжит хувилбаруудад төвлөрдөг. Монгол

Улсын хүн ам зүйн болон хүний шилжилт хөдөлгөөний онцлог, түүнчлэн сүүлийн 75 жилийн хугацаанд нүүлгэн шилжүүлэлтийн томоохон хямрал гараагүй зэрэг нь эрх бүхий байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэлтийн урт хугацааны шийдэл, түүнийг шийдвэрлэх үйл явцын удаашрал, үүссэн нөхцөл байдалтай холбоотой бэлэн байдлын тэргүүлэх чиглэлийг хэсэгчлэн бууруулах гэнэтийн жижиг, дунд хэмжээний дотоод шилжилт хөдөлгөөнд бэлэн байлгахад чиглүүлж байна.

7.1 Засаглал

Хууль эрх зүйн хүрээ:

2020 онд Монгол Улс хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой заалтуудыг агуулсан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого зэрэг хэд хэдэн тулгуур бодлого, хууль тогтоомжийг баталж эхэлсэн.

Гэсэн хэдий ч дотоодын шилжилт хөдөлгөөн, хүн амын шилжилт хөдөлгөөнийг илүү системтэй, үр дүнтэйгээр зохицуулах тусгайлсан бодлого боловсруулах шаардлага байсаар байна. Энэхүү хэрэгцээ шаардлага, дээрх баримт бичгийн үр дүнд гэнэтийн аюулт үзэгдэлд хүн амын шилжилт хөдөлгөөнд бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг зохицуулах сайн бүтэцтэй байгаа ч урт хугацааны шилжилт хөдөлгөөн, нүүлгэн шилжүүлэлтэд зохих хариу арга хэмжээ авах стандарт, бодлого дутмаг байна.

Монгол Улсад хүн амын шилжилт хөдөлгөөнийг системтэй бодлого, засаглалаар үр дүнтэй зохицуулж чадаагүйгээс Улаанбаатар хот руу

чиглэсэн зохицуулалтгүй шилжилт хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэж үүний үр дүнд гэр хороололд тэгш бус байдал, нийгмийн гадуурхал, ядуурлын олон хэлбэр бий болж байна.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого нь хүн амын шилжилт хөдөлгөөний бодлогын гол баримт бичиг юм³⁶. Монгол Улсын Засгийн газар хүн амын нягтрал, тогтвортой хөгжлийг хангах, хүн амын амьжиргааны чанарыг нэмэгдүүлэх зорилгоор 1994, 2004, 2016 онуудад гурван удаагийн бодлого боловсруулсан. Хүн амын талаар баримтлах хоёр дахь удаагийн бодлогын хугацаа (2004 он) дуусмагц Монгол Улсын Засгийн газраас 2016-2025 он хүртэл баримтлах “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг 261 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан боловч Засгийн газар 2021 оны 314 дүгээр тогтоолоор тус бодлогыг хүчингүй болгосон. Сүүлийн 10 жилийн хугацаанд Улаанбаатар хот руу чиглэсэн дотоодын шилжилт хөдөлгөөний хэмжээ жилд дунджаар 24000 орчмоор тогтмол нэмэгдэж байгаа нь тоо баримтаас өөрөөр харагдаж байна³⁷.

Засаглал:

Энэ тайлангийн өмнөх хэсэгт дэлгэрэнгүй дурдсанаар ОБЕГ нь хүн амын гэнэтийн нүүлгэн шилжүүлэлт/шилжилт хөдөлгөөн, гамшгийн үед хариу арга хэмжээ авах, хариу арга хэмжээ авахад оролцдог төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон нийтийн бүлгүүд, олон улсын байгууллага зэрэг бүх холбогдох талуудын үйл ажиллагааг ерөнхийд нь зохицуулах үүрэгтэй байгууллага юм. Уур амьсгалын гаралтай гамшиг, аюулт үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаа талаар нэгдсэн ойлголт мэдлэгтэй болж, үндэсний болон орон нутгийн түвшинд засаг захиргааны байгууллагууд хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хариуцлагатай, хүчин чармайлт гарган ажиллаж байна. Хүн амын шилжилт хөдөлгөөнийг ихэвчлэн байгалийн үзэгдэл, даван туулах стратеги (уламжлалт үед) эсвэл хүндрэл, эрсдэл (хөдөө орон нутгаас хот руу шилжих үед) гэж тооцдог хэвээр байна. Энэ хоёрдмол байдал нь ГЭБ эрх бүхий форумууд, шилжилт хөдөлгөөний чиглэлээр тусгайлан ажилладаг байгууллага хоорондын хамтын ажиллагааны орон зайг багасгаж магадгүй.

ОБЕГ-аас удирдан чиглүүлж буй ГЭБ төлөвлөгөөнд хүн амын шилжилт хөдөлгөөнийг тусгасан ч тус хөдөлгөөн нь гал түймэр, газар хөдлөлт, үер зэрэг гэнэтийн гамшгийн үр дагавраас үүдэлтэй шилжилт хөдөлгөөн юм. 2023 оны 08 дугаар сард Улаанбаатар хотод болсон үерийн улмаас албадан нүүлгэн шилжүүлэх ажлыг амжилттай туршсан бөгөөд шилжилт хөдөлгөөнд үзүүлэх нөлөөллийг багтаасан гэнэтийн гамшгийн үед авах хариу арга хэмжээг зохион байгуулах нормативын үйл ажиллагааны хүрээнд нарийвчилсан заалт, удирдамжууд байдаг. Нүүлгэн шилжүүлэх, нүүлгэн шилжүүлэх байршил зэрэг асуудлыг шийдвэрлэх найдвартай арга замыг эрэлхийлэх бүрэн эрхийг сайтар тодорхойлоогүй ба орон нутаг, үндэсний түвшний үүрэг хариуцлага, ялангуяа орон нутгийн эрх баригчид өргөн хүрээтэй үүрэг хариуцлага хүлээдэг нь Улаанбаатар хоттой давхацсан байж болзошгүй байдал харагдаж байна. Хөдөө орон нутгаас хот руу шилжих шилжилт хөдөлгөөн, УАӨДЗ

үйл ажиллагаатай холбоотой шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал, одоогийн хууль эрх зүйн болон байгууллагын орчин, нийгмийн бодлогын хүрээнд тулгарч буй бэрхшээлийн хувьд хангалттай бэлтгэгдээгүй байна. Мөн тухайн улсын онцлог (хүн ам, шилжилт хөдөлгөөний хандлага, аюулт үзэгдэл гэх мэт) одоо шаардлагатай байгаа болон ирээдүйн шилжилт хөдөлгөөний хандлагыг тодорхойлж, зохион байгуулах иж бүрэн тогтолцоог батлахад түлхэц болдог. Энэ тулгуур үйл ажиллагааны хүрээг хараахан тодорхойлоогүй байгаа бөгөөд холбогдох үүрэг хариуцлага нь яам, агентлаг, ОБЕГ, Улаанбаатар хотын удирдлага хооронд тодорхой бус хэвээр байна.

Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн удирдлага (ОНОГЭУ)-ын механизмыг амжилттай хэрэгжүүлсэн бусад улс орны туршлагаас Монгол Улс илүүтэй судлах шаардлага байна. Бат бөх байгууллагын тогтолцоо, зохицуулалт, эрх баригчид нь олон нийтийн оролцоотой хүн амын шилжилт хөдөлгөөнийг багтаасан ГЭБ үйл ажиллагааны баримт бичгийг боловсруулж байгаа ч орон нутгийн иргэд нь өртөх байдал өндөр бүс нутагт ОНОГЭУ-ын доороос дээш чиглэсэн арга замыг төлөвлөх замаар өөрсдийн бэлэн байдлыг илүүтэй хангах боломжтой.

ОУШХБ-аас Монгол Улсын Засгийн газрын үндэсний болон орон нутгийн бодлогод дотоодын шилжилт хөдөлгөөнийг тусгах ерөнхий стратеги, зорилт, хэрэгжилтийн зохицуулалтыг тодорхойлсон шилжилт хөдөлгөөний зураглалыг боловсруулах нөхцөл байдлын шинжилгээний тайланг 2023 онд гаргасан.

Монгол Улсын хил дамнасан шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхэд чиглэсэн байгууллагын бэлэн байдлын чадавх хязгаарлагдмал байна. Хил дамнасан шилжилт хөдөлгөөний үед төрөл бүрийн оролцогч талуудыг үүрэг хариуцлага, харилцаа холбоо/үйл ажиллагааны сувгуудыг тогтоосон ч гэнэтийн хил дамнасан шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэх хангалттай бэлэн байдлын чадавх байхгүй байна.

7.1.1 Давуу тал

- Гамшгийн үед маш сайн тодорхойлсон үүрэг, хариуцлагатай улс орны хатуу засаглалын тогтолцоо.
- Улс төрийн эрх мэдлийн дэмжлэгтэй бодит, найдвартай үндэсний хэмжээний ГЭБ бүтэц.
- ОБЕГ-аас удирдан чиглүүлж буй ГЭБ төлөвлөгөөнд хүн амын шилжилт

хөдөлгөөнийг тусгасан ч тус хөдөлгөөн гал түймэр, газар хөдлөлт, үер зэрэг гамшгийн үр дагавраас үүдэлтэй шилжилт хөдөлгөөн юм.

- ОБЕГ нь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, ТББ, хувийн хэвшил, мөн олон улсын байгууллага болон бусад олон төрлийн байгууллагатай үр дүнтэй хамтран ажилладаг.

7.1.2 Хүндрэл, бэрхшээл

- УАӨДЗ болон удаан үргэлжлэх гамшгийн аюулаас үүдэлтэй шилжилт хөдөлгөөнийг тодорхойлсон тодорхой баримт бичиг, тогтолцоо байхгүй.
- Нүүлгэн шилжүүлэх эсвэл удаан хугацаанд ашиглах шийдэл хайж байгаа тохиолдолд үндэсний болон орон нутгийн түвшинд ялангуяа нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд хариуцах бүрэн эрх нь тодорхойгүй, үүрэг хариуцлага давхцаж болзошгүй.

- Үндэсний, бүс/орон нутгийн удирдлага нь шилжилт хөдөлгөөний талаар мэдлэг ойлголттой байгаа ч албадан шилжилт хөдөлгөөнд нөлөөлж буй болон түүнээс үүдэлтэй эмзэг байдлыг иж бүрнээр нь шийдвэрлэх талаар зөвшилцөлд хүрч чадаагүй байна. Хил дамнасан томоохон нүүлгэн шилжүүлэлтийг шийдвэрлэх хангалттай заалт байхгүй.

7.1.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Улаанбаатар хотод нүүлгэн шилжүүлэх удирдамж зэрэг нүүлгэн шилжүүлэлтийг тодорхойлж, зохион байгуулах иж бүрэн тогтолцоог бий болгох	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Улс орны дотоодын нүүлгэн шилжүүлэх бодлогын талаар нээлттэй хэлэлцүүлэгт оролцох/өрнүүлэх. Монгол Улс чадварлаг хүний нөөцтэй хэдий ч үндэсний болон орон нутгийн хэмжээнд хүн амын шилжилт хөдөлгөөнийг илүү сайн хамруулсан, ИНБ болон бусад оролцогч талуудыг илүү өргөн хүрээнд нэгтгэхийн тулд одоогийн нормативын тогтоосон хэм хэмжээний тогтолцоог шинэчлэн боловсруулж, өөрчлөх шаардлагатай.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Эрсдэлд өртөж буй олон нийтийг чадавхжуулж, тэдний даван туулах чадавхыг бий болгох босоо чиглэлийн хандлага дээр олон нийтэд суурилсан ГЭБ (ОНОГЭУ) төлөвлөгөөг илүү системтэй сурталчлах.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Гэнэтийн хил дамнасан гамшгийн нөхцөл байдал, үүний улмаас хил дамнасан хүн амын шилжилт хөдөлгөөний үед хамтын ажиллагааны механизмыг тодорхойлох зорилгоор хөрш орнуудтай хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Шилжилт хөдөлгөөний асуудлыг тусгасан бодлого, төлөвлөгөөг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд уг асуудлыг шийдвэрлэх тогтолцоотой болж нөөцийг илүү хуваарилах шаардлагатай байна. Үүнд үндэсний хэмжээнд, хотын болон орон нутгийн түвшинд, ялангуяа Улаанбаатар хотын захиргаанд шилжилт хөдөлгөөн, шилжигсдийн асуудлыг зохицуулах агентлаг, хэлтэс, нэгж байгуулах	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв

7.2 Хэрэгжилт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран 2020-2021 онд хийсэн хөндлөнгийн үнэлгээгээр хүний нөөц дутмаг, төрийн байгууллагууд хоорондын зохицуулалт, хамтын ажиллагаа, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг хэрэгжүүлэхэд дутагдалтай асуудал байгааг тогтоосон. Шилжилт хөдөлгөөний үйл ажиллагааг тайлагнах ажилд ХНХЯ-аас оролцож байгаа хэдий ч яаманд шилжилт хөдөлгөөний чиглэлээр ажиллах томилсон мэргэжилтэн байхгүй байгааг үнэлгээнд онцолсон байна. 2021 оны 12 дугаар сард Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний

удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлснээр Хүн амын бодлогыг цуцалж, улмаар нийгмийн хөгжлийн дунд хугацааны зорилтот хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон.

Тус улсын ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Засгийн газар 2017 оны Гамшгаас хамгаалах тухай хуульд Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн тухай шинэ бүлгийг нэмж оруулсан бөгөөд үүнд заасны дагуу бүх тусламж, үйлчилгээ нь гамшигт өртсөн хүн амын хэрэгцээг хангаж, хүмүүнлэгийн тусламжийн стандартыг дагаж мөрдөх ёстой талаар тодорхойлсон.

Дотоодын шилжилт хөдөлгөөн ба бэлэн байдал:

ОБЕГ-ын удирдлага, алба хаагчид гамшгийн үед нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, гамшгийн үед шийдвэр гаргах үйл ажиллагааны талаар тогтмол сургалтад хамрагддаг. Сургалт нь үер, газар хөдлөлт, ой, хээрийн түймэр зэрэг тохиолдож болзошгүй хамгийн их магадлалтай гамшгийн төрлүүдэд чиглэгддэг. ОБЕГ-ын алба хаагчид сургалтын

үеэр дунд хэмжээний нүүлгэн шилжүүлэлтийн хувилбарууд дээр ажиллахаас гадна сургалт нь ТББ, НҮБ-ын төрөлжсөн байгууллага зэрэг төрийн бус хөндлөнгийн оролцогч талуудтай онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах зохицуулалтыг багтаасан байдаг. ОБЕГ болон бусад бүх яам, агентлагийн ажилтан, албан хаагчид ажилдаа мэргэшсэн, үндэсний

болон орон нутгийн хэмжээнд нүүлгэн шилжүүлэлтийн нөхцөл байдал, эрсдэлийн талаар зөв ойлголттой байна.

Нийслэл хотын зарим хэсэгт эрсдэлтэй бүс нутгаас нүүлгэн шилжүүлэх зайлшгүй шаардлагатай талаар ойлголт байгаа хэдий ч аюулгүй, эмх цэгцтэй нүүлгэн шилжүүлэх тодорхой алхам хараахан хийгдээгүй байна. Энэ нь нэг талаараа нүүлгэн шилжүүлэлтийн нарийн төвөгтэй байдал, хотын түвшинд зохих байгууламж, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө байхгүй байгаатай холбоотой. Аюулгүй байршил, орон сууц руу нүүлгэн шилжүүлэх асуудлыг хотын захиргаа сүүлийн арав гаруй жилийн хугацаанд анхааралдаа авч байгаа ч томоохон төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц хангалтгүй байна. Томоохон хэмжээний тогтмол нүүлгэн шилжүүлэлтийг хэзээ ч хэрэгжүүлээгүй бөгөөд аюулгүй, эмх цэгцтэй нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулаагүй нь нийслэл хотын ойрын ирээдүйд шийдвэрлэх шаардлагатай хот төлөвлөлт, бэлэн байдлыг хангах хамгийн том бэрхшээлийг бий болгож байна.

Гадаадад байгаа иргэд болон хил дамнасан шилжилт хөдөлгөөн:

Гамшгийн үед гадаад улс оронд хэцүү байдалд орсон иргэдэд үзүүлэх тусламж нь дипломат харилцааны сүлжээ, боломжит нөөц боломжоос шалтгаалан хязгаарлагдмал байдаг. Үүнийг КОВИД-19 халдварт /COVID-19/ цар тахлын үеэр Монгол Улсын олон иргэд эх орондоо буцаж ирэх боломжгүй болсон үед туршиж үзсэн ба ОУШХБ-ын ивээн тэтгэсэн сайн дурын буцах хөтөлбөрөөс олон иргэд тусламж, дэмжлэг хүртсэн. Гэсэн ч энэ тал дээр цаашид авч үзэх хүчин чармайлт ГХЯ-аас гадаад улсад оршин суугчдын талаарх мэдлэг, зохицуулалтыг сайжруулах ёстой.

Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ) нь улсын албан ёсны хилийн нэвтрэх цэг, хилийн бүс нутгийг хамгаалах, хяналт тавих үүрэгтэй. Хил хамгаалах чиг үүргийнхээ хүрээнд ХХЕГ-аас хилийн боомтод хүний тогтмол эсвэл түр хугацаанд орж ирсэн тохиолдол зэрэг хилийн боомтод гарч буй төрөл бүрийн нэвтрэх/гарах тохиолдлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тайлагнадаг.

Эрсдэлтэй бүс нутгаас шилжин суурьших нь өнөөг хүртэл Монгол Улсын хөдөө орон нутгийн уламжлалт дасан зохицох механизм байсаар ирсэн. Шилжилт хөдөлгөөнийг зохицуулсан тусгай гэрээ хэлэлцээр байхгүй ч Монгол Улсын Газрын тухай хуулийн (3.1.3 зүйлд) газар эзэмших гэж “газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг” гэж тодорхойлсон байдаг. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх газрыг зөвхөн Монгол Улсын иргэн өмчлөх боломжтой. Хотод 0,07 га газар өмчлөхөөр эрхийг хязгаарласан. Аймаг, орон нутгийн оршин суугчид 0.35 га талбайг эзэмшиж болох ба сумдын оршин суугчид 0.5 га газрын хязгаарлалттай. Газар өмчлөлийн энэ уян хатан арга барил, газрын хүртээмжтэй байдал зэрэг нь нүүлгэн шилжүүлэх боломжийг хөнгөвчлөхийн зэрэгцээ газрыг зориулалтын бусаар ашиглах, суурин газрын хяналт байхгүй үед эмх цэгцтэй нүүлгэн шилжүүлэлт, хот төлөвлөлтийг хийхэд төвөгтэй болгодог.

Гэнэтийн хил дамнасан шилжилт хөдөлгөөний талаар мэдээлэх харилцаа холбоо, удирдлагын систем бий боловч хил дамнасан шилжилт хөдөлгөөний шууд үр дагаврыг арилгах тусгайлсан төлөвлөлт байхгүй байна. Учир нь дээрх үйл явдал тохиолдох магадлал бага гэж үзэх тул нөөцийг төлөвлөх, хуваарилахдаа энэ асуудлыг нэн тэргүүнд тавьдаггүй.

Монгол Улс 1951 оны Дүрвэгсдийн тухай конвенцод нэгдэн ороогүй тул Монгол Улсын хил дамнасан дүрвэгсдийн асуудалд оролцох эрхийг хязгаарласан. Монгол Улсын хилийн урт 8252,6 км³⁸ бөгөөд хүн амын нягтрал багатай нь хил дамнасан шилжилт хөдөлгөөн тохиолдох магадлал багатай ба хариу арга хэмжээ авахад хүндрэлтэй болгодог. Гэсэн ч энэ нь хил дамнасан шилжилт хөдөлгөөний талаар журам, удирдамжийг сайжруулахад саад болохгүй. Энэ асуудал бол ХХЕГ, ОБЕГ, олон улсын байгууллагуудтай хамтран илүү нарийвчлан судлах шаардлагатай салбар юм.

7.2.1 Давуу тал

- ОБЕГ-ын алба хаагчид гамшигтай тэмцэх, гамшгийн үед шийдвэр гаргах үйл ажиллагааны талаар холбогдох сургалтад тогтмол хамрагддаг.
- ОБЕГ, холбогдох төрийн байгууллагууд Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт нүүлгэн шилжүүлэлт/шилжилт хөдөлгөөний нөхцөл байдлын талаар маш сайн мэдлэгтэй.
- Нүүлгэншилжүүлэх/шилжилт хөдөлгөөний төлөвлөлт, бэлэн байдлыг хангах ажил хэрэгжиж, тасралтгүй сайжирч байна.

7.2.2 Хүндрэл, бэрхшээл

- УАӨДЗ, удаан үргэлжилдэг гамшигтай холбоотой хөдөө орон нутгаас хот суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах тусгай журам байдаггүй.
- Нүүлгэн шилжүүлсэн нийгмийн эмзэг бүлэг, хувь хүмүүсийн хамгаалалтыг сайжруулах чиглэлээр ажилладаг ИНБ, нийгмийн оролцогчидтой хамтран ажиллах үйл ажиллагаа хязгаарлагдмал.
- Дунд болон их хэмжээний (<10,000 нүүлгэн шилжүүлсэн) хүн амын шилжилт хөдөлгөөнд хариу арга хэмжээ авах дэд бүтцийн хүчин чадал хангалтгүй байна.
- Олон улсын албан ёсны хилийн боомтуудад агуулах, хоргодох байрны хүчин чадал хангалтгүй.

7.2.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Шилжин ирэгсэд болон эмзэг бүлгийн иргэдийг хамгаалах чиглэлээр ажиллаж буй байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-ын техникийн оролцоог дэмжиж ОБЕГ, ИНБ-ууд хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Улаанбаатар хотод нүүлгэн шилжүүлэх нэмэлт цэг, шаардлагатай тоног төхрөөмжийг тодорхойлж хангах ажлыг үргэлжлүүлэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Шилжигсдийг хүлээн авч буй бүс нутгийн одоо, ирээдүйн газар ашиглалт, хөгжлийн төлөвлөлтийг тооцох, цаашдын нөхцөл байдлыг загварчлах, бүтээн байгуулалтын иж бүрэн төлөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд газрын боломж, давуу талыг ашиглах тогтолцоог бий болгох	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Өмнөх хэсэгт зөвлөсний дагуу Гамшгийн эрсдэлийг бууруулах(ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) үйл ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог хангах, тэднийг босоо чиглэлийн арга замаар чадавхжуулах.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Хилийн гол боомтуудын бэлэн байдлын чадавхыг сайжруулах, Баазын зохицуулалт, баазын менежментийн (СССМ) стандартыг Монгол Улсын нөхцөл байдалд тохируулсны дараа ХХЕГ, ОБЕГ-ын албан хаагчдыг сургах.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбарц	Их төсөв/ Бага төсөв

7.3 Санхүүжилт

Үндэсний эх сурвалж:

ХНХЯ, НҮБ-аас 2020-2021 онд хийсэн хөндлөнгийн үнэлгээгээр Хүн амын бодлогын хэрэгжилт, түүний дотор шилжилт хөдөлгөөний санхүүжилтийн хамаарал, үр нөлөө, үр ашиг, тогтвортой байдлын талаар бодитой мэдээлэл цуглуулсан. Үнэлгээний тайлангаас харахад төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэхэд төсвийн хангалтгүй байдал, хүний нөөцийн дутагдал байнга гарч байсан. Тухайлбал, 2016-2018 онд ердөө 244 сая орчим төгрөг төсөвлөж зарцуулсан байна. Энэ дүн нь хүн ам, суурьшлын төлөвлөгөөг боловсруулах, боловсрол, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөдөө орон нутагт ажиллуулах, хөдөө аж ахуйн салбарт хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг өргөн хүрээний төлөвлөгөөт ажлуудад хүрэлцэхгүй байна.

Гамшигтай холбогдох зардлын санхүүжилтийг Засаг даргын болон Засгийн газрын нөөц сангаар дамжуулан олгодог. Засгийн газрын нөөц сангаас байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй гамшгийн хохирлыг арилгах үйл ажиллагааг санхүүжүүлдэг. Төсвийн нэг хэсэг нь улс орны хэмжээнд стратегийн ач холбогдол бүхий хүнсний бүтээгдэхүүн, үр тариа, түлшний нөөцийг хамардаг ба нийт сангийн одоогийн хэмжээ тодорхойгүй байна. Үүнийг дотоодын үйлдвэрлэлийн гэнэтийн тасалдал, тэр дундаа байгалийн гамшигтай холбоотой гамшгийн үйл явдлын үед нөхөж Нөөц сангаас бүрдүүлдэг. Мөн орон нутгийн Засаг дарга нар орон нутгийн Засаг даргын нөөцийн санг ашиглах боломжтой.

Гадаадад оршин суугчид ба мөнгөн гуйвуулга:

Хэд хэдэн яамны удирдлага дор, ОУШХБ, Үндэсний статистикийн хороо, Хилийн чанадад дахь Монголчуудын зөвлөлтэй хамтран хэрэгжүүлж буй Монгол Улсын Засгийн газар, гадаадад оршин суугчид хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх зорилгоор гадаадад оршин суугчдын оролцооны шинэ төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэ төсөл гадаадад оршин суугчдын оролцоо, мөнгөн

Энэ тайланд өмнө нь дурдсаны дагуу, төсөв санхүүгийн хязгаарлагдмал, урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдал зэрэг нь гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг үндэсний болон орон нутгийн түвшинд нэгтгэхэд хүндрэл учруулдаг. Улаанбаатар хотод илүү аюулгүй хоргодох байрыг тодорхойлж, тоноглох, яаралтай нүүлгэн шилжүүлэх төлөвлөлтийг нэн тэргүүнд тавьж байна. Гэсэн хэдий ч одоогийн санхүүгийн төлөвлөлт нь жижиг, дунд хэмжээний шилжилт хөдөлгөөнийг түр хугацаанд дэмжих боломжийг олгож, урт хугацааны хямралын хариу арга хэмжээг тогтвортой байлгах боломжгүй тул нэмэлт хөрөнгө санхүү шаардлагатай. Санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд юу хийж болох талаар хязгаарлалт байгаа ч үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх бэлэн байдлын санхүүжилтийн мөчлөгийг илүү сайн урьдчилан таамаглах хүчин чармайлт гаргаж болно.

Хуулиар зохицуулсан газар олголтоос гадна төр, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчдын дийлэнх хөдөө орон нутагт шилжин суурьших, ажиллах үед олгодог урамшууллыг эс тооцвол хөдөө орон нутагт шилжилт хөдөлгөөнийг дэмжих санхүүгийн тодорхой хөшүүрэг байхгүй бөгөөд амьдралын түвшингийн дутагдал болон тусгаарлагдсан байдалд хариу үйлдэл болгож олгодог хүнд нөхцлийн нэмэлт урамшуулал өгч байна.

гуйвуулгын үйл ажиллагааг дэмжинэ гэж үзэж байна. 2022 онд анх удаа гадаадад оршин суугчдын зураглал хийсэн бөгөөд 2020 онд гадаадад оршин суугч Монгол иргэд Монгол Улс руу нийт 536³⁹ сая ам.доллар илгээсэн нь ДНБ-ний 4 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 12.5 хувьтай тэнцсэн гэсэн тооцоолол бий. Эдгээр мөнгөн гуйвуулгын ихэнх нь Коронавируст халдвар /COVID-19/-ын

хорио дэглэмийн үед бага орлоготой гэр бүл, хамаатан садандаа дэмжлэг үзүүлж, банкны найдвартай тогтолцооны үр шимийг хүртсэн

байна. Монгол Улсын Засгийн газар ГХЯ-ны дэргэд Гадаадад оршин суугчдын бодлогын алба байгуулахаар төлөвлөж байна.

7.3.1 Давуу тал

- Өмнөх хэсгүүдэд тайлбарласан төсвийн олон арга хэрэгслийг ГЭБ үйл ажиллагаанд ашиглаж, хүн амын шилжилт хөдөлгөөний бэлэн байдлыг санхүүжүүлж болно: Төсвийн хуваарилалтын 1.0%-ийн тухай хуулийн заалт /ГХТХ 51.2/; Улс/аймгийн нөөцийн 30 хувийг гамшгаас хамгаалах, сэргээн босгох/сэргээн засварлах ажилд ашиглах боломжтой; Байгалийн нөөцийн төлбөр; ГЭБ болон уур амьсгалд зориулсан төсвийн хяналт; СЯ-ны гүйцэтгэлд суурилсан төсвийн нэмэлт хуваарилалт гэх мэт.
- Нэмэлт аюулгүй хоргодох байруудыг байнга тодорхойлж, тоноглодог тул яаралтай нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг харьцангуй сайн санхүүжүүлдэг.
- Банкны систем хүртээмжтэй, олон улсын зах зээлд сайн холбогдсон. Цахим төлбөрийн систем сайн хөгжсөн бөгөөд нүүлгэн шилжүүлэх нөхцөлд ашиглах боломжтой.

7.3.2 Хүндрэл, бэрхшээл

- Нийт санхүүжилтийн боломж хязгаарлагдмал. Энэ тайлангийн бусад хэсэгт онцлон тэмдэглэсэнээр, санхүүжилтийн хүртээмж хязгаарлагдмал, урьдчилан таамаглах боломжгүй тул гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг үндэсний, орон нутгийн түвшинд оновчтой нэгтгэхэд хүндрэл учирдаг.

7.3.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Илүү тогтвортой, найдвартай санхүүжилтийн тогтолцоог судалж, бий болгох нь гамшгийн бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, мөн гамшгийн үеийн шилжилт хөдөлгөөний төлөвлөлтөд ихээхэн дэмжлэг болно.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв

7.4 Мэдлэг мэдээлэл

ОБЕГ-аас хүн амын шилжилт хөдөлгөөнийг сайн дурын, албадан шалтгаанаар нэг газраас нөгөө газар руу түр, улирлын шинж чанартай болон байнгын шилжилт хөдөлгөөн гэж тодорхойлсон. Энэ нь түр хугацааны шилжилт хөдөлгөөнөөс (жишээ нь малчид) урт хугацааны эсвэл байнгын нүүлгэн шилжүүлэлт хүртэлх бүх төрлийн хөдөлгөөнийг тодорхойлдог. Хүн амын шилжилт хөдөлгөөнийг тухайн орон нутгийн (баг/хороо гэх мэт) захиргааны албан хаагч нар дүүрэг, аймаг руу, дараа нь ҮСХ-нд мэдээлдэг. Эдгээр статистикийн хөдөлгөөнт байдлыг иж бүрнээр харуулсан мэдээллийг нэгдсэн санд оруулаагүй бөгөөд Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) санаачилгуудад ашиглаж болох байсан. Хүртээмжтэй мэдээлэл нь бүхэлдээ орон нутгийн засаг захиргааны нэгжийн чадавхад тулгуурладаг. Тусгайлсан Үндэсний мэдээллийн сан хөгжүүлэх ажлын хэсэг байгуулах нь бэлэн байдал, хариу арга хэмжээний аль алинд нь ашигтай.

ОУШХБ 2018 оноос хойш Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)-ын уур амьсгалын өөрчлөлт, гамшгаас үүдэлтэй шилжилт хөдөлгөөнийг хянах чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж ирсэн. ОУШХБ-ын Шилжилт хөдөлгөөнийг хянах матриц (ШХХМ) хэрэгслийг Монгол Улсын нөхцөлд тохируулж, ОБЕГ-ын мэдээлэл цуглуулах системийг ашиглан хүн амын шилжилт хөдөлгөөний талаарх бодит мэдээллийг хангадаг. 2019 онд ОУШХБ, ОБЕГ хамтран Монгол Улсын хүн амын шилжилт хөдөлгөөнийг хянах суурь судалгааг ШХХМ ашиглан хийсэн. Энэ судалгаа нь Монгол Улсын Засгийн газарт уур амьсгалын өөрчлөлт, байгалийн аюулт үзэгдлээс шалтгаалсан нүүлгэн шилжүүлэлтийн талаарх мэдээлэл цуглуулах иж бүрэн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, бэлэн байдал, хариу арга хэмжээний талаар мэдээлэл өгөх баттай нотлох баримт болно.

Улаанбаатар хотод шилжин ирж буй айл өрхийн гуравны нэг орчим нь бүртгэлгүй бөгөөд тэдгээр бүртгэлгүй өрхийн талаас илүү хувь нь гэр хороололд амьдардаг. Бүртгүүлэхгүй байх гол

шалтгаан нь шилжин суурьшихыг хориглосон (шилжин ирэгсэд хүссэн ч бүртгүүлэх боломжгүй) газар суурьшдагтай холбоотой юм. Мөн шилжин ирэгсэд холбогдох журмын талаар зохих мэдлэг ойлголтгүй, шаардлагатай бичиг баримт бүрдээгүйн улмаас оршин суугаа газраа бүртгүүлж чадахгүй байх тохиолдол харьцангуй түгээмэл байдаг. Зарим шилжин ирэгсэд бүртгүүлээгүйн бас нэг шалтгаан нь тэд өөр газар руу нүүх эсвэл төрсөн газар руугаа буцах хоёр хувилбараас сонгоогүй байгаад оршино.

УБЕГ, ҮСХ-ны аль алинд нь мэдээлэл цуглуулах техникийн маш өндөр туршлага байдаг ч хүн амын тооллогыг хийхэд ашигладаг аргачлал нь хаяг дээр суурилсан харьцангуй хуучирсан систем юм. Одоогийн E-Mongolia программ маш найдвартай ч онцгой байдлын үед хөдөө орон нутгаас хот руу шилжих шилжилт хөдөлгөөн эсвэл уламжлалт нүүдэлчдийн нэг хэсэг болох хөдөлгөөнт хүн амын шилжилт хөдөлгөөнийг бүртгэхэд хязгаарлагдмал байдаг. ОУШХБ-тай хамтран хийсэн сүүлийн үеийн ажил бол хүн амын Шилжилт хөдөлгөөнийг хянах матриц (ШХХМ) зэрэг хүн амын шилжилт хөдөлгөөнийг илүү сайн тодорхойлох боломжтой нэмэлт арга зүйг тодорхойлсон явдал юм.

Сүүлийн таван жилийн хугацаанд ОУШХБ, ОБЕГ хамтран Увс аймгийн Гамшгаас хамгаалах бэлэн байдлын хөдөлгөөнт хяналт (2018 он), өмнө нь дурдсан Монгол Улсын Дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх Нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан (ОУШХБ, 2023 он), Улаанбаатар хотын Шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа (ОУШХБ, 2021 он), мөн Монгол улс: Шилжилт хөдөлгөөн ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (ОУШХБ, Монгол Улсын Их Сургуулийн Хүн амын сургалт, судалгааны төв, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Их сургууль – Маастрихтийн Инноваци, технологийн эдийн засаг, нийгмийн судалгааны хүрээлэн, 2021 он) зэрэг хүн амын шилжилт хөдөлгөөний талаар нэлээд олон судалгаа, тайлан хийсэн. Эдгээр санаачилгын үр дүнд гарсан мэдээлэл, дүгнэлтийг Гамшгийн

эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох (УАӨДЗ) төлөвлөлт, хэрэгжилтэд хараахан нэгтгээгүй байгаа ба ГЭБ, бэлэн байдлын төлөвлөлтөд шилжилт хөдөлгөөний өгөгдөл ашигтай болохыг хүлээн зөвшөөрөхийн тулд холбогдох байгууллагуудад нэмэлт судалгаа хийх шаардлагатай байна.

Хамгаалалтын тохиолдлыг лавлах олон систем зэрэгцэн оршиж, нэгдмэл байдлыг шаарддаг бөгөөд энэ нь байнгын болон нүүлгэн шилжүүлэлтийн үеийн хамгаалалтад хамаарна.

7.4.1 Давуу тал

- УБЕГ, ҮСХ-ны аль алинд нь мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх техникийн өндөр туршлага, чадварлаг боловсон хүчин, тохиромжтой тоног төхөөрөмж байдаг.
- ОУШХБ-тай хийсэн сүүлийн үеийн ажил 2023 онд дууссан ШХХМ-ын хүчин чадлын хөтөлбөр гэх мэт хүн амын шилжилт хөдөлгөөнийг илүү сайн тогтоох боломжтой нэмэлт өгөгдлийн багц, арга зүйг тодорхойлсон.

7.4.2 Хүндрэл, бэрхшээл

- Бүртгэлийг цуглуулахад ашигласан аргачлал найдвартай боловч гэнэтийн нүүлгэн шилжүүлэх эсвэл хөдөлгөөнт байдлын динамик мэдээллийг авах үед үр дүнтэй ажиллах уян хатан чанар дутагдаж байна.
- Сүүлийн гурван жилийн хугацаанд хийсэн судалгааны үр дүнд гарсан мэдээлэл, дүгнэлтийг Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан

Монгол Улсын Жендерийн үндэсний хороо лавлагааны механизмын зураглалыг гаргаж, холбогдох эрх бүхий байгууллага, түншүүд хамтран нэгтгэх стратегийг санал болгосон.

Эцэст нь олон улсын цагаачид, дүрвэгсэд болон бусад гадаадын иргэдийн талаарх мэдээллийг бүрдүүлдэг мэдээллийн сангийн үйл ажиллагааг Хилийн удирдлагын газар, Гадаад хэргийн яам, ҮСХ болон бусад холбогдох байгууллагууд удирдан зохицуулдаг ба тус мэдээллийн санг нэгтгэх эсвэл илүү сайн зохицуулах боломжтой.

- Эрсдэлийг таниулах механизмууд төрөл бүрийн мэдээллийн сувгаар дамжуулан хүмүүст мэдээлэл өгч, улс орны газар нутгийн хэмжээ, хүн амын нягтрал бага зэрэг логистикийн бэрхшээлийг харгалзан нүүлгэн шилжүүлсэн хүн амд боломжийн хэмжээнд хүрч ажилладаг.

зохицох (УАӨДЗ) төлөвлөлт, хэрэгжилтэд хараахан нэгтгээгүй байна.

- Тус улсад шилжин ирэгсэд, гадаадын иргэдийн мэдээллийг төвлөрүүлэн удирдах систем байхгүй байна.
- Хамгаалалтын тохиолдлын лавлагааны нэгдсэн механизм байхгүй бөгөөд үүнийг засах шаардлагатайгаас гадна нүүлгэн шилжүүлэлтийн үед эмзэг бүлгийн хүмүүст нэмэлт эрсдэл учруулж байна.

7.4.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Гадаадын иргэд, цагаачдын мэдээллийн санг нэг мэдээллийн санд нэгтгэх эсвэл холбох.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Улс орон даяар хамгаалалтын тохиолдлыг шилжүүлэх нэгдсэн механизмыг бий болгож, төвлөрсөн байдлаар удирдах.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Улс орны Мэдээллийн удирдлага ба Мэдээллийн ажлын хэсэг байгуулах.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Оршин суух бүртгэлийг дараах байдлаар шинэчлэх, сайжруулах. Үүнд: үл хөдлөх хөрөнгийн өмчлөл, түрээсийн баримт нотолгоог багасгах, шилжигсдийг өөрсдийн байршлын талаар засаг захиргаанд үнэн зөв, цаг тухайд нь мэдэгдэхэд түлхэц өгөх; онлайн бүртгүүлэх боломжтой байх; шилжин суурьшигсдыг нийслэлд ирмэгцээ бүртгүүлэхийг дэмжсэн аян хэрэгжүүлэх	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Шилжин ирэгсдийн оршин суугаа газраас төрийн үйлчилгээг салгаж, хувь хүмүүстэй холбож өгөх. Үүний зэрэгцээ оршин суух бүртгэлийг хялбаршуулж, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн бүртгэлийн хүртээмжийг нэмэгдүүлэх.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв

7.5 Технологи, тоног төхөөрөмж

ОБЕГ болон төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага нь нүүлгэн шилжүүлэлтэд ашиглах хангалттай (заримдаа хуучирсан) технологи, харилцаа холбооны хэрэгсэлтэй боловч бэлтгэл бэлэн байдлын хувьд дутагдалтай тул нүүлгэн шилжүүлэхэд хэрэгцээтэй нэмэлт хангамж, ялангуяа өвлийн улиралд шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглох, шаардлагатай байна. Төвлөрсөн суурин газрын түвшинд ерөнхийдөө хангалттай нөөц, технологи байдаг ч аймаг, орон нутгийн түвшинд бага байдаг. ОБЕГ-ын хэмжээнд хүний болон материаллаг нөөцийг хуулиар хамгаалсан байдаг учраас энэ чиглэлээр үнэн зөв үнэлгээ хийх боломжгүй болсон тул ОБЕГ-аас хүсэлт гаргаж, тохиролцсон тохиолдолд нөөцийн талаар илүү нарийвчилсан үнэлгээ хийх боломжтой. Ихэнх хөдөө орон нутаг, бүх

хилийн гол боомтууд их бага хэмжээний нүүлгэн шилжүүлэлт эсвэл хямралын үед хоргодох байрны бараа материал эсвэл Хүнсний бус зүйл (ХБЗ)-ийн олдоц хязгаарлагдмал байдал ажиглагдаж байна.

Өвлийн улирлын хэрэгцээнд шаардлагатай бараа материалууд Монгол орны нөхцөлд нэн чухал бөгөөд хүний амь насыг аврахад ихээхэн чухал үүрэгтэй тул нөөц бэлэн байх ёстой. Орон нутагт гэр үйлдвэрлэхээс гадна хүн амын дийлэнх нь гэрийг ашиглах туршлагатай байдаг тул уламжлалт гэрийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу хүн амыг нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд өвөлжилтийн нөөц шийдэл болгон хадгалах, хөрөнгө оруулах боломжийг судлах боломжтой.

Эцэст нь хэлэхэд хил хамгаалах байгууллага гамшгийн үед хүн амын гэнэтийн буюу их урсгалыг зохицуулахад хангалттай бэлтгэлгүй байна. Хил орчмын бүсэд гэнэтийн хил дамнасан шилжилт хөдөлгөөнд хариу арга

хэмжээ авах ямар ч нөөц бололцоо байхгүй бөгөөд одоогийн хүчин чадал нь зөвхөн цөөн хэдэн хүнийг улсын нийслэл эсвэл аймгийн төвд тусгай байгууламжид богино хугацаанд шилжүүлэн байршуулахад л хангалттай.

7.5.1 Давуу тал

- Агуулахын удирдлагын сайн бүтэцтэй систем, хүчирхэг логистик.
- Үндэсний болон аймаг, орон нутгийн бэлэн байдлын чадавхыг хадгалах, хөрөнгө оруулах төвлөрсөн төлөвлөгөө, бодлого.
- ОБЕГ болон аймаг, орон нутгийн онцгой байдлын байгууллага хооронд хүн амын шилжилт хөдөлгөөнийг агуулсан аюул, эрсдэлийн талаар тогтмол харилцаатай байдал.

7.5.2 Хүндрэл, бэрхшээл

- Томоохон хэмжээний гамшиг (+10,000 хүн нүүлгэн шилжүүлсэн) эсвэл удаан үргэлжлэх нүүлгэн шилжүүлэлтийн үед ашиглагдах яаралтай тусламжийн нөөцийг хязгаарлагдмал байдлаар урьдчилан байршуулсан.
- Нийслэл хотоос бусад газар нутагт нөөц, материалын олдоц хязгаарлагдмал, хүргэлт хийх хугацаа их зарцуулдаг.

7.5.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Монгол орны нөхцөл байдалд тохируулан өвөлжилтөд шаардлагатай зүйлсийг нэмж нөөцлөх, урьдчилан байршуулахад хөрөнгө оруулах. Өвөлжилтийн уламжлалт болон уламжлалт бус аргуудыг судлах	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Нийслэл болон аймгуудад хариу арга хэмжээнд ашиглагдах тусгай нөөцийг түргэн шуурхай хүргэх, бүрдүүлэх.	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв
Хилийн гол боомтуудын ойролцоо бага оврын дамжин өнгөрөх төвүүдийг байгуулах.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөнд стандартчилсан ХБЗ-ийн тусламжийн иж бүрдлийг тодорхойлсноор худалдан авалтын зардлыг бууруулж, хүргэлтийн хугацааг түргэсгэнэ.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв



VIII. НИЙГМИЙН САЛБАР– НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Нийгмийн хамгаалал нь ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлтийг сайжруулах, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг сайжруулах, чанартай боловсролзэрэгТогтвортойхөгжлийнзорилтын хэд хэдэн хөшүүрэг юм. Энэ утгаараа аливаа болзошгүй гамшиг, хямралын үед нийгмийн хамгааллын үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэх нь аливаа, байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулахад чухал ач холбогдолтой. Гамшгийн үед олон аюулын төрөлд байнга өртдөг хүмүүс, нийгмийн бүлгүүд байдаг. Жишээлбэл, эмэгтэйчүүд, охид, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настан, цагаачид, дүрвэгсэд, архаг өвчтэй хүмүүс гэх мэт. Иймд нийгмийн хамгааллын салбар нь гамшгийн үед нийгмийн байдал хэрхэн хувьсан өөрчлөгдөж болохыг анхаарч, тодорхой хувь хүн, эмзэг бүлгийн эрсдэлийг тооцож, тэдний онцгой хэрэгцээг хангах шаардлагатай.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2022 оны судалгаагаар тус улсын нийт хүн ам 3,457,548 болж, өмнөх оноос 1.4%-иар (эмэгтэйчүүд 51%, эрэгтэйчүүд 49%) өссөн байна. 2022 оны байдлаар улсын хэмжээнд нийт 115,115 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (нийт хүн амын 3%), 60 ба түүнээс дээш насны 281,016 хүн (нийт хүн амын 8%) байна. Нийтдээ 1,104,799 нь 0-14 насны (нийт хүн амын 32%) хүүхэд байна. Эдгээр статистик

тоо баримтаас харахад гамшгийн үед нийгмийн хамгааллын тусгай дэмжлэг авах шаардлагатай эмзэг бүлгийн хүн амын эзлэх хувь өндөр байгааг харуулж байна.

ХНХЯ нийгмийн хамгааллын салбарт гамшгийн эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах зорилгоор гамшгаас хамгаалах орон тооны албан хаагчтай байх үүрэгтэй.

Түүнчлэн, гамшиг, онцгой байдлын үеийн нийгмийн хамгааллын тасралтгүй үйл ажиллагааг хангах, холбогдох дүрэм журам, заавар, стандартыг боловсруулан хэрэгжүүлэх үйл ажиллагааг яам хариуцна. Тухайн салбартай холбоотой эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийхэд нийгмийн хамгааллын салбарт гамшгийн эрсдэлийн үр дүнтэй менежментийн асуудал бүх түвшинд тусгагдаагүй байгаа нь харагдаж байна. Хууль эрх зүйн орчин, бодлого төлөвлөлт байхгүйгээс холбогдох дүрэм журам, заавар, стандарт, арга хэмжээг боловсруулаагүй байна.

Нийгмийн хамгааллын салбарын хувьд гамшгийн эрсдэлд өртөх хүрээ өргөн байдаг. Гамшгийн үед эмзэг бүлгийн иргэдэд учирч болзошгүй саад бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх, ямар арга хэмжээ авах, аюулд хариу арга хэмжээг хэрхэн авах вэ гэдэг асуудал хэвээр байгаа ба хариулт нь тодорхой бус байна.

8.1 Засаглал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар 2021-2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөтэй ба салбарын хэмжээнд 41 хуулийн хэрэгжилтийг хангасан түгээмэл хэрэглэгддэг 30 хууль байдаг. Эдгээр хуулиудад гамшгаас хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжиж байгаа заалтуудад дүн шинжилгээ хийж үзэхэд нийт долоон хуульд найман заалт орсон байна. Засаглалтай холбоотой хуулийн хоёр заалт, мэдлэг ойлголттой холбоотой хоёр заалт, санхүүжилттэй холбоотой гурван заалт, технологи, тоног төхөөрөмжтэй холбоотой нэг заалт байна. Үүнээс гадна аливаа гамшиг, аюул тохиолдсон үед төрийн холбогдох байгууллага онцгой байдлын үед хамгаалах үүргийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг тодорхойлсон. Нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд

салбарынхаа бодлого, стратеги, эрх зүйн баримт бичгийг боловсруулахдаа Гамшгаас хамгаалах тухай хууль, холбогдох бусад дүрэм журамд иж бүрэн нийцүүлээгүй байна.

ХНХЯ нийгмийн халамжийн бусад төрлийн дэмжлэг шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эх, хүүхэд, иргэдэд 12 төрлийн нийгмийн тусламж үзүүлдэг. Гэвч гамшгийн үед ямар арга хэмжээ авах, нийгмийн халамжийг хэрхэн зохицуулах, хүн амын эмзэг бүлгийн хэрэгцээг хэрхэн түргэн шуурхай тодорхойлох, шилжилт хөдөлгөөн байгаа эсэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг янз бүрийн нөхцөл байдалд хэрхэн хамгаалах, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг аюулд тэсвэртэй байдлаар үргэлжлүүлэх талаар тодорхой төлөвлөгөө байхгүй байна.

8.1.1 Давуу тал

- Тохиолдож болзошгүй төрөл бүрийн гамшгийн үед нийгмийн салбар хариуцсан яамдаас хүлээгдэж буй үйл ажиллагааг Гамшгаас хамгаалах тухай хууль, холбогдох журамд тодорхой тусгасан байдаг.
- ХНХЯ-ны нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоо сайн бүрдсэн. Жишээлбэл, саяхан тохиолдсон Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахал, үер, ган, хүчтэй цасан болон шороон шуурганы үеэр олон улсын байгууллагаас олгосон хүмүүнлэгийн тусламж, мөнгөн шилжүүлгийг ХНХЯ зорилтот бүлгүүдэд аюулгүй хүргэсэн.
- Тэтгэвэр, тэтгэмжийг эрүүл мэндийн байдал муу, ар гэрийнхний асаргаа байхгүй, бие даан амьдрах боломжгүй болон бусад

тусгай хэрэгцээт, эмзэг бүлгийн иргэдийн анхан шатны хэрэгцээг хангах зорилгоор төрөөс олгодог.

- Нийгмийн хамгааллын салбар зорилтот бүлэг, тэр дундаа тусгай хэрэгцээт хүмүүст туслах зорилгоор холбогдох мэдээллийг цуглуулж, хангадаг. Энэ нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж буй хууль эрх зүйн орчин, үйл ажиллагааны журмын дагуу зохицуулах боломжтойг харуулж байна. Жишээлбэл, ХНХЯ-ны Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэс хүүхэд хамгааллын чиглэлээр олон байгууллагатай хамтран ажиллаж, тэдний оролцоотойгоор Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын стандартыг боловсруулсан.

8.1.2 Хүндрэл, бэрхшээл

- Нийгмийн хамгааллын бодлогын баримт бичиг, хууль тогтоомжид болзошгүй аюулын үед хэрхэн хариу арга хэмжээ авах, нийгмийн эмзэг бүлэгт хэрхэн хүрч ажиллах зэрэг гамшгийн удирдлагын талаар тодорхой заалтуудыг тусгаагүй.
- Нийгмийн эмзэг бүлэг болзошгүй гамшиг, аюулд хэрхэн өртөж байгаа, эдгээрээс ямар тусгай хэрэгцээ гарч байгааг тодорхойлох холбогдох дүрэм, заавар, стандарт, үнэлгээний арга байхгүй байна.

- Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг сайн бүрдүүлж чадсан ч гамшгийн үед салбар хоорондын үйл ажиллагааг хангах, хянах чадавх хязгаарлагдмал.
- Нийгмийн хамгааллын салбарт гамшгийн асуудал хариуцсан бүтэц, нэгж байхгүй,

байгууллага бүрд нэг албан хаагч үндсэн ажил болон гамшгийн асуудлыг давхар хариуцаж ажилладаг. Эдгээр албан хаагчдад ерөнхийдөө байгууллагын удирдлага, урамшуулал, хамтран ажиллах багийн дэмжлэг байдаггүй.

8.1.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Салбар хоорондын зохицуулалтыг сайжруулахын тулд нийгмийн салбарын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай илүү нягт хамтран ажиллах.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
ХНХЯ-ны бүтэц, мэдээллийн сан, хүний нөөц, нийгмийн сүлжээг харгалзан гамшигтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах чадварт дүн шинжилгээ хийх.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Нийгмийн хамгааллын удирдлага, стратегид олон улсын хүмүүнлэгийн стандартыг тусгах, сайжруулах	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Нийгмийн төрөл бүрийн бүлгүүдэд анхаарлаа төвлөрүүлж, салбар бүрийн гамшгийн төлөвлөлт, нийгмийн төрөл бүрийн хүн ам зүйд нөлөөлж болзошгүй аюулд хариу арга хэмжээ авах цогц төлөвлөгөөг боловсруулах.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Нийгмийн хамгааллын салбарын байгууллагуудад тусгайлсан бүтэн цагийн ГЭБ төвлөрсөн цэгүүдийг байгуулж, тэднийг агентлагтаа ГЭБ үйл ажиллагааны удирдагч болгохын тулд сургалт зохион байгуулах.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Их төсөв

8.2 Хэрэгжилт

Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт нь төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчид, иргэдийг сургах, чадавхжуулах зорилготой. Энэ хүрээнд удирдах албан тушаалтан, онцгой байдлын байгууллага, сурагч, сургуулийн өмнөх насны хүүхэд, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хуулийн байгууллагын ажилтан, албан хаагчид, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, иргэд олон нийт гэсэн

төрлөөр сургалтыг тогтмол зохион байгуулж байна. Гэсэн ч салбарын онцлогт тохирсон чадавхыг бэхжүүлэх асуудал дутмаг байна. Сургалтад хамрагдсан оролцогчдын тоо цөөн учраас салбар бүрийн тулгамдсан асуудлыг ойлгох, улмаар байгууллага, салбар бүрийн бусад албан хаагчидтай давтан сургалт явуулах ур чадвар, мэдлэг, хүний нөөц дутмаг байна.

Нийгмийн хамгааллын салбар нь гамшгаас хамгаалах улсын албаны нэгд тооцогддог тул салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан. Гэвч Коронавируст халдвар /КОВИД-19/ зэрэг гамшгийн үед гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу ажиллахад нийгмийн хамгааллын салбарын албан хаагчид өөрсдийн үүрэг, хариуцлагын талаар хангалттай ойлголт мэдлэггүй, нийгмийн эмзэг бүлэгт хэрхэн хүрч ажиллах,

ажлаа дуусгах тодорхой, практик удирдамж дутмаг байсан нь ажиглагдсан.

Тиймээс түр журмыг Коронавируст халдвар / COVID-19/-д тусгайлан зориулж түргэн шуурхай боловсруулах шаардлагатай болсон. Гамшгийн үед тусламж шаардлагатай зорилтот бүлгийн хэрэгцээг тодорхойлох шуурхай үнэлгээний арга, онцгой байдлын үед ашиглах бүртгэлийн систем байхгүй байна.

8.2.1 Давуу тал

- Олон улсын байгууллагуудын гамшгаас хамгаалах төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан гамшгийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтын модуль, салбар бүрд хэрэглэх боломжтой олон улсын хүмүүнлэгийн стандартыг монгол хэлнээ хөрвүүлж, нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлыг тодорхойлохын тулд төрөл бүрийн судалгааны тайланг гаргасан.
- ХНХЯ, холбогдох агентлагууд тусламж шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийн амьжиргааны аюулгүй байдлыг хангах тайван цагт хүртээмжтэй нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлэх тогтолцоо, холбогдох мэдээлэл цуглуулах арга барилын хүчирхэг сүлжээтэй.

8.2.2 Хүндрэл, бэрхшээл

- Нийгмийн хамгааллын салбарт гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийгээгүйгээс бусад салбарын төлөвлөгөөг нийгмийн хамгааллын бүрэлдэхүүн хэсгийн үндэс болгон ашигладаг боловч тэдгээр нь хангалттай зохицож тохироогүй байна.
- ХНХЯ-ны чадавх хязгаарлагдмал байгаа тул гамшгаас хамгаалах асуудлыг нийгмийн хамгааллын түвшинд хэлэлцэж, гамшгаас хамгаалах иж бүрэн тогтолцоог бүрдүүлэхэд холбогдох албадаас шаардлагатай дэмжлэгийг авахад бэрхшээлтэй байна.
- Гамшгийн үед мэргэжлийн болон нийгмийн хамгааллын байгууллагууд хэрхэн хамтран ажиллах талаар ойлголт дутмаг байдаг. Нийгмийн даатгалаас мэргэжлийн дэмжлэг авахыг хүсдэг боловч салбарын хэмжээнд зохицуулалтыг онцгой байдлын байгууллагуудаас ихэвчлэн хүсдэг.
- Гамшгийн үед ХНХЯ нийгмийн хамгааллын болон орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллахад хүндрэлтэй байдаг. Монгол Улсад гамшгийн үед ажиллах онцгой комисс байдаг бөгөөд улсын хэмжээнд яамд, аймгийн удирдлагуудыг онцгой байдлын үйлчилгээний удирдлага дор гамшгаас хамгаалах, мэргэжлийн нэгж болгон зохион байгуулдаг. Энэ нь гамшгийн үед ХНХЯ-д салбаруудаа шууд удирдах боломжийг олгодоггүй.
- Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтыг тодорхой салбарын хэмжээнд зохион байгуулаагүй. Энэ нь нийгмийн хамгааллын салбарыг тэргүүлэх чиглэлээ тодорхойлох, гамшгийн үед авах арга хэмжээг ялгах боломжийг олгодоггүй.
- Одоогийн сургалтын материалуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулсан зорилтот бүлэгт чиглэсэн сургалтын хувилбар байхгүй.
- Олон нийтэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд гамшгийг хариуцсан

мэргэжилтэнгүй тул гамшгийн асуудлыг хариуцдаг төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс, тухайлбал санхүү, хүний нөөц,

сургалтын мэргэжилтэн, нярав гэх мэт үндсэн үүргээсээ гадна гамшигтай холбоотой асуудлыг давхар хариуцдаг.

8.2.3 Зөвлөмж

- Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллага сургалтын арга зүй, агуулгад дүн шинжилгээ хийж, салбарын яам, харьяа агентлагийн онцлогт тохирсон агуулгыг оруулах. Мөн практик сургалтын илүү олон хувилбарыг боловсруулах шаардлагатай. (Жишээ нь: нэг салбарын түвшний сургалт, олон салбар хоорондын үйл ажиллагааг сайжруулах салбар дундын сургалт, салбарын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулахад чиглэсэн сургалт гэх мэт)
- Аж ахуйн нэгжүүдэд гамшгаас хамгаалах мэргэжилтнийг томилохдоо хэлтсүүдийн төлөөллөөс бүрдсэн гамшгаас хамгаалах багийг бүрдүүлэх.
- Салбарын хэмжээнд хүмүүнлэгийн хариу арга хэмжээний олон улсын стандарт болон үүнийг одоогийн тогтолцоотой хэрхэн уялдуулан хэрэгжүүлэх талаар сурталчлах.
- Нийгмийн хамгааллын салбарт хийгдсэн олон салбарыг хамарсан судалгааны тайлангуудыг ашиглан сайжруулах шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэх.
- Олон нийтийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчид, өндөр настан зэрэг нийгмийн бүлэгт зориулсан сургалтын материалыг боловсролын байгууллагуудтай хамтран боловсруулахад онцгой анхаарах.

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Салбарын яам, холбогдох агентлагийн онцлогт тохирсон байдлыг хангаж онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын сургалтын арга зүй, агуулгад дүн шинжилгээ хийх.	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв
Салбарын түвшний сургалт, харилцан үйл ажиллагааны салбар дундын сургалт, салбарын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулахад чиглэсэн сургалт зэрэг олон төрлийн практик сургалтын хувилбаруудыг боловсруулах.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Хүмүүнлэгийн хариу арга хэмжээний олон улсын стандартыг өнөөгийн тогтолцоонд нийцүүлэн хэрэгжүүлэх	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Нийгмийн хамгааллын салбарт хийгдсэн олон салбарыг хамарсан судалгааны тайлангуудыг ашиглан сайжруулах шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэх.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний асран хамгаалагчид, өндөр настан зэрэг нийгмийн бүлэгт тусгайлан зориулсан сургалтын материалыг боловсролын байгууллагуудтай хамтран боловсруулж, сайжруулах.	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв

8.3 Санхүүжилт

Нийгмийн хамгааллын салбарт өргөн хэрэглэгдэж байгаа 30 хууль, эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийсэн бөгөөд гамшиг, онцгой байдлын үед нийгмийн хамгаалалтай холбоотой байж болох зөвхөн гурван хууль байгаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн хамгааллын тухай хууль,

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль юм. Гэхдээ эдгээр хуулийн заалтын аль нь ч гамшгийн удирдлагын тогтолцоог бүрэн авч үзээгүй байна. Түүнчлэн гамшгийн үед ашиглах хөрөнгө, төсвийн хуваарилалтын талаар огт дурдаагүй байна.

8.3.1 Давуу тал

- Гамшгийн үед төсөвлөгдсөн хөрөнгө байхгүй ч Засгийн газрын нөөцийн сан, Засаг даргын нөөцийн сан гэх мэт нөөцийн сан, тэтгэмжийн хуваарилалт, олон улсын байгууллагын хүмүүнлэгийн тусламжийн

хуваарилалт зэрэг нь хамгийн тулгамдсан бэрхшээлийг, ялангуяа эмзэг бүлгийнхний дунд шаардлагатай асуудал/хэрэгцээг шийдвэрлэхэд ерөнхийдөө хангалттай байсан.

8.3.2 Хүндрэл, бэрхшээл

- Нийгмийн хамгааллын салбарын хууль эрх зүйн орчинд гамшгаас хамгаалах, болзошгүй аюулын хариу арга хэмжээний талаар зохицуулалт байхгүйгээс холбогдох төсвийн төлөвлөлтийн тодорхой үндэслэл байхгүй байна.
- Одоогийн мөрдөж буй нийгмийн халамжийн хуулийн дагуу гамшигт нэрвэгдсэн иргэн, айл өрх гамшгийн улмаас учирсан хохирлын хэмжээнээс үл хамааран 1,200,000 (\$340)

мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж авдаг.

- Нийгмийн хамгааллын салбар аюулд тэсвэртэй нийгмийн хамгааллын төлөвлөгөөгүй, хууль эрх зүйн орчинд гамшгийн удирдлагатай холбоотой төсөв төлөвлөх заалтгүй, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, гамшгийн дараа сэргээн босгох үйл ажиллагаанд нийгмийн хамгааллын төсөв байхгүй.

8.3.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Нийгмийн хамгааллын хууль эрх зүйн орчныг шинэчлэх, гамшгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр тусгайлан төсөв төлөвлөх.	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв
Гамшгийн дараа иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмжийн хэмжээг уян хатан болгож, учирсан хохирол, эмзэг байдлын түвшинд тохируулах	Яаралтай	Төвөгтэй	Их төсөв
Тусгай хэрэгцээт хүмүүст хүрч ажиллахад анхаарч, нийгмийн хамгааллын чиглэлээр тусгай тоног төхөөрөмж худалдан авах, харилцааны суваг, ур чадварыг хөгжүүлэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Их төсөв

8.4 Мэдлэг ойлголт

Нийгмийн хамгааллын салбар нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдээлэл цуглуулах өөрийн гэсэн тогтолцоотой ч гамшгийн үед хариу арга хэмжээ авах чиглэлийн мэдээллийн агуулгыг оруулаагүй

байна. Олон нийтэд үйлчилгээ үзүүлж буй салбар бүр өөрийн үйл ажиллагаанд зориулж мэдээлэл цуглуулдаг ч гамшиг тохиолдоход тухайн үед шаардлагатай мэдээллийг дахин цуглуулах шаардлага гардаг.

8.4.1 Давуу тал

- ОБЕГ-аас аюулын төрөл тус бүрээр гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалд үндэслэн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааварчилгааг өгч, холбогдох сургалтыг явуулж байна.
- ХНХЯ нийгмийн бүх түвшинд байгаа судалгааны нөөцөд тулгуурлан өргөн хүрээний мэдээлэлд дүн шинжилгээ хийх бүрэн чадвартай.

8.4.2 Хүндрэл, бэрхшээл

- Нийгмийн хамгааллын салбарын хүмүүнлэгийн үйл ажиллагааг хянах, үнэлэх, тайлагнах механизм байхгүй.
- Аливаа гамшгийн үед эрсдэл өндөртэй бүс нутаг, тодорхой зорилтот бүлгийн байршлын талаар шуурхай мэдээлэл өгөх боломжгүй.
- Хүмүүнлэгийн байгууллага, онцгой байдлын байгууллагыг нийгмийн эмзэг бүлэг, тэдний тусгай хэрэгцээний талаар цаг тухайд нь мэдээллээр хангадаггүй.
- ХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал эрхэлсэн газар нийгмийн эмзэг бүлэг, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хэрхэн ажиллах талаар арга зүйн зөвлөмжийн дагуу хангалттай хамтран ажилладаггүй.

8.4.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Гамшгийн үед, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн бэлэн байдлын чиглэлээр ашиглах зорилгоор одоогийн мэдээллийн системээс цуглуулж болох мэдээлэлд дүн шинжилгээ хийх.	Яаралтай биш	Хэрэгжүүлэхэд хялбар	Бага төсөв
Онцгой байдлын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагуудын эрсдэлийн зураглал, цаг агаарын мэдээ, газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулж гамшгийн эрсдэл, эмзэг бүлгийн эрсдэлийг үнэлэх.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Тусламж авах шаардлагатай эмзэг бүлгийг тодорхойлсон нарийвчилсан судалгааны зураглал үүсгэх.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв

8.5 Технологи, тоног төхөөрөмж

Өнөөг хүртэл нийгмийн хамгааллын салбарын холбогдох талууд бэлэн байдал, ГЭБ үйл ажиллагааг тогтвортой байлгахын тулд өөрсдийн тоног төхөөрөмж, технологийн чадавхад тодорхой, иж бүрэн үнэлгээ хийгээгүй байна. Иймд энэ салбарын өнөөгийн техник технологи, мэдээллийн удирдлагын тогтолцоо, хүний нөөцийн чадавх, цаашид сайжруулах чиглэлийг оношлоход хүндрэлтэй байна. Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед ажиллаж байсан туршлагад үндэслэн, Хорио цээрийн дэглэм тогтоогдсон

үед нийгмийн аюулгүй байдлын салбарын албан хаагчид онцгой байдлын албанд ээлжлэн дайчлагдаж, шалгалтаар орж гарч байгаа хүмүүсийн бүртгэлийг хянаж, хөтөлж байсан. Тухайн үед мэргэжлийн хүмүүс хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан, ажилчдын аюулгүй байдал Коронавируст халдвар /COVID-19/-ын үед ажиллах нөхцөлд тохирсон байсан ч бусад салбарын ажилчдыг хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад чиглэсэн зохицуулалт байхгүй байсан.

8.5.1 Давуу тал

- ХНХЯ нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн үйлчилгээг нийгмийн зорилтот бүлэгт хүргэх, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, хүүхэд, эмэгтэйчүүдийн нийгмийн хамгааллын чиглэлээр мэдээлэл цуглуулах, мөнгөн шилжүүлэг хийх чиглэлээр маш өргөн цар хүрээтэй тогтолцоонд ажиллах чадвартай.
- ХНХЯ-ны стандарт систем гамшгаас хамгаалах бэлэн байдлын үндэс суурь болох боломжтой боловч цаг уурын өөрчлөлт, гамшгийн нөхцөл байдалтай тусгайлан холбогдоогүй бөгөөд шаардлагатай үед ашигладаг систем юм.

8.5.2 Хүндрэл, бэрхшээл

- Нийгмийн хамгааллын сүлжээг үргэлжлүүлэхийн тулд улс орон нийт салбарын хэмжээнд гамшгийн хариу арга хэмжээ авахад бэлэн биш байна. Энэ нь нийгмийн зорилтот бүлгүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээс бусад тохиолдолд гамшгийн нөхцөл байдалд ажиллах нийгмийн хамгааллын ажилчдын туршлага дутмаг байгаатай холбоотой.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулаад нийгмийн эмзэг бүлгийнхэн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл авах төхөөрөмжгүй, тэдэнд хэрхэн хүрч ажиллах, тэднийг дэмжихэд ямар тусгай хариу арга хэмжээ авах талаар зохицуулалт байхгүй.

8.5.3 Зөвлөмж

Зөвлөмж	Яаралтай байдал	Хэрэгжүүлэх байдал	Зардал
Гамшгийн үед эмзэг бүлгийн талаарх мэдээллийг илүү сайн цуглуулах, хуваалцах, дүн шинжилгээ хийх мэдээллийн технологийн хэрэгслийг сайжруулах.	Яаралтай биш	Төвөгтэй	Бага төсөв
Гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоог бүх түвшинд бэхжүүлж, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт тавих, гамшгийн үед эмзэг бүлгийн иргэдэд онцгой анхаарал хандуулж, санал хүсэлтийг хангах	Яаралтай	Төвөгтэй	Бага төсөв
Эрт сэрэмжлүүлэх мэдээллийн хүртээмжтэй системийг боловсруулснаар гамшгийн үед эмзэг бүлгийнхэнд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, бэрхшээлийг идэвхтэй шийдвэрлэх.	Яаралтай	Хэрэгжүүлэхэд хялбар	Их төсөв
Эмзэг бүлгийн тусгай хэрэгцээг хангахын тулд гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босголтод ашиглах нөөц, хангамжийн чанар, зохистой байдлыг сайжруулах.	Яаралтай биш	Төвөгтэй	Их төсөв

ХАВСРАЛТ

Хавсралт I:

ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТУУД ХИЙСЭН БАЙГУУЛЛАГУУД

Яам, агентлагууд

Онцгой байдлын ерөнхий газар

Аюулгүй байдал судлалын хүрээлэн

Үндэсний аврах бригад

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

- Бодлого төлөвлөлтийн газар
- Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
- Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
- Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
- Мал эмнэлгийн ерөнхий газар

Эрүүл мэндийн яам

- Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар
- Бодлого төлөвлөлтийн газар
- Нийтийн эрүүл мэндийн газар

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

- Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

Зам, тээврийн хөгжлийн яам

Боловсрол, шинжлэх ухааны яам

Барилга, хот байгуулалтын яам

- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хот байгуулалтын газар
- Салбарын хяналтын газар

Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Эдийн засаг, хөгжлийн яам

- Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар

Эрчим хүчний яам

- Салбарын хяналтын газар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

- Захиргааны удирдлагын газар
- Уур амьсгалын өөрчлөлтийн Монгол Улсын тусгай элч

Сангийн яам

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн

- Цаг агаар, орчны тоон загварчлал, судалгааны хэлтэс

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар

Цаг уур, орчны шинжилгээний газар

- Орчны шинжилгээний хэлтэс
- Урьдчилан мэдээлэх хэлтэс

Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн ерөнхий газар

- Орон зайн мэдээллийн хэлтэс

Барилгын хөгжлийн төв

- Барилга байгууламжийн зураг төсөл магадлалын хэлтэс
- Норм нормативын хэлтэс

Санхүүгийн зохицуулах хороо

- Даатгалын газар

Нийгмийн даатгалын ерөнхий газар

- Үйл ажиллагааны хөгжлийн хэлтэс

ХБХ хөгжлийн ерөнхий газар

- Тамгын газар

Геодези, усны барилга байгууламжийн газар

- Өндөржилт, төлөвлөлтийн хэлтэс

Үндэсний статистикийн хороо

- Тооллого, өгөгдлийн шинжилгээний газар

Нийслэл хот

- Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар
- Нийслэлийн Онцгой байдлын газар
- Бодлогын хэрэгжилтийн хяналтын хэлтэс

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

- Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
- Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Одон орон, геофизикийн хүрээлэн

Монгол Улсын Хөдөө аж ахуйн их сургууль

- Биологийн хүрээлэн
- Барилга, архитектурын сургууль

Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургууль

- Барилга, архитектурын сургууль

Монгол Улсын их сургууль

- Геологийн сургууль

ТББ-ууд

- Монголын Улаан Загалмай Нийгэмлэг
- Пипл ин Нийд
- Хүүхдийг Ивээх Сан
- Дэлхийн Зөн Монгол
- Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо

НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Хүний эрхийн үндэсний комисс

Жендерийн үндэсний хороо

Хувийн хэвшил

- Үндэсний давхар даатгал ХК (Үндэсний давхар даатгал ХК)
- Номин даатгал

Хавсралт II:

ЧАДАВХЫН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА

Энэхүү судалгаа нь Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны гамшгийн бэлэн байдалд үнэлгээ хийх зорилготой судалгаа хийсэн. ОБЕГ-ын гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, эрт сэрэмжүүлэх арга хэмжээнүүдийн чадавхийг тодорхойлох КАДРИ үнэлгээг дэмжих зорилготой хийв.

Асуулт 1. Та аль байгууллагад хамааралтайг тодорхойлон уу?

- Онцгой байдлын ерөнхий газрын
- Орон нутгийн онцгой байдлын газар

Асуулт 2. Та аль аймгаас судалгаа өгч байгаа вэ?

- Архангай
- Баян-Өлгий
- Баянхонгор
- Булган
- Дархан-Уул
- Дорнод
- Дорноговь
- Дундговь
- Говь-Алтай
- Говьсүмбэр
- Хэнтий
- Ховд
- Хөвсгөл
- Орхон
- Сэлэнгэ
- Сүхбаатар
- Төв
- Улаанбаатар
- Өмнөговь
- Увс
- Увс аймаг
- Завхан

Асуулт 3. Таны албан тушаалын түвшин?

- Гүйцэтгэх түвшний албан тушаалтан
- Дунд түвшний албан тушаалтан
- Удирдах түвшний албан тушаалтан

Асуулт 4. Таны боловсролын түвшин?

- Бүрэн дунд сургууль
- Дээд боловсрол (Их сургууль)
- Дээд боловсролын зэрэг (Магистр ба түүнээс дээш)

Асуулт 5. Таны хүйс?

- Эрэгтэй
- Эмэгтэй

Асуулт 6. Та хэдэн жил ОБЕГ/ орон нутгийн онцгой байдлын газарт ажиллаж байгаа вэ?

- 2 ба түүнээс доош жил
- 3-5 жил
- 6-10 жил
- 10 ба түүнээс дээш жил

Асуулт 7. Таны албан тушаалтай холбогдсон үүрэг/хариуцлагыг доорхи сонголтоос хамгийн сайн тодорхойлсныг олно уу?

- Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх
- Гамшгийн эрсдэлийн удирдах төлөвлөгөө боловсруулах
- Гамшгийн эрсдэлийг удирдах төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Гамшгийн эрсдэлийг удирдах төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад хяналт тавих
- Сургалтууд явуулах
- Гал унтраах болон гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах
- Онц байдлын үйл ажиллагаа
- Санхүү, захиргааны ажил

Асуулт 8. Гамшгийн бэлэн байдлыг удирдан зохион байгуулах этгээдийг сонгоно уу?

- Онцгой байдлын ерөнхий газрын/ Орон нутгийн онцгой байдлын газар
- Салбар хариуцсан яам
- Орон нутгийн удирдлагууд
- Гамшгийн эрсдэлийг удирдах зөвлөл
- Улсын Онцгой Комисс
- Онцгой байдлын шуурхай штаб (ЕОС)

Асуулт 9. Төрөл бүрийн гамшигт бэлтгэл, бэлэн байдлыг хангахад оролцох ёстой бүх талуудыг сонгоно уу?

- Онцгой байдлын ерөнхий газрын/ Орон нутгийн онцгой байдлын газар
- Салбар хариуцсан яам
- Орон нутгийн удирдлагууд
- Гамшгийн эрсдэлийг удирдах зөвлөл

Асуулт 10. Дараах гамшгуудад бэлтгэл, бэлэн байдлын үйл ажиллагааг зохион байгуулахад Та өөрийн чадавхыг үнэлнэ үү? (1- маш муу; 2 – муу; 3 – дунд; 4 – сайн; 5 – маш сайн)

- Ган
- Зуд
- Гал түймэр (ой, хээрийн)
- Гал түймэр (хотын орчин)
- Үер
- Газар хөдлөлт
- Цаг агаарын хэт аюулт үзэгдэл (жишээ нь, хүчтэй салхи гэх мэт)
- Хүн, амьтны халдварт өвчин
- Гэнэтийн шилжин суурьших хөдөлгөөн

Асуулт 11. Дараах үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд Таны өөрийн мэдлэгт үнэлгээ хийнэ үү? (1- итгэлгүй; 2 – муу; 3 – дунд; 4 – сайн; 5 – маш итгэлтэй)

- Гамшгийн хариу арга хэмжээ (Ажиллагаа: аврах ажиллагаа, нүүлгэн шилжүүлэлт, гал унтраах)
- Онцгой байдлын ерөнхий газар/ Орон нутгийн онцгой байдлын газрын дотоод болон бусад байгууллага, иргэдэд тухайн гамшгийн нөхцөлд хэрхэн эрсдэлийг бууруулах талаар чиглүүлж зааварчилгаа өгөх
- Гамшгийн дараах сэргээн босголт болон засвар үйлчилгээний үйл явцад яамдын болон орон нутгийн засаг захиргааны хэлтсүүдийг зохицуулалтаар хангах
- Гамшгийн эрсдэлийг бууруулах хууль, тогтоомжийн мэдлэг
- Төрөл бүрийн байгалийн аюулт үзэгдлүүд болон гамшиг яагаад тохиолддог талаарх мэдлэг

Асуулт 12. Гамшгийн эрсдэлийг бууруулах хамгийн сайн 3 аргаас сонгоно уу.

- Гамшиг тохиолдох үед тусламжийн бараа материалыг нөөцөлж, үр дүнтэй тараах
- Олон нийтийн барилга, эмнэлэг, сургуулиудыг газар хөдлөлтөд тэсвэртэй болгох
- Цаг уурын болон уур амьсгалын урьдчилсан мэдээг сайжруулах
- Хүүхэд, гэр бүлээ гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургах
- Цахилгаан автомашин ашиглах
- Гамшгийн даатгалд гэр, машинаа даатгуулах
- Үерийн хамгаалалтын байгууламжийг бэхжүүлэхэд санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх


Асуулт 13. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд юуг хэрэгжүүлвэл Танд хэрэгтэй вэ?

- Урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг
- Бусдыг сургах чадвар
- Санхүүгийн нөөц
- Мэдээлэл, өгөгдөл
- Биет багаж хэрэгсэл, яаралтай тусламжийн багц
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг


Асуулт 14. Үнэлгээний багтай хуваалцахыг хүссэн ямар нэгэн санаа, ойлголт эсвэл зөвлөмж байвал Та хуваалцана уу.

Судалгаанд оролцогчдын мэдээлэл


Судалгаанд оролцогчдын хүйс, харьяалал



Судалгаанд оролцогчдын ОБЕГ/ОНОБГ-т ажилласан ажлын туршлагын мэдээлэл




Судалгаанд оролцогчдын газар зүйн байршил




Зураг 21. Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Судалгаанд оролцогчдын албан үүргийн хүрээ




Зураг 22. Судалгаанд оролцогчдын албан үүргийн хүрээ

Судалгаанд оролцогчдын гамшгийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах мэдлэгийн өөрийн үнэлэмжийн дүн




Зураг 23. Судалгаанд оролцогчдын гамшгийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах өөрийн мэдлэгийн үнэлэмжийн дүн

Судалгаанд оролцогчдын тухайн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд өөрийн мэдлэгийн үнэлэмжийн дүн (хүйсээр)



Зураг 23. Судалгаанд оролцогчдын тухайн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхэд өөрийн мэдлэгийн үнэлэмжийн дүн (хүйсээр)

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны оролцогчдын ойлголт



Зураг 24. Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны оролцогчдын ойлголт

НОМ ЗҮЙ

- 1 Монгол Улсын эрсдэлийн дүр зураг. ТА-9878 БҮРТГЭЛ: Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд гамшгийн эрсдэл шилжүүлэх байгууламжийг хөгжүүлэх, 2022 оны 3-р сар ТАБНЭЗХА.
- 2 Монгол Улсын ядуурлын шинэчилсэн мэдээлэл 2018 он. “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” үндсэн тайлан, 2018 он, Дэлхийн банк групп, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо.
- 3 Уур амьсгалын өөрчлөлтийн эрүүл мэнд, амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл. Монгол Улсын үнэлгээ, 2021 он
- 4 Монгол Улсын боловсролын салбарт үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө. Монгол дахь НҮБХС-ийн төлөөлөгчийн газар, Боловсрол Шинжлэх Ухааны Яам, 2019 он
- 5 Засгийн газрын 2004 оны 08 дугаар тушаал
- 6 (УЦУОМСХ) (2023 он) АХБ-ны Монгол Улсын Гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх ТТ-9880 стандартын хүрээнд боловсруулсан Монгол улсын цаг уурын аюулын шинэчилсэн зураглал (төсөл)
- 7 Ю.Сузуки, Т.Наката, М.Ватанабэ, С.Баттулга, Д.Энхтайван, С.Дэмбэрэл, Ц.Одонбаатар, А.Баясгалан, Т.Бадрал (2020 он). Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн хагарлын илрүүлэг: Монгол Улсын нийслэл газар хөдлөлтийн шинэ аюул занал, Газар хөдлөлт судлал. Лав. Зах. 92, 437–447, doi: 10.1785/0220200109
- 8 Анх түргэн тусламж, гал командын тээврийн хэрэгслийг удирдан зохицуулах систем болгон боловсруулсан.
- 9 <https://www.desinventar.net/>
- 10 Монгол Улс, Улаанбаатар хотын Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх төсөл, Эцсийн тайлан, 2-р боть Үндсэн тайлан (2013 он), Азийн Гамшгийг бууруулах төв, Хотын гамшгийн судалгааны хүрээлэн, Токио хотын цахилгаан эрчим хүчний үйлчилгээ ХХК.
- 11 З.Төмөрбаатар.; Х.Миура; Ц.Цамба. Газар хөдлөлтийн алдагдал хохирлын тооцоололд зориулсан Монгол Улсын Улаанбаатар хотын Барилгын тооллогын мэдээлэл. ISPRS Int. - Фотограмметр ба зайнаас тандан судлах олон улсын нийгэмлэгийн (ФЗТСОУН) ОУ-ын Гео-Мэд сэтгүүл 2022, 11, 26. <https://www.mdpi.com/2220-9964/11/1/26>
- 12 АХБ-ны Монгол Улсын Гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах, шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх ТА-9880 стандартын хүрээнд бэлтгэсэн БОМОУТ (2023 он) Монгол Улсын Гамшгийн эрсдэлийн үндэсний үнэлгээ (төсөл)
- 13 Дэлхийн банкны тусламжтайгаар 2005 онд Мал аж ахуйн даатгалыг нэвтрүүлсэн
- 14 Монгол Улсын Засгийн газар 2014 онд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХХК-ийг үүсгэн байгуулсан нь 2018 онд өргөжин “Монгол Улсын Үндэсний давхар даатгал” ХК болгон нэрээ өөрчилсөн. Одоогоор Монгол Улсын Үндэсний давхар даатгал ХК улсын хэмжээнд нийт даатгалын зах зээлийн 15%-ийг эзэмшиж байна.
- 15 Үрийн тариалангийн даатгалын тухай хууль хэрэгжиж байгаа ч өндөр шимтгэл (Даатгуулсан хөрөнгийн үнийн дүнгийн 8% <https://legalinfo.mn/mn/detail/14>) нь тус хуулийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна. Үүнийг шийдвэрлэх зорилгоор Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийн төслийг шинээр боловсруулж байна.
- 16 Энэ нь төрөл бүрийн эд хөрөнгийг хамарч, даатгалын нөхөн олговор нь эд хөрөнгийн төрлөөс хамааран 5 саяас 50 сая хүртэл байна
- 17 2023 оны 9-р сарын байдлаар Эрсдэлийн даатгалын тухай хуулийн тавдугаар хувилбарыг боловсруулж байна

- 18 Доорх агентлагуудын төслүүдийн зураглалыг гаргасан. Үүнд: АХБ, Азийн сан, Кэйр Интернэшнл, ЕХГА, ЕСБХБ, НҮБХХААГ, ГОУХАК, ОУЦБ, ЯОУХАА, Мерси Корп, Монголын Улаан Загалмай нийгэмлэг, НҮБХХЭГ, Пипл ин Нийд, НҮБХХ, НҮББОХ, НҮБАНДЭЗНК, НҮББШУСБ, НҮБХАС, НҮБХАСХ, НҮБОУХЯТС, АНУОУХА, НХХ, ДХХ, ДЭМБ, Дэлхийн банк, Дэлхийн зөн.
- 19 х.40-41, Гамшгийн эрсдэлийг бууруулах (ГЭБ) Сендайн үйл ажиллагааны хүрээний Монгол Улсын дунд хугацааны тайлан, 2022 он.
- 20 <https://inff.org/country/mongolia>
- 21 Хот дахь Олон улсын эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлэг
- 22 Улсын хэмжээнд 320 орчим төрийн бус байгууллагыг хамрах Байгаль орчны Иргэний зөвлөл хэмээх ТББ-уудын нэгдэл бий.
- 23 Монгол Улсаас гаргасан тайлан, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц, 2023 оны 3-р сар
- 24 <https://www.gazar.gov.mn/storage/reports/October2023/oiur13U7gxFAioKwVrC2.pdf>
- 25 Монгол Улсын Засгийн газар, 2019 он. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр. <https://www.legalinfo.mn/annex/details/10091?lawid=14627>
- 26 <https://www.fao.org/documents/card/en?details=CA2181EN%2F>
- 27 <https://openknowledge.worldbank.org/server/api/core/bitstreams/6cd7c24b-a3c3-5c67-b6b5-3d0f5f600b5c/content>
- 28 <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/27019011/>
- 29 https://www4.unfccc.int/sites/SubmissionsStaging/NationalReports/Documents/06593841_Mongolia-NC3-2-Mongolia%20TNC%202018%20print%20version.pdf
- 30 Монгол Улсын сургуулийн аюулгүй байдлын иж бүрэн үнэлгээ. Улаанбаатар хот, Монгол улс, 2018 он, НҮБХХС
- 31 Судалгаанд хүртээмжтэй хэд хэдэн барилгын стандартыг харуулж, тус стандартыг сайжруулах, дагаж мөрдөх шаардлагатай. (Эх сурвалж: Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэд - Оролцоог хангахад гарч буй ахиц дэвшил, АХБ, 2019 оны 12-р сар)
- 32 Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх төсөл 1-р үе шат (2016-2019 он), Төслийн танилцуулга, ЖАЙКА
- 33 Сүүлийн жилүүдэд орон нутгаас нийслэл рүү шилжин ирж буй хүмүүсийн тоо нэмэгдэхийн хэрээр нийслэлд эрүүл мэндийн байгууллагуудын эрэлт хэрэгцээ хоёр дахин (бүр гурав дахин) нэмэгдсэн: Олон улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ), 2023 он Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал: Нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан. ОУШХБ, Улаанбаатар хот.
- 34 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн хороо, 2022 он.
- 35 Олон улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ), 2023 он Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал: Нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан. ОУШХБ, Улаанбаатар хот.
- 36 Шилжилт хөдөлгөөн, түүнтэй холбоотой асуудлыг зохицуулсан Монгол Улсын бусад хууль тогтоомжид дараах зүйлс орно: (а) 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хууль (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, 1992 он); (б) 2002 онд баталсан Монгол Улсын Иргэний хууль (Монгол Улсын Их Хурал, 2002 он); (в) 2018 онд баталсан Монгол Улсын Улсын бүртгэлийн ерөнхий хууль (Монгол Улсын Их Хурал, 2018 он); (г) 2018 онд баталсан Монгол Улсын Иргэний улсын бүртгэлийн тухай хууль (Монгол Улсын Их Хурал, 2018 он); (д) 2018 онд баталсан Монгол Улсын нутаг дэвсгэр дэх иргэний хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх удирдамж (Монгол Улсын Засгийн газар, 2018 он).
- 37 Олон улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ), 2023 он Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал: Нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан. ОУШХБ, Улаанбаатар хот.
- 38 Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар (bpo.gov.mn)
- 39 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн хороо, 2022 он.







НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



caDRi Partnership

Гамшгийн эрсдэлийг
бууруулах чадавхыг
бэхжүүлэх түншлэл



